

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-26
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	27-146
<hr/>	
1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга сонсох	27-27
2. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	28-85
3. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	85-118
4. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	118-146

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 31-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Э.Бат-Амгалан, П.Батчимэг, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Н.Наранбаатар, Ц.Туваан, Б.Тулга, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Ө.Шижир;

Чөлөөтэй: Э.Батиугар, Ж.Бат-Эрдэнэ, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ж.Ганбаатар, Б.Пунсалмаа, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Л.Гантөмөр, С.Лүндэг;

Хоцорсон: Н.Алтанхуяг-01 минут, Н.Алтанишагай-1 цаг 45 минут, М.Бадамсүрэн-17 минут, Б.Батбаатар-03 минут, Д.Батлут-03 минут, Н.Батсүмбэрэл-01 минут, Х.Баттулга-4 цаг 48 минут, Б.Батцэцэг-4 цаг 52 минут, Ж.Галбадрах-02 минут, Ц.Даваасүрэн-07 минут, Т.Доржханд-07 минут, Б.Жавхлан-3 цаг 38 минут, Т.Мөнхсайхан-01 минут, П.Мөнхтулга-14 минут, Ц.Мөнхтуяа-02 минут, Н.Номтойбаяр-04 минут, Э.Одбаяр-18 минут, Д.Пүрэвдаваа-03 минут, Х.Тэмүүжин-04 минут, Г.Тэмүүлэн-02 минут, А.Ундраа-10 минут, Ч.Ундрэм-12 минут, Г.Уянгахушиг-02 минут, Д.Цогтбаатар-50 минут, Ж.Чинбүрэн-20 минут, Б.Чойжилсүрэн-14 минут, Ж.Энхбаяр-1 цаг 31 минут, Л.Энх-Амгалан-1 цаг 56 минут, Д.Энхтуяа-10 минут.

Нэг. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:02/

Уг асуудлыг 10 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамьянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын

Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Л.Жаргалсайхан, Д.Баярхүү, Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Жаргалан, О.Батнайрамдал, С.Ганбаатар, С.Цэнгүүн, П.Сайнзориг, О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин, Л.Мөнхбаясгалан, Ч.Анар, Ц.Сандаг-Очир, Г.Лувсанжамц, С.Эрдэнэболд, Ж.Золжаргал, Г.Ганбаатар, Б.Түвшин, Ж.Галбадрах, Г.Уянгахишиг, Б.Батбаатар, А.Ундраа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Л.Жаргалсайхан, Д.Баярхүү, Г.Жамсрандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Усны газрын дарга З.Батбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Уг асуудлын санал хураалтыг 13 цаг 38 минутад түр хойшлуулав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 39 минут үргэлжилж, 13 цаг 39 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 42 минутад эхлэв.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, мөн албаны Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглал хариуцсан шинжээч Б.Пунцаг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, О.Батнайрамдал, Ж.Баясгалан, Д.Энхтүвшин, М.Мандхай, О.Номинчимэг, Л.Мөнхбаясгалан, Ч.Анар, Да.Цогтбаатар, П.Ганзориг, Б.Түвшин, Б.Батбаатар, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 15 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Х.Болормаа, Б.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 22.5.22 дахь заалтын “үзэл баримтлалд нийцсэн” гэснийг “үзэл баримтлалд туссан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 39

Бүгд: 100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 16 цаг 42 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Улсын Их Хурал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийн 22.5.22-т заасан хөнгөлөлтийг 22.5.11, 22.5.20, 22.5.21-д заасан хөнгөлөлттэй давхардуулан эдлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 36
Бүгд: 102
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “Монголын үндэсний олимпын хорооны” гэснийг “Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 36
Бүгд: 102
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 40
Бүгд: 102
60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Г.Очирбат нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “2 дугаар зүйл” нэмэх:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөлөх” гэсний дараа “, хөнгөлөх” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 38
Бүгд: 102
62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 37
Бүгд: 102
63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 11 дэх хэсгийн “, сонгон шалгаруулах этгээдийг” гэснийг “болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг” гэж өөрчлөх гэсэн гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 36
Бүгд: 102
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 9 дэх заалтын “болон бусад үйл ажиллагааны” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 46
Бүгд: 102
54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн “10”, “12” дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 42
Бүгд: 102
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх” заалт нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт, хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлан хийн, аудитын дүгнэлт гаргуулж нэгдсэн журмаар шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “төрийн болон орон нутгийн өмчит” гэсний дараа “, төрийн өмчийн оролцоотой” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 45
Бүгд: 102
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 6 дахь дэд заалтын “төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын” гэснийг “санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 43
Бүгд: 102
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 49
Бүгд: 102
52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 39
Бүгд: 102
61.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

Нэг. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “олон нийтэд” гэсний дараа “нээлтэй” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 53
Бүгд: 102
48.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “3 дахь” заалт нэмэх:

“3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар хөнгөлөлт эдлүүлэх төслийн жагсаалттай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 66
Бүгд: 102
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “3 дахь” дэд заалт нэмэх:

“3/хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 95
Бүгд: 102
6.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “4 дэх” дэд заалт нэмэх:

“4/инновац шингэж шинээр бүртгэгдсэн, олон улсад туршигдсан бараа, материал, барилгын ажил гүйцэтгэх арга барил, тэргүүн туршлагыг барилгын салбарт хурдацтай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, нормативын баримт бичиг, дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга, байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 94

Бүгд: 102
7.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн саналуудыг холбогдох хуулийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу товлосон асуудлыг ажлын цагт багтаан хэлэлцэж дуусаагүй тул хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгав./17:57/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийх санал:

1.Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд урсгал зардал шилжүүлэх санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Х.Болормаа, Б.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Мал, аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн гэсэн 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүжилт болох 16,492.5 сая төгрөгийг Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 55
Бүгд: 102
46.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 50
Бүгд: 102
51.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 48
Бүгд: 102
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийх санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.29.Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 70,105.1 сая төгрөг, санхүүжих дүн 20,802.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, ХХП.1.6.Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн барилга, 80 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 14,587.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,118.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 44
Бүгд: 102
56.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.42.Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх хатуу хучилттай авто зам /Ховд, Булган, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 22,607.2 сая төгрөг, санхүүжих дүн 13,030.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах, XVIII.1.18.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 600.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг болон XIV.1.1.77.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 1,560.0 сая төгрөг, санхүүжих дүн 780.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, нийт 12,880.0 сая төгрөгийн эх үүсвэрээр XVIII.1.12.Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ, бохир усны гол магистрал шугам 2 дугаар ээлж /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Тахилт, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,293.2 сая төгрөг, санхүүжих дүн 4,090.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,417.0 сая төгрөгөөр, Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, залууст чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Ховд аймагт хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зориулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцыг 2,000.0 сая төгрөгөөр, XIX.1.9."Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,463.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 51
Бүгд: 102
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 49

Бүгд: 102
52.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 49
Бүгд: 102
52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.24.Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, XIX.1.9."Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 55
Бүгд: 102
46.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XV.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 20,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,850.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн тоног төхөөрөмж, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн үйлдвэрийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,350.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 38
Бүгд: 102
62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц дотор зохицуулалт хийх санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд тусгагдсан 49.8 тэрбум төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас болгон зориулалтыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 68
Бүгд: 102
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр.Төсөл, хөтөлбөрийн нэр өөрчлөх санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 17.3.5.1.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох гэсэн төсөл, хөтөлбөрийн нэрийг “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 56
Бүгд: 102
45.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/ гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 39
Бүгд: 102
61.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Бусад Байнгын хорооны санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрийн 27.1.1 дэх арга хэмжээг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.1.Зэвсэгт хүчнийг “Нисгэгчгүй нисэх хэрэгсэл”, “Дрон”, “Хиймэл оюун ухаан”-д суурилсан дэвшилтэт техник, хэрэгслээр хангах, Шалгуур үзүүлэлтийн дугаар-27.1.1.1, Шалгуур үзүүлэлт-техник хэрэгслийн хангалт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-8.5, Зорилтот түвшин-20” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 35
Бүгд: 102
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.4 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, Шалгуур үзүүлэлтийн дугаар-27.1.4.1, Шалгуур үзүүлэлт-арга хэмжээний хэрэгжилт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-10, Зорилтот түвшин-15” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 36
Бүгд: 102
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.36.Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 9,618.3 сая төгрөг, санхүүжих дүн 4,555.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,219.3 сая төгрөгөөр бууруулж, Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, төсөвт өртөг 14,926.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,219.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 54
Бүгд: 102
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 46
Бүгд: 102
54.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 45
Бүгд: 102
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацаа, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн

эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 36
Бүгд: 102
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав. Найруулгын санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь” гэж, 8.1.3 дахь заалтын “хэрэгжилтэд” гэсний дараа “хяналт” гэж, 9.1.1.3 дахь дэд заалтын “дүгнэлт” гэсний дараа “өгөх” гэж, 10.1.2.1 дэх дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Улсын Их Хурлын” гэж, 13.1.10 дахь заалтын “гомдол” гэсний өмнө “зөрчлийн талаарх” гэж тус тус нэмэх.

2.Төсвийн 1 дүгээр хавсралтын 1.1.2 дахь заалтын “бэхжүүлж” гэснийг “хангаж” гэж, 1.2.1 дэх заалтын “Монгол Улсын төр засгийн удирдлага ба төв байгууллагууд” гэснийг “Төрийн байгууллага” гэж, 4.1.1 дэх заалтын “шударга, шуурхай шүүхээр” гэснийг “шударга шүүхээр шуурхай” гэж, 17.1.1 дэх заалтын “аж ахуйн нэгжүүдийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 25.1.1 дэх заалтын “эд зүйлийн илрүүлэлтийг 50” гэснийг “эд зүйлийн илрүүлэлтийг 85.5” гэж, “хэргийн илрүүлэлтийг 50” гэснийг “хэргийн илрүүлэлтийг 58” гэж, “арга хэмжээг 90” гэснийг “арга хэмжээг 92” гэж, 25.2.1 дэх заалтын “70” гэснийг “72” гэж, “85” гэснийг “86.1” гэж, 25.4.1.4 дэх дэд заалтын “чиглэлээр” гэснийг “ажиллагааны бодит биелэлт” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1 дэх заалтын “өргөн”, “гадаад ертөнц”, “дотоодын” гэснийг, 1.2.1.1 дэх дэд заалтын “Дотоодын” гэснийг, 2.1.1.1 дэх дэд заалтын “Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж,” гэснийг, 13.1.1.6 дахь дэд заалтыг, 13.1.6 дахь заалтын “өөрт нь” гэснийг, 17.2.3.2 дахь дэд заалтыг бүхэлд нь, 21.1.1 дэх заалтын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 38
Бүгд: 102
62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт буюу Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого 279,336.5 сая төгрөг гэснийг 295,822.0 сая төгрөг гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 41
Бүгд: 102
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүхийн байрууд /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 61,600.0 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 10,383.7 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг тус тус нэмэх. Нийт 71,983.7 сая төгрөгийн эх үүсвэрийг доор дурдсан төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулах замаар гаргах: Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын IV.1.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын Х.2.1.2.Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах /Бүсүүдэд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 11,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын Х.1.3.2.Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 12,983.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын Х.3.3.1.Татварын байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 8,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Д.Ганбат, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-т заасны дагуу дээрх саналыг Төсвийн байнгын хороонд чиглэл өгч, буцаах тухай санал гаргав.

Д.Амарбаясгалан: Дээрх саналыг Төсвийн байнгын хороонд чиглэл өгч, буцаахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	34
Бүгд:	102

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн тул дээрх саналыг Төсвийн байнгын хороонд буцаав.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.1.1.Улсын дээд шүүхийн цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,493.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,917.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр XXIV.3.1.Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,942.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн

байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 82
Бүгд: 102
19.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд тусгагдсан Нийгмийн халамжийн сангийн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилт болох 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс зориулалтаар нэмж тусгах гэсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 64
Бүгд: 102
37.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын бүх төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа үг хэлж, гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

5.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 19.1.1.2-т тусгасан “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт” гэснийг “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж” гэж, “хувь” гэснийг “тоо” гэж, мөн 19.1.1.3-т тусгасан Хэмжих нэгжийн “хувь” гэснийг “тоо” гэж тус тус өөрчлөх гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 98
Бүгд: 102
3.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай арга хэмжээ нэмэх:

“23.2.2.“Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулах” Шалгуур үзүүлэлтийн дугаар-23.2.2.1, Шалгуур үзүүлэлт-Гадаад улстай хийх хэлэлцээр, Хэмжих нэгж-тоо, Суурь он-2023, Суурь түвшин-64, 2025 оны зорилтот түвшин-75” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 75
Бүгд: 102
26.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5 гэсэн хөтөлбөр нэмэх:

“23.5.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр 23.5.1, Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн-“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Шалгуур үзүүлэлтийн дугаар-23.5.1.1, Шалгуур үзүүлэлт-Арга хэмжээний хэрэгжилт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-95, 2025 оны зорилтот түвшин-100” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 91
Бүгд: 102
10.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.2.Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх”, Шалгуур үзүүлэлтийн дугаар-27.1.2.1, Шалгуур үзүүлэлт-Бэлэн байдлын түвшин, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-28” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 97
Бүгд: 102
4.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.3 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.3.Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.3.1, Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь Хэмжих нэгж- хувь, Суурь он-2023, Суурь түвшин-25, Зорилтот түвшин-30” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны

дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 97
Бүгд: 102
4.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөр 23.5.2, Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн “Монгол Үндэстний үнэлэмж цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Шалгуур үзүүлэлтийн дугаар-23.5.2, Шалгуур үзүүлэлт-Арга хэмжээний хэрэгжилт, Хэмжих нэгж-Хувь, Суурь он-2023, Суурь түвшин-95, 2025 оны зорилтот түвшин-100” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 97
Бүгд: 102
4.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын IX.1.2.“Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Б.Батцэцэг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 56
Бүгд: 102
45.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 50
Бүгд: 102
51.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 48
Бүгд: 102
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 96
Бүгд: 102
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.2.Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/, төсөвт өртөг 90,000.0 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 30,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 96
Бүгд: 102
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх 12, 13 дахь саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур хариулж, тайлбар хийв. Хуралдаан даргалагч саналын найруулгыг анхаарах чиглэл өгөв.

14.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Орон нутгийн төсвийн хэсэгт 1,100.0 сая төгрөгөөр санхүү бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр тусгагдсанаас Аудитын дүгнэлтэд үндэслэн Нийслэлийн суурь зардлыг 600.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зориулалтаар Эрчим хүчний сайдын урсгал зардлыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

15.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр, 216 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчилж, уг төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 18,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулах замаар шийдвэрлэх. Үүнд:

-XV.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

-XVI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр;

-XVI.1.1.15.Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 км /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

-XVI.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр;

-XVI.1.2.2.Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр;

-XVI.3.1.1.Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлж, гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

16.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын VII.4.1.Авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 15,645.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,200.0 сая төгрөгөөр бууруулж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mm” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг болон санхүүжих дүнтэй гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 63
Бүгд: 103
38.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 5,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 65
Бүгд: 103
36.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.3.1.Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 49
Бүгд: 103
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.3.1.Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,590.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,590.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан үг хэлж, гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

20.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралын IV.2.1.1.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг 154,491.7 сая төгрөг, санхүүжих дүн 30,444.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 79

Бүгд: 103

23.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 28.5.Боловсролын сайд, хөтөлбөр 28.5.1, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах ажил амьдралын орчинд суралцах тэгш боломж бүрдүүлнэ.” гэснийг “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 83

Бүгд: 103

19.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлж, гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

23.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.5 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 200 ор /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,000.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 60
Бүгд: 103
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 59
Бүгд: 103
42.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

24.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.137.Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 6,710.4 сая төгрөг, санхүүжих дүн 5,910.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,100.0 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,810.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус шинээр нэмэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 60
Бүгд: 103
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

25.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Ч.Номин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан санал хураалтыг Баасан гарагт үргэлжлүүлэх талаар санал хэлж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан санал хураалтыг хойшлуулав./19:20/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 18 минут үргэлжилж, 126 гишүүнээс 104 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 19 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая. 65 гишүүн ирж, ирц 51,6 хувьтай байна. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлбэ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

2 дугаарт Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

3 дугаарт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

4 дүгээрт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

5 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Эцсийн найруулга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-т Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлох зөвшөөрөл гэж заасны дагуу “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг Эдийн засгийн байнгын хороо бэлтгэж, танилцуулахад бэлэн болсон байна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо./10:02/

10.02 цаг.

Хэлэлцэх асуудал 2. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг бий болгох нь зөвхөн Монгол Улсын төдийгүй хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа эрхэм зорилт бас сорилт юм.

Энэхүү зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогод нэгдэж, цөмийн эрчим хүчийг ногоон буюу тогтвортой цэвэр эх үүсвэр хэмээн зарлаж байна. Дэлхий нийтийн жишгээс үзэхэд цөмийн түлш ашиглан 1квт цаг эрчим хүч үйлдвэрлэхэд нүүрс ашиглахаас 68 дахин бага хэмжээгээр хүлэмжийн хий ялгаруулдаг бөгөөд 1 кг цөмийн түлш нь 100 мянган кг буюу 2 вагон нүүрсний хэрэглээтэй тэнцдэг байна. Дэлхийн зах зээлд цөмийн түлш, ураны хэрэгцээ жил бүр тасралтгүй өсөж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 32 улс 440 цөмийн реактор ашиглаж байгаа бол шинээр барьж байгаа 63, барихаар төлөвлөсөн 88, ирээдүйд төлөвлөж байгаа 344 реактор байна.

Олон улсын атомын энергийн агентлагаас ураны эрэлд 2024 онд 93 мянган тонн байгаа бол 2050 он гэхэд 177 мянган тонн болж нэмэгдэх тооцооллын гаргажээ. Монгол Улс байгаль орчныг хамгаалах, хүлэмжийн хийг тэглэх үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор 1997 оны Киотогийн протокол, 2015 оны Парисын хэлэлцээр, 2021 оны Класковын хэлэлцээрт тус тус нэгдэн орж, хүлэмжийн хийн ялгаралыг 2030 он гэхэд 22,7 хувиар бууруулах амлалтыг дэлхийн улс орнуудын өмнө хүлээгээд байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улс 192,2 мянган тонн ураны нөөц бүртгэсэн нь дэлхийн ураны нөөцийн 3 хувийг бүрдүүлж, нөөцийн хэмжээгээр дэлхийд 10-д жагсаж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн, боловсруулах аж үйлдвэр эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх зорилтуудыг тусгаж, улмаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийг улсын хөгжлийн бүтээн байгуулалтын 14 мега төслийн 1 болгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн юм.

Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын эрэл хайгуулыг эрчимжүүлж, олборлолт, ашиглалтыг олон улсын жишиг стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх нь экспортын орлого нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээс гадна олон улсын хамтын ажиллагаа түншлэлд чухал ач холбогдолтой.

Өнөөдөр хүн төрөлхтөн цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи, өндөр түвшний стандартыг нэвтрүүлснээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж аюулгүй байдлын баталгааг хангах болжээ. Манай улсын хувьд 1940-өөд оноос цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул судалгааны ажлыг эхлүүлж байсан бол сүүлийн жилүүдэд ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр томоохон судалгааг хийж холбогдох дүгнэлтүүдийг гаргасан байна.

Тухайлбал, уран олборлох, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал эмнэлэг, цацраг, химийн чиглэлээр хийсэн судалгаанаас ашиглалтын үйл ажиллагааг олон улсын сайн туршлага стандартын дагуу хэрэгжүүлэх нь сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах боломжтойг харуулж байна.

Гэвч цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалт нь хангалтгүй, хийдэлтэй байгаагаас нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг хязгаарлаж байна.

Монгол Улс 2009 онд Цөмийн энергийн тухай бие даасан хуулийг баталж, хүчин төгөлдөр үйлчилж эхлээд даруй 15 жил өнгөрсөн хэдий ч тухайн төрлийн ашигт малтмалын үндсэн олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн туршлага байхгүй, хуулийн хэрэгжилт сул хэвээр байсаар байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх суурь зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.1.1-д байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү байгалийн баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөжийн дэлийнх нь буюу 50-аас дээш хувь нь Монголын ард түмэнд ноогдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд 2024 онд Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг АМНАТ-ийн тодорхой хувь болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны ноогдол ашгаас бүрдүүлэхээр хуульчилсан. Гэвч Үндэсний баялгийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнийг нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулан тооцохтой холбоотой Ашигт малтмалын тухай хуулийн ерөнхий зохицуулалт нь цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах харилцааны онцлогт нийцэхгүй холбогдох харилцааг бүрэн зохицуулах чадамжгүй байна. Өөрөөр хэлбэл Цөмийн энергийн тухай хуульд эдгээр зохицуулалтыг орхигдуулснаас цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах эдийн засгийн үр ашигтай хувилбарын сонголтыг хязгаарлаж, үр өгөөжийн дийлэнхийг хүртэж чадахгүй байх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Түүнчлэн Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах үйл ажиллагаанд аюулгүй ажиллагаа, уурхайн хаалт, хаягдлын менежмент, нөхөн сэргээлтийн санхүүгийн баталгааг хангах зохицуулалтыг нарийвчлан тусгах шаардлага хэрэгцээ байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн олон улсын сайн туршлагыг үндэслэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулж байна.

Хуулийн төсөлд Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох эрх хэмжээг Улсын Их Хуралд олгосон. Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх

хувилбар буюу ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ зэргээр төрийн эзэмшлийн хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоохоор тусгалаа.

Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн суурь өсөн нэмэгдэх тусгай гэсэн төрлүүдийг хуульчилж суурь АМНАТ нь ашигт малтмалын борлуулалтын орлогын 5 хувь байхаар, нэмэгдүүлэн тооцох АМНАТ нь ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамааран 0-9 хувь байхаар. Харин тусгай АМНАТ-ийг тухайн ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Улсын Их Хурал өөрөөр тогтоохоор тусгалаа.

Цөмийн энергийн салбарын гадаад хамтын ажиллагаа, экспорт өргөжиж байгаа нөхцөлийг харгалзан гадаад улсын цацраг идэвхт хаягдал ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр оруулах, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох, мөн цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй байх заалтыг мөн тусгалаа.

Цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангаж, хүний эрүүл мэнд, байгаль орчныг цацрагийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн санхүүгийн баталгааг бүрдүүлж, тайлагналтыг хэрэгжүүлэх журмыг мөн тусгалаа. Цөмийн энергийн салбарт хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэлх жилийн хугацаатай байгуулахаар заасныг тусгай зөвшөөрлийн хугацаатай ижил болгож тусгалаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Цөмийн энергийн тухай хуульд эдгээр нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, үндэсний баялгийн сангаар дамжуулан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд ноогдуулах, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш шударга хүртээх Үндсэн хуулийн зарчим хэрэгжих нөхцөл хангагдана.

Мөн тухайн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, шинэ төрлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төсвийн орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, ажлын байр нэмэгдэх, дэвшилтэт технологи, мэдлэг, туршлагыг нэвтрүүлж мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгохоос гадна Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн экспортлогч орон болох нөхцөл бүрдэнэ. Цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, хүний эрүүл мэнд, байгаль орчныг цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэхэд тавигдах шаардлагыг олон улсын түвшинд хүргэх болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Цөмийн энергийн тухай Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, түүнийг дагалдуулан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Хуулийн төслийг та бүхнийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Стратегийн ач холбогдол бүхий цацраг идэвхт ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн Монгол Улсын Засгийн газрын эзэмших хувь хэмжээг АМНАТ-өөр орлуулан тооцох, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тогтоох, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарсан АМНАТ-ийн хувь хэмжээг тогтоох, хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа, цацраг идэвхт бодис, ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд тавигдах шаардлага зэрэг асуудлыг тодорхой болгох.

Түүнчлэн Цөмийн энергийн тухай хуулийн дагуу байгуулах хөрөнгө оруулалтын гэрээгээр татварыг тогтворжуулах асуудлыг тусгаагүй байгаа нь хууль хоорондын зөрчил үүсэх эрсдэлтэй. Мөн татварын тогтворжуулалтын хамрах хүрээг Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад зөвхөн хувь хэмжээг гэж заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад татварын орчин буюу татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ноогдуулах эрх зүйн зохицуулалтын бүрдлийг тогтворжуулахаар зөрүүтэй зохицуулсан байгаа. Уялдуулах, тодорхой болгох, хууль хоорондын нийцлийг хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд, цаашид хөрөнгө оруулалтыг татахад холбогдох хуулийн шинэчилсэн найруулгыг зайлшгүй оруулж ирэх шаардлагатай, стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэргээр хуульд өөрчлөлт оруулж байгаа дээр хориг тавих эрхийн асуудлыг хуульд тусгайлан оруулж ирэх боломж байсан эсэх, хуулийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ иргэд олон нийтэд мэдээллийг бодитой, үнэн зөв хүргэх, хүлэмжийн хийг бууруулах, ногоон эдийн засаг, эрчим хүчний эх үүсвэр шаардлагатай байгаа энэ үед хуулийн төслийг дэмжих нь зүйтэй. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр хориг тавих эрх авах эсэх, давуу эрхийн хувьцаа алтан хувьцааны талаар асуудал хөндөгдсөн эсэх, усны төлбөрийн асуудлыг өөрөө тогтоох боломжтой эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Батбаатар хуулийн төсөлтэй холбогдуулан орхигдсон явцын хяналтыг сайжруулах чиглэлд тодорхой өөрчлөлт төсөл дээр туссан эсэх, Төслийг хэлэлцэх явцад шаардлагатай хуулийн төслийг нэмж баталж болох эсэх, Гадаад улсын цацраг идэвхт хаягдал ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглоно гэсэн заалтыг

дэмжиж байгаа боловч хэрэгжилтийн механизмыг тодорхой болгох, хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага тооцох талаар нарийвчлан тусгах, хог хаягдлыг нэвтрэх цэгүүдэд илрүүлэх мэргэжлийн хяналтын байгууллагын Олон улсын байгууллагатай хамтран бий болгох, Төрийн өмчийн хувьцааг тусгай өөр хэлбэрээр орлуулах нь төрийн стратегийн ач холбогдлыг алдагдуулах эрсдэлтэй талаар, ил тод үнэлгээний системийг бий болгох олон нийтэд нээлттэй мэдээлдэг байх, нөхөн сэргээлтийн төлбөрийг зориулалтын дагуу зарцуулах, үүнд хяналт тавих, хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг сунгахад эдийн засаг, байгаль орчны өөрчлөлт, урт хугацаанд хяналт тавих тогтолцоог бий болгох,

Улсын Их Хурлын гишүүн Анар Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудтай уялдуулах заалтыг заавал тусгах, яаралтай горимоор оруулж ирэхдээ процессын шаардлага хангуулж өргөн мэдүүлэх, Хууль зүй, дотоод хэргийн сайд эдийн засгийн аюулгүй байдлын шаардлага хангасан эсэх тухай хууль зүйн дүгнэлт гаргах, Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь уурхай, үйлдвэрлэлийн хаалт, нөхөн сэргээлтэд зарцуулах мөнгөн хөрөнгийг төрийн дансанд байршуулна гэснийг өөрчлөх, Илүү уян хатан, өгөөжтэй эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бий болгох,

Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай Хуулийн төслийг дэмжээд, төсөл хэрэгжсэнээр үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээ хийгдсэн эсэх, тухайн олборлолт хийгдэх бүс нутгийн байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн талаар,

Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл төрийн дансанд нөхөн сэргээлтийн төлбөрийг байршуулахдаа ямар валютаар байршуулах, ханшийн алдагдлыг тооцсон эсэх, Монгол, Франц Улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ганбат Гадаад хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, иргэд хувьцаа эзэмших боломжтой эсэх, уран олборлох цөмийн хог хаягдлыг булшлах асуудлаар туршлага байгаа эсэх, гэрээний хэрэгжилт нөхцөлийн талаар,

Улсын Их Хурлын гишүүн Номтойбаяр хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд урантай холбоотой технологи олборлолтын горимууд зэрэг зайлшгүй судлах боловсон хүчний бодлого, хүрэлцээ зэрэгт анхаарах, хосолмол ашигт малтмал байгаа тохиолдолд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн төсөл нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох эсэхийг анхаарч, хуулийн төслийн томъёололыг анхаарах,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Хуулийн төсөлд төлбөр төлөгчийн экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдаалсан цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний эсвэл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан тооцно гэснийг хэн, яаж тогтоодог, олон улсын хүлээн зөвшөөрсөн бирж байдаг эсэх талаар, хуулийн төслийн томъёолол татварын уялдааг тодорхой болгох шаардлага талаар үг хэлж, хууль санаачлагчдаас асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх заалтыг үндэслэн байгаль орчны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулахад Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 72,2 хувь, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 72,2 хувь, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хуралдаанд

оролцсон гишүүдийн 72,2 хувь, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 72,2 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник технологийн хэлтсийн дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Зэнээмьдарын Батбаяр Усны газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга, Доржбалын Далайжаргал “Мон-Атом” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Амарсайханы Алтанхундага “Мон-Атом” ХХК-ийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер, Норовын Тэгшбаяр “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч, Галсангийн Жамсрандорж “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч, Лхасүрэнгийн Жаргалсайхан “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал, Дашдоржийн Баярхүү “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч, Дашдаваагийн Сугарсүрэн “Мон-Атом” ХХК-ийн Захиргааны удирдлагын албаны дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна.

Хуулийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх хугацаа 180 минут байгаа. Ингээд гишүүдийн нэрсийг оруулъя. Ирсэн ирцийн дарааллаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Хуулийн төслийг зарчмын хувьд хэлэлцэхийг дэмжиж байгаа. Хэлэлцүүлгийн шатанд тодруулах шаардлагатай гэх хүрээнд 2 асуулт байна.

1 дүгээрт уг хуулийг дагалдуулж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд татварын орчныг тогтвортой байлгах гэдэг заалтыг тогтворжуулах татварын орчныг тогтоох гэж өөрчлөхөөр улмаар Татварын ерөнхий хуульд тогтворжуулах татварын орчин гэж татварын хувь хэмжээ, элэгдэл хорогдол, тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг

хэлнэ гэсэн шинэ заалт нэмэхээр оруулж ирж байгаа. Энэ татварын хууль тогтоомж нь ганцхан цөмийн энергис гадна Монгол Улсын стратегийн орд газруудтай байгуулах, байгуулсан бусад хөрөнгө оруулалтын гэрээнд хэрэв давуу байдал болговол шууд үйлчилдэг онцлогтой. Тэр утгаараа бид нарын өмнө байгуулсан 2009 онд байгуулсан Оюутолгой хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой харилцаанд энэ ямар байдлаар тусаж үйлчлэх вэ. Өөрөөр хэлбэл өнөөдөр Монгол Улс Оюутолгой компаниас татвар авах асуудлаар Лондоны арбитрын шүүх дээр маргаантай байгаа. Энэ маргаанд Монголын талд, эсвэл айлын талд энэ татварыг авахтай холбоотой асуудлаар энэ өөрчлөлт хамаарч үйлчилж болзошгүй байна. Тийм учраас энэ дээр хийгдсэн хууль, эрх зүйн болон эдийн засгийн тооцоо судалгаа, дүгнэлт байна уу гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь энэхүү татварын тогтворжуулах татварын орчныг тогтоох гэдэг нь шинэ заалт нь 2013 онд Татварын ерөнхий хуульд орсон татварын орчныг тогтвортой байлгах гэдэг заалтыг хөндөж өөрчилж байна. 2013 онд Татварын ерөнхий хуульд энэ заалтыг оруулсан үндсэн учир шалтгаан нь 2009 онд байгуулагдсан Оюутолгойн гэрээ дээр гарсан алдаа буюу Монгол Улс уг төслөөс олж болох ашгийг бууруулсантай холбоотой хана хэрмийг татварын хуулиар бий болгох гэж 4 жилийн дараа 2013 онд Улсын Их Хуралд оруулж байсан өөрчлөлт байгаа. Улмаар энэ 2013 оны өөрчлөлтийг буцааж хөндөж, татварын орчны хувьд давуу байдал гэж хэлэх үү ийм хөнгөлөлттэй байдлыг Монгол Улсын төр, парламент одоо олгож байна. Энэ тохиолдолд айлын тал ямар эдийн засгийн үр тооцоо Монголын талд өгөх вэ гэдэг урьдчилсан ам нөхцөлийг бол энд ярихад бол хэцүү байгааг би бол ойлгож байна. Тэгэхдээ Монголын төр бол ямар ч байсан урьдчилсан нөхцөлүүдээ бол биелүүлэх нь байна. Биелүүлэх нь байна. Тэгвэл айлын тал яах вэ гэдэгтэй холбоотой асуудлыг Улсын Их Хурлын ажлын хэсгийн түвшинд хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй хамт өөрөөр хэлбэл тэр нууцлалын зэрэгтэй яригдаж байгаа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг ажлын хэсгийн түвшинд нарийн эдийн засгийн тооцоо судалгаа хийж боловсронгуй болгож явах шаардлагатай гэж үзэж байгаа. 2013 онд орсон Татварын ерөнхий хуулийн өөрчлөлт нь Улсын Их Хурал татвар тогтоох гэдэг Үндсэн хуулийн онцгой.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Тийм. Энхбаяр сайдын бас санаа зовниж байгаа зүйл болбол маш зөв л дөө. Жишээ нь Оюутолгойн гэрээг сайжруулахтай холбоотой 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг бас Засгийн газраас байгуулаад ажиллаж байгаа. Тэгээд үүн дээр бол энэ татвартай холбоотой асуудлаа шийдвэрлээч гэж. Ер нь энэ Хөрөнгө оруулалтын гэрээнээс ямар нөхцөл байдал үүссэн бэ гэхээр бид 2013 онд Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа татварын орчныг бүхэлд нь тогтворжуулсан. Тэгээд бүхэлд нь тогтворжуулна гэдэг нь юу вэ гэхээр, өнөөдрийн Хөрөнгө оруулалтын хуулийн 3.1.7-д татварын орчин гэдгээ тодорхойлоод, ерөнхий байдлаар ингээд тогтворжуулснаас болоод өнөөдөр энэ арбитр дээр үүсээд байгаа маргаан үргэлжилсээр байгаа юм. Тийм учраас өмнөх алдаагаа давтахгүйн тулд бид энэ удаа бол тогтворжуулах татварын орчин гэж юуг ойлгох вэ гэдэг дээр татварын хэмжээ, хувь хэмжээ, элэгдэл хорогдолд тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг тогтворжуулах татварын орчин гэж нэрлэнэ гэдгийг бүр ингээд тусгайлан зааж өгч байгаа юм. Тэгээд үүний дараа хөрөнгө оруулалтын ямар нэгэн гэрээ хэлцэл хийхэд үүсэх үр дагавраас бол бид нар сэргийлж байгаа юм. Тэгэхгүй бол 2013 онд тэр батлагдсан хөрөнгө оруулалтын хууль, энэ Оюутолгойтой үүсээд байгаа асуудал бол ерөөсөө л бүхэлд нь тогтворжуулчихсан. Тэгээд ирээдүйд ямар асуудал үүсэхийг бүрэн тооцож чадаагүй. Ингээд манай татварын

байгууллага, дээрээс нь ирэх жилийн 8 сард гэхэд ингээд бид нар шүүх дээр маргаан үүсчхээд ингээд явж байгаа байхгүй юу. Тийм ч учраас бид нар өнгөрсөн хугацаанд гаргасан алдаагаа дахиж давтахгүйн тулд энэ татварын хууль, хөрөнгө оруулалтын хуулиудыг өөрчилж, энэ удаа оруулж ирж байгаа юм. Тийм ч учраас бол энэ цөмийн энергийн хууль бол бүхэлдээ өмнөх алдааг давтахгүйн тулд энэ Цөмийн энергийн хуульд өөрчлөлт оруулж байгаагаараа онцлогтой.

Д.Амарбаясгалан: Нэмж тодруулъя. Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Ажлын хэсгийн түвшинд бол нэлээн мэдээлэл тооцоо судалгаатайгаар энэ дээр мэдээлэл авч ажиллана гэсэн бодолтой байна.

2 дугаарт энэ Компанийн хуульд өөрчлөлт оруулаад, стратегийн орд газар дахь саналын эрхээ эрхийн хувьцаанаасаа татгалзаж, давуу эрхийн хувьцаагаар солих өөрчлөлт орж ирж байгаа. Энэ өөрчлөлт ганцхан цөмийн энерги буюу уранаас гадна хуульд тусгайлан заасан гэдэг нөхцөл тавьсан тохиолдолд бусад стратегийн ордын хөрөнгө оруулалтын гэрээнд хамаарах үүд хаалга бас нээгдчих вий гэсэн болгоомжлол байна. Тэр дотроо Оюутолгойн гэрээг би хэлж байна. Яагаад ингэж ярьж байна вэ гэхээр саналын эрхтэй хувьцаа гэдэг бол Монголын талд үр өгөөж, Монголын ард түмэн стратегийн орд газрынхаа үр өгөөжийн дийлэнх олонхыг хүртэх гэсэн Үндсэн хуулийн өөрчлөлтөөс урган гардаг. Тэр тохиолдолд саналын эрхээсээ татгалзчихаж байгаа юм. Тэгвэл давуу... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт Учрал сайд өгье.

Н.Учрал: Ер нь энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгох эрх зүйн боломжийг Компанийн хуулиар зөвхөн энэ цөмийн энергийн хуулийн харилцаан дээр л зохицуулж байгаа нь өөрөө юу вэ гэхээр цаашдаа хөрөнгө оруулагч нартай хэлцэл хийхэд энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгоод Монголын тал ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй гэдэг энэ зарчмыг л барих гээд байгаа юм. Тийм учраас компанийн хуулийн 34.5 дээр энгийн хувьцаа компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно гэж заасныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд энгийн хувьцаа компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж болно гэж өөрчлөн найруулсан. Тэгэхээр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэж өөрчлөн найруулж байгаа нь бол зөвхөн Цөмийн энергийн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглахтай холбоотой харилцаа дээрээ л үйлчилнэ гэсэн ийм зохицуулалт. Шаардлагатай бол ажлын хэсэг дээр хуульд заасныг гэдгийг Цөмийн энергийн хуульд зааснаар гээд бас тодотгоод явж болох байх.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Монгол Улсын хувьд бол эдийн засгаа тэлэх олон салбаруудад бол гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах замаар технологийн шинэчлэл хийх, бас хүний нөөцөө бэлдэх зэрэг зорилтуудаа хангах нь чухал байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол бид гадаадын шууд хөрөнгө оруулалт татах явдал дээр бол бас маш муу ажиллалаа гэж харж дүгнэж болно. Оюутолгойн гэрээ манай бас улсын хувьд бол маш том ийм гэрээ байсан. Оюутолгойн гэрээ 2009 онд байгуулагдсан цагаас хойш бол 15 жил өнгөрч байна. Тухайн үед ингээд 30 жилийн гэрээ байгуулж байна гээд л бид нар ямар урт хугацаа вэ гэж ярьж байсан. Одоо уже тал нь өнгөрчихсөн байж байна. Тэгээд Оюутолгойн гэрээн дээр бол мэдээж хэрэг алдаа оноонууд бол байсан. Тэгээд энэ алдаа оноонуудаа бол бид нар бас өнгөрсөн 15 жилийн хугацаанд бол яг ямар зүйл дээр алдсан юм, юун дээр оносон юм гэдгээ бол бас улс үндэстний хувьд бол бас тэгтлээ тийм нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байгаа

байдал бас харагдаад байгаа. Тэгэхээр энэ утгаараа энэ ураны салбарт бас дараагийн гадаадын шууд хөрөнгө оруулалт гуравдагч хүчээс орж ирж байгаа явдлыг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ төсөл дээр бол бид бас Оюутолгойн гэрээнээс бий болсон алдаа сургамжуудаасаа бас сургамж аваад ингээд цаашдаа бас ингээд өөр өөр салбаруудад бол хөрөнгө оруулалт татах чиглэлийн бас ийм сайн туршлагуудыг бий болгох зүйлүүдийг тусгах нь зөв гэж харж байгаа.

Тэгээд Оюутолгойн гэрээний нэг алдаа бол яг гэрээ байгуулж байх явцдаа бас маш олон хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулаад хамт оруулаад ирчихсэн явдал байгаа. Тэгээд одоо энэ Цөмийн энергийн тухай хуульд бас өөрчлөлт оруулаад л дагалдах бас хуулиудад өөрчлөлт оруулаад явж байна. Тэгээд энэ хуулийн өөрчлөлтүүд зөвхөн энэ яригдаж байгаа Францын ураны төсөл дээр үйлчлэх үү. Аль эсвэл ер нь энэ салбарт ураны салбарт өөр бас яригдаж байгаа төслүүд байна уу. Ер нь хэчнээн бас лиценз эзэмшигч байгууллага байдаг юм бэ. Цаашид манай улс энэ ураны салбарт хэр том тоглогч болох боломжтой вэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуултын хувьд гэх юм бол. Төрийн эзэмших хувь хэмжээтэй холбоотой зүйл дээр бас ийм ойлголтын зөрүүнүүд өнөө хэр байсаар байх шиг байна. Миний ойлгож байгаагаар бол төрийн эзэмших 34 хувь ч гэдэг юм уу, 51 хувь гэдэг бол зөвхөн санхүүгийн ач холбогдол буюу ноогдол ашиг авахад чиглэсэн бас зүйл биш ээ. Бас яг ийм стратегийн ач холбогдолтой орд газрууд дээр, төслүүд дээр Монгол Улс бас тодорхой хэмжээнд нөгөө ийм хяналт тавих тэр үйл ажиллагаанд нь хяналт тавих ийм боломжийг нээж байгаа. Тэгээд тэр ТУЗ-аар нь дамжаад ч гэдэг юм уу, өдөр тутмын үйл ажиллагааных нь талаар мэдээлэл авах ийм боломжийг бас нээж байгаа явдал гэж харж байгаа. Тэгэхээр энийг бас орхигдуулахгүй байх нь чухал гэж бодож байна.

Өнгөрсөн хугацаанд Оюутолгойн ТУЗ хэр үр ашигтай ажилласан энэ тэр гэдэг нь бол тусдаа асуудал. Гэхдээ ер нь бол цаашид бол бид нар Монгол Улсад хэрэгжиж байгаа томоохон төслүүд дээр бол бас яг менежментийн хувьд бас ийм хяналт тавих бас боломжтой байх шаардлагатай гэж харж байгаа.

3 дугаар асуулт нь юу вэ гэхээр Монгол Улс бол Нэгдсэн Үндэсний байгууллагын хүрээнд олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд цөмийн зэвсэггүй улс орон гэдэг статусаараа бол бас маш их бахархаж ингэж ажилладаг. Хууль санаачлагчийн илтгэл дээр болохоор цөмийн эрчим хүчний асуудал хүртэл яригдаад байгаа юм. Тэгэхээр бол эхний ээлжид бид уран олборлох асуудлыг ярьж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд ер нь цаашдаа бол энэ цөмийн эрчим хүчтэй холбоотой гэдэг юм уу ингээд цаашдын асуудлууд дээр манай хууль тогтоомжийн хүрээнд үзэл баримтлалын хүрээнд ер нь ямар зорилтууд дэвшүүлсэн байдаг юм бэ. Энийг бол юу гэж харж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал гишүүн хариулна.

Н.Учрал: Цөмийн энергийн хууль бол 2009 онд анх батлагдсан юм байна. Түүнээс хойш бол Ашигт малтмалын хууль дээр ч гэсэн нэлээдгүй олон удаа өөрчлөлт орсон. Ялангуяа төрийн эзэмшлийн хувийг АМНАТ-аар орлуулах, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах энэ боломжийг нээсэн. Тэгээд Засгийн газар, Их Хуралд өргөн мэдүүлээд Их Хурал өөрөөр тогтоож болно гэдгийг хуульчилсан. Гэсэн хэдий ч Цөмийн энергийн хууль дээр бол эдгээр зохицуулалтууд бол ер нь тусаагүй юм билээ. Тэгэхээр энэ ураны буюу энэ цацраг идэвхт ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлийн төслүүд хэрэгжих гэхээр яг өнөөдрийн эрх зүйн орчинд бол төрийн эзэмшлийн 34 хувийг л илүү

албажуулаад явахаас өөр ийм эрх зүйн орчин байхгүй. Одоогийн эрх зүйн орчин. Тэгэхээр бид нар өнгөрсөнд гаргасан алдаагаа эргээд харахаар төр 34 хувийг эзэмшдэг. Тэгээд ноогдол ашиг авах хугацаа нь хойшлоод, одоо жишээ нь Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ дээр гэхэд л тэр 2,3 тэрбум долларыг тэглэснээс хойш 2037 онд ноогдол ашиг авах бололцоо бүрдсэн. Тэгээд энэ хугацаа хэдийд ахиж хойшлохыг бол хэн ч мэдэхгүй. Тэгэхээр ноогдол ашиг гарна гэдэг бол дандаа нөгөө зардал нэмэгдээд байдаг, менежмент нэмэгдээд байдаг. Тэгээд эргээд Үндсэн хуулийн нөгөө 6.2 газрын хэвлийн баялгийн 50 дээр нэмэх 1 нь ард түмэнд байна гэхээр төлбөрөөр, хураамжаар, татвараар, ашгаар ямар ч хэлбэрээрээ байж болно. Гол нь Монголын ард түмэнд 50 дээр нэмэх 1 нь байх ёстой суурь зарчим хангагддаггүй. Тэгэхээр бид нар хэлбэрийг ямар ч хэлбэрээр хийж болохыг нь хуулиараа нээж өгөөд, тухайн хөрөнгө оруулалтын гэрээ төсөл бүр дээр өөр өөр зохицуулалтуудыг хийгээд, тэр хөрөнгө оруулалтын гэрээгээ Их Хурлаар батлуулаад, үнэхээр тэр төрийн эзэмшлийн хувийг АМНАТ-аар байна уу, бүтээгдэхүүн хуваахаар байна уу, орлуулах гэж байгаа бол Их Хурал түүнийг нь шийдээд явдаг ийм эрх зүйн орчноо бүрдүүлье гэдэг зорилгоор энэ удаад Цөмийн энергийн хуулийг өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын хууль, өнгөрсөн парламентад батлагдсан Үндэсний баялгийн сангийн хуультай нийцүүлж байгаа юм. Тэгэхээр төр 34 хүртэлх хувь, төр 50 хүртэлх хувийг эзэмшихийг ер нь цаашдаа менежментэд нь хутгалдаад байдаг биш, ард түмэн шууд татвараа авдаг, тэгээд түүний ноогдол ашгийг нь хүртдэг энэ зарчим руу явахгүй бол цаашдаа бид нар олон улсын түвшинд ч гэсэн ер нь гэрээ хэлцэл хийгээд явахад бол нэлээд ийм бэрхшээл үүсэх юм байна гэдэг зорилгоор энэ удаа оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ Цөмийн энергийн хууль батлагдсанаар зөвхөн яригдаад байгаа энэ мега төслийн 14-д багтсан тэр Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээнээс гадна энэ ураны салбарт хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчин бүхэлдээ нээгдэж байна. Цаашдаа гэрээ хэлцэл хийх боломж үүснэ гэдэг ийм зорилгоор орж ирж байгаа учраас энэ бол зөвхөн нэг тийм ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд сайд гүйцээж хариулья.

Н.Учрал: Тийм энэ бол зөвхөн одоо нэг хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой харилцааг зохицуулахгүй. 2-т бол бид өнгөрсөнд гаргасан алдааг давтахгүйн тулд гэрээг олон улс хөрөнгө оруулалтын гэрээг барихдаа дагалдуулж хууль өөрчилдөг байдлаас салъя гэдэг зорилгоор Цөмийн энергийн хуулиа эхэлж оруулж ирээд, Их Хурлаар хэлэлцээд батлаад, түүний дараа Их Хурлаас батлагдсан хуульдаа нийцүүлсэн хөрөнгө оруулалтын гэрээгээ барьж явдаг. Энэ бас зөв жишиг рүүгээ орё. Тэрнээс биш нэг шинэ олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ хийгдэх гэж байна. Тэгээд үүнд нийцүүлээд хууль өөрчилъе гээд ороод ирэх бол бас тийм зохимжтой биш. Тэгэхээр сайн жишгийг нэвтрүүлье. Тийм учраас эхлээд хуулиа хэлэлцье. Хуульдаа нийцүүлсэн гэрээгээ өргөн барьдаг энэ зөв жишиг рүүгээ явъя гэж зорьж байгаа. Тэгээд нэмээд Ажлын хэсгээс хариулах байх.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон шинжээч Тэгшбаяр.

Н.Тэгшбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Физик ухааны доктор, шинжээч Тэгшбаяр байна. Жаргалан гишүүний асуултын сүүлийн хэсэгт хариулья. Монгол Улс болон Нэгдсэн Үндэсний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн оронтой бол энэ ураны салбарт хамтарч ажиллах нь бол стратегийн хувьд ач холбогдолтой. Дээрээс нь цөмийн зэвсгийн хувьд бол цөмийн зэвсэггүй бүс гэдгээрээ Монгол Улс бахархдаг гэж хэлж байна. Тэр бол үнэн. Яагаад гэвэл тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бол дипломат яриа хэлэлцээрийн шугамаар хамгаалах ёстой гэж заасан. Энэ хүрээнд бол цөмийн зэвсэггүй бүсийг бол зэвсэггүй бүс гэдэг НҮБ-аас баталгаажуулсан байдаг. Цаашлаад Нэгдсэн Үндэсний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн оронтой энэ ураны салбарт хамтарч ажиллах нь ч бас ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Мөн энэ Цөмийн энергийн тухай хуульд болохоор хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой асуудлуудыг бол бас хуульчилж өгсөн байдаг. Үүнд бол байгаль орчны асуудалтай холбоотой заалтууд харьцангуй бүрхэг туссан байна гэж харж байна. Тэгэхээр эдгээр заалтуудаа бас шууд тусгаад явах боломж байсан уу. Ер нь энэ хөрөнгө оруулалтын гэрээ дээр ч гэсэндээ байгаль орчинтой холбоотой асуудлууд хэрхэн яаж ер нь тусахаар байгаа вэ.

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө Цөмийн энергийн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар асуудал хэлэлцэж байгаа. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон шинжээч Тэгшбаяр хариулъя. Жаргалсайхан.

Л.Жаргалсайхан: Жаргалсайхан Шинжлэх ухааны академийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал. Асуултад хариулъя. Ер нь бол энэ хөрөнгө оруулалтын гэрээ дээр байгаль орчинтой холбоотой бүлэг хэсэг байгаа. Ер нь бол энэ цацрагийн зохицуулалтаас гадна байгаль орчны бүх хууль, дүрэм журмыг дагаж мөрдөнө. Тийм учраас энэ зохицуулалт бол Хөрөнгө оруулалтын гэрээн дээр бүр тусгайлан заагдаж явж байгаа.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд нэмж хариулъя.

С.Одонтуяа: Манай яамнаас анх гэрээ хэлцэл хийж байх үед нийт 65 асуудлыг хоорондоо ярилцсан. Эндээс дийлэнх нь бас энэ гэрээнд орж байгаа. Оюутолгойн асуудлаас хойш нэг чухал алдаа зассан нь юу вэ гэхээр манай байгаль орчинтой холбоотой, усны төлбөртэй холбоотой бүх л хууль бол энэ гэрээгээр тогтворжуулалтад хамрагдахгүй гэсэн ийм зүйлийг тохирч чадсан байгаа. Оюутолгойн гэрээ дээр бол бүх хуулийг тогтворжуулна гээд орчихсон. Одоо бол манай дээр бол Байгаль орчны хууль бол тогтворжуулалтын гэрээнд хамрагдахгүй гэдэг нь өөрөө маш чухал заалт. Ингээд 2 жил тутам олон улсын шинжээч нараар байгаль орчны энэ дүгнэлт гаргуулахаар ярилцаж, тохирсон нь өөрөө маш чухал ийм зүйл болж байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Гишүүд өнөөдөр бас энэ хэлэлцэж байгаа асуудал энэ Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хамт өргөн мэдүүлсэн хуулиудын асуудал хэлэлцэгдэж байгаа учраас яг энэ хэлэлцэж байгаатай холбоотой асуудлыг ярих нь зүйтэй. Мэдээж энэ хууль батлагдсаны дараа Засгийн газар хуульдаа нийцүүлсэн гэрээ хэлцлийг хийж, гэрээгээ албажуулж оруулж ирэх асуудал бол тусдаа асуудал гэдгийг сайтар ойлгоорой. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, үүгээрээ дамжуулаад Франц улстай байгуулах энэхүү том бас удаан хүлээсэн гэрээ явах гэж байгаад бол талархалтай хандаж байна. Тэгээд энэхүү гэрээг ахалж байгаа Учрал сайд болон баг хамт олонд нь бас амжилт хүсье. Бас нэг түүхэн гэрээ болох болов уу гэж бодож байна.

Миний асуулт илүү санхүүгийн талаас асуумаар байгаа юм.

1 дүгээрт за энэхүү бас Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол урьд нь стратегийн ач холбогдол бүхий орд дээр бид нар 34 хувь, жишээлбэл нэлээн ер нь гарч ирж байгаа ялангуяа санхүү талаасаа асуулт, эсвэл гарч ирж байгаа асуудал болгоныг бид нар Оюутолгойн гэрээтэй бол заавал харьцуулж харах ёстой. Олон талаараа бид нарын гаргасан сүүлийн 15 гаруй жил Оюутолгойн гэрээнээс сурсан алдаа оноог бол заавал тусгах

ёстой гэж харж байгаа юм. Тэгэхээр 34 хувийн энгийн хувьцааг өсөн нэмэгдэх АМНАТ-аар мөн давуу эрхийн хувьцаатай орлуулах хэлбэрийг нээж өгч байна л даа. Тэгэхээр илүү бас хэлцэл дээрээ яригдах байх. Гэхдээ энийг бол зарчмын хувьд бас зөв гэж харж байгаа юм. Ер нь санхүү талаас нь аваад үзэхэд. Энгийн хувьцаа ялангуяа ийм томоохон мега төслүүд дээр хөрөнгө оруулалтыг нь гаргаж чадахгүй. Мөн зардлыг нь бид нар нэгэнт хянаж чадахгүй тохиолдолд бол давуу эрхийн хувьцаа буюу preferred stock гэж ярьдаг. Тэгэхээр энэ нь өөрөө бас өөрийн гэсэн давуу талуудтай л даа. Тэгэхээр ер нь Монголд үр өгөөжийн дийлэнх нь ноогдох уу үгүй юу, түүний мөнгөн урсгалыг тооцоход ч гэсэн энэ бас 2 өөр аргаар явна л даа. Тэгэхээр давуу эрхийн хувьцаа ч гэсэн өөрийн гэсэн цаанаасаа ноогдол ашгийн хүрээнд ч гэсэн тэгээд нэмэлт санхүүжилт босгоход тухайн хувь эзэмшил өөрчлөгдөхгүй бас давуу талууд байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн юу гэж яг бас харж байгаа юм бол. Гэрээндээ хэр бас нарийвчлалтай тусгана гэж ажлын хэсгийн хүрээнд ярьж байгаа вэ. Монголын талын эрх ашгийг бас энэ нь илүү хэрхэн хангана гэж бас тооцоолж байгаа юм бол.

2 дугаарт, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол бид нар стратегийн ач холбогдол бүхий орд, энэ орд маань өөрөө яг энэ Цөмийн энергийн тухай хуулиараа бол стратегийн ач холбогдол бүхий орд. Тэгэхээр түүний үр өгөөж нь дийлэнх нь ард түмэнд ноогдох гэсэн хамгийн Үндсэн хуулийн энэ зарчмыг бид нар юунаас өмнө яг биелүүлэх ёстой. Тэгэхээр Оюутолгой дээр гаргасан нь бас нэг том алдааны нэг одоог хүртэл хэрүүлийн алим болсоор байгаа. Цаашдаа ч гэсэн үргэлжлэх шинжтэй нэг асуудал бол Монголын талд ноогдож байгаа үр өгөөж нь одоо яг Үндсэн хуулийн зарчимтай нийцэж байна уу, үгүй юу гэдэг л асуудал яваад байгаа юм л даа. Тэгэхээр энэ Оюутолгойн гэрээ дээр хөрөнгө оруулалтын гэрээ байна уу, хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлэгчдийн гэрээ байна уу. Огт тусгагдаагүй явж ирсэнтэй холбоотой 2 талын байр суурь хэзээ ч тохирдоггүй. Тэгэхээр энэ алдааг бид нар давтаж болохгүй. Тэгэхээр ер нь бид нар гэрээ дээрээ байна уу, хууль дээрээ байна уу, маш ойлгомжтойгоор ямар үр өгөөжийн хувьд Монголын талд ноогдох тэр үндсэн хуулийн зарчим бид нар бусад хуулиасаа түрүүлж авч үзэх ёстой. Тэгээд тэр бүрэлдэхүүнийг 2 талаасаа маш ойлгомжтой тохирох хэрэгтэй. Энэ дээр ямар нэгэн бас дараа нь маргаан гаргахгүйн тулд. Тэгэхээр Оюутолгойн бид нарын суралцах магадгүй хамгийн том гаргасан алдаа бол энэ байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн хэрхэн тооцоолж байгаа вэ. Нөгөө талаасаа ч гэсэн ер нь бол энэ зөвхөн Монголын тал гэлтгүй л дээ. Францын талдаа ч гэсэн дараагийн 10 жилдээ гарах хэрүүлээс бид нар сэргийлж чадна. Гэрээ гэдэг чинь ерөөсөө 2 талын эрсдэлийг л хамгаалж байгаа хуулийн баримт бичиг шүү дээ. Мөн дээрээс нь геополитикийн хувьд бас ач холбогдлыг нь бас юу гэж үзэж байгаа юм бол доо. Энэ 3 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн ахлагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Батнайрамдал гишүүний хөндөөд байгаа энэ Үндсэн хуулийн суурь зарчим байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, төрийн нийтийн өмч байх, эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэ баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөжийн дийлэнх гэдгийг тухайн үед тэр Үндсэн хуулийн 6.2-ыг бид парламент дээр яг хэлэлцэж байхад гишүүд саналаа хэлж байсан л даа. Дийлэнх гэж юуг ойлгох вэ гээд. Дийлэнх гэдэг бол 50 дээр нэмэх 1 байх ёстой. Түүнийг юугаар бүрдүүлэх вэ гэхээр татвараар байж болно, хураамжаар байж болно, бүх төрлийн төлбөрөөр байж болно. Эсвэл ноогдол ашиг хуваарилахаар байж болно. Гэхдээ тэр бол тухайн тэр хөрөнгө оруулалтын гэрээний тухайн кэйс дээрээс үүсэж, өөр өөрөөр хийгдэж эцсийн үр дүндээ ард түмэн тэр ноогдол ашгийг хүртэх ёстой. Гэтэл сая энэ Францын хөрөнгө оруулалтын асуудал яригдаж байхад, өнгөрсөн хугацаанд ажлын хэсэг ажиллаж байхад бол юу

ажиглагдсан бэ гэхээр 2 Ерөнхийлөгчийн үеийн айлчлал хийгдээд, тэр протокол дээр өсөн нэмэгдэх АМНАТ-ийг тооцож болно гэдгийг нь тусгачихсан байхад манай Цөмийн энергийн хуулийг харсан чинь тусгай АМНАТ бол 5-аас дээш байхгүй гээд. Тэгээд дээд таазыг нь тавиад өгчихсөн. Яагаад хөрөнгө оруулагч тал өсөн нэмэгдэх АМНАТ буюу тэр ашигт малтмалын үнэ жил ирэх тусам өсөж байгаа үед тэр прогрессив АМНАТ гэдгийг тооцъё гэж зарчмын хувьд зөвшөөрч байхад, манай эрх зүйн орчин нь дээд тааз нь 5 гэгчихсэн. Тэгэхээр энийг өөрчилъё гэхээр хууль өөрчлөхөөс өөр сонголт байхгүй. Манай талд ашигтай учраас. Тийм учраас бид нар бол ер нь төр нэг их хувь эзэмшээд, менежментэд оролцоод, тэнд нэг ТУЗ дээр хэдэн хүн суулгаад, тэгээд тэд бидний эрх ашгийг хамгаалаад үр дүнд хүрдэггүй юм гэдгийг бол өнгөрсөн хугацаанд харсан. Тийм учраас хөрөнгө оруулагч тал бай, бид ч бай, аль аль талдаа эрсдэлийг бууруулах үүднээсээ хууль, эрх зүйн орчин асар тодорхой байя. Нээж өгъё. Тэгээд хэлэлцээр хийхдээ 50 дээр нэмэх 1-ээ л заавал хангуулья. Байгалийнхаа баялагт ард түмэн эзэн байх суурь зарчим заавал хангагдана гээд гэдгийг л бид барьж хэлэлцээр хийх ёстой. Тийм ч учраас Цөмийн энергийн хууль ингэж батлагдсанаараа яг энэ Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана. Бид бол багадаа жишээ нь зөвхөн энэ Франц, Монголын хамтарсан ураны төсөл дээр ярихад хамгийн багадаа яг өнөөдөр ураны нэг фунтийн үнэ 81 доллар байна, 83 доллар байна гэж үзвэл яг өсөн нэмэгдэх АМНАТ-ийг энэ хуулиар нээж өгөөд, хэлэлцээр хийгдэх юм бол хамгийн багадаа 14 хувийн АМНАТ, дээд талдаа 19 хувийн АМНАТ авах, дээрээс нь төр хувьцаа эзэмшиж байгаа 10 хувиа тэр Golden shared болгох бололцоо бүрдэнэ гэж. Ингээд хуулиа нээгээд цаашдаа уул уурхайн салбарт орж ирэх хөрөнгө оруулагч нар аль аль талын эрсдэлийг бууруулсан. Монголын ард түмэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс нэмж хариулья. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Баярхүү гуай.

Д.Баярхүү: Тэр энэ Францтай байгуулах гэрээний геополитикийн ач холбогдол гэж асуусан. Тэгэхлээр энэ Монгол, Францын харилцааны онцлог гэж байна. Чухал гуравдагч хөрш гэж бид нэрлэсэн. Франц манайхыг хамгийн түрүүн онцгой түнш гэж нэрлэсэн. Өнөөдөр Монгол, Францын оронд онцгой эрх түншлэлийн харилцаа тогтоочихсон. Энэ болгон түншлэлийн харилцаатай 17 субъектээс Франц бол ганцаараа ямар ч шат дамжлага дамжихгүйгээр шууд ийм өндөр статустай болчихсон байгаа.

Нөгөө талаар энэ гадаад бодлого дээр манай гадаад бодлогын жин нөлөө нэмэгдэнэ. Хэрвээ энэ Монгол, Францын ураны төсөл хэрэгжих юм бол. Гадаад бодлогын жин нөлөө нэмэгдэнэ гэдэг маань бүс нутгийн бүс нутагтаа байтугай даян дэлхийд Монгол Улс стратегийн чухал түүхий эдийн том тоглогч болох боломж нээгдэж байна. Монгол, Францын харилцаанаас гадна Монгол, Европын Холбооны харилцаанд бас том түлхэц үзүүлнэ. Ганцхан Францын ураны салбар биш, цаашдаа Францын олон том том компаниуд корпорациуд Монголд орж ирэх ийм боломж нээгдэх юм.../минут дуусав//

Д.Амарбаясгалан: Баярхүү гуай гүйцээгээд хариулья.

Д.Баярхүү: Тэгээд энэ өнөөдөр нэг тийм бэлгэдлийн шинжтэй юм байна л даа. Хойтон 2025 онд Монгол, Францын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тэмдэглэх гэж байгаа юм. Тэгэхээр 60 жилийнхээ өмнө энэ Монгол, Францын хамтын ажиллагааны энэ том төслийг эхлүүлчихсэн байна гэдэг бол манайд олон улсын нэр хүндэд, тэгээд олон улсад итгэл төрүүлэхэд их том алхам болно гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Тэгэхээр бас бол уурхайн салбар өөрөө дотроо төрөлжих ёстой. Ер нь бид нар эдийн засаг төрөлжих гэж ярьдаг. Яг үнэндээ хамгийн өрсөлдөх давуу талтай уул уурхайн салбар өөрөө бас төрөлжиж байж бид нар дараагийн олон жилдээ уул уурхайгаас илүү Үндсэн хуулийнхаа зарчмаа ч гэсэн ашгаа хүртэх ёстой. Тэгэхээр энэ дотор бол уран тодорхой том байр суурь эзэлнэ гэдэгтэй итгэлтэй байна. Давуу эрхийн хувьцаа дээр бас нэмээд хэлэхэд давуу эрхийн хувьцааны давуу талыг бид нар энэ гэрээ дээрээ бүгдийг нь тусгах ёстой гэж үзэж байгаа юм л даа. Тэгэхээр энэ дотроо жишээлбэл классик давуу эрхийн хувьцаа бол ноогдол ашгийг бол тогтмол авдаг. Тэгэхээр хэрвээ авч чадахгүй жил нь бол ирээдүй рүүгээ шилжүүлээд авдаг гэх мэтчилэн. Тэгэхээр энэ нэгэнтээ давуу эрхийн хувьцаа руу шилжиж байгаа бол давуу талаа бид нар гэрээн дээрээ бүгд дээр нь заавал баталгаажуулж авах ёстой. Энэ гэрээгээр магадгүй бид нар үнэхээр л Үндсэн хуулийн бусад хуулиудаасаа илүүтэй Үндсэн хуулийн зарчмынхаа дагуу тэр үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ноогддог. Буцаад ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Манайхан Оюутолгойн алдааг их ярилаа. Зөв шүү дээ. Бид алдаагаа ухамсарлаж байх ёстой. Уран дээр хамгийн том алдаа гарах гээд байна. Оюутолгой дээрх хамгийн том алдаа юу гээч. Монголчууд мэддэггүйгээ мэддэггүй байсан. Одоо уран мэддэг царайлж ингэж ярихаа зогсоогоод, бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гарсан уу гэдгийг л би Оюутолгой дээр асууж байсан. Би Учрал сайдыг хүндэлдэг. Дараагийн Америк зугтчихсан, Оюутолгойн гэрээ байгуулж байгаад Америк руу зугтчихсан хүмүүсийн нэг болчих вий гэж би санаа зовж байна. Хувь заяаны түүхийн тоглоом болж болохгүй. Энэ дотор уран мэддэг, ураны талаар ийм хэмжээний гэрээ хийж байсан хүн үзээд буцаагаад өгчихье гэсэн ч байхгүй. Олон улсын болон үндэсний хэмжээний бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гарч байж, дүгнэлтээ тойрч улс төрчид ярьдаг болохоос биш ухаантай царайлж энэ уран мэддэг юм шиг царайлж ярихаа одоо зогсоо.

1 дүгээр асуулт. Үгүй ээ, ер нь Оюутолгойн хамгийн том алдаа юу байсан гээч. Бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гараагүй. Улс төрчид ярьсан учраас алдсан. Гадаад руу том том өөрсдийгөө ухаантайгаа бодсон улс төрчид яваад ирэхдээ нүд нь өөр болчихсон ирээд л, хуульд өөрчлөлт оруулмаар байна. Эрх зүйн өөрчлөлт хиймээр байна гэдэг яг өнөөдрийн энэ юмыг ярьдаг байсан. Оюутолгой дээр яаралгүйгээр, юу энэ уран дээр анхаарах хэрэгтэй. 1 дүгээрт та бүхэн шинжээчийн дүгнэлт гарсан уу гэдгийг асуусан.

2 дугаарт Үндсэн хуулийн 6.2-т заасан гагцхүү гэдэг үг байгаа юм шүү. Уран бол гагцхүү ард түмний мэдэлд байна гэж байгаа. Ард иргэдээс нь тэр тухайн байгаль орчны асуудал дээр нь яриад байгаа болон нийт ард иргэдтэй зөвлөлдөхгүйгээр яаралтайгаар 126 болчихсон хүмүүс шийдэж болохгүй. 1 дүгээр санаа. Яагаад яараад байгаа юм. 2 дугаарт одоо уранаар цахилгаан эрчим хүч гарах уу. Дандаа цахилгаан эрчим хүчийг гоё болгоно л гэж яриад байна. Та нар бид шар нунтаг гаргаад зөөх гэж байгаа л ард түмний тухай ярьж байгаа шүү дээ. Реакторын тухай горьдоож ярьчаад л, цахилгаан эрчим хүч гарах уу. Одоо энэ ярьж байгаа зүйл дээр чинь цахилгаан эрчим хүч гарах уу. Монголчууд хямдхан цахилгаантай болж чадах уу. Энэ тухай та нар энэ тухай талаар юу оруулсан юм. Африкаар дүүрэн шар нунтаг гаргаад ядуурчихсан орон дүүрэн байна. Тэдний нэг болох гэж байгаа бол уучлаарай. Энэ тэнэглэлээ зогсоо. Цахилгаан эрчим хүч гаргах уу. Миний 2 дугаар асуулт. Та нар юу ч энэ тухай ярихгүй байна.

3 дугаар асуулт. Та нар тэр 34 хувийг тойроод л яриад байна. Овоо доо. Тэр дээрээс АМНАТ-ийг 5 хувь болгох юм уу. Түүнээс нэмэх юм уу. 34-өө багасгаад 0 болгоход бид Оюутолгой дээр бол 15 хувийн роялти болж болох уу гэж тухайн үедээ би ярьж байсан. Та

нар энэ дээр тооцоо хийсэн юм байгаа юу. Ер нь бол явж явж манай ашиг 3 тэрбум доллар л гэж яриад байгаа. Ойролцоогоор 3 тэрбум доллар. 30 жилд 3 тэрбум доллар уранаас олъё гэдэг бол манайх нүүрснээсээ үүнээс чинь хамаагүй их мөнгийг 1 жилд олдог. Үүний төлөө ухаж болохгүй. Та нар судалгаатай бай.

4 дүгээр асуулт. Дулаан-Уул, Зөөвч овоо 2 бол манай нийт ураны нийт баялгийн хамгийн өрөм нь байгаа. 217 тоннд 217гр байгаа Дулаан-Уул. Зөөвч овоо тоннд 234гр байгаа. Бусдууд нь бол 0,11, 0,52, 0.152 эд нар гээд янз бүр байна. 13-аас үндсэндээ нийт ордынхоо 99 хувийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Тэгээд би бас Сайнхүүгийн Ганбаатар гишүүний энэ болгоомжилж байгааг бол хүндэтгэж, хүлээж авч байна. Үнэхээр энэ Оюутолгойн гэрээг сайжруулах ёстой. Тэр төр эзэмшлийн 34-ийн хооронд АМНАТ аваад ард түмэн ноогдол ашгаа хүртэх ёстой гэдгийг бол Ганбаатар гишүүн олон жил ярьсан. Тэгээд тэр түр хорооны үед ч гэсэн тэр 2,3 тэрбум долларыг тэглэх ажил дээр энэ түр хороо, Засгийн газар хамтарч ажиллаад үр дүнд хүрсний үр дүнд бас 2037 онд ноогдол ашгийг ярих уу, үгүй юу гэдэг дээр ирж байна шүү дээ.

Тухайн үед үнэхээр тэр төрийн эзэмшлийн 34-ийг тодорхой хувийг нь АМНАТ-аар орлуулчихсан байсан бол өнөөдөр 2,8 тэрбум долларын борлуулалт хийчихсэн компаниас 800 сая доллароор авсан АМНАТ хэд дахин өсөх байсан бэ гэдгийг харвал ард түмэн өнөөдөр ноогдол ашгаа хүртэх л байсан. Гэтэл бид нар бэлэн биш, таны хэлдгээр судалгаа шинжилгээ дутуу явж ороод, тэгээд дэлхийн том компанийн өмнө хүчин мөхөстсөн байхыг үгүйсгэхгүй. Тэгэхээр бид нар Цөмийн энергийн хуулиар бол миний хувьд бол энэ хуулийн төслийг, дээрээс нь цаашдаа энэ хэлэлцээрийг зөв явуулья л гэж хүсэж байгаа юм.

Тийм учраас Монголын тал юу нь ашигтай байх вэ. Ямар ч эрсдэл гарсан тэр 34 хувийн ноогдол ашгаа хүлээж суудаг биш, нөгөө тал нь зардал менежмент өсгөөд байдаг биш, эцсийн үр дүнд Монголын ард түмэн ашгийг нь хүртэж л байх ёстой. Тийм учраас нөгөө талтай хэлэлцээр хийхэд өнгөрсөн хугацаанд ажилласан ажлын хэсэг тэр өсөн нэмэгдэх АМНАТ байя. Өнөөдрийн танай хуулиар заачихсан суурь АМНАТ 5, тусгай АМНАТ 5. Тусгай АМНАТ 5-аас дээш гарч болохгүй гэдгийг нь таазыг нь өөрчилж өгөөд, хэлэлцээр сайн хийгдэх юм бол АМНАТ-аа өсгөө. Тэгэхээр энэ бол нөгөө гэрээний хэлэлцүүлэг огт биш. Тийм учраас энэ хууль одоо батлагдсанаараа бид цаашдаа энэ салбарт хэлэлцээр хийх өргөн боломж л нээгдэж байгаа. Хэлэлцээр хийх. Тэрнээс биш энэ бол хөрөнгө оруулалтын гэрээ орж ирчхээд байгаа зүйл биш.

Миний хувьд ажлын хэсгийг нь ахлаад 2 сар л болж байна л даа Томилогдоод. Тэгээд би өнгөрсөн хугацаанд ажилласан тайлан, дүгнэлтүүдтэй танилцсан. Ер нь 1997 онд л анх энэ төлөөлөгчийн газраа нээгээд л 2003 онд тусгай зөвшөөрлөө эзэмшээд л 2013 онд хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулаад эхэлсэн юм байна лээ. Норовын Алтанхуяг даргыг Ерөнхий сайд байхад 100 гаруй хүнтэй ажлын хэсэг байгуулагдаад их том шинжээчийн дүгнэлт гаргаад энэ ажил нэлээн урагшилсан юм билээ. Тэгээд түүнээс хойш хэсэг хугацаанд гацчихсан. Тэгээд сая Монгол Улсын Ерөнхийлөгч Францад айлчлах үеэр ийм улс төрийн манлайлал үзүүлээд энэ ажил хурдсаж байгаа. Гэтэл нэг гараанаас эхэлсэн Казахстан өнөөдөр дэлхийд уран олборлолтоороо тэргүүлж эхэллээ шүү дээ. 43 хувь болчихсон байна шүү дээ. Бид нар 27 жил ярьсан, 27 жил хэлэлцсэн, ажлын хэсэг ажилласан, анхааралтай ажигласан. Тэгээд 27 жил 1 гараанаас эхэлсэн орон урагшаа

гарчихсан. Тэгэхээр бүгдээрээ хамтдаа хэлэлцээд Их Хурлаараа шийдвэрлээд явах нь зөв. Тэгэхээр Ганбаатар гишүүнийг бас оролцуулаад, санал, дүгнэлтийг нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя. Дараа нь нэмж хариулт өгнө.

С.Ганбаатар: Энэ ажлын хэсгийнхэн надад тодруулаад өгөөч. Уранаар шар нутгаа гаргах гээд л байх шиг байна. Гаргах гээд байна ерөөсөө. Та нар эрчим хүч яг үйлдвэрлэх талаар яагаад энэ тухай ерөөсөө ярихгүй байгаа юм. Уранаа зөөх юм бол 2 орны хөрш орноор дамжиж гарна. Энэ вагоноор зөөнө, онгоцоор зөөдөггүй. Та нар энэ 2 хөрш оронтойгоо ярьсан уу. Оюутолгойн зэсийн баяжмалыг гадаадын хүн ирээд манай 1 хөрш орон руу брокер хийж л зардаг болчихсон шүү дээ. Одоо энэ 15 жилийн дараа. Одоо манай ураны баялгийг 1 хүн ирээд бас манай хөрш орнуудад зарах гэж байгаа л тухай ярих гэж байна. Бид брокердуулаад дууслаа. Тэгэхээр энэ цахилгаан эрчим хүч гарах тухай яривал энэ болно. Энийг ярих ёстой зүйл. Гоё юм яриад, худлаа ярьж болохгүй. Тэгэхээр энэ хөрш орнуудтай энэ тухайгаа ярьсан уу.

2 дугаарт ард иргэдтэй Үндсэн хуулийн 6.2-ын хэлэлцээр дээр ард иргэдийн оролцоог хангах тухай орсон уу. Хамгийн гол нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон Жамсрандорж. “Мон-Атом” компанийн мэргэжлийн шинжээч. 7 дугаар микрофон. Далайжаргал “Мон-Атом” компанийн захирал.

Д.Далайжаргал: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэр олон улсын шинжээч гэдгийг яг таны ярьж байгаа, санаа зовниж байгаа асуудлын дагуу олон улсын шинжээчийг 2018 онд Канадын Стантекс гэж компаниар олон улсын шинжилгээ үнэлгээ хийгээд Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. 2020 онд олон улсын атомын эрчим хүчний ангиллын македелийн төлөөлөгчид ирээд бас Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Тэрний өмнө бол Шинжлэх ухааны академиас 4 удаа, 2013 онд Алтанхуяг сайдын үед бас ингээд үе үе нийтдээ 7 удаа олон улсын болон дотоодын үнэлгээ хийсэн. Та цөмийн эрчим хүч гэж ярьж байна. Дэлхий дээр ураныг онцлог нь бид нар шар нутаг л гаргана. Энэ бол бид нарын боломж нь. Энийг баяжуулаад цөмийн эрчим хүч буюу АЦС-ыг түлш болгодог дэлхийд 5 улс л байгаа. Энийг Нэгдсэн Үндэсний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 5 улс буюу P5 гэдэг. Өөр энийг ямар ч орон хийж чадахгүй.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон. Шинжээч Жамсрандорж гуай. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Г.Жамсрандорж: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Монголын ураны судлаачид, эрдэмтдийн талаар. Тэгэхээр Монголын ураны судалгаа 1973 оноос анх эхэлсэн байдаг. Тэгэхдээ Оросын геологичид онцолж хийсэн боловч Монголын геологичдыг оролцуулж байсан. Тэр тухай улсын нууцад хамаардаг учраас тэр болгон мэдээлдэггүй байсан. Тэгэхээр Монголын эрдэмтэд анх 1993 онд Монгол Улсын ураны геологийн тогтцын талаар мэдээллийг цөмийн эрчим хүчний агентлагт өгч олон улсын тэр улаан номд хэвлэгдсэн байдаг. Энэ тухай бол миний нэр тэнд орсон байдаг. Ер нь бол 2002 оноос эхлээд гадаадын хөрөнгө оруулалт уран дээр эрс нэмэгдсэн учраас Монголын геологичид гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтарч уран дээр мэргэшээд одоо өнөөдөр Монголд ураны салбараар мэргэшсэн 30 гаруй геологичид, эрдэмтэд байдаг. 2 ч эрдэмтэн ураны салбараар эрдмийн зэрэг хамгаалсан. Жишээлбэл миний бие Монгол улсын ураны ордууд гэсэн номоо

бичээд олон улсын нэр хүндтэй спиринг хэвлэлийн газар англи хэл дээр хэвлүүлэхээр гэрээ хийгээд, ойрын үед гарах гэж байгаа. Тэгэхээр уран бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд нэмж хариулъя.

О.Алтангэрэл: Манай санхүүгийн Ганбаатар гишүүн яг энэ Оюутолгойн гэрээ ашиггүй боллоо гэж олон жил ярьж, үүнийхээ төлөө шүүмжлүүлж, эцэстээ бас энэ гэрээ өрөөсгөл байсан нь батлагдаж ингэж явсан. Тийм учраас энэ дээр алдаа гарах вий гэж санаа зовниж байгаа Ганбаатар гишүүнийхээ зовнилыг ойлгож байна. Өнөөдөр бид нар хуулийнхаа асуудлыг яриад дараа нь гэрээний асуудал ярья гэж байгаа. Тэгэхдээ энэ гэрээний ажлын хэсэг бол энэ хамтарсан гэрээний хүрээнд олон улсын ийм 2 ч том компанитай гэрээ байгуулж, зөвлөх үйлчилгээ авч байгаа. Энэ дээр бол Си Ар Эй, Вайт Кэйс гэсэн энэ 2 том компани дээр, дахиад бас гуравдагч компаниуд байгаа. Ингээд олон компаниудаас зөвлөгөө авч явж байгаа учраас бид нар энэ олон улсын жишигт нийцэх, эрсдэлийг багасгах тал дээр арга хэмжээ авч байгаа гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

Ганбаатар гишүүний асуулт нь нэг чухал зүйл байгаа шүү дээ. Гаднын экспертүүдээс санал, дүгнэлтийг ямар хэмжээнд авч байгаа вэ гэдэг асуудал яригдана. Тэгэхээр яах вэ, өнөөдөр Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт яригдаж байгаа үе учраас бас шууд хариулахад хэцүү байхыг үгүйсгэхгүй. Энэ хууль батлагдаад цаашаа ажлын хэсгүүд байгуулагдаад ажил явахад Улсын Их Хурлын гишүүдийг яг энэ чиглэлийн мэдээллээр бүрэн дүүрэн хангах ёстой. Мэдээж уран гэдэг бол амар сэдэв бол биш. Гэхдээ аюултай гээд бид хүрэхгүй байгаад сууж бас болохгүй. Яаж аюулгүй байх вэ, яаж алдаагүй байх вэ, яаж ойлгомжтой байх вэ гэдэг дээр бүгд төвлөрч ажиллах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт.

С.Цэнгүүн: Тэгэхээр Атомын цахилгаан станцын тухай ярьж байна. Ер нь бол бүтээмжийн хувьд бол маш өндөр бүтээмжтэй бас clean energy гэж бид нар ярьдаг. Тэгэхээр АЦС-тай болох юм бол ер нь бол нийт эрчим хүчний хэрэглээнийхээ 10-15 хувийг бол улсад зохицуулаад явах боломжтой гэж бол судалгааны дүнгүүд бол байдаг. Тэгэхээр бас орчин үед шинэ технологиуд хөгжөөд 300-600мвт-ын жишээ нь жижиг станцуудыг ч гэсэн барих боломж нь бид нарт байгаа. Тийм учраас манай Монгол Улс энэ боломжийн талаар цаашаа судлах үзэх хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхээр энэ шинэ эх үүсвэрүүдийг ер нь оруулахын тулд манай энэ эрчим хүчний реформ маань зайлшгүй явагдах шаардлагатай байгаад байгаа юм. Тэгэхээр ингээд бид нар өнөөдөр ярьж байгаа зүйл бол нэг түр үнийг тогтоогоод, тэгээд 1 үнийн өртгөө алдагдлаа нөхнө гэж бас нэг ийм зүйл яваад байгаа юм л даа. Энэ бол үнэхээр байж боломгүй зүйл. Яагаад вэ гэхээр үнэхээр үнэ өртгийг нэмлээ гээд тэгэхэд эрчим хүч үйлдвэрлэхэд давхар орж байгаа нүүрсний уурхайнууд, төмөр замын тээвэр зэрэг төрийн өмчид байгаа энэ компаниудыг бас бид нар давхар чөлөөлөх ёстой. Тэрийг чөлөөлөлтийг хийхгүйгээр зөвхөн одоо станцуудын өртгийг дарах байдлаар ингээд үнэ нэмэх юм бол энэ маань бол өөрөө өрөөсөө зах зээлийн зарчимд шилжээгүй асуудал бол болох юм. Тэгэхээр 1 зүйлийг бас ингээд харахаар төрийн давуу талыг ашиглаад урт хугацааны тогтвортой гэрээнүүд хийчихсэн.

Одоо энэ сэргээгдэх эрчим хүчний жишээ нь компаниуд байж байгаа. Энийг ингээд харахаар төр үнэ тогтоосноос болж эдгээр компаниудад ийм давуу тал бий болсон байгаа юм. Тэгэхээр эрчим хүчний реформ гээд маш чухал зүйл ярьж байгаатай холбоотой хамт

шинэ эх үүсвэрүүд орж ирнэ. Олон төрлийн шинэ эх үүсвэрүүд байгаа. Сэргээгдэх ч байна уу, нүүрсний ч байна уу. Энэ бүх эх үүсвэрүүд маань төртэй ямар нэгэн байдлаар гэрээ урт хугацааны тогтвортой гэрээ хийж болохгүй юм. Бид нар тэрний эсрэг байх ёстой. Яагаад гэхээр тэр тогтвортой гэрээнүүдээс болж л үнэ тогтоох гэдэг асуудал гарч ирээд байгаа юм. Бид нар үнийг зах зээлийнх нь шугамаар өөрөөр нь явуулах ёстой юм. Тэгэхгүй бол өнөөдөр байгаа бид нарын эрчим хүчний реформ гэдэг маань буруу зүйл рүү явах гээд байгаа юм шиг мэдрэмж төрж, би бас сэрэмжлээсэй гэж хүсэж байна. Их Хурлын гишүүд ч гэсэн энэ дээр маш том хяналтаа тавьж ажиллах байх гэж бодож байна.

Тэгэхээр ер нь энэ бөөрөлжүүт ч байна уу эсвэл шинэ сэргээгдэх эрчим хүчний станцууд барихаар төлөвлөж байгаа хөрөнгө оруулагч нар маань ч гэсэн ямар нэгэн төрийнхөнтэй оролцоотойгоор том, урт хугацааны гэрээ байгуулна гэж бодож болохгүй. Бид нар зах зээлийнх нь зарчмаар тавина. Хэн хямд нийлүүлж чадаж байгаа тэр эх үүсвэрүүд орох ёстой. Тэгэхээр одоо бид нар аймгууд дээр жишээ нь жижиг станцуудыг бариад, тэр маань бол өөрсдөө бие даасан байдлаар тархмалаар шийдэх энэ эх үүсвэрүүдийг бий болгож байгаа юм. Тэр нь олон талын хөрөнгө оруулагч нар олон төртэй хамааралгүй хүмүүст боломжийг нээж өгөх л үндсэн зорилго маань бол эрчим хүчний реформ байгаад байгаа юм.

Тэгэхээр 1 зүйлийг бас анхааруулж ингэж хэлэхэд бид нар ер нь энэ Атомын цахилгаан станцаас гадна ер нь зүгээр шинэ эх үүсвэрүүдээ яаж оруулж болох юм бэ. Атомын цахилгаан станц барихын тулд 12-оос бараг 15 жилийн үндсэн бэлтгэл ажил бид нарт шаардлагатай. Энэ бол урт хугацааны ажил. Гэхдээ үүнтэйгээ хамт бид нар ер нь шинэ эх үүсвэр оруулж ирэх энэ хууль зүйн орчны реформоо яаж харж байгаа вэ гэдгийг би бас асуумаар байна.

Бид нар үндсэндээ бол энэ эрчим хүчний реформыг хийх хамгийн үндсэн тулгуур зарчим маань бол чөлөөт зах зээл юм. Тэр дээр төр оролцохгүй байна. Төрийн оролцоотой монополийг бид нар үүсгэж болохгүй гэдэг дээр бол байр сууриа бол илэрхийлээд явж байгаа. Тэгэхээр эрчим хүчний Үндэсний хорооны гишүүний хувьд бол энийг хатуу сануулж хэлмээр байна. Яагаад гэхээр бидний энэ зөв санаачилгыг буруугаар ашиглаж төртэй нийлж том гэрээ байгуулах гэсэн бас оролдлогууд хажуугаар нь явах вий дээ гэдгээс бол сэрэмжлүүлэхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ер нь энэ олон улсын гэрээ томоохон төслүүд дээр төр менежментэд нь оролцдог байх зарчмыг бол халах ёстой. Гол нь ард түмэн тэр ноогдол ашгаа хүртдэг байх ийм эрх зүйн орчинтой л болох ёстой гэдэг утгаараа бид нар Цөмийн энергийн хуулийг парламентаар хэлэлцүүлж байна. Дээрээс нь бас Цэнгүүн гишүүний хэлээд байгаа үнэн л дээ. Дэлхий нийт бол өөрчлөгдөж байна. Эрчим хүчний салбар төрөлжиж байна. Солонгорч байна. Тэгээд дэлхий нийтэд бид нар болбол амласан амлалт бий 2030 он гэхэд хүлэмжийн хийг 22 хувиар бууруулна гээд амлачихсан. 3 хэлэлцээрт нэгдчихсэн. Гэтэл өнөөдөр бидний хэрэглээд байгаа нүүрснээс 68 дахин бага хүлэмжийн хий ялгаруулдаг энэ цөмийн эрчим хүч бол. Тэгэхээр ер нь бол энгийнээр бол 1 кг цөмийн түлш нь 100 мянган кг, 2 вагон нүүрстэй л тэнцэж байна шүү дээ. Тийм өндөр хэмжээний эрчим хүчийг ялгаруулдаг. Тэгээд бид нөгөө хөгжлөөсөө бүс нутгийн орнуудын дунд бол хоцроод байна. Тийм ч учраас хөдөлгөөн хийх ёстой. Өнөөдөр энэ 27 жил бид нар хэлэлцлээ шүү дээ. Тэгэхээр бараг Цэнгүүн гишүүн төрж байсан байгаа байхгүй юу. Цэнгүүн гишүүн төрж байхад Монголд Ораногийн төлөөлөгчийн газар нээгдэж байсан байгаа шүү дээ. 1 хүн төрөөд гишүүн болж байхад хэлэлцсээр л байдаг. Судалгаа хаана байна шинжилгээ хаана байна л гээд нэхээд

байдаг. Тэгэхээр бид нар чинь яг ийм байдалтай. Гэтэл нөгөө зэрэг гараанаас гарсан Казахстан болохоор ингээд уранаараа дэлхийн олборлолтоороо бараг 43 хувийг нь эзэлчихсэн. Тэгээд бид одоо дахиад хэлэлцэх үү, ярилцах уу, яах уу гээд байдаг. Ийм байдалтай байгаад байгаа.

Тийм учраас бүгдээрээ бас энэ цаг үедээ Монголын талд ашигтай хуулиа хийчхээд энэ хуульдаа нийцүүлээд хэлцлээ үр дүнд хүрэх ёстой. Тийм ч учраас ерөөсөө л төр, хувийн хэвшлийг дэмжье, бизнесийн эрх, эрх чөлөөг хангуулья гэсэн бол энэ Баялгийн сангийн хуулийг амилуулахад ч гэсэн ер нь цаашдаа бүгдээрээ л ерөөсөө л энэ ашигт малтмалын бүтээгдэхүүнийг үнэ өсөж байвал дагаад АМНАТ нь өсөж байдаг. Энэ прогрессив байдаг тэгээд үнэ нь буувал дагаад буурч байдаг энэ зарчим руугаа хангуулаад ханд хандаад эхлэх юм бол ингээд нэг ийм төрөөс бүх бизнес хамааралтай байдаг энэ зарчим бол холдоно. Тийм учраас бас би өөрийг чинь бас дэмжиж байна.

Тийм учраас эрчим хүчний салбарт бол энэ том өөрчлөлтийг авчирна. Тэр мэдээж Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан тэр АЦС-тай болох энэ тэр бол судалгааны ажлууд эхэлнэ гэсэн үг. Нэг ёсондоо бол энэ цөмийн энергийг бол батлагдаад ураны төслүүд эхнээсээ хэрэгжээд эхэлбэл энэ том судалгаанууд хийгдэнэ. Шинжлэх ухаан бас эргэлтэд орно. Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдвэл нэмэгдэнэ гээд ийм орчин сайжирна. Тэрнээс биш шууд энэ хууль батлагдаад, шууд төсөл хэрэгжсэнээр АЦС-тай болно гэдэг эндүүрэл л дээ. Тэгэхээр мэдээж урагшилна л гэсэн үг. Нэг алхам тийм.

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: Тэгэхээр саналаа хэлэхэд бол ер нь Монголчууд хөгжих ёстой байна. Бид нар энэ олон жил попролоос болоод, олон жил буруу ойлголтуудаас болоод гацчихсан байгаа төслүүдээ хөдөлгөж явмаар байгаа юм. Тэгээд бас энэ Засгийн газрын үед ураны төсөл орж ирж байгааг би бол гишүүнийхээ хувьд бол маш их дэмжиж байгаа. Яагаад гэхээр бид нар дэлхийн шилдэг технологиудыг хөгжүүлж чадаж байж л Монгол Улс дэлхийтэй хөл нийлүүлнэ. Тэгэхээр энэ АЦС гэдэг бол маш том өндөр технологийн асуудал. Бид нар олон жил ч бас судалгаанууд дээр нь урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах ажил нь гэхэд маш удаан байдаг ийм ажил байгаа. Тэгэхдээ Монгол Улсын хувьд бол яалт ч үгүй стратегийн бодлогоороо бид нар энэ асуудлыг дэмжиж явах шаардлагатай гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Та бүгддээ бас энэ өглөөний мэндийг хүргэе. Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Хуулийн төслийн үг найруулга, текстийг бол сайжруулаад явах боломж бол бидэнд байна. Сая Учрал сайдын ярианд бол гарлаа. 27 жил бараг 30 гаруй жил ярьж байгаа гээд. Өнгөрсөн Засгийн газрын үед бол буюу Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед бас энэ ажил нэлээн урагшлах алхам руугаа орсон юм. Өөрөөр хэлэх юм бол Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Нямбаатар гэдэг хүн энэ ажлын хэсгийг ахалж, энэ Француудтай хийх хэлэлцээрийг нь хийж, миний бие бас нарийн бичгийн даргаар нь ажиллаж, яг өнөөдрийн энэ суурь АМНАТ дээр нэмэх нь тусгай АМНАТ. Дээрээс нь энэ үнийн өсөлтөөс хамаарч байгаа өсөн нэмэгдэх АМНАТ-ийг авах асуудлуудыг үндсэндээ тохирсон. Энэ дээр ч гэсэн улс төрийн дэмжлэг болгож бас одоогийн Их Хурлын дарга ч гэсэн бас оролцоод явж байсныг би бас санаж байна. Тэгээд энэ ажил бас хэлэлцээр маань урагшлахад өнөөдөр энэ хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгээд энийг цаг алдалгүй бас оруулж ирж яаралтай горимоор хэлэлцүүлж байгаа Учрал сайдад бас талархаж байгаа юм.

Бас энэ асуудлыг ойлгож бас улс төрийн эр зориг гаргана гэдэг бол бас чухал байж байгаа. Тэгэхээр гишүүд маань ерөнхийд нь зарчмын хувьд бүгд дэмжиж байх шиг байна. Тэгээд Оюутолгойн төслийн дараагаар Монгол Улсад томоохон хөрөнгө оруулалт орж ирж байгаа ийм төсөл болох юм. Мэдээж юу гэдэг юм төслийн багтаамжийн хувьд бол тийм том төсөл биш. Оюутолгойтой харьцуулах юм бол жижгэвтэр. 5 тэрбум долларын л эргэлтийн тодорхой хэмжээний валютын урсгал орж ирэх ийм төсөл байгаа боловч ач холбогдлын хувьд маш өндөр юм. Гадаад харилцаа гуравдагч хөршийн эрх ашгийг Монголд оруулж ирэх, дээрээс нь тэр дундаа Нэгдсэн Үндэсний байгууллагын аюулгүйн зөвлөлийн 5 орны 1-тэй Монгол Улс хөрөнгө оруулалтын гэрээ хийнэ гэдэг бол бид хэдийн тусгаар тогтнол, аюулгүй байдлын талдаа бол хамгийн том баталгаа болж өгөх юм байгаа юм.

Тэгэхээр бас гишүүд маань 2 зүйлийг хольж ирээд байна. Энэ ураны олборлолтыг явуулахаас гадна цаашдаа энэ зүйлийг баяжуулж эрчим хүч гаргах уу гэдэг бол тусдаа асуудал. Энийг бид нар энэ ураны хэлэлцээрийг явж байж эхний ээлжид ядаж шар нунтаг олборлож, энийгээ экспортод гаргаж байж дараагийн ээлжид АЦС барих ажил бас нэг шат ч гэсэн урагшилна. Тэгэхээр өнөөдөр бас дэлхий дээр 1970 оноос хойш 470 АЦС буюу реакторууд ажиллаж байна. Нийт дэлхийн эрчим хүчний 10 хувийг үйлдвэрлэж байна. Саяын Ай Эм Эф-ийн хурал болон Дэлхийн банкны захирлуудын хурал дээр бол цэвэр энэ эрчим хүч буюу энэ clean energy гэдэг зүйл рүүгээ явна. Энэ дийлэнх хөрөнгө оруулалтыг Дэлхийн банк болон сонирхогч этгээдүүд хөрөнгө оруулалтаа хийнэ гэдэг зүйлийг хэлж байгаа дээр бид шийдвэр гаргаж урагшлахгүй бол бид Монгол Улсад хоцрох гээд байна. Энэ Төв Азийн Казахстан, Узбекистан ч гэдэг юм уу бид нараас энэ чинь бүр түрүүлээд гүйлээ шүү дээ. Тийм учраас бид хэд энэ дээр цаг алдалгүй хиймээр байна.

Тэгээд би хоёрхон асуулт асууя. Ерөнхийдөө энэ АМНАТ-ийг тогтоож байгаатай холбоотойгоор бас цаашдаа хэлэлцээрийг аль болохоор 34 хувь эзэмшихгүйгээр Монгол Улс одоо хөрөнгө оруулалт оруулахгүйгээр АМНАТ авч энэ үр өгөөжийг нь хүртэх энэ чиглэлийг баримтлах ёстой. Мэдээж 10 хувийг үнэгүй өгье гэдэг. Энэ дээр мэдээж давуу эрхийн хувьцаатай, тодорхой эрхүүд бас дагалдуулж өгье гэдэг. Энийгээ аваад бид нар бас явж болно.

2 дугаарт яг энэ чиглэлийг баримтална гэдэг дээрээ байгаа юу Учрал сайдаа энийг бас танхимын индэр дээрээс хэлмээр байна.

2 дугаарт олон нийтийг мэдээллээр хангамаар байна. Зөв мэдээллээр. Тэгэхгүй ингээд одоо баахан ард иргэдийг төөрөгдүүлнэ. Гадна дотнын эрх ашгууд ургаж эхэлнэ. Амилж эхэлнэ. Сүртэй сүртэй лайвууд хийж эхэлнэ. Орон нутагт нь очиж иргэдийг дарамтална. Эргээд энэ олон нийтийг төөрөгдүүлж янз янзын олон нүдтэй хурга, ишиг, тугал ярьж айлгана. Энэ зүйлээс бид хэд бас ангид байх ёстой. Зарчим барьж энэ том хөрөнгө оруулалтынхаа эрх ашгийг бодож бид нар урагшлах ёстой шүү. Энэ зүйлүүдийг би бас хэлмээр байгаа юм. Тэгэхээр олон нийтэд мэдээллээ зөв өгмөөр байна. Эцэст нь энэ ус.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Сайнзориг дарга бол энэ төслийн талаар маш сайн мэдээлэлтэй байгаа. Тэгээд энэ ажлын хэсгийн бас нарийн бичгээр ажиллаж байсны хувиар тухайн үед энэ хэлэлцээр нэлээдгүй бас урагшлаад, анх энэ өсөн нэмэгддэг АМНАТ-ийн талаар бас хэлэлцэж эхэлж байхад бол бас нарийн бичиг байсан. Тэгээд Нямбаатар сайд, Их Хурлын дарга гээд энэ ажлын хэсгүүдийг ахлаад ажиллаж байсан. Тэр хэлэлцээ бол нэлээдгүй урагшилсан. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч Францад айлчлах үеэр Амарбаясгалан

дарга тэр ажлын хэсгийг ахалж байхдаа тухайн үед тэр протоколд яг энэ төрийн эзэмшлийн 34 хувийг АМНАТ-аар орлуулах, тэр дотроо өсөн нэмэгдэх АМНАТ тооцох бүр энэ аргачлалыг протокол дээр тусгасан. Одоо энэ Цөмийн энергийн хуулийг дагалдуулаад энэ хувиудыг оруулж ирж байгаа. Тэгээд цаашдаа бол ураны үнэ бол жил ирэх тусам өснө. Яагаад гэхээр ирэх жил бол нийт эрэлт чинь 120 мянган тоннд хүрэх юм байна. Гэтэл бид дэлхий нийтээрээ нийлүүлэх боломжид 80 мянгатай байна гэхээр мэдээж энэ бол өсөх нь дамжиггүй. 2007 онд л энэ чинь 10 орчим л доллар байсан юм байна лээ шүү дээ. Гэтэл 2 мянга өнөөдрийн байдлаар 81тээ, 83 орчим байна. Тэгэхээр ингэж өсөж байгаа. Тэгэхээр бид хамгийн ашигтай нь юу вэ гэхээр юутай ч суурь АМНАТ-аа 5-аараа авъя. Дээрээс нь тусгай АМНАТ-ийг хэдээр яаж орлуулах вэ гэдгийг Засгийн газраас гэрээтэйгээ хамт өргөн мэдүүлээд Их Хурлаар шийдье. Тэгээд өсөн нэмэгдэх АМНАТ тооцё гэж. Тэгэхээр хамгийн багадаа 14, 15 хувийн АМНАТ авна. Ирэх жилээс үнэ өсөөд эхлэхээр мэдээж энэ бол 19 хүртлээ өснө. Тэгээд 10 хувь дээрээ ямар нэгэн байдлаар өмнөх алдсан алдаагаа давтахгүйн тулд тэр 10 хувийн энгийн хувьцаа дээрээ Монгол Улс санхүүгийн ямар нэгэн хариуцлага хүлээхээ больё гэдэг ийм л хэлцлийн зарчмыг хийж байгаа.

Тэгээд ер нь бас гайхаад байгаа юм. Цөмийн энергийн хууль дээр яагаад тусгай АМНАТ 5-аас дээш гарахгүй гээд ингээд хатуу хуульчилчихсан юм бэ. Яагаад. Тэгээд ингээд ямар ч хэлэлцээр хийгээд явахаар нөгөө тал нь зөвшөөрөөд тусгай АМНАТ-ийг ахиу бодъё гэхээр манай хууль дээр 5-аас дээш гаргахгүй гээд ийм хатуу зохицуулалттай. Хэний ашиг сонирхол байсан юм бэ гээд хүмүүс эргэлздэг. Хэлэлцээ яаж ч сайн хийгдэж болно шүү дээ. Тийм учраас энэ таазыг байхгүй л болгох ёстой. Ер нь Монголын төр зарим төсөл дээр хэдэн хувиа ч авч болно. Бүр цаашлаад тэр төр ямар ч хэлбэрээр тэр баялгийн сангийнхаа хуулийг хэрэгжүүлж болно шүү дээ. Тэгэхээр Хуримтлалын сан руу тэр давуу эрхийн хувьцааных нь ноогдол ашиг шилжээд, үлдсэн нь тусгай АМНАТ, өсөн нэмэгдэх АМНАТ, суурь АМНАТ-аа тооцдог. Тэгээд мэдээж нөгөө ААНОАТ, бусад татвар хураамжуудаа бол авна шүү дээ. Тэгээд эцсийн үр дүнд бид хожсон байх ёстой. Ийм л зарчмаа л хангуулах гэж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Учрал сайдад баярлалаа. Ер нь зүгээр энэ басзөвхөн ураны төсөл гэхгүй маш олон цаашдаа хөрөнгө оруулалтын гэрээний бенчмарк болох юм. Энийг л зөв хиймээр байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас чухал ач холбогдол өгч байгаа.

2 дугаарт яах вэ, энэ ураны олборлох үйл ажиллагаа дээр ус ашигласны төлбөр болон ус бохирдуулсны төлбөрийг арай өөрөөр тогтоочих боломж бол байсан юм. Энийг бас хэлэлцээрийн явцад уг нь ярьж байсан. Энэ удаад уг нь бас хөндөөд ороод ирсэн бол нэг мөр шийдчих байсан юм. Ер нь зүгээр цаашдаа энэ уран олборлолтыг дагаад АЦС-ын асуудал яригдаж болно. Өнөөдөр ерөнхийдөө 500мвт хүртэлх АЦС-ыг 1,2 тэрбум долларт барих, тухайн юу гэдэг юм хост буюу энэ төслийг хэрэгжүүлбэ гэж байгаа орнууд 25-30 хувиа гаргачихвал тодорхой олон улсын санхүүгийн группүүд бол зээл олгоход бэлэн байна гэж байгаа шүү дээ. Нэн хөнгөлөлттэй. Тэгэхээр бид хэд ийшээ урагшлах ёстой. Өнөөдөр бол дэлхий дээр 440 гаруй реакторууд ажиллаж байна. Дэлхийн хүлэмжийн хийг 2050 он.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Шинжээч Тэгшбаяр.

Н.Тэгшбаяр: Сайнзориг гишүүний тодруулгад хариулья. Ер нь энэ ус бохирдуулсан гэсэн ойлголт бол яг энэ жишээлбэл энэ ураны төсөл дээр байхгүй шүү дээ. Уран байгаа тэр газар бол уран өөрөө нэг талаасаа цацрагийн хувьд хоруу чанартай, нөгөө талаасаа химийн

хувьд хоруу чанартай. Тэр орчинд байгаа усыг нь өөрийг нь битүү циклээр ашиглаад ингээд явж байгаа учраас усны төлбөр авч болох байх. Гэхдээ ус бохирдуулсан гэсэн ойлголт нь бол яг физик талаасаа бол тийм зохимжгүй томъёолол байна л гэж хэлэхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Энэ томоохон хөрөнгө оруулалт тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулалт, энэ нь бас шинэ техник технологи, эрчим хүчний түүхий эдэд хөрөнгө оруулалт. Энийг оруулах гэж байгаа улс нь одоогоор яригдаж байгаа улс нь дэлхийн бодлогод нөлөө бүхий Европын бодлогод нөлөө бүхий ийм гуравдагч хөршийн асуудал яригдаж байгаа, түүнд бас тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын гэрээнд урьдач нөхцөл, хуулийн боломж бололцоог гаргах гэж байгаа энэ бодлогыг бол дэмжиж байгаа. Тэгэхээр энэ дээр ганц 2 зүйлүүд байгаад байгаа юм. Бид нар чинь өмнө нь уран дээр Мардайн, Хан ресорс гээд бас янз бүрийн жишээнүүд бид нарт бас байдаг. Монголчууд хэлсэн ярьсандаа хүрдэггүй, буруу зөрүү, дутуу дулимаг асуудлууд хийдэг. Сүүлд нь олон улсын арбитр дээр очоод Засгийн газар нь унадаг. Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэггүй олон олон нөхцөл байдлууд өнгөрсөн хугацаанд бас гарч байсан. Энэ бүгдийгээ бас мэдээж сургамж аваад, энэ дээрээ дүгнэлт хийж байгаа байлгүй дээ. Гол нь энэ хууль дээр орж ирж байгаа давуу эрхийн хувьцаа энийгээ энгийн хувьцаагаа, оролцоогоо, АМНАТ бол ашиг орлого өгөөжөөр нэмж болох энэ хувилбарыг бол би бүүр 2 гараа өргөөд дэмжиж байгаа юм. Оюутолгойгоос бид нар сургамж авах ёстой. Тэгэхээр энэ дээр яг энэ дагалдаж орсон орж ирсэн хуулиуд болоод бусад хуулиудаар харахад Үндэсний баялгийн сангийн хуультайгаа яаж нийцэж байгаа вэ. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд чинь стратегийн ордыг сүүлд Засгийн газрын мэдэгдэж байгаагаар 34 хувийг нь авна. Тэр дээр нь хэлэлцээр хийнэ гээд баахан заалтууд, тэрийг Баялгийн сангийн тухай хуулийг дагаад Засгийн газар чинь нэг баахан бодлого зарлаад байсан шүү дээ. Тэгэхээр Баялгийн сангийн тухай хууль энэ Цөмийн энергийн тухай хууль 2 маань хоорондоо яаж огтлолцож, яаж хамаарч хамаарч байгаа юм. Энэ дээр нэг тодорхой шийдэл гарцыг нь хэлээч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал хариулна.

Н.Учрал: Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоолыг баталсан. Энэ тогтоол дээр ер нь ямар агуулгатай тогтоол юм бэ гэхээр Үндэсний баялгийн сангийн хуулиар тэр газрын хэвлийн баялгийн 50 дээр нэмэх 1 буюу дийлэнхийг ард түмэн эзэмшигчдийн суурь зарчмыг хангуулахын тулд үндэсний баялгийн сан бол мэдээж дотроо 3 сантай байдаг. Тэгэхээр төрийн эзэмшлийн 34 хүртэлх хувь, төрийн эзэмшлийн 50 хүртэлх хувийг Ашигт малтмалын хууль, Баялгийн сангийн хуулиар өөрөө нөгөө төр үнэ төлбөргүйгээр авна гэдэг нэг ийм заалт байгаа. Батлагдсан Баялгийн сангийн хуулиар. Тэгээд үүн дээр болохоор үнэ төлбөргүйгээр авах дээр жишээ нь улсын төсвөөр хэрвээ тэр нөөцийг нь тодорхойлсон бол 50 хүртэлх хувий, хэрвээ өөрийнхөө санхүүжилтээр тэр хувийн хэвшил, хөрөнгө оруулагч нар нөөцийг нь тодорхойлсон бол 34 хүртэлх хувийг гээд заалттай. Тэгэхээр түүнийг өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын хуулиар бол бид АМНАТ-аар орлуулж болно.

Тэгэхээр сая Засгийн газрын шийдвэр болохоор тэр стратегийн орд эзэмшиж байгаа компаниуддаа хэлэлцээр хийе л гэдэг ийм л тогтоол батлагдсан юм. Тэгэхээр хэлэлцээр хийх ажлын хэсэг гарна. Яг энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээтэй адилхан. 34, 50 гэдэг энэ зарчмаа хангуулахын тулд жишээ нь суурь АМНАТ тооцох уу, тусгай АМНАТ тооцох уу, өсөн нэмэгдэх АМНАТ гэдэг ойлголт бий байж болох уу. Одоо төр магадгүй 34-ийг биш зүгээр 10 хувийн ноогдол ашиг авъя. Энэ нь өөрөө давуу эрхийн хувьцаа байя.

Санхүүгийн үүрэг хариуцлага хүлээхээ больё. Эсвэл бүүр 100 хувь АМНАТ-аар орлуулж болно. Тэгэхээр энэ чинь бол нөгөө гэрээ болгон дээр, төсөл болгон дээр өөр өөрөөр явагдах юм байна лээ. Тийм учраас хэлцлээ хийгээд, тэгээд гэрээгээ байгуулаад 34-ийг шууд АМНАТ-аар оруулж ирээд, Их Хурлаар батлаад л явчихъя. Ингэвэл хөрөнгө оруулагч талдаа энэ улс төрийн тогтворгүй байдлаас болж цаашдаа хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа явуулахад нь сөрөг нөлөө үзүүлэхгүй. Тэгэхгүй бол өнөөдөр хөрөнгө оруулагч нар ч гэсэн Монголд үйл ажиллагаа явуулахаасаа зүрхшээж байна шүү дээ.

Тийм учраас энэ төслүүдийнхээ гэрээнүүдийг нь албажуулаад тэр АМНАТ-аар оруулах бололцоог нь нээгээд явъя л гэж байгаа юм. Тийм учраас энэ Цөмийн энергийн хууль бол яг л Үндэсний баялгийн сангийн хуулийн дагуу жишээ нь цаашдаа бол тодорхой хувийг нь давуу эрх хувьцаатай авбал тэр ноогдол ашиг нь хуримтлалын сан руу шилждэг. Тэгээд АМНАТ-аар төлөгдсөн АМНАТ-ийнх нь 65 хувийн АМНАТ нь Ирээдүйн өв сан руу шилждэг. Үлдсэн нь Орон нутгийн сан руу, Тогтворжуулалтын сан руу очдог. Тэгээд орон нутгаа ч дэмждэг, Ирээдүйн өв санд ч хуримтлал үүсдэг, ноогдол ашгаа хуримтлалын сан руугаа авдаг. Тэр хуримтлалын сан нь эрүүл мэнд, орон сууц, боловсролд зарцуулагдана гэсэн Үндэсний баялгийн сангийн хууль хэрэгжээд явна л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тийм л дээ сая таны хэлж байгааг ойлгож байна. Тэгэхдээ Баялгийн сангийн тухай хууль дээр чинь тэгээд заачихсан байхад энэ хуулийг дагалдаж орж ирж байгаа хууль дээр чинь Баялгийн сангийн тухай хууль чинь байхгүй байна шүү дээ. Тэр зүйл, заалт чинь. Тэр зүйл заалт чинь хүчин төгөлдөр байхаар энэ дээр энэ асуудлыг чинь хөндөхгүй болохоор зөрчил үүсэх юм биш үү л гэж би асуугаад байна шүү дээ. Энэ дагалдаж байгаа хууль дээр Баялгийн сангийн тухай хуулийн ямарваа нэгэн зүйл заалт харилцааг давуу эрхийн хувьцаагаар орлуулж болох тухай заалт чинь энэ дээр алга байна шүү дээ гэж.

Д.Амарбаясгалан: Учрал сайд тодруулж хариулья.

Н.Учрал: Баялгийн сангийн хуулиар бол нөгөө төрийн эзэмшлийн 34, 50 хүртэлх хувийг эзэмшихийг заасан. Ашигт малтмалын хуулиар одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бол төрийн эзэмшлийн 34 хувийг АМНАТ-аар орлуулж болно гэдгийг нээчихсэн байсан ч Цөмийн энергийн хуулиар энэ нь нээлттэй биш байсан. Тэгэхээр ашигт малтмалын хуулиар бол нээлттэй. Энэ хэлэлцээр хийх нь бол. Тэртээ тэргүй Их Хурлын бүрэн эрх. Цөмийн энергийн хууль дээр одоо нээгээд өгсний дараа бол төр эзэмшлийнхээ 34, 50 хүртэлх хувийг шууд АМНАТ-аар орлуулж болно. Тодорхой хувиа энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгож болох нь шууд нээгдэнэ л гэсэн үг. Тэгэхээр заавал Баялгийн сангийн хууль дээр өөрчлөлт орох шаардлага бол байхгүй. Эцэстээ бол Их Хурлын бүрэн эрх. Яагаад гэхээр төрийн эзэмшлийн хувийг АМНАТ-аар орлуулах, тусгай Амнатыг хэдээр тооцох вэ гэдэг лийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Их Хурал тогтоодог.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: 2 асуулт байна.

1 дүгээрт нь Компанийн тухай хуультай холбоотой 34.5-тай холбоотой. Энгийн хувьцаа Компанийн тухай хууль дээр энгийн хувьцааг давуу эрхийн болон бусад өрийн хэлбэрт шилжүүлж болохгүй гээд заачихсан байгаа. Тэгэхдээ энэ хууль дээр онцгойлж

зөвхөн 1 төсөл л дээр 1 ашигт малтмал дээр ийм заалтыг оруулахаар өөрчилж байна л даа. Ер нь бол яах вэ энэ төсөлдөө итгэж байгаа итгэлийн асуудал. Тэгэхээр өөрийн компанийн засаглалд орохоос санхүүгийн эрсдэлээсээ болоод үүнээс зугтааж санхүүгийн эрсдэлээсээ бууруулахын тулд компанийн засаглал үйл ажиллагаанд орохгүй юм шиг ингэж харагдаад байна л даа. Тэгэхээр энэ олон улсын зах зээл дээр үнэ ханш чинь бас ингэж байнга хэлбэлзэж байдаг, өсөж байдаг, буурч байдаг. Тэгэхээр энэ нөхцөл байдлаа ямар хэзээ нь жишээлбэл та хэд энэ давуу эрх, энгийн хувьцаагаа давуу эрх рүү шилжүүлбэ гэсэн төлөвлөгөө юм байгаа юу, үгүй юу. Зүгээр хувь хүнийхээ хувьд бол заавал ингэж оруулах хэрэг байгаа юм уу гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд энэ дээр хэзээ энгийн хувьцаагаа давуу эрхийн хувьцаа руу шилжүүлэхээр та хэд төлөвлөж, бодож байгаа вэ гэдэг асуулт байна.

2 дугаарт нь болохоор нөөц ашигласны татвартай холбоотой. Энэ ер нь бол яах вэ, энэ хууль маань зөвхөн энэ төслийг хамаарахгүй. Монголд бас нэлээн олон төслүүд байгаа. Тэгэхээр та хэдийн хувьд бол бусад одоо байж болох болон ирээдүйд бий болох судалгаа хийгдчихсэн энэ төслүүд дээр энэ нөлөөлөл гэж харьцуулж үзсэн судалгаа байгаа юу. Ялангуяа би энэ өртгийн ашигт малтмалын нөөц ашигласны татвар дээр манай энэ судлагдсан болон ирээдүйд ашиглах энэ төслүүдийн хувьд өртгийн муруй дээрээ нийт жишээлбэл дэлхийн нийлүүлэлтийн өртгийн муруй дээрээ манай ордуудын өртөг аль хавьд нь байршиж байгаа вэ, хэдэн хувьд нь байдаг вэ. Тэгээд цаашдаа энэ ураны зах зээлийн үнийг ямаршуу бай байдлаар өөрчилнө гэсэн тийм төсөв төлөвлөгөө байгаа вэ гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаагийн шалтгаан бол энгийн хувьцааг давуу ерөнхий хувьцаа болгож хөрвүүлж болохыг Цөмийн энергийн хууль буюу стратегийн ач холбогдол бүхий цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглах тохиолдолд хэрэглэхийг бол хуульчилж өгч байгаа. Тэгэхээр энэ яагаад ийм өөрчлөлтийг оруулсан бэ гэхээр өнгөрсөн мэдээж алдаа. Төр ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй л гэж байгаа юм. Гэхдээ энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгохыг мэдээж л Их Хурлаар шийдээд л явна. Тэгэхдээ энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгосноороо төр ноогдол ашиг авахаа болино гэсэн үг биш. Адилхан ноогдол ашгаа тэргүүн ээлжид хүртдгээрээ хүртэнэ. Дээрээс нь тэр ТУЗ-д төлөөлөл суудгаараа сууна. Оролцоод явна гэсэн үг. Тэрнээс биш давуу эрхийн хувьцаа болголоо гээд ноогдол ашиг хүртэхээс татгалзаж байгаа эсвэл ТУЗ-д төлөөлөн суухаас татгалзаж байгаа ойлголт бол огт биш. Компанийн засаглал үйл ажиллагаанд, бодлогын шийдвэрт Монголын төр оролцож явна. 10 хувийн давуу эрхийн хувьцааны ноогдол ашиг бол Үндэсний баялгийн сангийн хуулиар батлагдсан хуримтлалын данс руу шилжинэ. Хуримтлалын данс руу. Тэгээд тэр нь эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулагдана.

Тэгэхээр бол өөрөө энэ давуу эрхийн хувьцаа болгосны онцгой ач холбогдол бол юу юм бэ гэхээр санхүүжилтийн ямар нэгэн хариуцлага хүлээхгүй л гэж байгаа юм. Хэрвээ өнөөдрийн өнгөрсөн хугацаанд энэ хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрийн үеэр юу яригдсан бэ гэхээр ерөөсөө хэрвээ Монгол төр 34 хувиа эзэмшээд яг өмнөх тэр гэрээнүүдтэй ижилхэн явах юм бол яг эхний хөрөнгө оруулалт дээр 125 сая доллар шууд төлөх үүрэг хүлээгээд байгаа юм. 10 хувийн ноогдол ашгаа аваад, давуу эрхийн хувьцаа болгоод явбал Монголын талаас 1 ч төгрөгийн санхүүжилт хийгдэхгүй. Цаашдаа өр үүсэхгүй. Цаашдаа бид нар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тэнд хөрөнгө оруулалт хийлээ бол тэр манай эзэмшиж байгаа хувь дээр ямар нэгэн импакт өгөөд байх зүйл огт байхгүй. Төсөл өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явна гэдэг ийм гэрээ хийгдэж байгаа учраас зүгээр ер нь бол

Цөмийн энергийн хууль батлагдсанаараа бид нар энийг нээнэ. Гэхдээ хөрөнгө оруулалтын гэрээг ярих бол эрт байна. Энэ хуулийг батлагдсаны дараа бол хэлэлцээр яаж явах вэ гэдэг дээр мэдээж Их хуралд, Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд тэр хувьцааг хөрвүүлэх, АМНАТ-ийг хэдээр тооцох, орлуулах эсэх асуудал бол та бүхэнд байгаа. Та бүхний онцгой бүрэн эрх.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Энэ усны төлбөрийн асуудлыг өөрөөр тусгах боломжтой байгаа юу. Энийг нарийн сайн тайлбарлаж өгөөч.

Тэгээд Дорноговь бол усны маш их хатуулагтай. Ундны ус нь бол шаардлага хангахгүй байгаа. Тэгэхээр энэ шар нунтаг үйлдвэрлэж эхлэх гэж байгаа бол энд ундны усанд ямар нэгэн сөргөөр нөлөөлөх, гүний усанд сөргөөр нөлөөлөх зүйл байгаа юу. Технологийг нь тайлбарлаж өгөөч ээ.

Тэгээд Учрал сайд аа, соён гэгээрүүлэх ажиллагаа хэр хийх юм. Одоо тэр нутгийн ард түмний эсэргүүцэлтэй тулах нь үнэн. Гарцаа байхгүй. Тэгэхээр үүний соён гэгээрүүлэх ажлыг сайн хийх юм уу. Одоо тэр технологио тайлбарлаж, нутгийн ард иргэдэд ойлгуулах уу. Дээр тайлбар нь тайлбар хийж байхад орон нутгийн үр өгөөжийг 1 гишүүн асуусан. Тэнд 1 сая долларын асуудал яригдсан. Тийм ээ. Тэр үнэн үү. Би бол энэ дээр их хатуу байр суурьтай байдаг. Юу вэ гэхээр Ашигт малтмалын хуулийн 42.1, 2 дугаар заалт бол орон нутагт нутгийн иргэдэд их ашигтай мэт боловч нутгийн өөрөө удирдах байгууллагыг гадаадын хөрөнгө оруулалттай юм уу, хувийн компаниуд худалдаж авах хэмжээнд оччихоод байгаа юм. Энэ хуулийн хэрэгжилт нь сөрөг тал нь. Яагаад гэвэл тэд нар мөнгөөр бүхнийг зохицуулаад байгаа. Тэгээд ргэдийн Хурлыг нь худалдаад авчихдаг. Сүүлдээ сонгуулийнх нь төлбөрийг төлчихдөг. Тэгээд өөрийнхөө эрх ашгийн дор барьчихдаг. Нутгийн өөрөө удирдах байгууллага шийдвэр гаргаад ийм асуудлыг шийдээд өгөөч ээ, ингээч ээ, тэгээч ээ гээд хэлэхээр зөвшөөрдөггүй. Зөвхөн өөрсдийнхөө үзэмжээр харьцдаг ийм сөрөг байдал орон нутагт гараад байгаа юм. Тэгэхээр энэ Ашигт малтмалын хуулийн 42.1, 2-оо бид бас эргэж харах цаг болчихсон байхгүй юу. Юу юуны духанд хүрэлгүй л гадаадын хөрөнгө оруулалттай ч юм уу ийм том төслүүд ороод ирэхээр л өөрөө удирдах байгууллагад нь тэдийг өгнө, эдийг өгнө, тийм сан байгуулна гээд байдаг. Энэ нь тэр байгууллагыг худалдаж аваад байгаа юм. Тийм сөрөг байдал гараад байгаа л даа. Ингээд 3 асуулт асуулаа.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулъя. Манай ажлын хэсгээс бас түрүүн Энхтүвшин гишүүний асуултын дутууг бас гүйцээж хариулаарай. Тэгээд Мөнхбаясгалан гишүүн ээ, энэ гэрээний асуудал яригдаагүй байгаа шүү дээ. Хэдүүлээ гэрээ дээр юу гэж тусгагдсан талаар Учрал сайд болон бусад ажлын хэсгийн гишүүд өнөөдөр хариулах бол 1 дүгээрт зохимжгүй. Албан ёсоор Засгийн газар нь хэлэлцээгүй, өргөн баригдаагүй байгаа гэрээний заалтын талаар тайлбар хариулт хийгээд сууж байна гэж бол болохгүй зүйл. Яг энэ хуулийнхаа нэмэлт, өөрчлөлт, хамт өргөн мэдүүлсэн хуулиудад орж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудал дээр тодорхой хариултуудыг маш сайн өг. Гэхдээ ер нь энэ гишүүдийн бас санаа зовоод байгаа, ер нь цаашдаа энэ уран гэдэг зүйл чинь өөрөө яг юу юм бэ гэдэг энэ ерөнхий ойлголтыг мэргэжлийн экспертүүд маань та бүхэн бас өнөөдөр хариулт өгөхдөө нэмж хариулаад байгаарай гэдгийг хэлье. Учрал сайд.

Н.Учрал: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ байгаль орчин нөхөн сэргээлтийн асуудал бол маш их чухал. Тийм ч учраас энэ ажлын хэсэг дээр 2013 оноос хойш хийгдсэн тэр худгуудаас авсан, цооногуудаас авсан олон дээжүүд, тэгээд тэр

хөндлөнгийн бас аудитын дүгнэлтүүд байгаль орчны чиглэлээр гарсан юм байна лээ. Сүүлд бас Байгаль орчны яам Шинжлэх ухааны академи нэлээн ажилласан. Тэгээд яах вэ, зүгээр ер нь жишээ гэвэл тэр яг энэ ураны төсөл дээр 10,4 тонныг олборлож үзээд, тэр дээжүүдээс нь шинжилгээ аваад ер нь байгаль орчинд ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа вэ гэдэг талаар бол ярилцаад, ингээд дүгнэлтүүдийг бол хийсэн нь бол хангалттай байсан. Гэхдээ бид нар хуульдаа Цөмийн энергийн хууль дээр өнөөдөр яг энэ байгаль орчныг нөхөн сэргээх асуудлуудыг ерөөсөө эрх зүйн орчныг сайжруулахгүй бол болохгүй юм байна лээ. Тийм учраас тэр байгаль орчныг хамгаалах барьцаа гэдэг агуулгыг энэ цөмийн энергийн хуулиар оруулж өгч, энэ барьцаа авч байж нөхөн сэргээх дээр нөгөө уурхай хаагдсаны дараа ямар асуудал үүсэх вэ гэдэг дээр барьцаа авч байхгүй бол дараа нь ирээдүйд ямар асуудал үүсэхийг тааж мэдэхгүй. Гэтэл өнөөдөр Байгаль орчны хуулиараа, Ашигт малтмалын хуулиараа бусад ашигт малтмалын нөөц дээр эргэлтэд оруулах дээр бол байгаад байдаг мөртөө Цөмийн энергийн хуулиар энэ харилцаа ерөөсөө зохицуулагдаагүй. Тийм учраас энэ барьцааны ойлголтуудыг тусгаж өгөөд, дээрээс нь энэ тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын шаардлага дээр нөхөн сэргээх асуудлуудыг бүр хатуу шаардлага болгож тусгаж өгсөн. Дээрээс нь уул уурхайн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд төлөвлөгөө хийгээд л ямар ч хараа хяналтгүй явдаг. Үүн дээр нь тэр цөмийн энергийн энэ комисс байгууллага нь хяналт тавих асуудлыг бол бас хуульд тусгаж өгсөн.

Дээрээс нь ер нь бол энэ нөхөн сэргээхтэй холбоотойгоос гадна орон нутгийн хөгжилд ямар нэгэн тийм нийгмийн дэд бүтцийг сайжруулах чиглэл рүү бол ажиллах ёстой. Энэ бол хариуцлага. Тийм учраас таны сая яриад байгаа тэр мөнгөн дүнтэй асуудал бол зүгээр тухайн үед энэ төсөл яригдаж байх үед протоколд бол бас ийм юм тусгагдаж байсан юм байна лээ. Тэгэхдээ түүнийг бол бид илүү тэр орон нутгийн хөгжилд зарцуулах, тодорхой тэр нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэхэд нь зориулах чиглэлээр бол цаашдаа ажиллах ёстой юм байна лээ. Тэрнээс биш хэн нэг нь санал аваад төвлөрүүлээд, хэн нэгэнд захирах эрхийг нь өгөхөөсөө илүүтэйгээр орон нутгийг хөгжүүлэхэд тухайн орон нутагт одоо хүн амьдрахад таатай нөхцөлийг бүрдүүлэхэд зарцуулах чиглэлээр гэрээ хэлцэл хийгээд явбал илүү бодитой болох болов уу гэж бодож байна.

Ингээд тэр байгаль орчны чиглэлээр ажлын хэсгээс нэмж хариулья.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон. Жамсрандорж гуай нэмж хариулья.

Г.Жамсрандорж: Тэр ундны усны тухай асуултад хариулья. Манай орны ХАА-н зориулалтын усны худгууд бол ерөөсөө 25 метрээс илүү гүнтэй байдаггүй. Энэ нь яагаад вэ гэхээр зэрэг бол усыг гаргаж авах эрчим хүчний эх үүсвэртэй холбоотой байдаг. Тэгвэл Зөөвч овоогийн уран ордны уран агуулсан давхаргууд нь 120-160 метрийн гүнд хоорондоо шаврын ус үл нэвчүүлэх давхаргуудын хооронд байдаг. Тэгээд энийг тэр гүнд байдаг учраас дээд ундны устай ямар нэг холбоогүй. Технологийн хувьд бол тэр ион солилцооны давирхай буюу олон шүүлтүүрээр бүхээтэн савуудад ураныг соруулж аваад уран агуулсан уусмалыг соруулж аваад, давирхайны шүүлтүүр дээр ураныг уусгаж аваад буцаагаад битүү эргэлтээр усаа шахдаг учраас усны алдагдал байхгүй. Ус бол битүү яваад, харин ураныг уусгаж авсны дараа цэвэршээд, буцаж дахиж хүхрийн уусмалаараа баяжуулаад эргэж дахин эргэлтээр ус нь уран авдаг учраас усны алдагдал үндсэндээ бараг байхгүйгээр ингэж ураныг авдаг ийм битүү циклийн зарчим байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. “Мон Атом” ХХК-ийн захирал Далайжаргал.

Д.Далайжаргал: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Би маш энгийн хариулчихъя. Шинжлэх ухааны нарийн юм. Уран гэдэг нь говийн нөхцөлд 140-170 метрт шавартай нойтон элсэнд байдаг юм. Тэгэхээр тэрийг гаргаж авахын тулд ганц хэрэглэдэг юм нь хүхрийн хүчил гэдэг элементээр авдаг. 99 хувь нь ус. 1 хувийн хүхрийн хүчил гэсэн пропорцтоор тэр ураныг уран доор байгаа тэр ус устай орчныг бүрдүүлчихээр тэр уран нь хүхрийн хүчилтэй усандаа шингэж байгаа. Өөрөөр хэлбэл бид нар усанд сахар хийхээр шингэдэгтэй адилхан. Тэгээд уусгаж гаргаж аваад уснаас нь ураныг нь салгаж аваад буцаагаад тэр усыг нь ахиж шахдаг. Тэгэхээр 2 юм байгаа юм. Говийн доор бол их хэмжээний ус байна гэсэн ойлголт байхгүй. 10 хувийн ус байгаа. 2 дугаарт 1 усаа дахин дахин эргэлдүүлж цикл болгож явдаг ийм процесс байгаа. Энийг гидро химийн процесс гэж нэрлээд байгаа юм. Газар доор уусган олборлох гэдэг.

Тэр олон нийттэй харилцах юм үнэхээр чухал асуудал. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд энэ “Мон Атом” ХХК олон нийтэд чиглэсэн олон арга хэмжээ хийсэн. Зөвч овоо, Дулаан-Уулын орд дээр нийтдээ 3300 хүн очиж... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. “Мон Атом”-ийн мэргэжлийн шинжээч Тэгшбаяр нэмж хариулн.

Н.Тэгшбаяр: Энхтүвшин гишүүний асуултад нэмж хариул гэсэн учраас хариулж байна. Үнэ хаашаа явж байгаа тухай асуусан. Өнөөдөр бол 1кг нь 280 орчим доллар. Фаундаар бол 81 орчим доллар байна. Ер нь бол 2030 онд мэргэжлийн судлаачдын прогноз хийж байгаа хүмүүсийн, судалгааны байгууллагуудын үзэж байгаагаар бол дэлхий дээр ураны нөөц 120 орчим мянган тонн хэрэгтэй болно. Тэр үед бол дэлхийн ойролцоогоор 80 орчим мянгыг бол зах зээлд нийлүүлж чадна. Үүний зөрөө 40 орчим мянгын ингээд ийм сох дутаж байгаа. Эндээс үүдээд бол ураны үнэ өсөх магадлал бол маш өндөр байна гэсэн хариултыг өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Тэр гүний ус бол хэрэглэхгүй юм байна гэж ойлголоо. Тэгэхээр тэр хэрэглэсэн усаа шахаад дахиад хэрэглэнэ гээд байна шүү дээ. Тэр нэг хэрэглэсэн усаа л эргэлдүүлээд байхыг хэлээд байна уу. Ус бохирдуулах юм уу. Хэрвээ ус бохирдуулж байгаа бол ус бохирдуулсны төлбөрийг яаж тогтоох вэ. Тэр дээр ямар нэгэн өөр хуульд зааснаар байгаа юу, тусгай нөхцөл байгаа юм болов уу. Ажлын хэсэг.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Жаргалсайхан: Газар доор уусган олборлох аргаар энэ уран олборлоход усыг бол циклээр эргэлдүүлж ашиглана. Ямар нэгэн байдлаар газрын хөрсөнд ч юм уу, гадаргын усанд ч юм уу нийлүүлэх ийм юм байхгүй. Тийм учраас бол ер нь усны төлбөр гэдэг маань ус бохирдуулсны төлбөр гэдэг маань байгаль орчинд бохирдуулсан усыг хаяхад, хаясан тохиолдолд төлөх ийм заалт байгаа. Тэгэхээр энэ бол ямар нэгэн байдлаар байгаль орчинд ус хаягдахгүй циклээр эргэлдэнэ.

Түрүүн таны асуусан асуултад бас нэг тодруулаад хэлэхэд ундны усны стандартын шаардлага гэдэг бол ямар учиртай байдаг вэ гэхээр ер нь хүн өдөрт 2 литр ус уухад ямар эрдэс минералыг тэр усаараа авах ёстой юм. Хэрвээ хэтрэх юм бол хүний эрүүл мэндэд нөлөөлөх юм гэдгийг заасан ийм стандарт зөвшөөрөх хэмжээ байдаг болохоос ямар нэгэн байгаль дээр байгаа ундны ус нь.../минут дуусва/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Усны газрын дарга Батбаяр.

З.Батбаяр: Гишүүний асуултад хариулъя. Тэр ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг өөрөөр тогтоох боломж байгаа юу гээд. Сайнзориг гишүүн ч гэсэн асуусан. Одоогийн байдлаар устай холбоотой асуудлаар татварын тогтворжуулалтад огт хамааруулахгүй гэж түрүүн Одонтуяа сайд тайлбарласантай яг ижилхнээр тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журам, стандартын дагуу шийдэгдэх учраас тухайн үед хууль тогтоогчийн хүсэл эрмэлзлийн дагуу усны төлбөрийг нэмэгдүүлээд, өөрчлөөд явчих бүрэн боломжтой. Тэр боломжийг хадгалж авч үлдэж байгаа нь хамгийн чухал юм.

2 дугаарт нь технологийн тухай асуудал дээр одоогийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар ус ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр, усны үйлчилгээний төлбөр, ус хомсдуулсны төлбөр гэсэн 4 төлбөрийг авч байгаа. Энэ төлбөрийг бүх талаар нь төлөх үүргээ хүлээсээр байх болно. Үргэлж г технологийн тухай асуудал дээр эргэлтийг хийж байх үед тухайн орд газар, орд гэдэг нь уул уурхайн орд газраас гадна усны орд газар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 20 дугаар микрофон.

З.Батбаяр: Усны орд газрууд дээр байрлуулсан мониторингийн цооногуудынхаа хүрээгээр мониторингийн цооног гэдэг маань олборлолт явуулж байгаа цооногуудаас тусдаа цооног байж байгаа. Тэр цооногуудаар эхний ээлжид газрын доорх усны түвшний өөрчлөлтийг хэмжинэ.

2 дугаарт нь чанарыг нь байнга хэмжээд явах юм. Тэгэхээр олборлолт явахаас өмнө судалгаа хийх замаар газрын доорх усны тэр хөрсний усны бүх төрлийн шинжилгээг нь хийгээд, хатуулагтай байсан ч гэсэн үндсэн суурь түвшин гэж үзээд, энэ түвшиндээ хүртэл үйл ажиллагаа дуусаад 44 жилийн дараа үйл ажиллагаа дуусахад энэ түвшиндээ байх ёстой гэсэн шаардлагын дагуу явах учраас нөгөө нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа ч гэсэн үүнтэйгээ холбогдоод явна гэсэн ийм тооцоололтой сууж байна.

Д.Амарбаясгалан: Одоо Чинбаатарын Анар гишүүн асуултаа асууна.

Ч.Анар: Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт нь яаралтай орж ирж байгаа шалтгаан нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ач холбогдолтойгоор орж ирж байгаа буюу гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой. Гэтэл байнга л яриад байгаа миний нэг зүйл 34.5. Энэ тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар үйлчилгээнд зарцуулах мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 34.6-д заасан журмын дагуу тооцож, төрийн дансанд байршуулна гээд байгаа юм. Энэ дээр 2 асуудал байгаа юм. Би өөрөө бол өнгөрсөн ч олон жилийн хугацаанд гаднын хөрөнгө оруулалтын маш олон хэлэлцээр хийсэн. Монголд хөрөнгө оруулахад хамгийн том эрсдэл бүх хөрөнгө оруулагч ярьдаг. Улс төрийн эрсдэл. Бид нараас үл шалтгаалсан улс төрийн эрсдэл Монголд маш өндөр л гэдэг. Тэгэхээр энэ өндөр эрсдэлийг үүсгэсэн заалт байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар хуулиа үүгээрээ баталчих юм бол эргээд Орано байна уу, дараа нь Мардай байна уу, энэ жишиг хууль болоод явна. Энэ ямар үндэслэл үүсээд байгаа юм бэ гэхээр хуульдаа заагаагүй журам, журмаа цөөлнө гэж яриад байдаг. Хуулиасаа давсан журам батлагдах эрсдэлтэй. Засгийн газар нь дараагийн 10, 20 жилд хэд солигдох билээ. Энэ журам дээр тэр мөнгөн хөрөнгийг хэдэн жилээр яаж татан төвлөрүүлэх нь хууль дээрээ зохицуулагдаагүй. Тэгэхээр Засгийн газрын гишүүдийн тухайн үеийн төсвийн шаардлагаар энийг

дуртайгаараа зохицуулах боломжтой. Энэ нь хөрөнгө оруулагчдад бол шууд улс төрийн эрсдэл болж харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг илүү тодорхой болгож оруулмаар байна.

2 дугаарт энэ төрийн дансанд байршуулж байгаа асуудал. Цөмийн энергийн тухай хуулийн 28.9 дээр ослын үеийн заалтаар барьцаа байршуулдаг. Бадрахын Энержигийн зүгээс бол одоогоор 900 мянган доллар байршсан байгаа. Энэ бол энэ 34.5 заалттай хамаагүй. Гэхдээ энэ төрийн данс нь өөрөө байршсан мөнгөө эргэлтэд оруулж чаддаггүй. Тэгэхээр энийг бол өөрөө улс тусгай данс юм уу, эсвэл банкны баталгааны зохицуулалтаар ч юм уу илүү үр ашигтай байх зохицуулалтыг оруулж ирмээр байна гэдэг саналыг хэлээд байгаа. Тэгэхээр энэ дээр бол ажлын хэсэгтээ ерөнхийдөө Байнгын хорооны хурал дээр ойлголцсон гэж ойлгож байгаа. Гэхдээ үүний цаад ач холбогдол нь энэ мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх эрхийг хууль дээрээ яг тодорхой зааж өгмөөр байна л гэдэг санал байгаа. Тэгэхгүй бол энэ өөрөө энэ хууль маань батлагдсаны дараагаар яаралтай хийх гэж байгаа гэрээ маань хэрэгжихэд эрсдэл үүсэх вий гэдэг л асуудал байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Яг зөв энэ Анар гишүүний энэ хөндөж байгаа сэдвийг бид бас ажлын хэсэг байгуулаад ажиллахдаа, хэлэлцэх эсэхээ шийдчихээд энэ дээр их анхаарах хэрэгтэй. Ер нь бол гаднын хөрөнгө оруулагчдын тавьж байгаа шаардлагыг л бид баталгаатай, дээрээс нь дотоодод эрсдэлгүй байх гэдэг 2 зүйлээ л байнга бодож байх ёстой учраас Тийм ээ. Хэн хариулах билээ. Учрал сайд хариулья. Нэмж ажлын хэсгийн 1 дүгээр микрофон Манлайжав Цөмийн энергийн газрын дарга.

Н.Учрал: Ашиг малтмалын хуулийн 39.1-д заасны дагуу энэ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болбол нөгөө байгаль орчныг хамгаалах үүргийг хүлээдэг. Тэгэхээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бол энэ мөнгөн хөрөнгийг байршуулдаг. Энэ мөнгөн хөрөнгийг байршуулж байгаагийн зорилго бол ямар нэгэн байдлаар нөхөн сэргээхгүйгээр төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг нөхөн сэргээлгүй орхиж гарах эрсдэлээс сэргийлдэг. Тийм учраас энэ үүргийг хүлээж байгаа учраас тэр мөнгөн хөрөнгийг байршуулаад, хэрвээ ямар нэгэн эрсдэл ирээдүйд үүсвэл тухайн мөнгөн хөрөнгөөр нь мэргэжлийн компанийг сонгон шалгаруулаад, тэгээд нөхөн сэргээх ажлыг нь хийлгэх ийм зорилготойгоор л энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгддөг. Тийм учраас Цөмийн энергийн хууль дээр ч гэсэн энэ томоохон төслүүд хэрэгжих учраас бид энэ бас төслийн хугацаанд ийм асуудал үүсэхээс урьдчилан сэргийлээд энэ заалтыг бол бусад Ашигт малтмалын хууль, Байгаль орчны хуультай нийцүүлж ингэж оруулж ирсэн. Төрийн дансанд байршуулах, тэр банканд байршуулах асуудлыг бол ажлын хэсэг дээр ярьж болно.

Гэхдээ яагаад энэ заалт орж ирсэн юм бэ гэхээр нөгөө хөрөнгө оруулагч тал чинь өөрөө, төсөл хэрэгжүүлэгч тал чинь өөрөө нөхөн сэргээхгүйгээр гараад явчихсан тохиолдолд Монгол Улсад тэр нөхөн сэргээх тодорхой мөнгөн хөрөнгө чинь үлдэх ёстой байхгүй юу даа. Тэр утгаараа л бид нар энэ байршуулах асуудлыг л ингэж оруулж ирж, одоо байгаа Байгаль орчны хууль, Ашигт малтмалын хуулийн зохицуулалттай нийцүүлж байгаа болохоос шинээр орж ирж байгаа зүйл огт биш. Хэрвээ олон улсын ямар нэгэн банканд байршуулья гээд Их Хурал дээр ажлын хэсэг шийдвэл үүнийг аваад явж бол болно.

Мөнгөн хөрөнгө тооцох, байршуулах тэр журам гээд байгаа. Тэгэхээр нөгөө уурхай ашиглалтын хугацаанд жил бүр тодорхой хөрөнгө байршуулаад, засвар арчилгаа зарцуулах энэ хуримтлалыг бий болгож байгаа. Тэгэхээр мэдээж энэ бол тухайн тэр ураны ислийн үнэ дэлхийн зах зээл дээр ямар байна. Эрэлт нийлүүлэлт нь ямар байна. Тухайн төсөл амжилттай хэрэгжиж байгаа. Зах зээл дээр эрэлт нийлүүлэлт нь ямар байна вэ гэдгээс шалтгаалаад тэр мөнгөн хөрөнгө байршуулах хувь, зардал чинь өөр өөрөөр тооцогдож явахгүй бол шууд ингээд хатуу заачихаар харин хөрөнгө оруулагч талдаа эрсдэлтэй. Тийм

учраас энийг Засгийн газар магадгүй ураны үнэ 10 жилийн дотор 83 хүрчихсэн шиг 5 жилийн дараа 100 гараад явчихвал мөнгөн хөрөнгийн байршуулах хуримтлалын хэмжээ ч гэсэн ихсэх л ёстой шүү дээ. Тэгээд тэрнийг нь Засгийн газар шинээр шийдээд явна. Тэгээд яах вэ, ер нь хууль давсан журам байна гэж их ярьж байгаа ч гэсэн бүх процессыг хуульчилна гэдэг бол бас ийм боломжгүй. Яагаад гэвэл энэ чинь зах зээлийн харилцаа юм гэдгийг бас хэлэх гээд байгаа юм. Тэгээд яах вэ, Анар гишүүний саналыг ажлын хэсэг дээр ярилцаад явъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Анар гишүүн тодруулж асууя.

Ч.Анар: Учрал сайд аа, энэ заалтыг бол маш сайн ойлгож байгаа. Зайлшгүй байх ёстой заалт юм. Би үнийн зохицуулалтыг нь журамлаад, хууль дээр оруулж ирье гээд байгаа юм биш. Ашигт малтмалын тухай хуулийн 3.1 дээрээ цацраг идэвхт ашигт малтмалыг уг хуулиар зохицуулахгүй гээд заачихсан байгаа. Тэгэхээр 39.1 маань энэ хуультай хамаарахгүй. Тэгэхээр энэ заалтыг бол би ерөөсөө эсэргүүцээгүй. Энэ бол зөв. Зайлшгүй байх ёстой заалт. Зүгээр процессын хувьд энэ зохицуулалт маань хууль дээрээ тодорхой орж ирээч ээ. Үнийн зохицуулалт нь бол журам дээрээ байж болно. Зүгээр хууль дээрээ энэ яаж, хэдий хугацаагаар яаж татан төвлөрүүлэхийгээ оруулья гэдэг санал байгаа. Тэгэхдээ ажлын хэсэг дээрээ энийг ойлголцоод явчихсан. Ойлголцож эхэлсэн гэж ойлгож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Манлайжав нэмж хариулна.

Г.Манлайжав: Анар гишүүний асуултад тодруулга өгье. Манай Цөмийн энергийн тухай хууль дээр орж байгаа нэмэлт, өөрчлөлт маань хэдийгээр хөрөнгө оруулалтын гэрээтэй тусмаа, тэр тусмаа Зөвч овоо төсөлтэй холбоотой боловч дараа дараагийн бас хөрөнгө оруулалтын энэ ураны төслүүдтэй бол хамааралтай. Тэгэхээр бид нар бол хаалттай холбоотой, нөхөн сэргээлттэй холбоотой асуудлууд дээр яг тоо тодорхой хэмжээгээр хэлэхэд бас хүндрэлтэй байгаа. Өнөөдөр бол бид нар говийн бүсэд байгаа тунамал элсэн ордуудын асуудлууд ярьж байна. Бас Монгол Улсын одоогоор нөөц нь тогтоогдсон. Зүүн бүсэд байгаа бас галт уулын гаралтай далд уурхай, ил уурхайн асуудлууд дээр бид нар нөхөн сэргээлтийн асуудлыг ярихад хуульд бол Учрал сайд сая хэллээ. Хуульд бид нар ямар ч байсан нөхөн сэргээлттэй холбоотой, хаалттай холбоотой асуудлыг заавал тусгая. Тэр тусмаа хаалтын ажиллагааг 5 жил хүртэл ч гэсэн явъя гэж ярьсан. Энэ Байгаль орчныг хамгаалах тухай хууль дээр ч гэсэн манай энэ ордуудын заавал байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт холбоотой зардлуудыг жил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон

Г.Манлайжав: Баярлалаа. Бид нар бол энэ ажлын хэсэг ярьж байхдаа энд заавал бид нар бол сая Анар гишүүн хэллээ. Түүрүүн 900. Энэ нөгөө технологийн үйлдвэрлэлийн туршилтын үед Монгол Улсад анх удаа энэ туршилт хийж байсан учраас бид нар ямарваа нэгэн цацрагийн осол байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдолд гэдэг үүднээс тэр тооцооллыг Засгийн газар дээр 3 яам бол гаргаж энэ мөнгийг одоогоор байршуулсан. Энэ том төслийн хувьд бол бид нар 1 удаа авах гэж байгаа юм биш. Ер нь бүтээгдэхүүн гараад анхны борлуулалт эхэлснээс хойш тодорхой хувийг нь хөрөнгө оруулагч талтайгаа төсөл хэрэгжүүлэгч компанитай бол ярилцаж хөрөнгө оруулалтын гэрээндээ тусгана гэсэн ийм бодолтой байгаа. Энэ бас олон улсын практикт бол олон аргууд байдаг. Тэр дотроо бол бид нар энэ хуримтлалын сан байгуулах, с анхүүгийн баталгаа, эрсдэлийн даатгалын сан, уурхайн хаалтын сан, улсын сан гэсэн ийм олон жишгүүдийг бол судалж үзээд хөрөнгө

оруулагчтайгаа бол хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үедээ тухайн үед бол ярьж тохиролцоно гэж бодож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Шинжээч Тэгшбаяр нэмж хариулья.

Н.Тэгшбаяр: Анар гишүүний асуултад хариулья. Анар гишүүний хэлж байгаа тэр ослын үеийн мөнгийг бол тухайн үед нь шийдээд байршуулах боломжтой. Энэ бол бас харьцангуй энэ төслийн нийт зардалтай харьцуулахад бага мөнгө байдаг. Харин тэр нөхөн сэргээлттэй холбоотойг бол жишээлбэл дэлхийн энэ өндөр хэмжээний банканд баталгаа гаргуулаад, хэрвээ хийхгүй бол тэрүүгээр нь хариуцлага тооцох ийм юмыг бол сая Хэрэг эрхлэхийн дарга хэлсэн чиглэлээр хийх юм бол хөрөнгө оруулагчдад эрсдэл багатай. Энэ ганцхан энэ Бадрах Энержигийн тухай биш, бусад хөрөнгө оруулагчид бол эрсдэл багатай ийм юм байгаа юм. Тэгэхгүйгээр түрүүлээд бүх мөнгөө авчих юм бол жишээлбэл 1 тэрбум гаруй доллар оруулах ёстой байтал 300 саяыг авчих юм бол энэ чинь төслийг хойшлуулах нөхцөл үүсэх учраас таны хэлж байгаа бол Учрал дарга та 2 бол яг зөв ойлголцож байна гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ төслийг хэлэлцэх эсэхийг ярилцаж байгаа учраас зарим нэг зүйлүүдийг хэлмээр байна. Мэдээж нарийн заалтуудыг бол хэлэлцүүлгийн шатанд ярилцаад явна биз дээ. Тайлбар, хариултуудаас сонслоо. Өмнөх Оюутолгойн гэрээний алдааг давтахгүй байх асуудлыг нэлээн ярьж байна. Энэ сургамж дээрээ үндэслэж алдаа гаргахгүй байх нь мэдээж зүйтэй. Гэхдээ аливаа төсөл 2 талтай байдаг. Сөрөг болоод давуу тал. Мэдээж Монгол тал авах татвар юмаа бол авах нь зайлшгүй эдийн засгийн үр ашиг талаасаа, нөгөө талаасаа байгаль орчин, амьтан, хөрс ургамал, газар шороо, тэгээд хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд баталгаа юу байгаа юм бэ. Дүгнэлтүүд гарсан байгаа байх. Яг өнөөдөр одоо баталгаатай аюулгүй гэж бүрэн дүүрэн хэлж чадах уу, үгүй юу. Хэний, хэзээ хийсэн дүгнэлтүүд байна. Энэ эдийн засгийн хувьд ашигтай юм байна. Тэгвэл энэ төслөөс гарах сөрөг үр дагавар гэж байна уу. Нэг ийм сөрөг үр дагавар байгаа юм, гарчих гээд байгаа юм гэвэл. өрөг үр дагавар байна уу, үгүй юу. Огт сөрөг үр дагаваргүй, маш сайн эдийн засгийн давуу талтай төсөл юм уу. Энийг нэг тодруулж өгөөч.

Энэ төслийг хэрэгжүүлэхэд ер нь бол анхдагч байх. Бэлтгэгдсэн боловсон хүчний нөөц ер нь манай улсад хэр юм бэ. Үндсэндээ бараг энэ ажлын хэсэг энэ зааланд сууж байгаа хүмүүс л боловсон хүчин байна уу, үгүй юу. Өөр мэргэжлийн боловсон хүчин ер нь энэ чиглэлийн хүмүүс хэр байдаг юм. Тэгээд гаднаас баахан хүмүүс ирдэг. Ажилладаг. Мэргэжилтэн боловсон хүчнүүдийг нь баахан л гаднынхан хийдэг. Цалин мөнгө өндөр цалин мөнгийг нь тэд нар авдаг. Манай монголчууд болохоор туслах ажлыг нь хийдэг. Хэд дахин бага цалин авдаг. Нөгөө Оюутолгойн гэрээний л бас нэг алдаа шүү дээ. Энэ дээр цаашдаа хэрвээ төсөл хэрэгжээд эхэлбэл яаж ажиллах юм. Ямар боловсон хүчинтэй байгаа юм. Нөгөө саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг шүү дээ.

Нөгөө талаар 3 дахь нь Монгол Улсын хүлээх үүрэг гэж юу байгаа вэ энэ төсөл дээр. Манай улсын өмнөх, олон жилийн өмнөх зээл тусламжийн асуудлууд дээр харж байхад манайх чинь бас л их хулхи юм шиг байна лээ шүү дээ. Ярьсан хэлсэндээ байдаггүй. Төр засаг нь байнга өөрчлөгдөж байдаг. Хууль тогтоомж нь тогтворгүй, өмнөх Засгийн газрынхаа ажлыг үгүйсгэдэг. Ингэсээр байгаад нөгөө хүлээх үүргээ бид нар хийж ирэхгүй байсаар байгаад хөрөнгө оруулагчдыг дайжуулах нэг үндэслэл чинь энэ шүү дээ. Итгэдэггүй. Энэ төсөл дээр манай талын хүлээх үүрэг гэж юу байгаа вэ гэсэн ийм 3 асуултад хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулья.

Н.Учрал: Байгаль орчинд үүсгэх эрсдэлийн үнэлгээний талаар бол түрүүн би хэлсэн. 2013 оноос хойш нэлээн л олон ажлын хэсэг ажилласан юм байна лээ. Тэгээд одоо эхний олборлолт хийгээд тэр дээжүүдээс шинжилгээ авсан гээд мэргэжлийн хүмүүсийн дүгнэлтүүдийг бол ажлын хэсэг дээр нэлээн олон удаа сонслоо. Дээрээс нь олон улсын бас хөндлөнгийн дүгнэлт гаргадаг энэ байгаль орчны чиглэлийн компаниуд бас нэлээдгүй ажилласан юм байна. Тэгээд ийм олон дүгнэлтүүдийг бол гаргасан юм байна лээ. Цаашдаа бол бид олон улсын зөвлөх үйлчилгээний компаниудтай бас ажлаа үргэлжлүүлнэ. Одоогийн байдлаар бас байгаль орчны чиглэлийн компанитай бол ажиллаж байгаа. Хууль, эрх зүй дээр ч гэсэн ер нь чиглэл чиглэлээрээ бол олон улсын зөвлөх үйлчилгээний компаниуд өнгөрсөн хугацаанд ажилласан энэ ажил үргэлжилнэ. Хууль батлагдвал хэлэлцээр дээрээ тэр зөвлөхүүдийн саналыг тусгаад явна.

Тэгээд Сандаг-Очир гишүүний бас их санаа зовниж байгаа зүйл бол яг үнэн. Жишээ нь Оюутолгойн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсэг Засгийн газраас байгуулагдсанаас хойш бол би энд ажиллаж л байна. Тэгээд ерөөсөө 1 зүйл маш их сэтгэл зовниж байгаа. Нийт ажиллагчийн 95, 96 хувь нь Монголчууд мөртөө авч байгаа цалингийн хэмжээ ямар вэ гэдэг дээр хүмүүс бол маш их эмзэглэж байгаа. Тийм ч учраас бид нар бол энэ хөрөнгө оруулалтын гэрээ өнгөрсөн хугацаанд ажлын хэсэг дээр яригдах үеэр бид бол ажиллах хүчний хувь хэмжээнээс илүү гадаад тооны иргэдийг ажиллуулах тохиолдолд сар бүр Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд төлбөр төлөх асуудлыг тусгана. Дээрээс нь Монгол ажилтнуудыг тодорхой хувийг бол яг энэ нутгийн Дорноговь аймгийн иргэдийг бүрдүүлэх асуудлыг бол ажлын хэсэг дээр бол тавьсан. Дээрээс нь төсөл хэрэгжүүлэгч болон туслан гүйцэтгэгч компанийн ажилтнуудын 90 хувиас доошгүй нь Монгол Улсын иргэд байх, сул ажлын байрны оронд тухайн ажилд ороход мэргэшсэн тохиромжтой ажил горилогч нь Монгол Улсын иргэн байх юм бол тэргүүн ээлжид авна гэдэг ийм шаардлагыг бол ажлын хэсэг дээр тавиад явж байгаа. Тийм учраас бол хүний нөөц бэлтгэх дээр бид онцгой анхаарах ёстой. Яах вэ, өнгөрсөн хугацаанд бас төсөл хэрэгжээд эхлээгүй, бүрэн эхлээгүй байсан учраас бол хүний нөөц бэлтгэх ажил бол бас тийм их өндөр түвшинд хийгдээгүй. Гэхдээ л нэг жилд 10 орчим шинэ ажлын байрыг бэлтгэх ажлыг бол Мон Атом-ынхан хийгээд л явсан. Тэгээд та цаашдаа энэ тоо ч гэсэн бол өргөжинө.

Манай улсын хүлээх үүрэг бол бид нар хууль, эрх зүйн орчныг тогтвортой байлгах, дээрээс нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулах орчныг нь тэр дундаа нөгөө мэдээж татварыг тодорхой хэмжээнд тогтворжуулах, хөрөнгө оруулагч нарыг тогтвортой эрх зүйн орчинд үйл ажиллагаа явуулах боломжийг бол хангах үүрэгтэй. Тийм учраас энэ гэрээг ч бай, хуулийг ч бай тал бүрээс нь яриад шийдэж өгөх ёстой.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон. “Мон-Атом”-ийн захирал Далайжаргал.

Д.Далайжаргал: Боловсон хүчний асуудлаар маш чухал асуудал хөндлөө. Францын төсөл 2003 онд анх ашиглалтын ажлын хайгуулын лиценз авахад тэрнээс хойш боловсон хүчнээ бэлдээд явсан. Өнгөрсөн хугацаанд 5 жилийн хугацаанд нийтдээ 77 орны 215 удаагийн тэтгэлгээр сургасан. ШУТИС дээр энэ хамтарсан тэтгэлэгт хөтөлбөр явуулаад тэнд хүмүүс сургаж байгаа. Яг одоо Орано групп Парисын Францад байгаа төвд Ораногийн хувьд 2 ажилтан тэнд ажиллаж байна. Францын хамгийн том төсөл Казахстанд байдаг. Казахстанд 2 геологич тэнд ажиллаад, 6 сараар 2, 2-оороо ээлжлээд явж байгаа. Төсөл хэрэгжихэд бол нийтдээ 1600 хүн ажилна гэхэд 14 хүн л гаднын хүмүүс байх юм. Бусад нь бол дандаа Монгол ажилчид байна. 2016 онд бид нар орд ашиглах гэрээ байгуулахад орд

ашиглах гэрээний дагуу нийт ажилчдын 90 хувь нь бол Монгол ажилчид байна гэж тийм гэрээтэй байгаа. Одоо ч 70 гаруй хүн ажиллаж байгаа гэхэд 1 л гадаадын хүн тэнд ажиллаж байгаа. Төсөл хэрэгжээд явахад бол нийтдээ энэ болсон хүчин, таны ярьж байгаа энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Манлайжав дарга нэмж хариулъя.

Г.Манлайжав: Сандаг-Очир гишүүний асуултад нэмж хариулъя. Та түрүүн асуулаа. Аюулгүй байдал үйл ажиллагаатай холбоотой. Ямар ч уул уурхай бол бас эрсдэлтэй. Тийм учраас бид нар байгаль орчныг хамгаалах, нийгмийн хүн амыг хамгаалах асуудлаар бүх үйл ажиллагаануудыг бол энэ хуулиудаараа зохицуулж хийж байгаа. Өнөөдөр орж ирж байгаа Цөмийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас энэ ашигт малтмал ашигладаг ААН-үүд ашиглалтад тавигдах шаардлага гээд бас 34.4 дүгээр зүйл дээр нэмэлт орж ирж байгаа. Энэ дээр цацрагийн хамгаалалтын хөтөлбөртэй байх ёстой асуудал гээд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх ёстой. Энэ хөтөлбөрийг бол улсын байцаагч батална. Хамгийн гол нь бол энэ хөтөлбөрт тусгагдах асуудлуудыг нь бид нар өнгөрсөн хугацаанд энэ цацрагийн хамгаалалт, аюулгүй байдалтай холбоотой нийтлэг, тэр тусмаа урантай холбоотой үйл ажиллагаа, хайгуул, олборлолтын үед хэрэгжүүлэх аюулгүй ажиллагааны дүрэм, хүдрийн хаягдлын менежментийн дүрэм, үндсэн гол гол дүрмүүддээ бол тусгаж өгсөн учраас энэ дүрэм журмын хэрэгжилтийг болхангуулах тэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Манай улсад нэн шаардлагатай байгаа, манай эдийн засгийг хөгжүүлэх, тэлэх ийм чухал төслийг Учрал сайд ахлаад, ажлын хэсэг нь маш сайн ажиллаад орж ирээд, өргөн барьж байгаад бол их сэтгэл хангалуун байна. Өнөөдрийг хүртэл цуг ажилласан, дэмжсэн бүх багийн гишүүдэд энэ хүртэл ирсэнд нь баяр хүргээд, цаашдаа бас илүү нарийн зүйлүүдийг нь тодорхой болгоод алдаагүйгээр, Оюутолгой шиг хэрүүл уруул болохгүйгээр энэ төслийг хэрэгжүүлээд яваасай гэж бодож байна.

Энэ дээр 2 асуулт байгаа юм. Манай улсын хөрөнгө оруулалт бизнесийн орчин ер нь бол тодорхой, ойлгомжтой, тогтвортой байх ёстой. Тэгээд яг одоогийн нөхцөл байдал бол гаднын хөрөнгө оруулалт гэлтгүй манай бизнес эрхлэгчдэд хүртэл төвөгтэй байдал үүсгээд байдаг. Ялангуяа ийм том төслүүд дээр эхнээсээ маргаангүйгээр ойлголцоод явах нь чухал учраас 2 асуулт асууя.

Эхнийх нь Байгаль орчны яам. Цөмийн энергийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлд байхгүй болохоор нь асууж байна. Байгаль орчны багц хуулийг хэзээ өргөн барих вэ. Одоогийн агуулгаас ер нь хэр өөрчлөгдөх вэ. Ялангуяа усны төлбөр болон хог хаягдлыг хэрхэн тооцож байгаа вэ. Төслийн агуулгад болохлоор газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл дунд зэрэг гэж заасан байна. Ус ашигласан эсвэл бохирдуулсан төлбөрийг цаашдаа хэрхэх юм бэ. Эртнээс тохирох ёстой болов уу гэж бодож байна.

Дараагийнх нь бага цацраг идэвхт хог хаягдал жилд 250 тонн гарна гэж байна. Нөгөө талдаа бас манай нутагт цөмийн хаягдал булшлахыг хориглоно гэхихсэн байгаа юм. Манайд булшлахгүй гэхээр одоо 2 хөрш рүүгээ гаргаж хаях юм уу, яах юм гэсэн нэг тийм асуудал үүсэх гээд байна. Эдгээрийг ер нь хэрхэх вэ гэдэг эхний асуулт.

2 дахь нь Эдийн засаг хөгжлийн яамнаас асуумаар байна. Үр өгөөж гэдэг дээр яг юу юуг тооцож байгаа юм бэ. Энэ биччихсэн байгаа АМНАТ энэ тэр гээд бүх төрлийн татвар юм уу, эсвэл ноогдол ашиг юм уу, тэрнээс өөр зүйл байгаа юм уу, үгүй юм уу. Үүнийгээ тодорхой зааж өгөөд хөрөнгө оруулагчдад ойлгомжтой болгохгүй бол яг гэрээ хэлэлцээр эхлээд эсвэл гэрээ байгуулаад төсөл эхлэх гээд ирэхээр гэнэт байгаль орчин нь хууль өөрчлөгдсөн. Төлбөр ондоо болно. Хог хаягдал дээр ийм асуудал үүснэ. Эсвэл нэмээд ийм татвар авна. Нэмж ийм төлбөр авахаар юм байна шүү гээд гэрээгээ хийснийхээ дараа ингээд нэг шантаажилж байгаа юм шиг тийм нөхцөл байдал үүсгэхээд байдаг. Оюутолгойн гэрээ бол ерөөсөө л тийм л зүйл болсон шүү дээ. Тэгэхээр эхнээсээ бид нар ингээд олон улсад Монгол Улсад хөрөнгө оруулалтыг таатай болгож байгаа шүү. Ойлгомжтой болгож байгаа шүү, тодорхой болгож байгаа шүү. Бид нар хэлснээсээ буцахгүй гэдэг тийм зүйлүүдийг нь ингээд эхний энэ бэлдэж байгаа энэ үе шатан дээрээ хийчихмээр байна гэсэн тийм тодорхой 2 асуултыг асууж байна.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Би хариулъя. Усны нарийвчилсан талаар манай усны газрын дарга хариулаарай. Байгаль орчны багц хуулийг бид нар энэ намрынхаар бол амжихгүй. Одоо шинээр бүх зүйл дээр санал аваад, хэлэлцүүлэг хийгээд бэлтгэлийн шатанд бол байж байна. Үзэл баримтлалаа удахгүй батлуулна. Хаврын чуулганаар бид энэ хуулийг батлуулахаар төлөвлөөд ажиллаж байгаа. Манай энэ удаагийн гэрээнд бид бидний бас нэг тохирч чадсан амжилт юу вэ гэхээр байгаль орчинтой холбоотой усны асуудал ч юм уу, ус бохирдуулсны төлбөр бүх л зүйлийг бол тухайн хуулийн хэрэгжиж байгаа үеийнхээр л тогтоно. Энийг бол наана нь тогтворжуулахгүй гэдэг ийм зүйлд яриа хэлцэлд хүрсэн. Энэ бол өөрөө их чухал. Тэгэхээр дараа Байгаль орчны хууль энэ гэрээ хийгдсэний дараа Байгаль орчны хууль батлагдаад л усны төлбөрийн хууль нэмэгдэхэд энэ 2 тал бол шууд энэ шинэчилсэн тухайн үеийнхээ мөрдөгдөж байгаагаар явна.

Усны нарийвчилсан юуг нь манай Усны газрын дарга 20 номерын микрофон.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Усны газрын дарга Батбаяр хариулна.

З.Батбаяр: Усны тухай хууль дээр түрүүн ярьсан 4 янзын төлбөр байгаа. Тэрний ус бохирдуулсны төлбөр маань байгальд нийлүүлж байгаа бохир усны найрлагаас хамаардаг учраас бид нар тэр найрлагынх нь байдлаар нь стандартаараа шахаад явчих боломжтой. Ус ашигласны төлбөр маань 3 үндсэн зүйлээс хамаарсан байгаа. Одоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль дээр усны экологи эдийн засгийн үнэлгээний дээд, доод хязгаараар нь тогтоогоод өгчихсөн байгаа учраас энэ дотроо хөдөлгөөд байх бүрэн боломжтой. Экологи, эдийн засгийн үнэлгээ дээр харин өөрчлөлт хийх шаардлага байгаа. Тэр нь 2013 онд экологи, эдийн засгийн үнэлгээ батлагдсан. Одоо хүртэл 11 жилийн хугацаанд өөрчлөгдөөгүй учраас энэ дээр усны газраас ажиллаж байна. Цаашдаа бол усны үнэлгээг бодитой буюу үнэлэмжийг нь нэмэгдүүлэх тал руу анхаарна. Магадгүй энэ төсөл хэрэгжиж дуусах 44 жилийн хугацаанд магадгүй шинэ усны төлбөрүүдийн тухай асуудлууд ч гэсэн яригдах байх. Тэгэхээр энэ бүгдийг сая сайдын хэлснээр тогтворжуулахгүйгээр авч үлдсэн учраас бид энэ бүх боломжоо Улсын Их Хурал дээрээ хууль тогтоогч болон Засгийн газар дээрээ энэ эрхээ авч үлдсэн нь давуу тал болж байгаа юм гэж.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Манлайжав дарга нэмж хариулна.

Г.Манлайжав: Гишүүний асуулт нэмж хариулъя. Бага цацраг идэвхт хог хаягдлын асуудлаар асуудал ярилаа. Тэгэхээр бид нар бол цөмийн тухай хуульд нэмэлтээр орж ирж байгаа өөрчлөлттэй зөвхөн гадаад улсын цацраг идэвхт хаягдал гэж ярьж байгаа. Гадаад улсын цацраг идэвхт хаягдал. Тэгээд ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын газар нутаг булшлахыг хориглоно гэж. Тэгэхээр бид нар бол Монгол улсад үүсэж байгаа ямарваа нэгэн цацрагтай холбоотой үйл ажиллагаа бас үүсэх хаягдлуудыг бол бид нар өөрсдөө энд хаягдлын менежментийг зохицуулна.

Дорноговь аймгийн Улаанбадрах суманд хэрэгжих энэ ураны төслийн хувьд ч гэсэн аж ахуйн нэгж маань өөрийнхөө талбай дээрээ энэ хаягдлын менежментийг явуулах юм. Үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хийж өгсөн. Цөмийн төхөөрөмж холбоотой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Монгол Улсын Засгийн газар баталсан. Мөн хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн дүрмийг цөмийн комисс баталсан. Тэгэхээр энэ дүрэм журмуудын хүрээнд бол аж ахуйн нэгж аюулгүй ажиллагааг хангаж ажиллуулна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн хөгжлийн яамнаас үр өгөөжтэй холбоотой асуудлаар хэн хариулт өгөх вэ. Энэ яг нөгөө гэрээний асуудал яригдаагүй учраас гэрээний үр өгөөжийг шууд ярихад бол эрт байгаа. Үндсэн хуулиар үр өгөөжийн дийлэнх нь Монголын талд байх ёстой гэдэг үндсэн зарчим барьж, гэрээ байгуулагдах ажил бол хийгдэж байгаа. Мэдээж тэр бол 50 дээр нэмэх 1 хувийн өгөөж Монголчуудад оногдож байж энэ гэрээ хийгдэнэ гэсэн ийм зарчим бол явж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Усны асуудал сая энэ хог хаягдлын төлбөрийн асуудал жишээ нь шинэ усны төлбөрийн асуудал яригдана гээд тэгж байна шүү дээ. Гэрээ хийж, хэлэлцэж байх үед ч байдаг юм уу, хийснийхээ дараа дахиад энийгээ нээрээ мэдээж энэ төлбөрөө авах юм байна шүү дээ гээд ороод ирэхээр ялангуяа энэ гүнээс олборлож байгаа ийм уурхайнууд чинь маш том хэрүүл болдог болохоор тэрийг л хэлээд байгаа юм л даа. Хэрвээ ингээд үзэл баримтлалаа батлаад батлуулах гээд явж байгаа бол яг энэ хэлэлцээрийн шатад орохоосоо өмнө гаднын жишгүүд ямар байдаг юм бэ. Ер нь бид нар хамгийн ихдээ хэр ихийг авах боломжтой юм бэ. Эсвэл авахаар төлөвлөж байгаа юм бэ. Тийм хүрээгээ тодорхой болгож өгөхгүй бол дахиад л нэг хүмүүс нь гарч ирээд л манай улс бохирдчихлоо яалаа ийлээ гээд тэгээд хэрүүл болоод явахаар манай ийм том төслүүд чинь гацчихаад байгаа. Тэрэндээ байгаа болохоор тэр дээр нямбай хандаасай. Тэрийг хийх үү гэсэн тодорхой асууж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Усны газрын дарга Батбаяр тодруулж хариулъя.

З.Батбаяр: Баярлалаа. Боломжоо авч үлдэж байгаа тухай түрүүн хариулсан. Ерөнхийдөө дэлхийн улс орнуудын жишгийг аваад үзэх юм бол 5 төрлийн усны төлбөртэй байдаг. Тэр 5 төрлийн усны төлбөрийн 4-ийг нь Монгол Улсад хуульчилчихсан. Бидний хэрэгжүүлж чадахгүй байгаа усны төлбөр бол ус хомсдуулсны төлбөр байгаа. Хамгийн чухал төлбөр болсон эхэн дээр нь буюу ус ашиглаж байх үеийн ус ашиглалтын төлбөр, байгальд нийлүүлэх үеийн ус бохирдуулсны төлбөр маань явчихсан. Тогтоогдчихсон дээд доод хязгаарыг нь тогтоочихсон учраас одоо бидний хамгийн чухал ажил бол хэрэгжүүлж хүн болгоноос авч сурах, ус ашиглалтын төлбөрийг, ус ашигласны төлбөрийг ус бохирдуулсны төлбөрийг болохоор найрлагын тухай асуудлуудыг нь стандартаар шахаад

явчих боломжтой учраас гишүүний санаа зовнилд нь бүрэн санал нийлж байна. Гэхдээ энэ нь хууль зүйн үүднээсээ гэхээсээ илүү стандартаар техникийн бичиг баримтуудаараа шахаад явах боломжтой. Энийг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байгаа. Түрүүн ярьсан мониторингийн хяналт хийнэ гэдэг маань бол үүнтэй зайлшгүй холбоотой.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон. Нэмэлт хариулт өгье.

Н.Жамьянхүү: Гишүүний асуултад бас нэмээд хариулья. Нөгөө үр өгөөж болон цаашдаа бас энэ хуульд орчихсон өөрчлөлтүүд бол энэ төслүүдэд бас нөлөөлөх үү гэдэг асуудал дээр. Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т бол нөгөө үр өгөөжийн дийлэнх нь бол ард түмэнд байна гэсэн ийм гол зарчим батлагдсан. Тэгэхээр тухайн үеийн Үндсэн хуулийг хэлэлцэж байх явцад бол энэ үр өгөөж гэдгийг ямар байх ёстой юм бэ гэдгийг бол энэ хуулийн протоколд бол оруулсан байгаа. Тэгэхээр энэ төслийн явцад бол энэ гэрээ, эрх зүйн ажлын хэсэг гэж байгуулагдсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан. Тэгэхээр энэ ажлын хэсгээс бол яг энэ Үндсэн хуулийг хэлэлцэж байх явц дахь энэ протоколыг баримтлаад бол үр өгөөж гэдэг нь ерөөсөө татвар байх юм. 2 дугаарт нь АМНАТ байх юм. АМНАТ дээр нь нэмэх нь ноогдол ашиг байх юм гэдэг ийм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Одоо 25 жилийн дараа 2050 оноор хараалж Монгол Улс хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөгөө батлаад явж байгаа. Тэгэхээр 25 жилийн дараа дэлхий дахинд тулгарах 3 том сорилтын 1 нь өөрөө эрчим хүчний хомсдол, 2-т нь ундны усны хомсдол, 3 дугаарт нь хоол хүнс, тэжээлийн хомсдол болно гэж. Тэгэхээр ер нь бол дэлхий нийт, бүс нутаг, хүн төрөлхтний өмнө тулгамдаж байгаа урт хугацааны сорилтод бэлэн байх, түүн рүү чиглэсэн стратегийн ач холбогдолтой хуулиудыг бид нар одоогоос ярихгүй бол хоцрох төлөвтэй болно. Тэр утгаараа агуулгын хувьд бол төслийг дэмжиж байгаа.

2 дугаарт гуравдагч орны хөрөнгө оруулалтыг бас татах нь өөрөө Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, энэ ардчилыг бэхжүүлэх үйлстэй шууд холбоотой учраас дэмжиж байгаа.

3 дугаарт нь бол нэг зүйл байгаа. Энэ дээр Их Хурлын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүний хувьд бас хариулбал сайн байна. Юу гэхээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлж нийцэж буй асуудлаар эсэх дээр энэ дээр шинжилгээ хийж байгаа юу. Судалгаа хийж байгаа юу. Дүгнэлт гаргаж байгаа юу. Яаралтай горимоор оруулж ирж байгаагийн шалтгаан нь бол эдийн засгийн үр өгөөж, тэгээд дагаж орж ирэх төслүүдтэй холбоотой асуултауд гараад байгаа юм. Тэгэхээр яг энэ дээр бол бид нар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын аюулгүй байдал, Монгол хүний аюулгүй байдал, тэгээд энд хамаарах бүх л төрлийн аюулгүй байдлын асуудал дээр энэ хуулийн төсөл маань хэр зэрэг нийцэж байгаа талаарх дүгнэлт чухал байна.

4 дүгээрт яаралтай горимоор оруулж ирж байгаа энэ асуудал нь өөрөө маш их эргэлзээ төрүүлж байгаа. Яагаад гэхээр хууль ба гэрээ хоёроо ялахгүй. Үүнээс болоод хэдий чинээ мэдээллийн дутмаг байдал байна. Төдий чинээ иргэдийн эсэргүүцэл мушгин гуйвуулалтай тулгарна. Эндээс үүдээд нөгөө хайран стратегийн ач холбогдолтой хууль, хайран төсөл нь эргээд улс төржилт, магадгүй гаднын орнуудын зохион байгуулалттай ч гэдэг юм уу ямар нэгэн социал тархи угаалтад өртөөд, нэрвэгдээд ач холбогдолгүй болох эрсдэлтэй шүү. Тийм учраас энэ яарвал даарна, 7 хэмжиж 1 огтол, бушуу туулай эд нар гээд Монгол үг байгаа шүү дээ. Энэ утгаараа бол тэр яарч байгаа үндэслэл нь зөвхөн эдийн засгийн ач

холбогдол талаасаа гадна ийм ийм зүйл юм гэдэг тал дээр нь бас манай энэ ажлын хэсгийнхэн эд нар маш сайн мэдээлэл өгөх ёстой байгаад байгаа юм.

Тэгээд энэ 27 жилийн туршид ярьж байна гэж байгаа юм. 27 жилийн туршид ярихдаа бид нар тэр болгон томруулдаг шилээр энэ асуудлыг хараагүй. 1997 онд сошиал медиа байгаагүй. 2012, 2013 оны үед энэ асуудал яригдаж байхад бас 10 жилийн өмнө 2014 онд энэ асуудал яригдаж байхад олон нийтийн өргөн хэлэлцүүлэг болоогүй, дээрээс нь тэр ажлын хэсгийн гишүүн хэлж байна. 3 мянган хүнд тэр газрыг очиж үзүүлсэн эд нар гээд. Тэгээд 3 сая 500 мянган хүний 3 мянган хүн гэдэг бол хүн амын хэчнээн ч хувь юм. Тэгээд энэ нөгөө мэдээллийн дутам байдлаасаа болоод хангалттай иргэдэд ойлголт өгөхгүй байгаагаасаа болоод маш их буруу ойлготол мушгин гуйвалт явагдана. Байтугай Их Хурлын гишүүд хүртэл яаралтай горимоор орж ирээд, бид нар чинь танилцаад удаагүй байгаа. Тэгээд бид нар экспертүүд бол биш. Тэр мэдэхгүй юмаараа бол хүн бас нэг их мэдэгдэл хийгээд, улс төржөөд байх шаардлагагүй. Тэр утгаараа энэ Монгол Улсын стратегийн ач холбогдолтой төсөл дээр бол түрүүн Сайнхүүгийн Ганбаатар гишүүний хэлсэнчлэн мөн бас Сайнзориг гишүүний хэлсэнчлэн бас энэ олон нийтийг мэдээлэлжүүлэх хөндлөнгийн экспертүүд эд нар гэдэг зүйл дээр бас анхаармаар байгаа юм.

Тэгэхээр манай улсын хувьд түрүүний ярианаас харлаа. 30-40 хүн болбол экспертийн түвшинд бэлтгэгдээд явж байгаа юм байна гэж. Тэгээд энэ бол яаралтай гэдэг асуудлаа арай жоохон зөөллөөд, арай жоохон хугацаа цаг аваад, иргэд олон нийтийг мэдээлэлжүүлээд Их Хурлын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулъя. Тэрнээс өмнө Засгийн газар хуралдаанаа хийгээд бас Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг нэн яаралтай горимоор хэлэлцэж өгөх санал ирсэн. Тэгээд үүнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын нийт гишүүд яаралтай хэлэлцэх асуудлаар санал хурааж, олонхын шийдвэрээр яаралтай хэлэлцээд явж байгаа. Ер нь бол Засгийн газраас барьж байгаа зарчмыг бол би зөв гэж үзэж байгаа. Эрх зүйн орчноо тодорхой болгоё. Түүндээ нийцсэн гэрээ хэлцлийг үргэлжлүүлбэ л гэж байгаа юм. Гэрээ бол эцэслэн хийгдчихсэн зүйл байхгүй. Гэрээ нь яриа хэлэлцээрийн түвшинд бүх ажил явагдаж байгаа. Тэгээд энэ гэрээгээ хуульдаа нийцүүлж хийх үүднээс нэн яаралтай горимоор хэлэлцэж өгөөч гэдэг асуудал ярьсан байх гэж ингэж үзэж байгаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зүгээс энэ Ораногийн төсөлтэй холбоотой цөмийн, ураны төслүүдийг Монгол Улсад хэрэгжүүлэх чиглэлтэй холбоотой асуудлаар бол сонссон байгаа. Харшилж байгаа зүйл бол байхгүй. Мэдээж энэ олборлолтын үйл ажиллагаа байгальд, хүнд ээлтэй хэлбэрээр явагдах ёстой л гэсэн үндсэн зарчим байж байгаа юм. Монгол Улсад эдийн засгийн төрлөө төрөлжүүлэх томоохон бодлогыг сүүлийн жилүүдэд хэрэглэж ирсэн. Дан уул уурхай голлож байна гэж үздэг. Уул уурхай дотроо өнөөдөр ганц нүүрс голлоод байна. Тэгэхээр энэ уул уурхайгаа бас төрөлжүүлэх. Олон улсын зах зээл дээр үнэ нь өсөж байгаа ураныг эргэлтэд оруулах чиглэл дээр ер нь Монгол Улс эдийн засгийн бодлогынхоо хувьд үр ашигтай гэж үзэж, энэ асуудалд анхаарах нь зөв юм. Ялангуяа сүүлийн жилүүдэд хурцадмал байдалтай холбоотой асуудлаар ураны үнэ өөрөө дэлхийн зах зээл дээр ойрын жилүүдэд огцом өсөх боломж нөхцөл бүрдэж байна. Тийм учраас энэ боломжийг Монгол Улс алдахгүй ашиглах нь зөв юм гэсэн ийм бодлого тайлбарууд бас энд хийгдэж явдаг гэдгийг бас хэлье.

Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм хэлэлцээний үед Монгол талд аль нь илүү ашигтай байх вэ гээд өмнө нь бас ажлын хэсгийн ахлагч нар, хөрөнгө оруулагч талдаа нэлээдгүй л яриа хэлцэл өрнүүлсэн. Мэдээж хөрөнгө оруулагч талд бол өнөөдрийн байгаа эрх зүйн орчин дээр хэлэлцээ хийгээд явчих нь ашигтай. Гэтэл бид нар тоглоомын дүрмээ тодорхой болгоогүйгээр хэлэлцээ хийгээд байх нь өөрөө Монгол талд ашигтай юу, үгүй юу гэдэг дээр дүгнэлт хийх ёстой. 2023 оны 10 сард Монгол Улсын Ерөнхийлөгч Францад айлчлах үеэр тэр протоколд гарын үсэг “Мон Атом” компани эд нар зурсан. Түүн дээр анх удаа Монгол талд ашигтай байх ийм хэлэлцээ байж болох юм гэдэг ийм үндэслэл тавигдчихсан. Гэтэл байгаа хуулиа харсан чинь АМНАТ-ийн босготой, өсөн нэмэгдэх АМНАТ-ийн зохицуулалт байхгүй. Байгаль орчны үнэлгээгээ хийх, тэр нөгөө уурхайн хаалтын төлөвлөгөө хийх хариуцлага нь тодорхойгүй ийм байгаад байсан. Тэгээд цаашдаа яаж хэлэлцээ үргэлжлэх вэ цаашдаа. Тэгээд бид нар эхлээд хууль, эрх зүйн орчноо тодорхой болгоод, үүн дээрээ нийцсэн хэлэлцээгээ үргэлжлүүлээд гэрээгээ Их Хуралд барьчихвал энэ өөрөө хамгийн сайн туршлага болно. Тэрнээс биш ажлын хэсгийн үеэр бол зарим гишүүд эд нар бол бас хэлж л байсан л даа. Гэрээгээ давхар хуультай нь оруулаад ингээд хэлэлцээд явахад яадаг юм бэ. Бид нар энэ буруу жишгээс бол татгалзах ёстой. Тийм учраас хуулиа батлаад, хуульдаа нийцсэн хэлэлцээ хийгээд, тэгээд хуульдаа нийцсэн гэрээгээ оруулж ирээд ингээд хамтдаа шийдээд явах ёстой. Тэр Засгийн газар 14 мега төслийг үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгасан. Парламентын сонгуулийн дараа хамтарсан Засгийн газар байгуулсан. Хамтарсан Засгийн газрын хамгийн гол зорилт юу юм бэ гэхээр энэ олон жил энэ хийрхэлээс болж энэ улс төржилтөөс болж гацсан эдийн засгийг тэлэх боломжтой төслүүдээ урагшлуулъя л гэж хамтарсан шүү дээ. Тийм л учраас энэ асуудлаа хамтраад зориг гаргаад шийдвэрлье. Зөвшилцлөөр шийдвэрлэе. Тийм ч учраас өнгөрсөн парламентын үеэр Баялгийн сангийн хуулийг улс төрийн намууд хамтраад баталсан. Зарчмынхаа хувьд нэгдье гээд. Түүн шиг энэ 14 мега төслийг явуулах хүрээндээ цаашдаа зөв жишиг болох үүднээсээ бид энэ хуулиа баталъя гээд энийг бол яаралтай горимоор өргөн мэдүүлж байгаа. Тэгээд цаг алдах бол бид нарт эрх бас байхгүй. Одоо үнэхээр 27 жил хэлэлцсэн нь үнэн шүү дээ. Тэгээд ирэх жилүүдээс ураны үнэ улам өсөөд байдаг. Бид дэлхийн тоглоом, дэлхийн эдийн засгаас хоцроод байдаг. Тэгээд өсөлтөө хөгжил гээд андуурчихсан. Өсөлт чинь яаж хөгжил болжбуух юм бэ. Яаж нэмүү өртөг шингэх юм бэ. Яаж ард түмний амьжиргаанд энэ эдийн засгийн өсөлт чинь очих юм бэ гэдэг асуудлаа шийдэж чадаагүй. Тийм учраас хамтдаа цаг алдалгүй шийдье л гэдэг зорилго бид өвөрлөж байна.

Д.Амарбаясгалан: Болсон тийм ээ.Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Монгол Улс энэ дэлхий нийтийн гишүүн ингэж байхад мэдээж 3 дахь улсын хөрөнгө оруулалт бол маш чухал. Тийм болохоор энэ гэрээ дараа нь нэгдэнэ. Хууль дээр нь өөрчлөлтийг бол бид нар их нухацтайхарж үзэх хэрэгтэй л дээ. Гэхдээ төөрөөд байна. Оршил дээрээ бас ингээд цөмийн эрчим хүч, цахилгаан станц энэ тэр гээд биччихсэн. Яг энэ санал дээр бол цахилгаан эрчим хүч, дулааны үйлдвэрлэлтэй холбоотой юу ч байхгүй. Тэгэхээр энийгээ ингээд тусад нь болгочихмоор байна. Хиймэл дагуул цөмийн юутай холбоотой ч юм шиг, үгүй ч юм шиг бас нэг байна. Тэр бас ингээд тусдаа. Тэгэхээр яг асуудал руугаа ормоор байгаа юм. Тэр француудын бас ярьдаг нөгөө агаарын дүүжин тээвэр бол бүр тусдаа.

Тэгээд асуулт байна. 1 дүгээрт нь Монгол Улсын Цөмийн эрчим хүчний тухай хуулийн 6-д хэмжээнээс үл хамаараад стратегийн орд, Ашигт малтмалын хуулийн 5 дугаар зүйлд стратегийн ордын хувьцааны 34-өөс ихийг 1 этгээд дангаараа юм уу, хамаатантайгаа нийлээд ашиглаж болохгүй гэж байгаа юм. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалт хийх гээд энэ

яригдаж байгаа тохиолдолд цөмийн эрчим хүчний цацраг идэвхт бодис чинь өөрөө стратегийн орд. Та мөнгөө оруулж ашиглалтаа явуул тэгэхдээ 34-өөс илүүг эзэмшихгүй шүү гэж бид нар хэлж байгаа байхгүй юу энэ хуулиар. Тэгэхээр ажлын хэсэг та бүхэн энэ дээр суусан уу. Энийг яаж зохицуулах гэж байгаа вэ. Эсвэл энийг энэ чигээр нь орхиод Цөмийн эрчим хүчний тухай хууль нь тусдаа ингээд явах юм уу. Үлдээсэн тохиолдолд хөрөнгө оруулалт нь 34-өөр хязгаарлагдах гэж байна. Тэгэхээр нөгөөдүүл чинь орж ирэх юм уу.

Энэ сонгуулийн өмнө гэнэт Ашигт малтмалын хуульд сонин заалтууд оруулаад ирчихсэн. Одоо тэр 34 хувийг төр үнэгүй эзэмшинэ. Тэгэхдээ АМНАТ-аараа тооцож болно. Түрүүн бас энэ төслийн хувьд бол 34-ийг эзэмших гэхээр нэлээн их хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаад байгаа учраас 10 болгосон гээд. Тэгэхээр бид нар энэ үнэгүй юм уу, үнэтэй юм уу. Ер нь энэ зохицуулалт нь их тодорхой биш байгаа. Энийг зүгээр давхар дараа бид анхаарчих хэрэгтэй байх.

2 дахь асуулт нь нөөцийн төлбөр 5 хувь. 34-өөсөө татгалзаад 5 хувь нэмэх талаар анхан шатын хэлэлцээр явсан байгаа гэж ойлгосон. Тэгэхдээ энэ бол гэрээ хийгдээгүй. Одоо тэрийг бол бид нар хэдээр ч тохирч бас магадгүй. 1-5 хувь мэдэхгүй байна. Өсөн нэмэгдэх энэ хуулийн төслөөр 1-9 хувь. Ингээд бүгдийг нь нийлүүлэх юм бол 5-19 хувь хүртэл нөөцийн төлбөр байх нь. Энэ бол маш том интервал. Энэ хооронд хаана нь яаж тохирох вэ гэдэг нь тухайн төсөл, тухайн үеийн нөхцөл байдлаас хамаараад ингэнэ. Тэгэхээр ингэж ч болно, тэгж ч болно гэдэг юм бол улс төрчид их бага хэмжээгээр нөлөөлөлд автдаг, орон зайгаар нь тэнд нь алдаа гаргах магадлал ихтэй. Тэгэхээр энийг илүү тодорхой болгочхож болохгүй юм уу. Одоо жишээ нь тэр 34 хувийг өгөөд, АМНАТ-аа оронд нь нэмээд байгаа ч юм шиг. Тэгж байхаар зүгээр АМНАТ-ийг өндөр тавьчихаж болохгүй юм уу. Казахстаны жишээг би харлаа л даа. 4-18 хувь байна. 500 тонн бол 4 хувь, 4 мянган тонноос дээш бол 18 хувь. Монголд энэ 6 мянга гэдэг чинь бол тэр том руу нь орж байгаа гэсэн үг. Тэгэхээр эд нар чинь бол ингээд зүгээр тодорхой тавьчихаж байна. Тэгээд бид нар ингээд л хэлэлцээр хийгээд л сольж холиод л ингээд тодорхой биш юмандаа өөрсдөө дараа нь ийм орооцолдсон алдаатай юм гарах вий дээ гэсэн ийм юу байна.

Тэгээд дүгнээд хэлэхэд ер нь энэ Ашигт малтмалын тухай хууль дээр байдаг тэр өөрчлөлт өөрөө тайлбарлахад хэцүү, тодорхойгүй. Би бол энийг их бүдүүлэг алдаа гэж үздэг юм. Энэ салбарын хүмүүс нь одоо болтол ойлгодоггүй. Тэр дээр тулгуурлаад, тэрнээс эш татаж байгаад энэ хуульдаа өөрчлөлт оруулахаар бас нэг тийм барьцгүй яаж ч өөрчлөгдөж болох явцын дунд алдаа гарч ирэх юм болчих вий. Ийм 2 асуулт байна. Тэгээд ажлын хэсэг үүн дээр анхаарч ажиллана биз дээ гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Хууль, эрх зүйн орчин бол бас хэлэлцээ хийхэд Монголын талд яаж ашигтай хийж болох вэ гэдэг ийм эрх зүйн орчныг л бүрдүүлж өгөх ёстой. Тэрнээс биш хатуу, тухайлан зааж өгөх нь бас тийм зохимжтой биш. Яагаад гэхээр Цөмийн энергийн хууль батлагдсанаараа зөвхөн Монгол Францын хамтарсан ураны төсөл хэрэгжих гээд байгаа зүйл биш. Цаашдаа энэ салбарт олон төсөл хөтөлбөр хэрэгжих байх. Бас гадна дотнын хөрөнгө оруулагч нар ирэх байх гэдэг бид нарт хүлээлт байгаа. Эхнээсээ бас тусгай зөвшөөрөл эзэмшээд явж байгаа хүмүүс ч байдаг л юм байна шүү дээ. Тэгэхээр энэ хууль дээр болохоор яг таны хэлж байгаа тэр Ашигт малтмалын хууль дээр дурдсан төрийн эзэмшлийн хувь хэмжээг АМНАТ-аар оруулах эрх зүйн орчныг л энэ хуулиараа л нээж байгаа юм. Тэрнээс биш энэ хуульд тийм ойлголт байгаагүй. Гэхдээ төрийн эзэмшлийн 34-ийг АМНАТ-аар орлуулах уу, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах уу, магадгүй төр хөрөнгө

оруулалт хийгээд бүр илүү их хувиа ч эзэмших үү энэ тэр гэдэг бол бас л хуулиараа чөлөөтэй нээлттэй л болчихно гэсэн үг. Тэгэхээр төсөл болгон дээр бол мэдээж өөрөөр яригдана. Тэгэхдээ 1 зүйл маш тодорхой. Энэ юу вэ гэхээр суурь АМНАТ бол 5 бол авдгаараа авна. Тусгай АМНАТ-ийн хувь хэмжээ бол бас дээшээ хэд ч байж болно. Дээрээс нь өсөн нэмэгдэх АМНАТ-ийг бол харин үнэ өссөн тохиолдолд яах вэ гэдгийг нь ингээд 0-9 гээд үнийн дүн 80-90 байгаа тохиолдолд бол 4 хувь, 90-100 байгаа тохиолдолд 5 хувь гээд заачихаар магадгүй ураны үнэ ирээдүйд уналаа гэвэл тэр өсөн нэмэгдэх АМНАТ адилхан буураад явдаг. Энэ бол шударга зарчим. Энэ бол нэг талаасаа хөрөнгө оруулагч талдаа ч гэсэн бас нээлттэй ийм орчин бол бүрдэж байгаа гэсэн үг.

Тийм ч учраас ер нь болбол энэ төрийн эзэмшлийн хувь хэмжээг АМНАТ, бүтээгдэхүүн хуваах бүх төрлөөр орлуулах, тусгай АМНАТ-ийн хувь хэмжээ хэд байх вэ гэдэг асуудлыг бол шийдэх эрх нь бол хаана байна вэ гэвэл Их Хуралд хадгалагдаж байгаа юм. Тэгэхээр нөгөө гэрээ орж ирэхдээ Их Хурлын тогтоол хамтатгаж оруулж ирээд зөвшилцөөд, хэлэлцээ бол ингэж хийгдсэн. Энэ хэлбэрээр байж болох уу гээд тогтоол дээрээ тусгай оруулаад ирнэ. Үүнийг нь Их Хурал хэлэлцээд шийдвэрлэнэ гэсэн үг. Тэгэхээр үүнийг нээхгүй бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх үү. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн дарга нэмж хариулт өгье. Ажлын хэсгийн микрофон. 18.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Золжаргал гишүүний асуултад хариулъя. АМНАТ-ийн хувьд бол бид Ашигт малтмалын хуулиар биш Цөмийн энергийн хуулиар яг энэ цөмийн энергитэй холбоотой харилцаагаа яг ингээд точный оруулаад ирж байгаа. Таны хэлж байгаа Ашигт малтмалын хуульд байгаа маш олон төрлийн цөмийн энергитэй холбоо хамааралгүй зохицуулалтууд байдаг. Тэгэхээр энэ хууль дээрээ бид нар яг ийм тодорхой татвар ногдох зүйл, төлбөр төлөгч нь хэн байх, ногдуулах, төлөх, тайлагнах гэхээр энэ харилцаагаа маш тодорхой оруулж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт Учрал сайдын хэлснээр бол бид үндсэн АМНАТ-ийн хувьд 5 хувиа авна. Дээрээс нь өсөн нэмэгдэх нэмэлт төлбөрөө бол бид нар 9 хүртэл бол тохирч чадсан. Урьдчилсан байдлаар бол бид тусгаар роялтиг бол 5 хувиар ингээд тохирчихсон байгаа. Яг эдгээрийг зөвхөн АМНАТ-ийн хувь хэмжээгээр үзэхэд одоо бид нарын одоогийн байдлаар урьдчилсан байдлаар тохирсон байгаа энэ хувь хэмжээ бол дэлхийд хамгийн өндөр. Яг одоогийн үнийн түвшин дээр бол 15 орчим хувийн АМНАТ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Нөгөө уран тордоод байгаа Дорноговь аймгийн ураны мах иддэг гишүүн байна. 10-аад жилийн өмнө аймгийн Иргэдийн Хурлын дарга байхдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл аваад, Арива компанийн урилгаар Франц улсад томилолтоор ажиллаад тэгээд Шилэн Цогоо тэргүүтэй нөхдүүдэд цоллуулж байсан нөхөр байна. 10-аад жилийн дараа бас иргэдийн хандлага арай өөр болоод, Засгийн газар бас энэ хуулийг яаралтай горимоор Улсын Их Хуралд хэлэлцүүлж байгаад талархаж байна. Бас 10 жил гэдэг их хугацаа шүү. Ер нь гэхдээ цаашдаа манай улс төрд явж байгаа хүмүүс бас тийм ад үзэгдэх эр зоригтой байвал зүгээр юм шиг байгаа юм. Хуулийг бол зарчмын хувьд нь дэмжиж байгаа. 2009 оны энэ 7 сарын 16-нд батлагдсан Цөмийн энергийн тухай хуульд бол хөрөнгө оруулалттай, татвар АМНАТ-тай холбоотой ер нь бас зарим зохицуулалт нэн шаардлагатай байгаа учраас энэ хуулийг оруулж ирсэн гэж бодож байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас 1 ерөнхий асуулт байна. Та бүхэн санхүүгийнхээ ач холбогдлын хувьд энийг эрэмбэлж байна уу. Стратегийн ач холбогдлынх нь хувьд 1 дүгээрт эрэмбэлж байна уу. Бид Оюутолгой дээр яах вэ хөрөнгө оруулалтын тухай төсөл яригдаагүй байгаа ч гэсэн Оюутолгой дээр хөрөнгө оруулалтынхаа гэрээ дээр алдчихаад, сүүлд нь эдийн засаг яах вэ үндэсний эрх ашиг чухал гээд ингээд булзаараад байдаг шүү.

2 дахь нь хуулийн төсөлтэй холбоотой. Хуулийн төслийн 4.9.1.10 дээр цацраг идэвхт ашигт малтмалын орд талбайн хилийн заагийг тогтоох тухай заалт байна. Энэ хилийн заагийг хэн яаж тогтоох юм. Тэр бүс нутагт ажиллаж амьдарч байгаа ард иргэд малчдын эрх ашиг хөндөгдөх үү. Уул уурхайн нөлөөллийн бүс шиг хэл ам, хэрүүл маргаан дагуулсан зүйл болох юм биш биз дээ гэдэг асуулт байна. Үүнтэй холбоотой зүгээр яах вэ бид нарт шинэ өрөг гээд нэг ийм сүрхий мундаг сэтгүүл шахуу юм даа. Энэ дээр бас жоохон ташаа ойлголт байна шүү. Манай Дорноговь аймгийг бараг төсвүүд хараат аймаг, их боломж гарч байгаа эд нар гээд. Манай Дорноговь аймаг чинь бол улсын төсөвт төсөв төвлөрүүлдэг аймаг шүү. Тэгээд энэ хаанаас гарсан юм. Энд энэ дээр нэг зүйл байгаа юм. Тэр тусгай АМНАТ-тай холбоотой байна лээ. Энэ тусгай АМНАТ 5 хувь нь өсөн нэмэгдэх АМНАТ гээд. Үүнтэй холбоотой тэр тусгай АМНАТ гэж зүйлийг чинь би олж харсангүй. Сая ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ноогдуулах журам дээр ийм зүйлийг би олж харсангүй юу, эсвэл тэр тусгай АМНАТ гэдэг ойлголт хаана байгаа юм бэ гэж.

Цөмийн энергийн чиглэлээр Тэгшбаяр доктороос бас нэг асуулт байна. Бид нарыг Дорноговь аймгийг удирдаж байх үед, 8 жил удирдаж байх үед энэ хамгийн их хар сэр маргаан дагуулж байгаа нөгөө сүрхий эх орончдын асуугаад байдаг сэдэв бол 2 зүйл байдаг юм л даа. 1 дүгээрт нь тэр газар доор уусган олборлох арга их хортой л гэдэг. Тэр хүхрийн хүчил газар луу шингээгээд ус хорддог, энээ тэрээ гэж яриад байдаг. Энэ аргаар олборлохын давуу, сул талыг одоо яг олон нийтэд нэг тодорхой хэлчихвэл зүгээр байх. Энэ нэг их айхтар нууцад ороод байхгүй байх гэж бодож байна. Манай ураны нөөцийн тоо нь хэтийн төлөвтэй холбоотой бас мэдээлэл өгчихвөл зүгээр байх. Бид нарыг ажиллаж байхад нэг шөнө Норовсүрэн гэдэг хүний 21 бяруу 1 шөнө худаг дээрээ үхээд бөөн юм болж байсан юм л даа. Тэгээд Засгийн газраас ажлын хэсэг гараад, одоо тэр ажлын хэсэгт суучихсан Манлайжав эд нар энд сууж байх шиг байна. Нэлээн хэдэн таньдаг хүмүүс байна. Селен ихдсэнээс болсон гэсэн дүгнэлт гарсан. Селентэй холбоотой бас та нар нийтлэг ойлголт өгчхөөрэй. Байгаль дээр яагаад гэнэт ихэсчихдэг юм. Тэгээд бусад хажуу айл нь яагаад зүгээр байгаад байдаг юм. Ер нь тэгэхдээ түрүүнд Эрдэнэболд гишүүн хэлж байна. Яг юу нь зөв, юу нь бурууг нь ингээд ард иргэдэд цэгцтэй тайлбарлах, олон нийтэд хүргэх асуудал чинь их дутмаг явдаг шүү. Тэгээд энэ тал дээрээ анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Өөр зүйл нь ер нь тэгэхдээ энэ иргэдэд нээлттэй байх, нээлттэй байна гэдэг чинь мэдэх эрх шүү дээ. Иргэдийн оролцоо гэдэг чинь дэмжлэг. Энэ чиглэлийн юмнууд дээр анхаарч ажиллах .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулья.

Н.Учрал: Тэр тусгай АМНАТ-тай холбоотой зохицуулалт бол энэ хуулийн 5.4-д заасны дагуу “цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-д зааснаас бас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно” гэдэг заалт байгаа. Дээрээс нь энэ хуульд заасан “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тусгай төлбөрийн хувь хэмжээг тухайн ордын онцлог ашигт малтмалын зах зээлийн үнийн

түвшнийг харгалзан тогтооно” гээд нөгөө өсөн нэмэгдэх АМНАТ гээд бүхэлд нь бол бүгдийг нь зохицуулсан зохицуулалтууд байгаа.

Тэр 9.1.10.цацраг идэвхт ашигт малтмалын ордын талбайн хил заагийг тогтоох буюу өнөөдрийн хуулиар Ашигт малтмалын хуулийн 9.1.12 дээр стратегийн ордын хил заагийг Засгийн газар тогтоохоор хуульчилсан байдаг. Тэр хил заагийг бол Засгийн газар тогтоогоод явдаг. Яг үүнтэй адилхан цацраг идэвхт ашигт малтмалын ордын талбайн хил заагийг мөн ингээд Засгийн газар тогтооно гэдгээр хуулийг уялдуулж бас өөрчилсөн. Яагаад гэхээр Цөмийн энергийн хуулийн 6.1-д цацраг идэвхт ашигт малтмалын ордын хэмжээнээс үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод тооцдог. Тэгэхээр Монголд нөгөө 16 стратегийн орд Их Хурлын жагсаалтаар батлагдсан бол яг үүнтэй адилтгаад хэмжээ хязгаар нь хамаа байхгүй. Цацраг идэвхт ашигт малтмалын орд бол өөрөө стратегийн ач холбогдол бүхий ордод бол тооцогддог.

Мэдээж энэ төсөл бол санхүүгийн хувьд үр өгөөжтэй. Түүнээсээ гадна гуравдагч хөршийн 2 дахь том хөрөнгө оруулалт, эрэлт өндөртэй стратегийн бүтээгдэхүүнийг олборлоно. Цаашдаа мэдээж Монгол Улсад АЦС-тай болох, цөмийн эрчим хүч ашиглах гээд ийм чиглэлийн давуу талууд бол бий болно. Мэдээж Монгол Улсад орох валютын урсгал нэмэгдэнэ. Бид ямар нэгэн эхний санхүүжилт ч бай, төслийн дунд ч гэсэн санхүүгийн ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй. Нийт төслийн хугацаанд 5 тэрбум долларын ашигтай ажиллана. Жилд бол төсвийн орлогод 135 сая доллар бүрдүүлнэ гэсэн урьдчилсан ТЭЗҮ байгаа. Улсын төсөвт 69, орон нутагт 30 сая доллар, Ирээдүй өв санд 36, Хуримтлалын санд жилд 18 сая доллар гэсэн ийм одоо урьдчилсан ТЭЗҮ, хэрвээ энэ хууль батлагдаад яг одоо протоколд тусгагдсан хэлэлцээ яг зөвшилцөлд хүрээд Их Хурлаар батлагдаж чадвал ийм тооцоололтой бол байгаа. Тэгэхээр яг нөгөө хэлэлцээрийн протоколд дурдагдсан энэ тусгай АМНАТ-тай холбоотой болон өсөн нэмэгдэх АМНАТ-тай холбоотой зохицуулалтуудыг амилуулахад энэ хууль туслалцаа үзүүлнэ.

Хэрвээ бид яг протоколд тусгагдсан асуудлуудаа явуулж чадвал дэлхийд хамгийн өндөр хэмжээнд тооцогдох АМНАТ авсан, авах ийм төсөл хэрэгжин гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Шинжээч Тэгшбаяр.

Н.Тэгшбаяр: Сая нөөцийн тухай асууж байна. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улс одоогоор бол тогтоогдсон нөөц 192 мянган тонн. Үүгээр бол дэлхийд 10-т дэлхийн нийт нөөцийн батлагдсан нөөцийн 2 хувийг эзэмшиж байна. Манай перспектив буюу ирээдүйн нөөц бол ойролцоогоор 1,5 сая тонн болно. Энийг бид тогтоож чадвал дэлхийд тэргүүлэгч эхний 5 нөөцтэй орны нэг болох боломжтой. Газар доор уусган баяжуулах аргын тухай асууж байна. Энэ бол дэ дэлхийд олборлож байгаа нийт ураны жилд олборлож байгаа ураны 56-аас дээш хувийг бол газар доор уусган баяжуулах аргаар олборлож байгаа учраас энэ дэлхийд хүлээн зөвшөөрсөн арга гэж хэлж болно. Одоо дэлхийд тэргүүлэгч Казахстан бол ер нь ихэнх ураныхаа ордыг бол ингэж ашиглаж байгаа. Селений тухайд бол бороо ихтэй уулархаг хангай газар бол Селений дутагдсанаас болж малын шөрмөс цайх өвчин бий болдог бол говийн нутагт бол селений ихтгэм байдаг ч.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт.

Н.Тэгшбаяр: Тэр 2013 онд би Цөмийн энергийн агентлагийн даргаар ажиллаж байх үед манай Манлайжав дарга бид нар бол тэр 100 гаруй хүнтэй ажлын хэсэг дээр бол хөндлөнгөөс нь би харж, Манлайжав дарга ахалж ажиллаж байсан. Тэр үед бол энэ

Цэрэнчимэд гэж эмч уранаас болсон гээд ингэж цуурхал дэгдээсэн. Өнөөдөр хүртэл Монгол Улсын төр иймэрхүү юманд хариуцлага тооцож чадахгүй байгаа нь ийм төслийг хойшлуулахтай холбоотой ийм бэрхшээлүүдийг авч ирж байгаа. Хойшдоо бол тэр хүмүүс, олон нийтэд танилцуулах ажил дээр бол санал нэг байна. Энэ хариуцлага тооцох ажил дээр бол Монголын хууль хяналтын байгууллагууд ажиллаасай гэж мэргэжлийн хүний хувьд бол боддог. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ хэлэлцэж байгаа асуудлыг хэлэлцэж дуусахад 37 минут үлдсэн байгаа бидэнд. Үлдсэн 6 гишүүн асуултаа асууж, хариулт авна. 6 гишүүн үг хэлнэ. Хариулт өгч байгаа хүмүүс тодорхой, аль болох товч хэлбэрээр хариултаа өгөөд явахыг хүсэж байна. Тийм учраас үдийн завсарлага 13 цагт байгаа. 13 цаг 30 минут хүртэл хурал үргэлжилж хуралдана. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Цөмийн энергийн хуулиуд, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, тэгээд уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан төслийг нэн яаралтайгаар гэж оруулж ирээд хэлэлцэж байна. Тэгээд энэ нэн яаралтай үндэслэлүүдийг ойлгохгүй байгаад байгаа учраас дахиад нэг тайлбарлаад өгөөч. Энэ тайлбар дээр бичсэнээрээ 6, 7 газар лиценз эзэмшдэг. Лиценз эзэмшээд өнөөдрийг хүртэл ашиглалт, олборлолт явуулж чадахгүй байгаа нь энэ өөрчлөлтүүдийг оруулах шаардлага гээд нэг талаасаа биччихсэн байгаад байдаг. Амаар ярихаараа эдийн засгийн үндэслэлтэй гээд байдаг. Саяын ярьж байгаагаар 135 сая доллар гэдэг бол 472,5 тэрбум төгрөг. Манай 2025 онд батлах гэж байгаа урсгал зардлын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний 1,4 их наядын ердөө л 1/3. Тэгэхээр энэ бол тийм их том мөнгө биш.

3 дугаарт эдийн засгийг солонгоруулах тухай гээд яриад байдаг. Манай улсын чинь уул уурхайгаас хэтэрхий их хамааралтай болчихлоо. Өөр салбараас солонгоруулъя гээд байдаг. Тэгэхээр энэ салбар чинь өөрөө бас уул уурхайн салбар болоод байдаг. Тэгэхээр манай улсад яг үүсээд байгаа, тэгээд тэр тусмаа нэн шаардлагатайгаар оруулж ирэх шаардлага нь яг тодорхой юу юм бэ. 1 дүгээр асуулт.

2 дугаарт яг энэ үндэслэл дээр бичээд байгаа нь яг тодорхойгүй харагдахгүй л байгаад байна л даа. Олборлох гээд байгаа юм уу, цөмийн эрчим хүч үйлдвэрлэх гээд байгаа юм уу гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа юм. Яг аль алийг нь нийлүүлээд л биччихсэн. Олборлох гэж байгаа бол хэдэн асуулт байгаад байгаа юм. Түрүүний тэр одоо муухай л үзэгдээд байна гэж яриад байх шиг байна. Тэр газар дор байж байгаа хүхрийн хүчил чинь хэдэн метрийн гүнд байх юм. Хэр хугацаанд байх юм. Тэрийг иргэдэд болон ирээдүйд байгаль орчинд хохиролгүй, усанд хохиролгүй, гүний усанд хохиролгүй гэдгийг баталсан олон улсын байгууллагуудын байгууллагуудын шинжилгээ дүгнэлтүүд байна уу. Ер нь энийг яаж, ямар олон улсын байгууллагууд дүгнэж шинжилдэг юм бэ.

Дээрээс нь энэ олборлох талаар Арива, Орано, Бадрах Энержи гээд ингээд 3, 4 компанийн нэрүүд яваад байна. Яг зарим дээр нь энэ тайлан дээр бичсэнээс ингээд харахаар 20 жил ажиллаж байгаа юм шиг. Зарим дээр нь ажиллахлаар 2 жил ажиллаж байгаа юм ши. Яг хэдэн жил ажиллаад хэдэн тонн уран олборлоод гаргаад байгаа юм бэ. Тэр Бадрах Энержи болон Орано, Арива нар хоорондоо ямар хамааралтай, ямар эзэмшлийн хувьтай компаниуд бэ гэдэг ийм асуулт байна.

Дээрээс нь эрчим хүчний асуудлын тухай яригдаад байна. Эрчим хүчний асуудал дээр бол хэрвээ үйлдвэрлээд эхлэх юм бол цөмийн түлшний асуудлаа яаж шийдэж байгаа вэ.

Ер нь энэ нэн яаралтай гэдэг энэ асуудлуудын үндэслэлийн цаана ингээд харахаар голдуу эдийн засгийн асуудлуудыг яриад байхлаар манай улсад өөрөө энэ гадуур явж байгаа гайг яг өөр дээрээ дуудах хэрэгтэй юм уу. Стратегийн болон геополитикийн хувьд ач холбогдолтой гээд яриад байгаа юм. Эсрэгээрээ бүр харин их төвөгтэй юм биш үү. Бид нар өнөөдөр үйлдвэрлэж байгаа алт, зэс, нүүрс зэрэг энгийн металлуудаа ашиглах, үүнтэй холбоотой хэл амаа цэгцэлж чадаагүй. Үүнтэй холбоотой уул уурхай нөхөн сэргээлтээ хийгээгүй байж байж, дараагийн ийм бүр олон улсын хэмжээний түвшинд яригддаг энэ юм руу орох үнэхээр тийм гарцаагүй шаардлага байна уу гэсэн ийм хэдэн асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал хариулт өгнө.

Н.Учрал: Яаралтай горимоор оруулж ирдгийн шалтгаан бол Цөмийн энергийн хууль 2009 онд батлагдсаныхаа дараа ерөөсөө л 3 жилийн дараагаас авхуулаад л хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгүүд байгуулагдаад л ажиллаад л явсан юм билээ. Тэгээд энэ төсөл бол бичигдээд бараг хуучирсан байсан. Хэд хэдэн л төсөл явдаг. Тэгээд бид нар шинэчилж сайжруулаад л энэ удаагийн хамтарсан Засгийн газрын үед нэгэнт үйл ажиллагааны хөтөлбөрт энд бас төслүүд суучихлаа. Одоо ингээд оруулж ирээд хуулийнхаа орчныг тодорхой болгочихъё. Ялангуяа маш сайнаар тохирч чадсан тэр хэлэлцээрийн протоколыг байгуулснаас хойш бүтэн жил дахиад алдчихлаа шүү дээ. Бүтэн жил. Уг нь тэр хаврын чуулганаар бас бололцоо байсан.

Гэтэл Баялгийн сангийн хууль хүлээгдэж байсан. Тэр баялгийн сангийн хуулиа гаргаад, тэгээд дараа нь явъя гэдэг шалтгаанаар бол бас ингээд явж байгаад сая хамтарсан Засгийн газрын үед энэ бол цаг үе нь мөн гээд оруулж ирсэн. Тэгээд энэ хуулийг батлахгүйгээр тэр жил болчихсон хэлэлцээрийн тэр протокол чинь цаашдаа хэдэн жил хүчин төгөлдөр амьтай үйлчлэх вэ. Сая бол Сангийн яамнаас хэлж байна шүү дээ. Ер нь дэлхийд хамгийн өндрөөр тогтоосон АМНАТ-ийг хэлэлцээрийн протоколд зурчихаад байхад үүнийгээ хэрхэн амилуулах вэ. Эсвэл бид нар тусгай АМНАТ 5-аас дээш байхгүй гээд манай хууль ийм гээд суугаад цаашаа хэлэлцээ үргэлжилнэ гэдэг бол зохимжгүй. Тийм ч учраас нөгөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялгийг олон улсын стандартын дагуу ашиглан хөгжүүлж, түүнээс олох орлогыг үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хангуулахад олон тулгуурт эдийн засгийг дэмжихэд чиглэх ийм ач холбогдолтой төсөл гэж үзэж байгаа. Энэ бол зөвхөн санхүүгийн үр өгөөжөөс авахаас илүүтэйгээр гуравдагч хөршийн хөрөнгө оруулалт, өсөн нэмэгдэж байгаа эрэлт өндөртэй стратегийн бүтээгдэхүүн гэдэг утгаараа оруулж байна. Дээрээс нь дэлхий дахинд бол өнөөдөр нүүрстөрөгчөөс татгалзаж байгаа энэ цаг үед бол бид нар уул уурхайн салбараа бас төрөлжүүлэх, солонгоруулах шаардлагатай.

2-т бол мэдээж 1 том шалтгаан бол эндээс харагдаад байгаа. Энэ бол ер нь бид нар өсөлтийн хөгжил гэж андуурсан. Тийм ч учраас бид нар илүү нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл явуулах ч зайлшгүй шаардлагатай. Тийм ч учраас энэ төсөл хэрэгжсэнээрээ шууд ба шууд бус үр өгөөжтэй. Дээрээс нь хүхрийн хүчдэлийн одоо үйлдвэр байгуулах бололцоо бол үүнээс бүрдэнэ. Дээрээс нь цаашлаад бол хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах гээд ийм олон талын өндөр ач холбогдол байгаа. Тэгэхээр зөвхөн өнөөдрийн санхүүгийн ач холбогдол гээд энэ төсвийн орлогод бүрдүүлж байгаа орлогоор бас хэмжиж бол болохгүй. Тийм учраас энэ бол олон талын өндөр ач холбогдолтой шинэ технологи, инновац бас манай улсад нэвтрэх ийм боломж бололцоо бол бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон. “Мон-Атом” компанийн захирал Далайжаргал.

Д.Далайжаргал: Тэр Орано гэдэг нь 2018 оныг хүртэл Орана гэж байсан. Орано бол 100 хувь Францын ТӨК. Тэрний өмнө бол Арива гэж байсан. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа нь Бадрах Энержи гэж компани байгаа. Тэрний 66 хувийг нь Орано эзэмшиж байгаа. 34-ийг нь “Мон-Атом” эзэмшиж байгаа. 2017 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Өнөөдрийг хүртэл уран олборлоогүй. Зөвхөн туршилтын үйлдвэрийнх нь 10 тонн уран олборлоод л байж байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Баярхүү гуай нэмж хариулья.

Д.Баярхүү: Тэр геополитикийн эрсдэл гэж асууж байна. Тэгэхээр өнөөдөр хүн төрөлхтөн чинь ер нь энхийн атом руу явж байгаа цаг л даа. Нөгөө хүлэмжийн хийг бууруулна гээд 2030 он наад талд нь, тэгээд 2050 он гээд даян дэлхийгээрээ хүлэмжийн хий бууруулаад, нүүрсний цахилгаан станцаас татгалзсан тохиолдолд хамгийн боломжийн, хамгийн смарт, хамгийн хямд төсөр хэрэглэж болох эрчим хүч бол уран болоод явчхаж байгаа юм. Тэгэхээр бол дэлхий нийтээрээ энд бол бэлдэж байна. Дэлхийн хандлага юм. Монгол Улс бол цөмийн зэвсгээс ангид бүс улсаараа болчихсон. Дээрээс нь цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээ, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээний идэвхтэй гишүүн улс. Нөгөө цөмийн зэвсэгтэй 5 гүрэн чинь Нэгдсэн Үндэсний байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн. 5-уулаа дотроо цөмийн зэвсэгтэй хэр нь P5 гэж онцлог байгаа нь бол хоорондоо энэ цөмийн аж үйлдвэр, цөмийн эрчим хүчний асуудлаар тийм нэгдсэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья. 7 дугаар микрофон.

Д.Баярхүү: Тэдний P5-бын 1 Францтай Монгол Улс энэ талаар хамтран ажиллаж байгаа явдалд бол энэ бусад улс оронд учрах юм уу, бүс нутагт учрах геополитикийн эрсдэл эсвэл эргэж манайд учрах ямар нэгэн аюул уршиг гэж гарахгүй. Тэгэхээр энхийн атом гэдэг талаас нь харж үзээрэй. Ойлгоорой гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төслийг энэ хуулийн төслийг хэлэлцэхийг бол их дэмжиж байгаа. Ер нь орж ирэх өгөөж нь бол АМНАТ-ийн орлогоос бүрдэх юм байна. Сая Учрал сайд бас хэлж байна. Дэлхийд хамгийн том АМНАТ-ийн орлого олсон ийм төсөл ч болох боломжтой гэж хэлж байна. Тэгээд татвар нь бол ингээд суурь татвар байдаг юм байна. Үнээсээ хамаараад 50-аас дээш доллартой бол тэгээд 1-9 хувийн ийм нэмэлт татвар ингээд аваад явдаг юм байна.

Ер нь би зүгээр бас физикч хүнийхээ хувьд би нөөцийнх нь талаас бас асууя гэж бодоод байгаа юм. Одоогийн Монгол орны энэ ураны олборлолт, ураны хайгуулыг хэдэн компани хийж байгаа вэ. Монгол Улсын хэмжээнд. Ер нь байршил нь хаагуур байдаг вэ. Тэр Дорноговьд л байгаад байна уу. Хөвсгөл энэ тэр лүү бас байна уу. Ер нь түрүүн Тэгшбаяр бас хэлж байна. Эрдэмтэн доктор. Манайх бол нөөцөөрөө ер нь дэлхийд эхний 10-д байгаа, бас цаашлаад 5-д ч орно гэж юм ярьж байна. Тэгэхээр бид нар хэдий хэмжээний талбайд хайгуул хийх зөвшөөрөл Монгол Улс эзэмшиж байдаг юм. Энэ төсөл орж ирэхээр тэр нь хэчнээн талбайгаар нэмэгдэх юм гэдэг юмыг нэг асууя.

Тэгээд ер нь одоо энэ хайгуул хийж байгаа энэ компаниуд Матад энэ тэр гээд байж байдаг тийм ээ. Тэр компаниуд дотроос ер нь хэчнээн хэмжээний татвар төлдөг юм бэ. Ингээд хууль батлагдсаны дараа нийт манай улсын татварын тоо хэмжээг бас хэлээд байна. Тэгээд энийг би бас асууя гэж бодож байсан юм. Өөрөөр хэлбэл ТЭЗҮ нь хэр хийгдсэн төсөл юм бэ гэдгийг сонирхож асууя. Мэдээж энэ бол олон улсын төслөөр санхүүжилтээр хийгдэж байгаа учраас манай төсөв энэ тэрд бол хүндрэл учрахгүй байгаа нь их сайн талтай.

Технологийн талаар нь бас асуумаар байгаа юм. Технологи нь хэр баталгаатай технологи байна. Хаана хаана хэрэглэгдэж байсан. Нөхөн сэргээлт энэ тэрээ яаж хийдэг юм гэдэг талаас нь. Тэгээд ус бол маш их ашиглагдана. Тэгээд манай “Мон Атом” компани маань нэлээн олон жилийн өмнөөс бас сонсож байсан, хийж байсан. Тэгээд яг энэ төсөл дээр бол нэлээн судалгаа хийчихсэн юм болов уу гэж ингэж сонсогдож байна. Тэгэхээр усны нөөц нь хэр байгаад байгаа юм. Ураны нөөц нь хэд байгаад байгаа юм. Энэ ер нь хэдэн жилийн турш үргэлжлэх төсөл гэж харж байгаа вэ. Оюутолгойг бид нар 30 жил гээд яриад одоо 15, 16 жил нь болчихлоо гэж байх шиг. Ураны төсөл бас энэ төсөл хэдэн жилийн юутай вэ гэдэг талаар, тэгээд технологийнх нь талаар нь асуугаад байгаа юм. Ялангуяа тэр усны хомсдол үүсгэх тал дээр ямар нөлөө үзүүлэх юм бол гэдгийг асуумаар байна.

Тэгээд эцэст нь бол Мега төслийн маань алсын хараа юу вэ. Бид нар зөвхөн энэ олборлолт хийгээд байх биш, бид нар үүгээрээ цахилгаан эрчим хүч гаргах нь л бид нарын ирээдүй. Бид нар яагаад Монгол Улсад АЦС бас барьж болохгүй гэж. Энэ технологи ингээд хөгжөөд Японд гэхэд л 40 хэдэн АЦС ажиллаж байдаг. АЦС тэр фукушимагийн цунами болсны дараа бол бас нэг хааж үзэхэд бас сэргээгдэх эрчим хүчээр ч бас орлуульж байгаа ийм дэвшлүүд бас байдаг.

Тэгээд хамгийн эцэст нь би одоо багш хүний хувьд хүний нөөцийг хэр бэлдэж байна. Манай МУИС-ийн физикийн тэнхим энэ тэртэй яаж хамтарч ажилладаг юм. ШУТИС-ийн ялангуяа инженер, техникийн ажилтнууд. Бид нар нэг тийм хар ажлыг нь бол хийчхээд инженер техникийн өндөр цалинтай нь гадаадынхан байгаад байх юм баймааргүй байна. Тэгээд 1600 хүн дотор 90 хэдэн хувь тэгээд 14 хүн л зөвхөн гадаад хүн байна гэж ярьж байна л даа. Тэгэхээр үндэсний инженерүүдээ бэлдээд сургаж аваад, үүний дараа маш их олон эрсдэлүүд ашиглалт дээр гарч ирэх учраас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон. Жаргалсайхан гуай, Жамсрандорж.

Г.Жамсрандорж: Хайгуулын тухай ярья. Өнөөдөр Монгол Улсад 192 мянган тонн ураны нөөц бэлтгэснээс ашиглалтын лицензийг 2 компани эзэмшиж байгаа. 1 нь Орано 193 мянган тонн нөөцтэй Дулаан-Уул болон Зөөвч овоогийн орд бүхий 2 лиценз. Нөгөөдөх нь 3 сайхан компани Монгол Чехийн хамтарсан Дундговь аймагт 3 сайхан, Хараат хайрхан гэсэн ордуудыг хамарсан ордууд юу байгаа.

Нөгөө 3 дугаарт нь хувийн хайгуулын лиценз эзэмшдэг Дорнодын Адамс майнинг гэж компани байгаа. Өөр хайгуулын ажлыг эрхэлж байгаа компани Монголын нутаг дэвсгэрт байхгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Шинжээч Тэгшбаяр.

Н.Тэгшбаяр: Газар доор уусган баяжуулах аргаар Монгол Улсад бол олборлохоор ингэж төлөвлөж байгаа. Тэгээд Сенд Эстон төрлийн ийм уурхайг бол ингэж ашигладаг. Дэлхий дээр бол сая би хэлсэн. 56 орчим хувь нь бол энэ аргаар бол олборлож байгаа. Тэгээд

энэ бол хүлээн зөвшөөрөгдсөн ийм технологи. Ус бага хэрэглэдэг. Ер нь тэгээд энэ газрын доор уран байна гэдэг бол өөрөө тэр орчинд бол техникийн ус байна гэсэн үг. Тийм учраас тэр орчны усыг бол бохирдуулаад байна гэсэн ойлголтоос илүү техникийн усан дээр одоо хүхрийн хүчлийг ашиглаж, техникийн ус хэлбэрээр нь хэрэглэж байна л гэж ойлговол зүйтэй байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Усны газрын дарга Батбаяр

З.Батбаяр: Гишүүний асуултад нөөцийн талаар маш товчхон мэдээлэл өгөхийг хичээе. Зөөвч овоо, Дулаан-Уулын орчимд тогтоогдсон усны нөөц нь 516 литр секунд байгаа. Литр секундээр. Одоо Бадрах Энержи компанийн ашигласан усны хэмжээ нь 2022 онд 58 литр секунд, 2023 онд 38 литр секунд байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл яг энэ хэмжээгээрээ тооцвол харьцангуй усны нөөцийн хувьд бол боломжтой гэж харагдаж байгаа. Олборлолт явагдах үед байнгын хяналт тавина. Гэхдээ сая манай ажлын хэсгийнхний хэлснээр энэ газрын доор уусган баяжуулах технологийн онцлог нь магадгүй 90 орчим хувь юм уу, 80-90 хувь орчимд нь дахин ашиглалт байх учраас усны тал дээр бол санаа зоволтгүй байх гэж бодно. Гэхдээ энэ нь санаа зоволтгүй бүх юмыг хэвийн гэсэн утга биш, байнгын хяналт шалгалттай ажиллах болно.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон. “Мон Атом”-ын захирал Далайжаргал.

Д.Далайжаргал: Боловсон хүчний тухай маш чухал асуулт тавьсан. Би түрүүн бас хариулсан. 2003 оноос хойш энэ боловсон хүчний мэргэшүүлэх чиглэлээр ажиллаж байгаа. Сүүлийн 5 жил 77 орны 225 удаагийн тэтгэлгээр сургаж байгаа. ШУТИС дээр тэтгэлэг хөтөлбөр зарлаад, өнгөрсөн хугацаанд 35 багшийг мэргэшүүлж сургасан. Яг одоо Орано групп дээр бол 2 хүн төвд нь ажиллаж байгаа. Казахын төсөл дээр 2 геологич 6 сарын хугацаатай 2, 2 геологичийг ингэж ажиллуулж ажиллуулж байгаа. Ер нь төсөл эхлэхэд нийтдээ 1600 ажил хийхэд 14 хүн л гаднын экспертүүд байна. Бусад нь дандаа Монголчууд 99 хувиар Монголчууд байна гэсэн байгаа. Зүгээр төсөл хэрэгжүүлэх гэхээр нийтдээ 9 сая долларыг боловсон хүчинд зарцуулахаар төлөвлөчихсөн байгаа.

Д.Амарбаясгалан: Галбадрах гишүүн тодруулж асууя. Галбадрах гишүүний микрофоныг өгье. Тодруулж асууя.

Ж.Галбадрах: 1 асуултыг нь авчихъя гэж бодож байна. Ер нь мега төсөл байгаа. Тэр алсын хараа нь бид нар ер нь ирээдүйд АЦС бариад, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үү. Энэ чиглэл нь байвал одоогийн гэрээ энэ тэр дээр бид нар чинь үйлдвэрлээд ирвэл хог хаягдлаа яах вэ энэ тэр гээд асуудлууд бас үүснэ шүү дээ. Тэгэхээр энэ чиглэл рүү ер нь бид нар одоо тусгаад ирээдүйдээ бид нар нэгэнт л түрүүн Баярхүү гуайн хэлж байсан. Энэ хямд ийм уран гэдэг ийм боломжтой юм байна гэж байгаа бол технологи гаргаж ирээд бид нар бас байгуулбал өнөөдөр бас боломж Монгол Улсад байгаа гэж хардаг. Тэгэхээр энэ чиглэлийн хариултыг авъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Шинжээч Тэгшбаяр.

Н.Тэгшбаяр: Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бол 2 зүйл тусгачихсан байгаа. 1 нь цөмийн эрчим хүчийг ашиглах тухай судалгаа, нөгөөх нь бол энэ Оранотай хамтарсан Франц Монголын гэрээг явуулна гээд тусгачихсан. Яг энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд явж байгаа. Энэ ажил ингээд явсан тохиолдолд бол АЦС-тай болоход бол 1 алхам ойртож байгаа. Жишээлбэл Казахстан бол дэлхийн тэргүүлэгч уран

олборлогч. Энэ хүрээнд бол саяхан иргэдээсээ санал асуулга авахад бол 71 хувь нь бол атомын цахилгаан станцыг ашиглая гэдэг ийм санал асуулгыг зөвшөөрсөн. Энэ ураныг олборлох, боловсруулах, тээвэрлэх энэ ажил бол алсдаа бол АЦС-ыг хүлээн зөвшөөрүүлэхэд бас их нэмэртэй. Нэг алхам ойртож байгаа л юм байгаа.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Г.Уянгахишиг: Цөмийн энергийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт болон бусад дагалдах хуулиудын нэмэлт, өөрчлөлттэй холбоотой бид нар өнөөдөр хэлэлцэх эсэхээ хэлэлцэж байна. Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Харин мэдээж найруулгын хувьд болон хуулийн зохицуулалтуудын хувьд бол нэлээн ажиллагаатай харагдаж байна л даа. Жишээлбэл 5.2, 5.3, 5.4 дээр бол хоорондоо зохицолтой байлгах, зөв нэр томъёогоор хэрэгжүүлэх, оруулах гэдэг шаардлагын хүрээнд бол нэлээн олон юмыг харах хэрэгтэй болж байна. Нөгөө талаасаа бид нар бас одоо яг хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд гэдэг талаасаа бас анхаарах хэрэгтэй байгаад байна. Гэрээ бол дараа нь энэ хуулийнхаа хүрээ хязгаарт багтаад гэрээнийхээ зохицуулалтуудыг бол нэлээн нарийвчилж хийгдэх ёстой харагдаж байна.

Мөн түүнчлэн дагаж орж ирж байгаа 3 хууль байгаа. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүд. Энэ дээр бол энэ 3-ыг бол гурвууланг нь шаардлагагүй, хэлэлцэх шаардлагагүй гэж харж байна.

1 дүгээрт Компанийн тухай хуулийн 34.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулна буюу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хүрэх боломжтой болгох энэ зохицуулалтыг оруулъя гэж байна. Тэгэхээр энийг бол гэрээний зохицуулалтаар хийгээд явах бүрэн боломжтой зүйл. Заавал энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлээд байх шаардлагагүй. Өөр хуулийн зохицуулалтууд буюу өөр хэлцлийн зохицуулалтуудад оруулж ирж болох учраас ерөнхий нөгөө Компанийн хуулийнхаа онолын хувьд өөрчлөгддөггүй энэ заалтыг бол хөндмөөргүй байна. Олон улсдаа угаасаа хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг талаасаа болон компанийн эрх зүйн хүрээндээ энгийн хувьцаа бол өөрөө давуу эрхийн хувьцаанд хүргэдэггүй ийм зарчимтай.

2 дугаарт болохоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулъя гэхихсэн байна. Энэ дээр тогтворжуулах татварын орчин гэж оруулаад, хязгаарлалттай тавих гээд байна л даа. Энийг бол гэрээндээ бол болно. Өөрөөр хэлэх юм бол хууль дээр татварын орчин гэдгийг тодорхойлоод тавьчихсан байгаа. Тэр татварын орчин дотор өөрөө хувь хэмжээ орж байгаа. Ноогдуулалт орж байгаа. Тийм ээ, энэ бусад бүх юунууд ороод, тодорхойлогдоод явчихсан байгаа. Тэгэхээр энэ орчноос яг аль хэсгүүдийг нь тогтворжуулах юм бэ гэдэг энэ хэсгийг бол гэрээндээ суулгаад явахгүй бол зөвхөн 1 гэрээнд зориулаад шууд хуулийнхаа тэр тогтворжуулах орчноо ингээд хязгаарлаад оруулаад ирнэ гэдэг бол буруу гэж харж байна.

Яг үүнтэй уялдаатайгаар энэ ААНОАТ-ын тухай хууль дээр 6.1.50-д тогтворжуулах татварын орчин гэж тодорхойлолт оруулж ирээд, үүгээрээ хязгаарлалт оруулаад байна. Тэгэхээр энэ 3 хуулийн дагалдаж орж ирж байгаа хуулийн төслүүдийг бол хэлэлцэх шаардлагагүй гэдэг саналтай байгаад байна.

Тэгээд асуултын хувьд болохоороо одоо яг энэ Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороод бид нар олборлогч болох гээд байна шүү дээ. Тэгэхээр олборлогч болчихсон тохиолдолд олон улсынхаа дүрэм журмын дагуу бид нар дээр яг ямар үүргүүд нэмэгдэж орж ирэх вэ. Тэд нарын талаар бас мэргэжилтнүүдээсээ мэдээлэл авмаар байна.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ер нь манай өнгөрсөн хугацааны алдаа гээд түрүүн зөндөө ярилаа. Оюутолгой компанитай үүсээд байгаа маргааны 1 үндсэн шалтгаан бол тухайн үед Татварын ерөнхий хуулиараа Тогтворжуулах татварын орчныг ерөнхийлж заасан. Ингээд Хөрөнгө оруулалтын гэрээгээрээ аль аль татвараа тогтворжуулах вэ гэдгээ оруулж ир гэдэг байдлаар нээгээд өгчихсөн. Тэгээд одоо яриад байгаа шүү дээ нөгөө гэрээнд тохируулаад хууль хийчихсэн гээд шүүмжлээд байгаа чинь энэ юм. Энэ удаа бол бид нар тогтворжуулах татварын орчин гэдэг нь юу вэ гэдгийг заахдаа бол тодорхойлж өгсөн. Гол онцлог нь бол тодорхойлж өгч байгаа. Яг тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ноогдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг нь хэт ерөнхий заасан байсныг нь энэ удаа бол ерөнхийлөлтөөс нь бол татгалзаж байгаа гэсэн үг. Нэг ёсондоо бол татварын тогтворжуулах орчин гэдэг нь татварынх нь хувь хэмжээ, элэгдэл хорогдол тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйн шилжүүлэх, тооцох хугацааг ойлгоно гэнэ тодорхой зааж өгсөн. Ингэж байж эрх зүйн орчиндоо хэлэлцээ хийхгүй бол хэт их нээгээд өгчихөөр л дахиад л хэлэлцээний явцад асуудал үүсчихдэг. Тийм учраас энэ маргааныг цэглэх үүднээс нь энийг тодорхой болгож байгаа. Тэр энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгох асуудлыг хуульчилж өгөхгүй бол болохгүй байгаагийн шалтгаан бол байгаа юм. Энэ юу вэ гэвэл компанийн хуулиар бол энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлэхийг хориглохож байгаа юм.

Гэхдээ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэж компанийн хууль дээрээ өөрчлөөд, Цөмийн энергийн хууль дээрээ энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгож болохыг зөвхөн Цөмийн энергийн хуулийн хүрээнд тэр харилцааг зохицуулах дээр нь тавьж өгч байгаа юм. Бусад харилцаанд хамаарахгүй. Зөвхөн Цөмийн энергийн хуулийн хүрээнд. Яагаад ингэж байгаа вэ гэхээр 10 хувийнжишээ нь Мон Атом компани 34-ийг эзэмшлээ гэхээр 10 хувийн энгийн хувьцаатай байвал санхүүгийн хувьд хариуцлага хүлээх асуудал дахиад л үүснэ. Дахиад л нөгөө тал нэмэлт санхүүжилт хийлээ, хөрөнгө оруулалт хийлээ гээд эхлэхээр яг одоо Оюутолгойтой адилхан нөгөө манай эзэмшээд байгаа 10 хувь дээр шууд 1 импакт өгч эхэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энгийн хувьцаагаа давуу эрхийн хувьцаанд болгосноороо ноогдол ашгаа авахгүй гэсэн ойлголт биш, ноогдол ашгаа авна, ТУЗ-д төлөөллөө байлгана. Тэгээд шийдвэр гаргалтад оролцоно. Гэхдээ давуу эрхийн хувьцаа болсноороо бид нар санхүүгийн үүрэг хүлээхгүй болж байгаа. Төсөл өөрөө тэр олсон хөрөнгө мөнгөөрөө санхүүжилтээ хийгээд явах болохоос биш дахиад тэр 10 хувь дээрээ өнөөдрийн тэр Оюутолгойн хөрөнгө оруулалт шиг 34 хувь дээрээ хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээгээд байхгүй болно. Тийм учраас ирээдүйд үүсэх өрөөс сэргийлэх зорилгоор энэ зохицуулалт бол зөвхөн Цөмийн энергийн хуулийн хүрээнд хэрэгжих болохоос биш Компанийн хуулийн энгийн хувьцааг давуу ерөнхий хувьцаанд хүргүүлж байгаа заалт бол хүчин төгөлдөр үйлчилнэ л гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Давуу эрхийн хувьцаа энгийн хувьцаа 2-т мэдээж өөрсдийн ялгаа зааг байгаа шүү дээ. Гэхдээ аль аль нь үүрэг хүлээвэл хөрөнгө оруулж болно. Гэхдээ энэ гэрээ хэлцэл дээр яригдаж байгаа зүйл нь бол хөрөнгө оруулах үүрэг хүлээхгүйгээр төрийн оролцоо 10 хувь байх ёстой л гэж хөрөнгө оруулагч нарын зүгээс тавьж байгаа санал хүсэлт гэж талаас нь ойлгох хэрэгтэй. Тэгэхдээ энэ тэр гэрээ яригдах үедээ бол тодорхой яригдах байх. Түүнээс одоо нөгөө юун дээрээ давуу эрхийнх учраас хөрөнгө оруулахгүй гэдэг ойлголт бас байж болохгүй байх гэж бодож байна. Мэргэжлийн хуулийн хүмүүс бас энд яана биз. Манлайжав дарга Цөмийн энергийн хууль болон энэ уран олборлохтой холбоотой үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд бид ямар үүрэг хүлээх вэ гэж олон улсын гэрээ конвенцуудын өмнө хүлээсэн үүргүүд юу байна вэ.

Г.Манлайжав: Уянгахишиг гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Цацраг идэвхт ашигт малтмал тэрэндээ шар нунтгийг бид нар гаргаад авлаа. Одоо бид нар 10,4 тонн урантай экваленттай 20 орчим тонн аммонийн дюронат гээд энэ бол ерөнхийдөө шар нунтаг гэсэн ангилалдаа ордог. Гэхдээ яах вэ агуулга нь бол харьцангуй бага 36 хувийн массынхаа уриантай. Тэгэхээр бид нар бол 10 тонноос илүү шар нунтагтай болчихсон учраас олон улсын байгууллагуудын хүлээсэн үүргээрээ мэдэгдлээ хүргүүлсэн. Энэ бол 10-аас дээшээ тоннттой баяжмалыг хаана хадгалж байгаа вэ. Хэн эзэмшиж байгаа вэ, ямар аргаар гаргаж авсан гэдэг. Тэгэхээр энэ төсөл бол бүхэлдээ бол энхийн зорилгоор ашиглагддаг төслүүд. Монгол Улс бол олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн олон конвенц гэрээгээр бол энэ үүргийг хүлээсэн. Энэ чиглэлдээ бол ажлууд нь эхэлсэн. Тэгэхээр бид нар бол цаашдаа энэ чиглэлийн ОУБ-ын хяналтыг улс орондоо хүлээж авах бас үүрэг хүлээж байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг тодруулж асууя.

Энэ асуудал хэлэлцэж дуусахад 11 минут үлдсэн. Хугацаандаа хэлэлцэж дуусах ёстой.

Г.Уянгахишиг: Саяын олон улсын үүрэгтэй холбоотойгоор жишээлбэл хуульд өөрчлөлт орох шаардлагатай ч юм уу, тийм зохицуулалтууд шаардлагууд байхгүй юу. 1 дүгээрт тодруулга асуулт нь.

2 дугаарт бол тэр давуу эрхийн хувьцаа байх шаардлагатай гэдгийг бол ойлгоод байгаа юм. Тэрийг энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлнэ гэдгээр битгий оруулаач л гэж хэлэх гээд байгаа юм. Тэрийгээ бид нар дараа нь гэрээгээрээ зохицуулчхаж болно шүү дээ.

Д.Амарбаясгалан: Тодруулж хариулъя. Манлайжав дарга. Маш товч тодорхой.

Г.Манлайжав: Таны тодруулалд нэмж хариулъя. Ер нь бол бид нар манай хуулиудад бас нэмэлтээр өөрчлөлт орох шаардлага байхгүй. Одоо бас ирэх 7 хоногт бол бид нар цөмийн аюулгүй ажиллагааны конвенц, тэгээд бага хэмжээний цөмийн материалын протоколын нэмэлт гээд энэ асуудлыг бас Улсын Их Хурлаар оруулж ирж байгаа. Энэ дээр бас Монгол Улсын хүлээх үүрэг, хариуцлага дээр нэмэлтээр бид нар энэ протоколууд нэгдэхээр орж ирж байгаа. Тэр үед нь Их Хурал дээр танилцуулагдах байх. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тэгээд ажлын хэсэг дээр энэ гишүүдэд мэдээлэл маш сайн өгнө шүү. Батын Батбаатар гишүүн асуултаа асуунаб

Б.Батбаатар: Зарим асуултаа цөөлнө өө. Өчигдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр энэ асуудлыг хэлэлцээд, хэлэлцэх эсэх нь зүйтэй гээд хэлэлцүүлэх нь зүйтэй гээд ороод ирсэн. Ер нь аливаа асуудлаас бид нар тойрч гүйдэг, ухарч зугтдаг баймааргүй байна. Барьж аваад нүүр тулаад, шийддэг л болох ёстой. Зөв байна уу, буруу байна уу, сайн байна уу, муу байна уу гэлгүйгээр. Тэгээд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт болон дагалдах хуулийн төслүүдэд маань бол Монгол Улсын цөмийн эрчим хүчний ирээдүйн бодлогыг тодорхойлох зорилготой. Тэгээд энэ бодлого бол энэ өөрчлөлтөөр ингээд цаашаа явна гэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр манай эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчны тогтвортой байдал, олон улсын өмнө хүлээсэ үүрэг хариуцлага зэрэг ийм урт хугацаандаа нөлөө үзүүлж болзошгүй байгаад байгаа учраас асуултаа заримыг нь сая давхардаад асуугдаад хариулт авчихсан учраас тэрийг нь орхиод ганц 2 юмыг асууя.

Засгийн газар эдгээр энэ нэмэлт, өөрчлөлтийн зорилгыг тодорхой болгож чадах уу гэдэг дээр Монгол Улсын энэ өргөн хүрээний эрчим хүч, байгаль орчны стратеги, тэгээд

ялангуяа энэ цэвэр буюу сэргээгдэх эрчим хүчний санаачилгыг ахиулах тал дээр цаашид явж байгаа бодлого дээр энэ өөрчлөлтүүд маань хэр нийцэж байгаа вэ гээд. Цөмийн материал энэ байгууламжийн аюулгүй байдал, зохицуулалтаа хангах талаар ямар арга хэмжээ авахыг санал болгож байгаа юм. Цөмийн эрчим хүч чинь өөрөө эрсдэлтэй зүйл бас мөн. Хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах хамгаалалтын арга хэмжээгээ ойлгож авах нь их чухал. Энэ чиглэлээр ямар зүйлийг иргэд болон олон нийтийн байгууллагууд мөн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хүргүүлж анхаарах вэ гэдэг дээр бас бодмоор юм шиг байгаа юм. Энэ цөмийн энергийн асуудлаар ингээд удахгүй гэрээ хийгдэнэ гэж байна. Шийдвэр гаргах үйл явцад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар хуульд заалт орсон юм уу, ороогүй юм уу. Олон нийтийн санаа зовоод байгаа зүйлд одоо эергээр юм уу үнэн бодит, зөв зүйтэй мэдээллээр хүрэхийн тулд яаж тэр дуу хоолой тэнд явагдаад байгаа зүйлийг хүргэх вэ гэдэг дээр анхаарч байгаа зүйл нь юу байгаа юм бэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн эдийн засгийн хүлээгдэж байгаа үр нөлөө, ашиг нь яг ямар байх юм гэдэг дээр бас энд хэлсэн нь зүйтэй болов уу гэж бодож байна. Тогтвортой хөгжилд ажлын байр түрүүн 1600 хүний ажлын байр нэмэгдэнэ гээд хэлчих шиг болно лээ. Тэгээд энэ технологийн дэвшлийн хувьд юу юу яг үр нөлөөтэй юм бэ гэдгийг хэлэх нь бас иргэдэд очих ойлголтын хувьд зөв болов уу гэж бодож асууж байна.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Хамтарсан Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт бид 14 мега төсөл, 14 эрх зүйн реформ гэж томъёолсон. Тэгэхээр мега төслүүд яг эрх зүйн орчныг бүрдүүлээгүйгээр цаашаа урагшилна гэж бол байхгүй. Тийм ч учраас энэ эрх зүйн реформ ч бай, төслүүд ч бай харилцан уялдаатай. Яг таны хэлж байгаагаар үнэхээр энэ төрийн өмчийн компаниудын засаглалыг ил тод болгох асуудал бол үнэхээр нийгмийн анхаарлын төвд байна. Төсвөөс гадуур хөрөнгө мөнгө хяналтгүй зарцуулагдаж байна гэдэг бол онцгой анхаарах сэдэв мөн үү гэвэл мөн.

Тийм ч учраас сая төсвийг дагалдуулаад энэ төрийн өмчийн компаниудын ил тод нээлттэй байдлын талаар Компанийн хууль дээр хэдэн зохицуулалт оруулж өгсөн. Засгийн газраас төрийн өмчийн компанийн болон орон нутгийн өмчийн компанийн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэж байна. Тэгээд энэ төрийн өмчийн компанийн засаглалын реформ хэрэгжсэнээрээ цаашдаа энэ “Мон Атом” компани Монгол талаас энэ төслийг хэрэгжүүлэгч байгууллага гаднын хөрөнгө оруулагч нартай ажиллахад процесс нь өөрөө ил тод байх энэ суурь зарчмаа хангуулъя. Засаглал нь ил тод байгаад иргэд нь хяналтаа тавьдаг энэ нөхцөл рүү явъя гэж бид нар бас зорьж байгаа. Тэгэхээр энэ бол хууль, эрх зүйн орчимтойгоо хамт явна. Тийм ч учраас энэ төслүүд хэрэгжихийн тулд эрх зүйн орчин сайжрах ёстой гэдэг утгаараа энэ удаа бас энэ Цөмийн энергийн хууль, дагалдах энэ Компанийн хууль, Татварын хуулийг ингэж өөрчлөлт оруулж байгаа юм. Тэгээд хамтдаа явж байж шийдэхгүй бол зүгээр ийм косметик засвар хийгээд бол энд өөрчлөлт бол гарахгүй юм байна гэдэг зорилгоор энэ асуудалд бас хандаж байгаа юм.

Цаашдаа бид нар бас уул уурхайн салбарт бол энэ хайгуулын салбарт нэлээн дэвшил гаргах зайлшгүй шаардлага байгаа. Нөөцийг илүү тодорхой болгох хэрэгтэй байна. Тийм ч учраас бид нар энэ Засгийн газар дээр бас энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад бас энэ асуудлаар үүрэг болгоод явж байгаа. Дээрээс нь Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр цогц реформ хийгдэнэ. Энэ бол бүхэлдээ Их Хурлаас батлагдсан тогтоолын дагуу тэр стратегийн ордуудыг баталчихсан яваад байдаг. Гэтэл хэрэгтээ зүгээр нэг цаасан дээр бичигдсэн мөртөө ард түмэн ашгийг нь хүртдэггүй. Тийм ч учраас хувийн хэвшлийн оролцоотойгоор иргэд ашгаа хүртдэг, зөв зохистой хэлбэр лүү явъя гэдэг утгаараа ингээд хэлэлцээрүүдийг үргэлжлүүлж байгаа. Үүний эхний алхам бол өнөөдөр

Цөмийн энергийн хууль анх удаа төр эзэмшлийнхээ хувийг АМНАТ-аар орлуулж авч, ард түмэндээ ноогдол ашгийг хүртээх, хувийн хэвшлийгээ ч дэмжсэн, хөрөнгө оруулагч нарыгаа ч дэмжсэн хөрөнгө оруулагч нарт тогтвортой үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн ийм бас цогц шинэчлэлийг хийж байна гэж ингэж бас ойлгож болно. Тэгээд Батбаатар даргад баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Агваанлуvsсангийн Ундраа гишүүн асуулт асууна. Чинбүрэн гишүүн асуулт асуух минутгүй болж байна. Уучлаарай.

А.Ундраа: Чинбүрэн гишүүндээ бас минут үлдээхийн тулд хурдан асууя. Монгол, Францын хооронд Засгийн газрын хэлэлцээр байгуулагдсанаас хойш 10 гаруй жил болж байна. 2010 оны 10 сарын 14-нд энэ хэлэлцээр байгуулагдаад 10 жил гаруй хугацаанд нэлээд их хойшоо ухарч, урагшаа алхаж, тэгээд 2 алхам урагшаа, 1 алхам хойшоо гэдэг шиг явж ирлээ. Тэгээд Цөмийн энергийн хуулийн энэ өөрчлөлтүүдийг зарчмын хувьд дэмжиж байна. Хийгдэх нь зөв зүйтэй. Хамрах хүрээг бол эргэж харах хэрэгтэй санагдаж байна. Магадгүй хуулийн өөрчлөлтийг ойрын хугацаанд дахиж оруулж ирэх шаардлага үүсэж болзошгүй юм. Тэгээд 5 асуулт байна.

1 дүгээрт “Мон Атом”-ын захирлаас асуумаар байна. Одоо “Мон Атом” компани бол байгуулагдсан цагаасаа хойш бас нэлээд асуудлуудтай тулгарч ирсэн. Зарим таны өмнөх удирдлагуудын хувьд бол нэлээд их өр төлбөрийн асуудлууд үүссэн. Гаднын улсаас авсан зээл тусламжийг бол буруу зарцуулсан гэх мэтчилэн асуудлууд нэлээд байсан гэдгийг бол мэдэж байна. Тэгэхээр энэ өмнөх асуудлууд, өр төлбөрийг хэрхэн шийдсэн байгаа вэ. Энэ асуудлуудын талаар бас тодруулна уу.

2 дугаар асуулт. Нийтдээ 98 мянган га талбайд тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрлийг бас хайгуулын зөвшөөрөл байна. Дээр нь “А” зөвшөөрлийг 8 талбайд 7 аж ахуйн нэгж олгосон байгаа юм байна. Энэ ямар ямар аж ахуйн нэгжүүд байгаа вэ гэдгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас асуумаар байна.

3 дугаар асуулт энэ Засгийн газрын хэлэлцээрийг ахалж хийсэн хүний хувьд бол тухайн үед хэлэлцээр хийгдэж байхад хамгийн чухал юм бол хүний нөөцийн асуудал гэдгийг тусгаж байсан. Сая бас гишүүд асууж байна. Галбадрах гишүүн ч гэсэн асууж байна. Ер нь мэдлэгт тулгуурласан эдийн засаг гэж ярьж байгаа үед бид энэ цөмийн энергийн салбар, мэдлэгийн салбарыг хөгжүүлэхийн тулд өнөөдөр тавьж байгаа хариулт бол ингээд 2 геологич төв дээр ажиллаж байгаа эд нар зэргээр ярьж байгаа юм. Гэтэл бид бол цаашлаад бас цөмийн эрчим хүчний салбарын хүмүүсээ бэлтгэхэд зөвхөн геологиор хязгаарлахгүй байх нь ойлгомжтой. Энэ үүднээсээ жишээлэхэд гүний усны динамик тооцооллын хийх, хяналтыг тавих хүний нөөцөө бэлдэх шаардлагатай гэдгийг хэлэлцээрт тусгасан. Хүмүүсээ бэлдэж чадаагүй гэдэг ийм мэдээллүүд бол явдаг. Өөрөөр хэлбэл удирдлагын шатад байгаа зарим хүмүүс нь мэргэжлийг солиод, шаардлагагүй мэргэжлээр хүн сургах зэргээр энэ авч байгаа тусламжийг бол үр ашиггүй зарцуулсан зүйлс нэлээд байгаа. Тэгэхээр Усны газрын даргаас тодруулахад гидрогеологи, усны гүний тэр динамик тооцоолол хийх хүний нөөцөө бэлдэж чадсан уу. Танай газраас санал авч байсан уу. Тийм хүмүүсийг бэлтгэх чиглэлээр цаашдаа анхаарахад бас танайхыг оролцуулж явах нь зүйтэй гэж бодож байна.

4 дүгээр асуулт Манлайжав даргаас асуумаар байгаа. Бид нар бол Цөмийн энергийн хууль гэж ярьж байгаа боловч энэ бол цөмийн циклийн хамгийн урд талын шатын буюу зөвхөн уусган баяжуулах алхмыг ярьж байна. Цаашаа бид боловсруулах баяжуулах чиглэлээр ажиллах ёстой юу, үгүй юу. Цөмийн цахилгаан станц, Атомын станц барих

тохиолдолд энэ чиглэл рүү, ялангуяа жижиг, дунд оврын реакторын судалгаа хийж байна уу. Оросын Холбооны Улс, Франц Улстай хамтарч хийж байгаа гэдэг анхан шатын мэдээлэл байна. Гэхдээ та энэ талаар тодруулж хэлж өгнө үү гэж хүсэж байна. Хэрвээ цаг үлдвэл цацрагийн хамгаалалтын хүний нөөцийн чиглэлээр бас тодруулж хэлж өгвөл сайн байна.

5 дугаар асуулт Учрал сайдаас асуухад бид бол ахиц дэвшилтэй байх үед Цөмийн энергийн газар гэж байсан л даа. Тэгээд тодорхой хэмжээний хийрхэл явагдангуут ахиад нөгөө ухралт хийдгээрээ хийгээд Цөмийн энергийн газраа татан буулгасан. Тэгээд цацраг гэдэг үгнээс л бараг айх шахуу ийм нөхцөл байдал тухайн үед явж байсан л даа. Тэгэхээр Цөмийн энергийн газрыг ахиж байгуулах уу. Байгуулах нь зүйтэй гэсэн байр суурьтай байдаг хүний хувьд бас таны Хэрэг эрхлэх газрын даргын хувьд байр суурь чинь сонсьё. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал 180 минутад багтаж асуулт асууж, хариулт авах дэгтэй. Тэгээд яг 180 минут ингээд дууссан учраас дараагийн хүн асуулт асуух боломжгүй болж байна. Чинбүрэн гишүүнд тайлбарлахад. Хариулт өгье. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон Далайжаргал. “Мон Атом”-ын захирал.

Д.Далайжаргал: Гишүүний асуултад хариулъя. Би 2017 оны 1 сард томилогдсон. Тэрнээс өмнөх байсан өр төлбөрийг бүгдийг нь барагдуулж дууссан байгаа. Хэрвээ шаардлагатай гэж байгаа бол танд би бичгээр яаж барагдуулсан тухай бичгээр явуулъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Усны газрын дарга Батбаяр.

З.Батбаяр: Ундраа гишүүнд баярлалаа. Гидрогеологийн гэлтгүй гидротехник гидрологийн мэргэжилтнүүдийн хомсдолд ороод байгаа. 2023-2024 оны хичээлийн жилд Монгол Улсын Их сургуулиуд усны мэргэжлээр ердөө 14, 15-хан оюутан суралцаж байгаа гэсэн ийм харамсалтай мэдээтэй байгаа. Тийм учраас энэ тал дээр зайлшгүй анхаарах ёстой.

Яг гидрогеологийн динамик тооцооллын тухайд бол энэ төсөлтэй холбоотойгоор хийж чадсан байгаа. Гэхдээ цаашдаа улам илүү өргөжүүлэх ёстой, байнга хийгдэх ёстой. 30 жилийн дараа ч гэсэн хийх ёстой учраас боловсон хүчний зайлшгүй шаардлагатай байгаа. Энд 10, 20 хүний бэлтгэлийн асуудал биш, 200, 300-аар бүх төрлийн усны мэргэжлийн инженерүүдийн шаардлага бол байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон хариулт өгье.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэрийн, эрдэс баялгийн яам Техник технологийн хэлтсийн дарга Намчинсүрэн. Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг бол Франц Монголын хамтарсан “Бадрах Энержи”, мөн Монголын Монгол, Чехийн хамтарсан “Гурван сайхан” компаниуд бол эзэмшиж байгаа байгаа. Танилцуулгад дурдсанаар бол 7 ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаа. Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл дээр бол “Адамс Майнинг” компани 3 зөвшөөрөл эзэмшиж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон. Манлайжав дарга.

Г.Манлайжав: Ундраа гишүүний асуултад хариулъя. Бид нар бага хэмжээний цөмийн цахилгаан станцын талаар бол судалгаанууд хийж байгаа. Тэгэхдээ бол тухайлсан улстай бол одоогоор яг судалгааны ажил, хамтарсан судалгаа хийсэн зүйл одоогоор байхгүй байна. Харин бид нар олон улсын атомын нэг агентлагтай Монгол Улсад цөмийн цахилгаан

станцыг анх удаа хөгжүүлэх орны хувьд тухайн улсын бол заавал гүйцэтгэх ёстой үндсэн 19 асуудлуудаар судалгааны ажлууд эхлээд эхний бас 2 чиглэлээр хэлэлцүүлэг явагдсан. Энэ үндэсний байр суурь болон эрчим хүчний төлөвлөлт гэдэг бай судалгаа бол явагдаж байгаа. Хүний нөөцийн хувь дээр бас нэгэнт л бид нар зүгээр цацрагийн хамгаалалт аяллын ажиллагаа чиглэлээр нэлээд бас хүний нөөцөд бэлдэж байна. Энэ ураны төсөлтэй холбоотойгоор бол бид нар Францын атомын энергийн комиссираттай бас хүний нөөц бэлтгэх чиглэлээр санамж бичиг зурсан байгаа. Бид нар энд 10 хэдэн нарийн мэргэжлийн хүмүүс, тэр дотор бол гидрогеологийн хүмүүс бас бий. Энэ төслийн нөгөө гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор санхүүжилт түр хугацаагаар бас сааталтай байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Учрал сайд нэмж хариулах юм уу. Нэмж хариулъя.

Н.Учрал: Цөмийн энергийн хуульд дагаж энэ нэмэлт, өөрчлөлт орж байгаа хуулиуд дээр ч гэсэн ялангуяа тэр уурхай хаалтын төлөвлөгөө нөхөн сэргээх ажил дээр цөмийн энергийн комисс хяналт тавих гээд ингээд үүргийн хувьд бол их өндөр болж байгаа. Тийм ч учраас ер нь бол цаашдаа цөмийн энергийн байгууллагыг бол төрийн захиргааны байгууллага болгох статусыг нь өргөжүүлэх шаардлага бол зүй ёсоор тавигдана гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Нэр өгсөн дарааллаар Пүрэвдорж гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Ураны энэ төслийг жадлан эсэргүүцээд тэгнээд хэвтээгүй шүү дээ. Та нар зүгээр шар нунтаг гаргах тухай л яриад байхаа болиод, хямд, ногоон эрчим хүч гаргая л гэдэг тухай ярьж байгаа шүү дээ. Тэр тухай энэ эрх зүйн орчин дээр юу ч алга. Зүгээр л шар нунтаг гаргадаг Африкийн орнуудын нэг больё л гэж эрх зүйн орчин орж ирж байна. Энэ дээрээ өөрчлөөд, дараад нь энэ уранаар эрчим хүч гаргаж хямд эх үүсвэрээр аюулгүй байдлаар Монголын ард түмнийг хангана гэдэг эрх зүйн орчин оруулж ирж болоогүй юм уу л гэж асууж байгаа. Яагаад энийг эсэргүүцэж байгаа учир нь энэ.

2 дугаарт Эрдэнэболд гишүүн маш чухал зүйл ярьсан. Түрүүн олон нийтийн мэдээллийг өгөх, мэдлэгжүүлэх оролцоог хангах гэдгийг одоо бол ерөөсөө л фэйсбүүкээр та нар ярих л юм бол гадаадын тагнуул болно шүү л гэж айлгаад байдаг. Хэдэн тархи угаагчдаар яг Оюутолгой дээр ярьж байсан хүмүүсээр яриулж байгаа. Энэ тэнэглэлээ зогсоо та нар. Өнөөдөр Үндсэн хуулийн 6.2-т Монголын ард гагцхүү гэж үг байгаа шүү. Гагцхүү Монголын ард түмний мэдэлд байдаг ураны уурхай ярьж байгаа шүү. Ураны ашигт малтмалын тухай ярьж байгаа. Тэгэхэд тэр ард иргэд нь өнөөдөр олдож байгаа нь фэйсбүүк л дээ. Та нар шиг том том нэвтрүүлэг хийж чадахгүйгээс цааш. Ярих эрхийг нь битгий хаагаарай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Эрдэнэболд гишүүн бас хэлсэн 6 заалттай шинжээчийн дүгнэлтийг нийлүүлсэн үү гэж асуусан. Миний түрүүн ярьж байгаа уран мэддэг ураныг долоож үзсэн гээд та нарын киног үзсэн л дээ. Долоож үзсэн. Тэр тухай экспертүүдийг би яриагүй шүү. Ураны талаар ийм хэмжээний гэрээ, эрх зүйн гэрээ байгуулж үзсэн хүн байгаа юу л гэж байгаа юм. Манайх Оюутолгой дээр гэрээн дээрээ л алуулсан байхгүй юу. Тэр Оюутолгойн тэр уул уурхайн инженерийн байгууламж дээр бол

би ярих юм байдаггүй. Оюутолгойг нэг ч удаа эсэргүүцэж байгаагүй. Ганцхан Монголд ашигтай юу гэж хэлсэн. Өнөөдөр энэ Монголд аюултай юу. Хямд эх үүсвэр эндээс үүсэх үү, бий болох уу, цахилгаан үйлдвэрлэх үү, үгүй ээ. Бусад орны хямд эх үүсвэрээр цахилгаанаар хангахад нь манайх шар нутгаар нийлүүлнэ гэдэг эрх зүйн орчин орж ирж байна. Арай гомдмоор юм. Байгаль орчны үнэлгээний талаар 1 ч ярихгүй байна.

Энэ 8 хүн бол дахиад 10 жилийн дараа сайн ёрлоё. Уранаар бид нар чинь зүгээр сайхан цахилгаантай болсны дараа та 8-ыг Монголчууд мартаггүй. Эсрэгээрээ бол бас Монголчууд мартаггүй. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл Оюутолгой дээр би 600 тэрбум долларын үнэтэй уул уурхайн курст суучихсан ард түмэн шүү дээ. Одоо бид нар энэ 3-5 тэрбум долларын л эргэлт гарч байгаа. Ашиг нь 3 тэрбум доллар л гэж ярьж байгаа. 30 жил гэвэл 1 жилд 100 сая доллар л юм шиг байгаа юм. Эдийн засгийн хувьд маш бага үр ашигтай, стратегийн хувьд хямд эрчим хүч, хямд эх үүсвэрээр хангагдана гэдэг нь л бидний туйлын зорилго. Энийгээ эрх зүйн орчныг нь бүрдүүлэхгүйгээр зүгээр эхлээд шар нутгаа гаргаадахъя гэвэл одоо би гол зүйлээ ярих гэсэн юм. 13 лиценз байна энэ уурхайн. 13 лиценз, 13 ураны лиценз байна. Үүний Зөөвч овоо, Дулаану-Уул 2 нь үндсэндээ нийт энэ ураны өрөм нь байгаа. 97 хувь байгаа 1 тоннд харьцах грамм нь 234 гр гэдэг нь Зөөвч овоо, Дулаан-Уул нь 188 байгаа. 217 байгаа. 3 янз байгаа. Бусдууд нь 1 тоннд 0,034, зарим нь 347, хамгийн их нь 0,111гр байсан. Үндсэндээ та нар энэ өрмийг нь шар нунтаг болгоод Оранад өгчхөөд дараа нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ. Индэр дээрээс. Алга байна. Батын Батбаатар гишүүн. Индэр дээрээс үг хэлнэ.

Сая дэг зөрчигдөөд ширээн дээрээс хэлүүлчихлээ уучлаарай. Дэгээрээ индэр дээрээс хэлэхээр байгаа. 2 дугаар индэр дээр очихыг хүсье.

Б.Батбаатар: Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох хуулийн хуулийн өөрчлөлтийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг өнөөдөр шийдвэрлэхээр болж байна. Энэ шийдвэр нь цөмийн эрчим хүчний хувьд ихээхэн ач холбогдолтой асуудал байна. Бодлого нь үндэсний аюулгүй байдал, байгаль орчны эрүүл мэнд, Монгол улсын тогтвортой хөгжлийн замд шууд нөлөөлнө. Тийм учраас дараах саналыг хэлж байна.

1 дүгээрт нь манай цөмийн энергийн хуулиудад оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг аюулгүй байдал, байгаль орчны стандартын дагуу үнэлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Санал болгож буй өөрчлөлтүүд нь Монгол Улсын эрчим хүчний ландшафтыг өөрчлөх боломжтой тул эдгээр нэмэлт өөрчлөлтийн үр дагаврыг бүхэлд нь үнэлэхийн тулд сайтар судалж үзэх шаардлагатай.

2 дугаарт нь цөмийн бодлогын талаарх аливаа хэлэлцүүлэгт олон нийтийн оролцоо ил тод байдал амин чухал. Цөмийн энергийн мэдрэмжтэй учраас төр олон нийтэд олон нийтэд мэдээлэл авах санал бодлоо илэрхийлэх боломжийг нь иргэдэд хангаж өгөх ёстой. Энэ нь олон нийтийн итгэлийг бий болгоод зогсохгүй, ардчилсан засаглалын төлөөх бидний амлалттай нийцэх ёстой.

3 дугаарт нь. Эдийн засгийн боломжит нөлөөллийг сайтар судлах шаардлагатай. Цөмийн энерги нь боломж эрсдэлийг хоёуланг нь авчирна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь ажлын байр бий болгож, технологийн хөрөнгө оруулалтыг татаж, дэлхийн эрчим хүчний

зах зээлд Монгол Улсын байр суурийг ахиулж чадах уу, эсвэл тогтворгүй, хараат байдалд хүргэж эрсдэл байна уу гэдгийг бид ойлгох ёстой.

Түүнчлэн эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь манай олон улсын үүрэг ялангуяа цөмийн аюулгүй байдал, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлагатай нийцэж байх ёстой. Монгол Улсын нэр хүнд, энх тайвныг эрхэмлэгч гүрэн цөмийн зэвсгээс ангид статус нь бидний олон улсын өвөрмөц байдлын үндэс юм. Аливаа хууль, эрх зүйн өөрчлөлт нь эдгээр амлалтыг хүндэтгэж, дэлхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлд ажиллаж байх ёстой.

Тиймээс Монгол Улс ногоон хөгжлийн төлөө тууштай ажиллаж байгааг харгалзан энэхүү хэлэлцүүлгээр сэргээгдэх эрчим хүчний зорилтууд болон хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зэрэг өргөн хүрээний эрчим хүчний стратегид цөмийн эрчим хүч хэрхэн нийцэж байгааг хууль хэлэлцэх явцдаа авч үзэх нь гэдэгт итгэл дүүрэн байна.

Цөмийн эрчим хүч нь бидний хувьд тогтвортой сонголт мөн үү гэдгийг бодолцож, түүний үүргийг илүү ногоон, илүү эрүүл ирээдүйн төлөөх бидний хүсэл тэмүүлэлтэй харьцуулан авч явах хэрэгтэй байна. Эдгээр шалтгааны улмаас энэ асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг дэмжиж байна.

Ард түмний төлөөлөл болсон бид эдгээр нэмэлт, өөрчлөлтийн нарийн ширийнийг сайтар судалж, Монгол Улсын эрх ашигт нийцэж, бидний үндсэн үнэт зүйл, алсын хараатай нийцэж байгаа эсэхийг шалгаж, нягталсны үндсэн дээр хуулийг батлах нь зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн индэр дээрээс үг хэлнэ. 2 дугаар индэр.

Н.Номтойбаяр: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Дэмжиж байгаа шалтгаан нь юу вэ гэхээр энэ гадаад харилцааны нэг таатай цонх үе Монголчууд бидэнд тохиогоод байна. Тэгээд энэ үед бас энэ чухал стратегийн түншлэл, гадаад харилцаа, эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдал хангагдах ийм нөхцөл үүсэж байгаад талархаж байна. Манайх чинь нүүрс, зэс экспортлохоос өөр илүүцгүй, ядруухан эдийн засагтай. Нөгөө талаараа эдийн засгийн бодлогын хүрээнд бас нэг бодитой олон жил дуншиж гацсан энэ ажил маань бас эхлэл болж байна. Гэхдээ анхаарах хэд хэдэн зүйлүүд байна. Хууль, эрх зүйн орчин хэлэлцээр хийх таатай нөхцөлийг бүрдүүлээ гээд хэлэлцээрээ бид урьд урьдын алдааг давтахгүйгээр улс орныхоо язгуур эрх ашгийг хамгаалсан эдийн засаг, гадаад харилцааныхаа бодлогыг чухалчилж үзсэн. Ийм байр сууринаас хандах хэрэгтэй. Үүний хажуугаар элдэв авлига, далд тохироо хэрхэвч байж болохгүй. Тэгэхээр энэ хэлэлцээрийн үе шат эхлэхэд ил тод нээлттэй явах ёстой гэдгийг анхааруулж хэлмээр байна.

2-т нь юу вэ гэхээр энд 1 зүйлийг ингээд анзаараад байхаар атаархаад байх юм. Юу вэ гэхээр яаралтай горимоор орж ирж байгаа юм. Яах вэ бас нөхцөл байдал олон ч учир шалтгаан байна. Энэ гаднын хөрөнгөтэй хүчирхэг компанийн өмнө л манайхан өвдөг сулраад л тайчих нь холгүй л болоод байдаг. Дотоодынхоо хэдэн аж ахуйн нэгж, компаниуд дотор болохоор дээрэлхээд л, доромжлоод л, хааж боогоод байдаг. Энэ ялгавартай ханддаг хандлагыг өөрчилмөөр байна. Энэ гэрээний нөхцөлүүдийг энэ дагалдаад орж ирж байгаа хуулиудын өөрчлөлтүүдийг харахаар бас атаархмаар байгаа байхгүй юу. Маш сайхан таатай нөхцөлүүдийг бүрдүүлж байна. Энэ жишгээрээ бид нар бас явмаар байх юм. Үүнтэй уялдуулаад энэ гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засгийн болон эрх зүйн таатай нөхцөл байдал Монголын төр бүрдүүлчхээд орж ирээд байгаа зүйл ердөөсөө биш. Яах аргагүй энэ

ураны түүхий эд дэлхийд хомсдоод, үйлдвэрлэлийн хүчин чадал Монгол руу л чиглээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар гэрээ хэлэлцээрээ хийхдээ булган сүүлтэй гэж монголчууд ярьдаг даа. Үнэхээр нэг Монголын төр гаднын хөрөнгө оруулалтад ийм харилцан ашигтай байдлаар хандаж байгаа гэдгийг үлгэр жишээ болгож гэрээ байгуулаад, өөр бусад олон салбарууд дээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах ийм боломжийг бас бүрдүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Үлгэр жишээ гэрээ байгаасай гэж хүсэж байна. Энэ дээр Засгийн газар бас анхаарна биз. Тэгээд дэмжиж байгаа шалтгаанууд энэ байна. Тэгээд хамгийн гол нь хэлэлцээр их чухал. Хууль батлах нэг асуудал. Хамгийн гол нь хэлэлцээр. Энэ дээрээ л ил тод, нээлттэй, улс орныхоо язгуур эрх ашгийг хамгаалсан холыг харсан ийм л хэлэлцээр хийгээсэй гэж хүсэж байна. Амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ. 2 дугаар индрийн микрофон дээр очъё.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Тэгэхээр би бас Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжиж үг хэлэх гэж байна. Чухал хууль бид бас яаралтай журмаар хэдий орсон ч гэсэн Монгол Улс бас урагшлах том, ялангуяа геополитикийн ийм хүнд үед тэр дотроо тухайн улсын тусгаар тогтнолыг баталгаажуулдаг энергийн эх үүсвэрийн сувернитетийг хадгалж байгаа зүйл бол бид бас энэ нүүрс, түүхий нүүрс түлдэг, түүхий нүүрс хэрэглэдэг энэ байдлаасаа гарах нэг алхмын эхний алхам энэ байхгүй юу. Тэгэхээр 1 дор бүгдийг шийднэ гэж бодож байгаа бол энэ бас тийм амархан зүйл биш. Аливаа зүйл алхам алхмаар урагшлах ёстой. Тийм учраас эхний том алхам бол одоо хийгдэх гэж байгаа энэ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Би бас тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатартай яг Улаанбадрах дээр очиж шар нунтгийг гараараа барьж үзэж байсан. Эмч хүний хувьд бас дозиметр тавьж шалгаж үзэж байсан. Иргэдийн дунд басих тийм айдас байгаад байгаа юм шиг байгаа юм. Шар нунтгаа гаргаад, тэгээд буцаагаад гаргасан учраас буцаагаад нөгөө хэрэглэсэн хаягдлыг нь Монголдоо булшлах юм шиг ойлгоод байгаа юм. Тэгвэл энэ хууль дээр бүр 4.2-т гадаад улсын цацраг идэвхт хаягдал ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын дэвсгэрт булшлахыг хориглоно гээд бүр заалттай орчихсон учраас иргэд одоо итгэл дүүрэн байх боломжтой шүү. Энийг одоо Монголдоо буцааж авчирч булшлах тийм асуудал байхгүй. Тийм учраас бол итгэл дүүрэн байж болно.

2 дахь зүйл бол бас энэ цахилгаан эрчим хүчтэй одоо яг ид олон нийтийн дунд яригдаж байгаа. Эрчим хүчний үнийг чөлөөлөхтэй холбоотой асуудал яригдаж байна. Баянзүрх дүүргийн иргэд маань одоо бас олон мессежүүд ирж байна. Үнэ тариф өслөө, барилаа гэж. Буцаад л нөгөө түүхий нүүрсээ түлэх ийм эрсдэл, аюул байна. Би бас өөрөө энэ түүхий нүүрсээс ялгардаг хүхрийн ислийн дутуу исэлтэй холбоотой энэ нь хүний эрүүл мэндэд ямар хортой нөлөөлдгийг бас судалгаа хийж баталгаажуулсан. Тийм учраас бид бас эрчим хүчний асуудал дээр бас онцгой анхаарч бэлтгэл хангах, тэгээд бэлтгэлийг нь хангаж байж дараагийн том чөлөөлөх асуудалд орох ёстой. Үүнтэй уялдаад бас цөмийн энергийн аюулгүй ашиглах асуудлыг бид бас ярих ёстой байхгүй юу. Цацраг идэвхтэй бодис гэхээр бид зөвхөн одоо энэ уул уурхайн бүтээгдэхүүн гэж бодоод байх юм. Тийм биш шүү дээ. Өнөөдөр бид аюулгүй, цацраг идэвхтэй цөмийн энергийг эрүүл мэндийн салбарт өргөн ашигладаг болсон.

Би Хавдар судлалын төвийн захирал байхдаа олон олон цацраг идэвхтэй бодисуудыг нэвтрүүлэх гээд ямар их шалгуурыг давдаг байсан. Одоо бүр байхгүй болчихжээ. Мэргэжлийн байгууллага нь бүр статус нь буучихсан. Сая Засгийн газрын Хэрэг эрхлэхийн

дарга Учрал гишүүн бас хэлж байх шиг байна. Статусыг нь анхаарна гэж. Тэр хууль хэлэлцэх явцад бүр агентлагийн хэмжээнд цацрагийн хяналтын албыг аваачих ёстой шүү дээ. Тийм ээ. Энэ бол улсын хэмжээнд цацраг идэвхтэй бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, технологийг ашиглах тогтолцоог аюулгүй байлгах, ард иргэдэд ямар нэгэн цацрагийн аюул учруулахгүй байх энэ тогтолцоог бид дээшлүүлэх ёстой. Энэ хуулийн төслийг хэлэлцэх үед та бүхэн энэ дээр илүү их анхаарч, манай гишүүд ч гэсэн энэ дээр анхаарал тавих байх гэж бас найдаж байна. Тэгээд энэ ажилд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Ингээд үдийн цайны завсарлага 13 цаг 30 минут хүртэл үргэлжлэхээр байсан. Үдээс өмнөх чуулган. Тэгээд үдийн цайны завсарлага болсон байгаа учраас санал хураалтыг хойшлууллаа. Түр завсарлага. Нэгдсэн хуралдааны үдээс хойших чуулган 14 цаг 30 минутаас үргэлжилнэ.

13.39 цаг.

ЗАВСАРЛАГА.

Д.Амарбаясгалан: Түр хойшлуулж байна. 3 дахь асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

З.Мэндсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 5 хууль, Улсын Их Хурлын 3 тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэн санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд болон хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн.

Төслүүдийн тухайн зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явууллаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал туссан төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батлахаар, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гаалийн татварын хөнгөлөлт эдлэх боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батлахаар, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим хэсэг заалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7 дахь заалтад заасны дагуу бусад хуультай нийцүүлэн өөрчлөх саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Дээрх ажлын хэсгээс “Засгийн газрын үнэт цаас гаргах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын Засгийн газраас 2025 онд гадаад, дотоодод гаргах үнэт цаасны хэмжээг 4 их наяд төгрөгөөр тогтоох өөрчлөлт оруулах, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлан өөрчлөхгүй байхтай холбоотойгоор ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, ТЭЗҮ зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох, мөн нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх, Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн аудитын дүгнэлт гаргуулж, нэгдсэн журмаар шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх мөн дэмжсэн болно.

Ажлын хэсгээс гаргасан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварын хөнгөлөлт эдлүүлэх жагсаалтыг 2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцаас гаргасан Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх, Инновац шингэж, шинээр бүтээгдсэн олон улсад туршигдсан бараа материал, барилгын ажил гүйцэтгэх арга барил, тэргүүн туршлагыг барилгын салбарт хурдацтай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм нормативын баримт бичиг, дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга, байгууламжийн норм нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу зүйл бүрээр хэлэлцэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мэндсайхан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Сүхээгийн Тэнгис Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны ажлын албаны дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батнямын Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Цэрэннадмидын Шинэхүү Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга, Даваасамбын Дэлгэрмаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Бат-Эрдэнийн Пунцаг Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны ажлын албаны Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглал хариуцсан шинжээч.

Ингээд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 19 гишүүний нэр ирсэн байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Та бүхэндээ бага үдийн мэндийг хүргэе. Улсын төсвийн хуулийг дагалдуулаад бас олон хууль оруулж ирж байгааг бол эсэргүүцэж байгаа анхнаасаа. Яагаад гэхлээр ингээд дагах байдлаар хуулиуд оруулж ирээд байхаар бас тухайн хууль тогтоомжуудын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь олон нийтийн хэлэлцүүлгээр явахгүй ийм байдлаар илүү хөнгөн хуумгай яаруу сандруу байдлаар батлах гэж байгаа ийм зүй тогтол яваад байна. Тэгээд энэ татварын тухай хууль, Гаалийн тухай хууль энэ тэр дээр болохоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг ингэж төсвийн хуулийг дагалдуулж орж ирүүлэх нь цаашдаа бас асуудал дагуулна гэсэн ийм байр суурьтай байгаад байгаа. Тэгээд энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуультай холбоотой, мөн одоо Гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудлаар ажлын хэсгээс дараах асуултыг асуумаар байна. Тэр нь юу вэ гэхээр ер нь энэ хууль хэрэгжсэнээр хэдий хэмжээний татварын хөнгөлөлт ирэх жил бөгөөд дараа дараагийн жилүүдэд хэчнээн аж ахуйн нэгж ямар татварын хөнгөлөлт эдлэх вэ гэдэг дээр яг ийм тодорхой тооцоо судалгаануудаа хэлж өгөөч гэдэг 1 дүгээр асуудал байгаад байна.

Тэгээд мөн 3 Улсын Их Хурлын тогтоолын төсөл энэ хуулийг дагалдаж орж ирж байгаа. Энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор Засгийн газарт үнэт цаас гаргах эрх олгох тогтоолын төсөл ороод ирчихсэн байж байгаа. Тэгээд энэ тогтоолын төсөл дээр болохоор тодорхой үнийн дүн бол огт тавигдаагүй. Сая зарчмын зөрүүтэй саналууд дээр болохоор 4 их наяд гэсэн ийм тоо тавигдаад орж ирсэн байна. Тэгэхээр ер нь энэ 2025 онд Монгол Улсын Засгийн газар ямар хэмжээтэй, ямар бондуудыг хаана, аль зах зээл дээр гаргахаар төлөвлөж байгаа юм бэ. Тэгээд тэр дээр бас тодорхой тайлбар өгөөч. Тэгээд энэ бондын эх үүсвэрээр олж ирж байгаа мөнгийг ямар зүйлүүд дээр бас зарцуулах вэ гэдэг ийм асуулт байна. 2 дугаар асуулт.

Тэгээд энэ хуулийн хэлэлцүүлэгтэй холбоотой бас Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр бас тодорхой ийм зөрчлүүд байгаад байна. Яасан бэ гэхээр Төсвийн тухай хуулийг дагалдаж орж ирж байгаа хуулийн төслүүдийг бид өнгөрсөн баасан гарагт хэлэлцэх эсэхийг нь бол нэгдсэн чуулганаар хэлэлцсэн. Тэгмэгц Байнгын хороодын хуваарь болохоор хагас сайн өдөр бямба гарагт тавигдсан байж байгаа. Тэгээд зарчмын зөрүүтэй саналуудыг харьяалагдах мэргэжлийн Байнгын хороонд 2 хоногийн өмнө өгнө гэсэн ийм хязгаарлалт байгаад байгаа юм. Тэгээд 1 дэх өдөр очоод Байнгын хороондоо зарчмын зөрүүтэй санал өгье гэхээр хугацаа нь дуусчихсан гэсэн ийм асуудал яригдсан. Тэгэхээр энэ дээр бол энэ 48 цагийн буюу 2 хоногийн хязгаарлалт өгч байгаа нь бол Улсын Их Хурлын гишүүдийн бас бүрэн эрхийг хязгаарласан, Улсын Их Хурлын бүрэн эрхэд бас халдсан ийм зохицуулалт байгаад байна. Тэгэхээр энэ дээр бас Хурлын дарга анхаарч өгөөч гэсэн хүсэл байгаад байна.

Тэгээд энэ Дэгийн тухай хуулиараа жишээлбэл хэлэлцүүлэг хоорондын зай 5 хоногийн зайтай байх ёстой гэж байгаа. Тэгэхээр энэ бямба гарагт хэлэлцсэн асуудлын дараагийн хэлэлцүүлгийн үе шат өнөөдөр ороод ирж байна. Тэгэхээр 4 хоногийн зайтай байна гэж хараад байна. Тэгэхээр энэ мэт Дэгийн тухай хуулийнхаа хэрэгжилт дээр бас хэдүүлээ анхаармаар байна. Эс бөгөөс бид энэ хуулийн төслүүдийг бол маш тийм замбараагүй байдлуудаар хэлэлцээд, тэгээд энэ цаг хугацааны хайчинд баригдсан байдлаар бас нэг ийм тодорхой ийм бодлогын мэтгэлцээнүүд, хэлэлцүүлгүүд бол тийм чанарын шаардлага хангахгүй байна гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн. Даваасүрэн гишүүний микрофон өгье.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Жаргалан гишүүний асуултад хариулъя. Ер нь саяын ялангуяа энэ төсвийн хуулийг дагаж өргөн мэдүүлсэн хуулиуд дээр гишүүд бол нэлээн хариуцлагатай хандсан гэж би бодож байгаа. Тийм учраас ажлын хэсэг дээр ч тэр, Байнгын хороон дээр энэ дагасан хуулиудыг хэлэлцэхдээ бид нарын нэг анхаарсан юм бол гишүүдийн саналыг аль болох тусгахыг эрхэмлэсэн байгаа. Тухайлах юм бол Татварын тухай хуулиуд. Татварын хууль дээр бол ерөнхий заасан байна. Их Хурлын эрхэнд халдсан байна гэдэг саналуудыг Баярмаа гишүүн, Энхбаяр гишүүд чуулганы хуралдаан дээр бас ярьж байсан. Энэ саналыг бид нар бас хэлэлцүүлгийн явцад Жаргалан гишүүн ч бас тэгсэн байх. Тэгээд бид хэлэлцүүлгийн явцад ер нь нэлээн нарийвчилъя гээд. Тухайлах юм бол

экспортыг дэмжих, импортыг орлох бүсчлэлийн шинж чанартай татварын зохицуулалтыг хийх асуудлыг бол жагсаалтыг нь гаргаж ирээд ингээд Их Хурлаар батлуул гэсэн байгаа. Ерөнхий биш гэж.

2-т мөн боловсруулах үйлдвэрийг ч гэсэн тодорхой салбарыг нь зааж өгнө Их Хурлаар. Яагаад гэвэл Их Хурлын онцгой бүрэн эрхэд бол ямар бараа бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх вэ, ямар хэмжээгээр чөлөөлөх вэ гэдэг бол байдаг зүйл. Тийм учраас гэх мэтийн Их Хурлын гишүүдийн чуулганы хуралдаан дээр, Байнгын хорооны хуралдаан дээр гаргасан саналуудыг бол аль болох бид нар энэ дагасан хуулиуд дээр тусгаж оруулж ирсэн байгаа. Тийм учраас би дагасан хуулиуд дээр бол та бүгдийн санал боломжийн хэмжээнд туссан гэж үзэж байна.

Тэр хэлэлцүүлэгтэй холбогдолтой асуудал дээр бол бас ер нь сая орон нутгийн сонгууль бас нэлээн нөлөөлчихлөө. Орон нутгийн сонгуулиас өмнө бол хэлэлцүүлэг хийсэн шүү дээ. 9 сард хийгдсэн. Тэгэхдээ тэр бол бас хангалттай биш байх. Яг Байнгын хороодоор хэлэлцэх явцад бол тэгж хэлэлцүүлэг бол хийгдэж чадаагүй. Хэлэлцэхээс өмнө 10 сарын 1-ээс өмнө бол иргэдийн дунд цахим янз бүрийн хэлбэрээр бол бас тодорхой салбаруудын төлөөлөлтэй хийсэн хэлэлцүүлгүүд бол явагдсан.

Төсвийн байнгын хороо дээр ажлын хэсэг дээр нэг яригдсан зүйл бол зарчмын зөрүүтэй саналуудыг 2 хоногийн өмнө гэдэг хязгаар бол бас хүндрэлтэй байна гэдэг зүйлийг гишүүд нэлээн ярьсан. Зарим дээр нь ч маргаан ч үүссэн. Жаргалан гишүүн дээр ч маргаан ч үүссэн байх. Аль 2 хоногийг нь тооцох юм. Ажлын өдрүүдийг тооцох юм уу, үгүй юу. Амралтын өдрүүд орох юм уу, үгүй юу гээд л. Тэгээд ер нь ялангуяа энэ төсвийн хэлэлцүүлэг дээр бол 2 хоногийн өмнө гэж хязгаарлаж байгаа бол жоохон зохимж муутай юм шиг байна лээ. Тийм учраас энийг Дэгийн хуулийг ер нь нэг эргэж харах, тэгээд Дэгийн хууль маань өөрөө яг сонгуулийн өмнөхөн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулья. Тэр дагасан хууль ямар учиртай юм бэ гэж Жаргалан гишүүн асуулаа. Би танд нэг хуулийн заалт уншиж өгье. Татварын ерөнхий хууль дээр ийм заалт байгаа.

“4.2.Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна.” Татварын ерөнхий хуулийн 4.2 шүү. Ийм хуулийн заалттай байдаг. Тэгэхээр сүүлийн 30 жил ингэж явж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл ирэх жилийн төсвийг өргөн барихад олон нийт ирэх жилд татварын бодлого ямар байх нь вэ, ямар өөрчлөлт гарах нь вэ гээд яг ингээд хүлээж байдаг. Дараа жилийнхээ бизнесийг боловсруулахдаа, төсөөллөө хийхдээ төсөв дагасан ямар өөрчлөлтүүд гарах нь вэ, ирэх жилийн төсвөөр эдийн засгийн төлөвлөлт ямар байх нь вэ энэ бүгдийг харж байдаг, хүлээж байдаг ийм зүйл байдаг.

Д.Амарбаясгалан: Энэ дээр бас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй Төсвийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны гишүүдийн хамтаар бас бид уулзалт хийсэн байгаа. Тэгээд энэ оны төсөв батлагдсаны дараа бид бүх талын оролцоог хангасан ажлын хэсгийг өргөн хүрээгээр байгуулаад, ирэх жилээс эхлээд дахиад энэ төсөв өргөн барих процесс, дэгийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа хугацааны интервал зэрэг зүйлүүдийг элдэв зөрчилгүй болгох чиглэл дээр бүх талаасаа хамтарч ажиллаа гэж байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсэгт бас Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн саналаа, нэрээ өгөөд

бас ажлын хэсэгт орж болно. 11 сарын 20-д хавьцаа энэ ажлын хэсгийг байгуулаад явна гэж байгаа юм. Дараа жилийн төсөв хэлэлцэхэд иймэрхүү төрлийн зөрчлүүд байдаггүй байх тэр нөхцөлийг бий болгоно гэж ингэж зорьж байгаа. Болдын Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Би ойлгосон, ойлгосон. Нэмж хариулья тэгвэл. Ийм юм байгаа юм шүү Жаргалан гишүүн ээ. Та хуулиа нэг бүрчлэн уншиж байгаа болов уу гэж би найдаж байна. Ирэх жил гаргах гадаад, дотоод бонд зээллэгийн хэмжээг 300 тэрбум төгрөг хүртэл гээд хууль дотор нь орчихсон байгаа. Тэрүүгээр хэмжээг нь заачхаж байгаа юм. Тэрийг тогтоолоор нөгөө бонд гаргах процессыг нь тавьж өгч байна гэсэн үг байхгүй юу. Тэгээд дараа нь тэр чинь дахиад Их Хурлаар орж ирнэ. Яг ямар бонд гаргах вэ, юунд зориулах вэ гэдгээ. 300 тэрбум төгрөг хүртэлх нь бол Засгийн газар юундаа зарцуулахаа тухайн үедээ бодлогоороо шийднэ гэсэн үг. Энэ дээр ажлын хэсэг харин хэмжээ тавьсан. Хэмжээ тавьсан. Хэмжээ нь 4 их наяд гэж тавьсан. Ажлын хэсгийн дарга бас нэмж хариулах болов уу гэж бодож байна.

Засгийн газрын өрийн үлдэгдлийг нэмдэг бонд байна, нэмдэггүй бонд байна. Дахин санхүүжилт хийж байгаа бондууд бол гадаад зээл дээр ямар ч өр, авлага үүсэхгүй. Нэмэгдэхгүй гэсэн үг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна. Алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Надад 2 асуулт байгаа юм. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хууль бас нэлээн олон юм болж бас батлагдсан. Үндэсний баялгийн сан дотроо бас хамгийн чухал нэг сан нь өөрөө үндсэн хуулийн 6.2-т заасан байгалийн баялаг одоо болон ирээдүй үедээ илүү тэгш, шударга, хүртээмжтэй очно гэсэн концептын дагуу бол хуримтлал үүсгэх, ирээдүйн өвдөө хадгалах ирээдүйн өв сан байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1а-д Орон нутгийн хөгжлийн сан болон Тогтворжуулалтын санд ороод үлдсэн АМНАТ-ийн 65 хувийг бид нар хуримтлуулж явна. Нэг ёсондоо АМНАТ-ийнхаа 2/3-г бид нар дандаа ингээд цаашаагаа ирээдүй үедээ хадгалж явах ёстой. Байгалийн баялаг өөрөө шавхагдах баялаг. Тэгэхээр энэ хуримтлал, ялангуяа эдийн засаг, төсөв тэлж байгаа үед улам бид нар хуримтлалаа илүү журмынхаа дагуу ч юм уу, эсвэл хуулийнхаа дагуу бүрдүүлэх боломж нь гэсэн үг л дээ. Эдийн засаг хүнд үед бол бас дахин авч үзэх шаардлага гарч магадгүй юм. Тэгэхээр одоо яг энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмаар бол бид нар нөгөө 65-аа энэ дээр 40 болоод орж ирж байгаа юм байна л даа. Тэгэхээр би ойлгож байна. 2024 онд бол энэ бас бүр 20 хувь болсон шүү дээ. 20 хувиар энэ дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад. Тэгэхээр бид нар сүүлийн 2 жил 20, 40 хувь болгочихоор яг үүүний дундаасаа дахиад тооцоолох юм. Би нэг тооцоолол гэж үзсэн л дээ. Тэгэхээр бараг 3 их наядыг бид нар хадгалах боломж нэг ёсондоо алдагдсан боломжийн өртөг болоод үлдчихэж байгаа юм л даа. Тэгэхээр энийг бид нар цаашдаа яах вэ. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журам чинь ингээд өөрчлөөд байхаар Үндэсний баялгийн сангийнхаа гол концептыг ингээд эвдээд байх юм биш үү.

2 дугаарт “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоол бас орж ирж байгаа. Энийг бол үнэхээр дэмжиж байгаа. Ёстой л 2 гараа өргөөд дэмжиж байгаа. Ялангуяа тэр дундаа төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал үр ашигтай ажиллагааг сайжруулах. 2 л статистик хэлье. Төрийн өмчит 100 топ компанийн 2023 оны дата л надад байна. Хөрөнгийн өгөөжийг нь аваад үзэх юм бол ерөөсөө 3,5 хувь л байсан байгаа юм. Нийт хөрөнгийн хэмжээ нь 60 их наяд буюу өнөөдрийн ДНБ-тэй бараг 80 хувьд нь хүрэхүйц

хэмжээнд ингээд томорчихсон гэсэн үг. Төсөв тэлж байгаа энэ үед эдийн засагт нэг ёсондоо төрийн мөнгө илүү мөнгөн дүн илүү урсаж орж байгаа энэ үед бол нөгөө талдаа төрийн оролцоог баланслахын тулд ТӨК-удын томоохон реформууд нөгөө талдаа бид нар явж байж бас эдийн засаг хувийн сектор илүү байх орон зайг нь бид нар баланслах ёстой юм. Тэгэхээр 1 талаасаа төсөв тэлж байгаа бол яг нөгөө талдаа тэлсэн чигээрээ ТӨК-ийн шинэчлэл яг тэр чинээгээрээ давхар паралельны хийгдэх ёстой. Тэгэхээр яг энэ төрийн өмчит компанийн томоохон шинэчлэлийг оруулж ирж байгаа хуулийн нэмэлт, өөрчлөлт бас энэ чиглэл дээр орж ирж байгаа нь аягүй сайшаалтай хүлээж авч байгаа. Тэр дундаа бас яг 1.6 дээр нь нэг асуулт байгаа юм л даа. Ер нь энэ топ 10 ААН-ийг нь хөрөнгийн хэмжээгээр нь аваад үзэх юм бол Төрийн банк байгаа. Төрийн банкны чиг үүргээр шинэчлэн зохион байгуулна гэж орж ирснийг бас дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч. Ер нь Төрийн банкны чиг үүргийг цаашаа явуулахад энийг яг юу гэж харж байгаа юм бол. Тэгэхээр төрд бас банк байх нь Төв банкнаас өөр банк байх нь бас ямар давуу талыг энэ дээр бас үүсгэж байгаа юм бол. Энэ талаар асуух гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Эхний тэр ашигт малтмалын нөөцийн 65 хувийн төвлөрөлтэй холбогдлууд нь хариулаад, 2 дахь тэр банкны асуудлыг Жавхлан сайд хариулах байх. Тэр өөрсдийнхөө бодлогын хүрээнд хийсэн асуудал оруулж ирсэн учраас банктай холбогдолтой.

Тэр нөөцийн төлбөрийн 65 хувийг төвлөрүүлэх асуудал бол хуулиараа байгаа юм. Өмнөх жилүүдэд ялангуяа ковидын үед хүүхдийн мөнгөтэй холбогдолтойгоор ашиглачихсан. Тэгээд тэрийгээ нөгөө 65 хувиарнь бүрдүүлж чадахгүй ингээд яваад байгаа. Тэгэхдээ 2025 онд бол 40 хувь гээд тэгээд цаашдаа бол хуулийн дагуу 65 хувь болгоно гэсэн ийм төсөөлөлтэй яваа юм байна лээ. Тэгэх ёстой, хуулиараа тийм.

Ер нь одоо бид нарын ялангуяа гол экспортын орлогын хамаарал чинь хэдхэн нэр төрлийн бүтээгдэхүүнээс байгаа юм. Нүүрс. Гол нь нүүрс 60, 70 хувь. Тийм учраас нүүрсний үнэ өндөр байгаа үедээ болж өгвөл энэ мөнгөө хуримтлуулаад, энэ сандаа хадгалаад явах нь зөв л дөө. Бас манай гишүүд ингэж үзэж байгаа бол сайн байна. Тогтворжилтын сан энэ бүгдийг бид нар анх байгуулахдаа тэгж төсөөлсөн юм. Уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай улс орнууд ингэдэг. Үнэ өсөж байх үедээ хуримтлуулаад, үнэ буурсан үедээ тэрийгээ зарцуулдаг. Тийм байдлаар бид нар энэ байгалийн баялгаа ашиглаж явах ёстой. Тэрнээс биш ингээд 2021 онд 11 их наяд байсан төсөв 2024 онд 3 жилийн дотор 33 их наяд болоод 3 дахин өснө гэдэг бол уг нь зохимжгүй юм байхгүй юу. Үүний цаана мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байгаа. Үүний цаана инфляц үнэртэж эхэлнэ. Тийм учраас та бүгдийн хэлээд байгаа тэр болж өгвөл орлого нэмэгдэж байгаа үедээ хуримтлал бий болгож явах асуудал хамгийн чухал. Тэр Норвегийн сан шиг хуримтлуулаад, ирээдүйдээ ашигладаг байх энэ зарчим бол уг нь зөв зарчим юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Ер нь дэлхий нийтээрээ л ногоон хөгжлийн концепц руу бүгд шилжиж байна даа. Тийм учраас Монгол Улс маань ч гэсэн эндээс хоцорч болохгүй. Ялангуяа хөрөнгө мөнгөний зах зээл дээр бид ногоон төсөл байх юм бол мөнгө олдохоор л байгаа. Боломжууд маш их байгаа. Тийм учраас Төрийн банкны концепцыг энэ рүү чиглүүлэх, илүү их нарийсгах, тодорхой болгох, өөрөөр хэлбэл Засгийн газрын ногоон хөгжлийн бодлогыг дэмждэг ийм санхүүгийн институт байвал яасан юм бэ гэдэг ийм зорилгоор орж ирж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл жижиг, дунд ч бай ямар

ч хэмжээний төсөл бай ногоон хөгжлийг дэмжсэн, ногоон эрчим хүч, ногоон санхүүжилт гээд бүхий л төслүүдийг санхүүжүүлдэг, бусад өөр санхүүгийн бүтээгдэхүүнүүд гаргадаг ийм л банк болгоё гэж байгаа юм.

Тэр 20, 40, 65 гэдэг дээр Батнайрамдал гишүүн ээ ийм юм байгаа юм шүү. Ковидын үед.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ковидын үед төсөв маш их хэмжээний алдагдал хүлээсэн. Гэсэн хэдий ч бид хүүхдийн мөнгөө аль болох тасалдуулахгүй, бүтнээр нь өгч явах том сорилттой тулсан. Тийм учраас 1 жил 2022 онд бид Ирээдүй өв сангийн хууль дээр бол 65 гэдгээрээ байж байгаа. Дагаж мөрдөх журам дээрээ 1 удаа хүүхдийн мөнгийг Ирээдүй өв сангаасаа тавья гэдэг ийм өөрчлөлт орсон байгаа юм. Тэрнээс хойш шууд 65-аар нь буцааж тавьж бас энэ төсөвт дийлэхгүй байгаа учраас 20, 45, 65 гээд 3 жил дараалаад явах юм байгаа юм. Өөрөөр хэлбэл 2025 онд 40, 2026 онд 65 гээд бүтнээрээ буцаж нөхөж орно гэсэн үг. Тэгээд тэрнээс цаашид 65-аараа явна гэсэн үг. Тэгэхээр буурсан биш нэмж орж ирж байгаа гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуултаа асууя.

Ж.Баясгалан: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн төсөлтэй холбоотой асуулт асууя. Тэгээд энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлд. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд өөрчлөлт орох бүрд цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлнэ.” гэж заасан байгаа. Тэгээд энэ бас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан 345 дугаар тогтоол бас байгаа. Тэгэхээр энэ дээр юу юу байгаа вэ гэхээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийн гишүүн солигдох, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, тэгээд л бүтэц, зохион байгуулалт, саналын эрхийн мэдээлэл, тухайн жилд хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрүүд, бараа, үйлчилгээний худалдан авалтын төлөвлөгөө, түүний хэрэгжүүлэлт байгаа. Тэгээд санхүүгийн жилд төлсөн албан татвар хураамж. Хамгийн гол нь энэ төсвийн болон бусад эх үүсвэрээс авсан бусдад өгсөн дэмжлэг хандив, тусламж гэх мэтээр Шилэн дансны хуульд байгаа. Тэгэхээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 100 гаруй компани байгаа. Тэгвэл энэ компаниудаас хэд нь энэ мэдээллийг яг тогтмол тавьж ирсэн бэ. Төрийн өмчийн хаалттай засаглалын байдлыг үүсгэж, хуулийн этгээдэд ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх, төрийн өмч үнэгүйдүүлэх, төрд үүссэн зардлыг нэмэгдүүлсэн, тэгээд Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй хэдэн захирал, удирдлагад ямар хариуцлага хүлээлгэсэн бэ. Энэ дээр яг тодорхой хариулаад өгөөч. Энэ хуулийг биелүүлээгүй ямар, ямар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын захиралд ямар, ямар хариуцлага хүлээлгэсэн байдаг юм бол.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал.

Н.Учрал: Энэ төрийн өмчийн өөрийнх нь хууль дээр мэдээллийг ил тод нээлттэй болгохыг тухайлан зааж өгснөөрөө энэ төсөв дагуулж байгаа хууль их онцлогтой. Тэрнээс биш Нийтийн мэдээллийн ил тод байдлыг өнгөрсөн парламентын үед бид батлахдаа 68 нэр төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг бол мэдээлэл хариуцагч нарт оногдуулсан. Ингээд нөгөө “5Ш” ажиллагааны хүрээнд шилэн ажиллагаа явуулаад 800

гаруй мянган мөр өгөгдлийг нэгтгэхэд төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниуд бас төдийлөн идэвх санаачилгатай ажиллаагүй. Тийм учраас бид нар 7 хоног тутам мэдээллийг нэгтгэ гэдэг ийм шаардлагыг хүргүүлээд, нөгөө shilen.gov.mn дээр нэгтгээд байсан. Яагаад энэ мэдээллийг нэгтгэсэн юм бэ гэхээр бид нар үүнийг нөгөө их өгөгдөл болгоод цаашдаа шийдвэр гаргалтад ашиглая. Анализ хийдэг болъё гэдэг ийм зорилготой байсан. Мэдээж нөгөө талаараа бол иргэдийн мэдэх эрхийг хангуулахад чиглэгдэж байсан. Үүний үр дүнд одоо бол төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагуудын мэдээлэл нэгтгэсний үндсэн дээр одоо Засгийн газар нөгөө e-cabinet 2 гээд өдөр тутмын мэдээллүүдийг real time-аар ч авч байгаа. Шинэ мэдээлэл нэгтгэгдвэл бас тэр болгон нь одоо мэдээллүүдийг нэгтгээд түүн дээр анализ хийдэг ийм шинэ жишиг рүү бол явсан. Үүнийг хэрэгжүүлэхэд төсвөөс гадуур тэр 23 тэрбум төгрөгийн орлого олоод байгаа тэр төрийн өмчит тайлан балансаа өгдөг 99 компани. Өнөөдөр энэ цалин хөлс, орлого, дотоод тэр ТУЗ-ийн гишүүдийн нэр ус, ашиг сонирхлын зөрчил бүх мэдээллийг хуулиараа нээлтэй болгох ёстой. Тийм учраас энэ төсөв дагуулаад төрийн өмчийн өөрийнх нь хууль дээр мэдээллээ ил болго гэдэг ийм үүргийг хүлээлгэсэн учраас үүний дараа бид нар бас хариуцлагыг шахаад явъя гэдэг ийм зорилготой байгаа.

Мэдээж төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах чиглэлээр бол одоо төрийн өмчийн компанийн хуулийг бол Их Хуралд өргөн мэдүүлнэ. Гэхдээ үүнээс өмнө бид энэ төсөв өөрөө ийм ил тод шилэн дансаар мэдээ мэдээлэл нь яваад, нийтийн мэдээллийн хууль хэрэгжээд байгаа шиг энэ төрийн өмчийн компаниуд бас адилхан энэ үүргээ хүлээх ёстой. Тэрнээс мэдээллийг ил болго гэхээр цахим хуудас дээрээ нэг хэн ч уншаад ойлгогдохгүй ийм хэдэн мэдээлэл тавьчихдаг. Тэгээд тэр нь хуучирчихдаг. 2, 3 сараар хоцорчихсон. Тэгээд хуучин мэдээлэл яваад байдаг. Гэтэл энэ мэдээллүүд бол тогтмол шинэчлэгдэж байх ёстой. Цаашлаад өнөөдөр бол мэдээллүүдийг ийм real time-аар шууд шинэчлэгдэж байдаг болгочоод байна шүү дээ. Тийм ч учраас энэ төрийн өмчийн компаниудыгаа мэдээллийг ил болго гэдэг үүрэг бол цаашаа төсвийн ил тод байдалд ч гэсэн маш эергээр нөлөөлнө гэдэг зорилготой байгаа. Энэ мэдээллийн санг нэгтгэж байгаад цаашаа бид нар үүнийг их өгөгдөл болгож шийдвэр гаргалтад ашиглана.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би энэ тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гэж байгаа. Номад бондын төлбөр болох 578 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төсөвт дарамт учруулахгүйгээр ингээд өрийн зохицуулалт хийнэ гэсэн ийм танилцуулга дээр үндэслээд, Улсын Их Хурлын тогтоол нь болохоор тодорхой дүнтэй мөртөө энэ дээрээ болохоор нөгөө талдаа тогтоол нь болохоор ямар ч үнийн дүнгүйгээр гадаад, дотоод үнэт цаас гаргах эрхийг Засгийн газарт өгсөн ийм заалт байгаа. Тэгээд яах вэ, үүнтэй холбоотой би хуралд сууж байгаад энэ заалт дээр бас энийг энэ сая оруулж ирж байна. Дүнгүй байсныг энийг дүнтэй болгох ёстой гэж бодож байсан. Дүнтэй болгохдоо 4 их наяд хүртэл гэж нэмж орж ирж байна л даа. Тэгэхээр уг нь энэ танилцуулга хийхдээ танилцуулга дээрээ суурилсан байхгүй бол ингээд яг задлаад харахаар өөр юмнууд ингээд нуугдчихсан. Одоо жишээлбэл, бид хэдийг шинэ гишүүд гэж боддог юм уу, эсвэл зарим энэ тэнд нь тоо юмнууд боломжуудаа өөртөө авч үлдэх гэдэг юм уу бас ингээд ийм ил тод биш юмнууд харагдаад байна л даа. Тэгэхээр энэ шиг ингээд бид хэдийг шинийг далимдуулаад ч юм уу энэ тодорхойгүй ийм ярингуут энийг жишээлбэл 4 их наяд болгох ямар ч хэрэггүй байхгүй юу. Танилцуулга дээрээ 2 их наядын юм байхад чинь энийгээ 2 их наяд болгохын оронд ярьж байснаа 4 их наяд болгочихъё. Энэ яаж байгаа нь тодорхойгүй байдлаар ингэж ийм наймаалцдаг ийм байдалд ормооргүй байна.

Тэгээд Засгийн газар ч гэсэн Улсын Их Хуралд мэдээлэл оруулж ирэхдээ ил тод, тодорхой танилцуулдаг баймаар байна. Тэгээд ийм наймаалцаж байгаа юм шиг, тэгснээ танилцуулгынхаа утга агуулгыг нь ингээд өөрчилдөг ийм байдал бол Улсын Их Хурлын мэдэх эрх, тэгээд энэ ил тод Засгийн газар асуудлаа бүрэн ил тод танилцуулах энэ зарчимтай нийцэхгүй байна. Тэгэхээр үүнтэй адилхан өөр энд тэнд нууж хаасан жишээлбэл бид хэдийг мэдэхгүй гэж ч юм уу, эсвэл ярихаар гарч ирэх бид нарын гаргаж ирж чадаагүй ийм заалт байгаа юу, үгүй юу. Энийг 1 дүгээрт асуумаар байна. Тэгээд энэ заалтыг яагаад жишээлбэл одоо зарчмын зөрүүтэй санал дээр орж ирж байна л даа. 4 их наяд болгож байгаа юм. Энэ тайлбар дээрээ 2 их наяд гэж хийж болох юмыг яагаад дүнгүй оруулж ирснээ, тэгээд энийг нэмэгдүүлчхэж байгаа юм бэ. Зүгээр 2 их наядаар нь тавьж болдоггүй юм уу. Тэгэхээр энэ хэмжээний жишээлбэл Засгийн газрын өр нэмэгдүүлэх энэ бололцоо боломжуудыг чинь ингээд нээгээд өгчхөж байна. Тэгэхээр энэ дээр тайлбар хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм. Энхтүвшин гишүүн чухал асуудал хөндлөө. Олон гишүүн тогтоолын төсөл дээр бондын хэмжээ зааж өгөөгүй байна. Энэ бол өр гэдэг ийм зүйлийг бол нэлээд ярьсан байгаа. Энэ үнэн. Бид нар ер нь зүгээр энэ ковидоос өмнө ялангуяа 2010 аад оны үе энэ тэрд бонд гаргахдаа дандаа хэмжээ тавьж өгдөг байсан байхгүй юу. Сүүлдээ тэгээд ковид гээд хэмжээ тавихаа болиод ингээд явчихсан байсан. Хэмжээ тавихгүй байна гэдэг чинь бүүр 4-өөс дээш ч их наядыг гаргачхаж болно шүү дээ. Тийм учраас бид нар төсөв дээр байгаа тэр эх үүсвэр талд бичигдсэн дотоод, гадаадын бондууд, зээлийн үйлчилгээний төлбөр, тэгээд мөн графикайн дагуу төлөгдөх гадаад төлбөрүүдийн хуваариудыг харж байгаад зарим зээлийг бол дахин санхүүжүүлбэл гэдэг энэ саналыг нь сонсоод, тэгээд энэ 4 их наяд хүртэл гэсэн байгаа. Тэгэхээр 4 их наяд хүртэл гэдэг бол 4 их наядыг гаргана гэсэн үг биш. Нөгөө талаараа бол зүгээр яах вэ та нарт тайлбарлахдаа ингэж байгаа л даа. Одоо ингээд Төсвийн хууль дээр бол энэ хэмжээнүүд байгаа юу байгаа. Гэхдээ тэглээ гээд бондынхоо хэмжээг зааж өгөхгүй гэж болохгүй байхгүй юу. Тийм учраас бид нар тэр төсөв дээр тусчихсан байж байгаа, эх үүсвэр талд бичигдсэн байж байгаа бондууд, зээлийн үйлчилгээний төлбөрүүд, гадаад төлбөрүүд энэ графикайн дагуу нь үзэж байгаад яах вэ 2026 онд төлөгдөх вэ. Энэ өөрийн чинь хэлээд байгаа бонд бол 2,5 их наяд шаардагдана 2026 оных. Тэгэхдээ урьдчилаад төлбөр хийхэд таатай нөхцөл байдал үүсэх юм бол зээлийн хүү хямд байгаа энэ үед гэдэг ч юм уу, хүүгийн төлбөр хямд байгаа энэ үед ч гэдэг юм уу, бондын хүү хямдарсан үед гэдэг ч юм уу, зээлжих зэрэг сайжирчихсан байгаа тохиолдолд арай хямдхан төлөх боломж байвал урьдчилаад зээлээ дахин санхүүжүүлчихье гэж байгаа ийм зүйлийг бас ярьж байгаа учраас 4 их наяд хүртэл бол багтах юм байна гэж бид үзсэн байгаа. Тэрнээс биш тоогүй ийм зөвшөөрөл ав авч болохгүй гэж гишүүд үзсэн учраас тоо тавьж өгсөн байгаа. Тоог тавихдаа тэр төсөв дээр байж байгаа эх үүсвэр талд бичигдсэн болон цэвэр зээлийн дүнд байгаа зээлийн үйлчилгээний төлбөрийг нь бүгдийг тооцож байгаад тавьсан байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин тодруулъя.

Д.Энхтүвшин: Яах вэ би энэ нөгөө танилцуулга гэдэг юмны агуулга нь болохоор угаасаа энэ номад бондыг л refinance хийхдээ асуудал. Өөрөөр хэлбэл энэ дүн дээр болохоор 2 тэрбум гэсэн ийм дүн л тайлбар хийсэн. Тэрэнд дагалдуулж энэ Засгийн газарт үнэт цаас гаргах эрх олгож байгаа учраас энд нь таарсан дүн тавихгүй, дээр нь дахиад нэмээд. Эсвэл зүгээр энэ танилцуулгаа өөрчлөх ёстой байхгүй юу. Номад бонд болон ийм ийм юмнууд тэгэхээр ингээд бөгснөөс нь хөөгөөд өөр одоо жишээлбэл л энэ асуудлыг шийдэхийн тулд л ийм тогтоолын төсөл орж ирж байгаа болохоос биш өөр асуудал шийдэхийн тулд буцаад энэ тайлбараасаа өөр юм хийж болохгүй гэдэг ийм л санаа байгаад байгаа юм. Тэгэхээр

энийг 4 тэрбум гэж бичих нь өөрөө энэ тайлбараа үндэслээд харахад бол буруу. Үүгээр бол 2 их наядын л асуудал байна лээ л дээ. Тэгэхээр тэр дүнгээр нь тавих ёстой юм биш үү гэдэг ийм саналтай байна.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны Даваасүрэн дарга.

Ц.Даваасүрэн: Еөв зөв. Ер нь яах вэ танилцуулгаа бас тэгээд жишээ нь л гэсэн байдлаар авчихсан юм байна лээ л дээ. Зөвхөн тэр бондын төлбөр биш юм. Ирэх жил гарах жишээлбэл дотоод зах зээл дээр гарах 300 тэрбумын бонд бас энд орж байгаа. Тэр эх үүсвэр талд биччихсэн байж байгаа. Тэгээд зээлийн үйлчилгээний төлбөр дээр зээлийн үйлчилгээний төлбөр чинь 1 их наяд гаруй байгаа билүү дээ. Ингээд энэ бонд чинь 2026 онд төлөгдөх байгаа байх шүү. 2025 биш. Тэгэхдээ энэ бондыг төлөх боломж бүрдээд, зээлжих зэрэглэл сайжраад, зээлийн хүү хямдарчих юм бол бас урьдчилаад төлчихье гэж байгаа юм билээ. Тэр талаасаа аваачаад жишээ татчихгүй юу. Тэгээд та нарыг төөрөлдүүлсэн байдалд оруулчихсан. Энэ дотор чинь гаргах гадаад, дотоод бонд, нөгөөдөх нь болохоор тэр нөгөө зээл дахин санхүүжүүлэх эх үүсвэр нь бүгд багтаж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай асуулт асууна.

М.Мандхай: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар албан татварын хөнгөлөлт эдлүүлэх тухай бол заасан. Энэхүү төслийн жагсаалтыг Засгийн газар батлахаар холбогдох заалтыг хуулийн төсөлд бол нэмж тусгасан байна. Гэхдээ үүнтэй холбоотойгоор Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох тооцоо судалгаа, татварын хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүний жагсаалтыг оруулж ирээгүй учраас би тодруулж асуух гээд байгаа юм. Энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотойгоор бид импортоос хараат улс. Өнөөдөр дотоодын үйлдвэрлэл бүгд хүнсний, хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэлүүд ч гэсэн бусад бүх үйлдвэрүүд импортоос тодорхой түвшинд хараат явж байгаа. Бүхий л бүтээгдэхүүн энэ импортыг орлож байгаа гэхэд бол хилсдэхгүй. Яг ямар бүтээгдэхүүнийг импортыг орлох, экспортыг дэмжих бүтээгдэхүүн гэж үзэж байгаа юм бэ. Энийг тодорхой болгохгүй болохоор хууль баталчихаар үндсэндээ энэ үйлдвэрлэгчид татварынхан, аж ахуйн нэгжүүдийн дунд бол нэлээн маргаан, хэл ам гарахаар харагдаж байна л даа. Тэгээд энэ дээр яг ямар зохицуулалт хийж байгаа вэ гэдгийг бас асуумаар байна.

2-т нь импортыг орлох, экспортыг дэмжих бүтээгдэхүүнийг бас мөн адилхан ямар шалгуур үзүүлэлтээр тогтоож байгаа вэ. Энэ дээр яагаад би ингэж хэлж байна вэ гэхээр үндсэндээ бол манай бүр цаашлаад ярих юм бол хуулийн зөрчил харагдаж байгаа. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн Улсын Их Хурал татварын бодлогыг тодорхойлж, батлах, шийдвэрлэх онцгой бүрэн эрхэд бол хадгалагддаг. Тэгэхээр энэ татвараас хөнгөлөх төслийн жагсаалтыг Засгийн газар тогтооно гэсэн нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаж байна гэж харж байна.

Мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлээр татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж заасан байгаа. Ингээд татварын хуулиас гадна энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийг төслийг бол бас хамтран боловсруулж оруулж ирэх ёстой байгаа. Тэгэхээр энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн

дагаж мөрдөх журам бол батлах ёстой. Хууль дагасан журмуудыг бол дараа нь бол бас баталдаг. Тэгэхээр хуулиасаа давсан журам Улсын Их Хурлын дарга бас энийг л нэлээн хэлж байгаа. Хуулиасаа давсан журам бол манайд хэрээс хэтэрлээ. Иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэдэг гээд. Тэгэхээр энэ Хууль тогтоомжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмыг бол зайлшгүй батлах ёстой гэж харж байгаа. Тэгээд би энэ дээр эхлээд хариултаа авчихъя.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн.

Ц.Даваасүрэн: Тийм ер нь бол яг таны хөндөж байгаа асуудлыг нэлээн хэдэн гишүүн хэлэлцүүлгийн явцад гаргасан юм. Хэтэрхий ерөнхий байна. Ямар бүтээгдэхүүн орж чөлөөлөгдөх юм бэ гэдэг асуудал бол үзэмжийн болчхож магадгүй. Үүний цаана авлигын асуудал яригдаж магадгүй гэдэг ийм шүүмжүүд нэлээн гарсан. Яг үнэн. Ер нь бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд ямар бүтээгдэхүүнийг чөлөөлөх юм, хэдэн хувиар чөлөөлөх юм гэдэг нь бол байдаг. Тийм учраас ямар бүтээгдэхүүнийг чөлөөлөхийг нь мэдэхгүйгээр тодорхой хувь тавиад Их Хурал шийдэж болохгүй. Тэгж үзсэн байгаа. Тийм учраас бид нар бас нэлээн энэ дээр Их Хурлын гишүүд хариуцлагатай хандаад, манай Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүд энэ ямар бүтээгдэхүүнийг тэргүүлэх ач холбогдол өгч оруулж ирэх юм, алийг нь чөлөөлөх юм гэдэг энэ асуудлыг бол дахиж Их Хурлаар ярьж жагсаалтыг нь баталж өгнө гэж Их Хурал батлахаар Их Хурлын онцгой бүрэн эрх хадгалагдахаар ингэж шийдсэн байгаа. Тийм учраас бол таны хэлээд байгаа шиг ямар бүтээгдэхүүнийг бид нар онцгойлж тэргүүлэх ач холбогдол өгч чөлөөлөх вэ гэдэг асуудлыг эргээд бид нар Их Хурлаараа шийдэхээр болсон байгаа.

Тэр журам хуулиас илүү давж үйлчилж байна гэдэг дээр одоо хэн нь хариулах юм бол доо. Зүгээр ийм зүйл бол яригдаагүй. Тэгэхдээ энэ дээр манай хуулийнхан хариулах юм уу.

Х.Булгантуяа: Хэн хариулах уу. Ажлын хэсгээс хариулах уу. Мандхай гишүүний асуултад. Хүн байгаа юм уу. Хууль зүйн яамнаас Хууль зүйн сайд уг нь энэ дагаж мөрдөх хуулиуд асууж байхад Алтангэрэл сайд хариулах уу. Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Уучлаарай асуултыг нь сонссонгүй. Үнэнээ л хэлье. Энд асуулт нь давхардах юм байна. Би тэгээд хариулчихъя.

Х.Булгантуяа: Мэндбаярын Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Ер нь бол би түрүүн хэлсэн. Үндсэн хууль, Татварын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулиудын заалтуудыг бол энэ асуудал бол онцгой зөрчиж байгаа. Хуулийн заалтууд нь ч гэсэн би шаардлагатай бол уншиж танилцуулж болно. Тэгэхээр шийдэл бол ерөөсөө Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3.22.14-д заасан “Засгийн газар” гэснийг “Улсын Их Хурал” гэж өөрчилмөөр байна. Яагаад гэхээр бид нар ямар төслийн жагсаалтууд энэ татварын хөнгөлөлтөд эдлэгдэх гэж байгаа юм бэ гэдгийг Засгийн газраар бид нар шийдээд явчих юм бол яг үнэнээ хэлэхэд тэнд бид нар ямар ч Улсын Их Хурал хяналт тавих боломжгүй болчихно гэсэн үг. Хэний компаниуд орж байгаа юм. Тэгэхээр энэ 90 хувийн хөнгөлөлтийг авахын тулд хэн ч, ямар ч аж ахуйн нэгжүүд орох боломжтой учраас энэ төслийн жагсаалтуудыг Улсын Их Хурлаар заавал батлуулах шаардлагатай гэж үзэж байгаа.

2-т нь болохоор Аж ахуйн нэгжийн орлогын албан.../минут дуусав/

Х.Булгантуяа: Тэгэхээр санал хэлж байна уу. Санал хэлж байх шиг байна. Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Баярлалаа. Төсөв дагасан хуулийн анхны хэлэлцүүлэг дээр Төсвийн байнгын хороо болон ажлын хэсгийн даргаас асуулт асуух гэсэн юм. Төсөв дагасан хуулиар энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль өргөн баригдсан. Энэ дээр гол зорилго бол мэдээж төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын ил тод байдлыг хангах замаар засаглалаа сайжруулъя, эдийн засгийн үр дүнгээ сайжруулъя, цаашдаа энэ бол өөрөө Монгол Улс дахь авлигыг бууруулахад маш хүчтэй, үр дүнтэй, үр нөлөөтэй ажил байгаа юм. Тэгээд ийм хуулийг бол дагаад оруулж ирсэн. Тэгтэл өнөөдөр сая тараагдсан Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал буюу бид нарын хураах гэж байгаа санал дээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд оруулсан 2 зүйлийг ил тод болгоё гээд оруулж ирсэн 2 зүйлийг ажлын хэсгийн саналаар хасчихсан байна л даа. 1 дүгээрт төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд ямар тендер явуулж байна. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын талаарх мэдээлэл, хэн нийлүүлэгч нь юм, хугацаа нь хэд юм, гэрээний дүн нь хэд юм, сонгон шалгаруулалтын аргачлал нь юу юм гэдэг мэдээллийг ил тод байлгах шаардлагагүй гээд хасчхаж.

2 дугаарт энэ төрийн болон орон нутгийн өмч, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн, тэгээд цалин урамшууллын асуудал бол олон нийтэд ил байх шаардлагагүй гээд хасчхаж. Тэгээд яах вэ, энэ одоо давхардсан юм байгаа юм болов уу гээд би бас Нийтийн мэдээллийн тухай хууль, Шилэн дансны хуулийг харлаа л даа. Ер нь бол манай энэ хуулиуд дээр ихэвчлэн тендертэй холбоотой юм байх юм бол тендерийн хянан шалгалт, аудитын дүгнэлт, мэдээллийг нь л ил болго гэсэн юмтай. Тэгээд энийг нь нарийвчлаад бүр хугацаатай нь, үнийн дүнтэй нь аргачлалтай нь ингээд оруулъя гээд нарийвчлаад ороод ирэхээр энэ заалт яагаад хасагдчихав. Цалин хөлс, удирдах албан тушаалын цалин хөлстэй холбоотой асуудлыг бол ер нь олон улс даяар нийтэд нээлттэй компаниудын гүйцэтгэх удирдлагын цалин хөлс угаасаа л нээлттэй байдаг. Яагаад гэвэл энэ бол тэнд хувьцаа эзэмшигч этгээдүүдийн эрх ашиг тэнд хэр үр ашигтай гүйцэтгэх захирал үйл ажиллагаагаа явуулж байна гэдэг шалгуур үзүүлэлт, хяналт тавихад бол маш чухал мэдээлэл байдаг. Тэгээд Монгол Улсын энэ ТӨК, орон нутгийн өмчит компани ч гэсэн ер нь эцсийн эцэст бол ард түмэн, иргэдийн л энэ өмчийг яаж зөв зохицуулах вэ л гэж байгуулагдаж байгаа. Зарим нь бол яг үнэнийг хэлэхэд үр ашиггүй баахан татаастай явж байгаа. Татаастай явж байгаа гэдэг бол иргэдийн төлсөн татвараар л бид нар энэ компаниудын үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа юм. Тэгээд энэ утгаараа иргэд бол энд гүйцэтгэх удирдлага нь хэр үр дүнтэй, хэн ямар үйл ажиллагаа хийж байна гэдэг мэдээлэл бол ил тод байх ёстой байх гэж бодож байна. Тэгээд яагаад энэ ажлын хэсэг дээр энэ мэдээллүүдийг тендертэй холбоотой нарийвчилсан мэдээлэл болон гүйцэтгэх удирдлагатай холбоотой мэдээллүүдийг ажлын хэсэг хассан бэ гэдэг дээр тайлбар авъя.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн.

Ц.Даваасүрэн: Гишүүний асуултад хариулъя. Яг энэ асуудал яригдсан. Яагаад хасаж байгаа юм бэ гэдэг. Тэгэхээр энэ мэдээлэл чинь өөрөө угаасаа Төрийн өмчийн хорооны шилэн мэдээлэлд нь байдаг юм байна лээ л дээ. Зүгээр тэр мэдээллийг энэ бүх мэдээллийг хэрэг эрхлэхүүд татаж авъя гээд байгааг бас үгүй ээ, энэ ерөөсөө шаардлагагүй гэдэг санал хураалт ч хийгдсэн байгаа. Яагаад гэвэл өөрөө угаасаа ТӨХ-ны тэр юун дээр энэ хүмүүсийн бүх одоо таны яриад байгаа тэр тендерүүд, мөн энэ цалин хөлсний асуудлууд бүгд байдаг юм байна лээ. Зүгээр л энэ юугаар хэрэг эрхлэх дээр энэ мэдээллийг дахиж авч зүгээр

ашиглая гэж байгаа юм байна лээ. Энэ мэдээллийг ашиглах зориулалтаар. Тэрнээс биш нөгөө мэдээллийг үзэж харъя гэх юм бол ТӨХ-ны энэ сайтад бол энэ бүгд байж байгаа юм байна лээ. Тэр агуулгаар давхардсан байна л гэж оруулж ирсэн юм байна лээ.

Х.Булгантуяа: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Давхацсан гээд юм болов уу гэж бодоод би өөрөө бас харлаа л даа. Тэгэхээр та Нийтийн мэдээллийн тухай хууль, Шилэн дансны хууль нь яг аль, аль дээр яг энэ үг үсгээрээ давхацсан юм бол гэдгийг бас тайлбарлаж өгвөл зүгээр байна. Миний харж байгаагаар бол энд ерөнхийдөө хяналт шалгалт хийсэн аудитын дүгнэлт, мэдээлэл байна гээд өөр томъёололтой байгаа байхгүй юу. Тэгээд өөр томъёололтой байхаар энэ дээр яг амьдрал дээр юу гардаг вэ гэхээр тэр болгон нарийвчилсан мэдээлэл Шилэн данс, Нийтийн мэдээллийн хуулийн дагуу компаниуд, хуулийн этгээдүүд бол өөрсдөө нээлттэй болгодоггүй. Тэгээд яах вэ, нэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орж байгаа энэ нэмэлт өөрчлөлтийг харахаар зөвхөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гэхээсээ илүү Хэрэг эрхлэх газар энийгээ аваад, өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлнэ гэхихсэн байгаа байхгүй юу. Хэрэг эрхлэх биш, тухайн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь. Тэгэхээр энэ хуулийн заалт дээрээ өөрсдөө цахим хуудсаараа нийтэд мэдээлнэ гэхихсэн байгаа юм нь та яагаад бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр сантай байгаад ингэнэ гэсэн юм бол. Тэрийг нь ер нь бол яах вэ, сантай .../минут дуусав/

Х.Булгантуяа: Даваасүрэн дарга нэмж хариулах уу.

Ц.Даваасүрэн: Тийм. Би одоо яг хэн энэ санал гаргасныг нь бол санахгүй байна. Ажлын хэсэг дээр бол гишүүд яг ийм тодруулга авсан байгаа. Тэгэхээр энэ мэдээлэл нийтэд и нээлттэй юм байна лээ. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар байгаа юм байна лээ. Энэ мэдээллийг давхардуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр авчих ямар шаардлага байгаа юм бэ гэдэг зүйл их яригдсан манай Мэндсайхан гишүүн өөрөө ялангуяа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга байсан учраас энэ нь ямар ч ач холбогдолгүй л юм, давхардсан л юм байна гэдэг зүйлийг нэлээн ярьсан. Ер нь тийм юм байна лээ. Тэнд бол энэ мэдээллийг авъя гэх юм бол шилэн, ил бүгд байгаа юм байна лээ.

Х.Булгантуяа: Болсон уу Номинчимэг гишүүн. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Би өөрөө ажлын хэсгийн гишүүн байж ажлын хэсгийн даргаасаа асуулт асуугаад байлтай биш. Гэхдээ гишүүдэд хандаж үг хэлье гэж бодож байна.

Түрүүн Мандхай гишүүнтэй санал нэг байгаа. 2025 оны 1 сарын 1-ээс эхлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт мөрдөгдөж эхлэх юм. Үүний 22.5.22 дахь заалт дээр Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн 90 хувиар хөнгөлөлт эдлүүлнэ гэсэн энэ маш чухал заалт. Гэтэл энийг яг дараагийнх нь 22.5.22 дахь дээр Засгийн газар энэ жагсаалтыг батална гэхихсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгээс ямар санал оруулж байгаа вэ гэхээр одоо та бүхэн санал хурааж эхэлнэ. Тэгэхээр энэ дээр сайн анхаараад өгөөч ээ.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналын 2-т байгаа. Ажлын хэсэг төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Улсын Их Хурал” гэж өөрчлөхийг дэмжиж өгөөч гэж хэлмээр байгаа юм. Энэ нь 1 дүгээрт Улсын Их

Хурлын онцгой бүрэн эрх рүү халдсан. Хэрвээ Засгийн газар энэ жагсаалтыг батлаад байх юм бол, дээрээс нь цаанадаж авлигад хэн нэгний лоббид өртөх магадлалтай. Засгийн газраа бас аврах давхар санаа явж байгаа шүү. Тэгэхээр манай гишүүд энэ дээр анхаараад ажлын хэсгийн энэ саналыг “Засгийн газар” гэдгийг “Улсын Их Хурал” болгож өөрчилж өгөөч гэж хүсье.

Х.Булгантуяа: Мөнхбаясгалан гишүүн санал хэллээ. Чинбаатарын Анар гишүүн.

Ч.Анар: Энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр тодруулга байна.

6.2.1 дээр тухайн санд тухайн жилд төвлөрөх орлого, зарлага.

6.2.2 хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалт төсөвт өртөг гэж заасан. Гэтэл Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан шаардлагаа хангаагүй буюу зарлагаа тусгаагүй байна.

Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн 4.3.1.2-т Үндэсний баялгийн сангийн 1-ээс доошгүй хувийг инновац технологийн салбарт зориулна гэсэн тэр заалт орж ирээгүй байна. Энэ хэзээ орж ирэх вэ. Энэ 2 асуулт.

Бас нэг юм. Энэ сангуудыг ингээд харахаар Монгол Улсад чинь их олон гоё сангууд байдаг юм байна. Хувийн хэвшил, аж үйлдвэрийг дэмжих, иргэний, нийгмийн халамж маш их мөнгөтэй байх ёстой. Гэхдээ мөнгө нь байхгүй. Тэгээд энэ сангууд нь зарим нь дампуурчихсан. Хойноос нь ухаад хөөгөөд явахаар зарим үед төсвийн алдагдлаа нөхөх гээд жишээ нь Ирээдүй өв сангаас мөнгийг нь авчихсан асуудлууд байх юм. Тэгээд энэ Үндэсний баялгийн сан чинь яг Нийгмийн даатгалын сан, Тэтгэврийн сан шиг араас нь орох гээд байгаа юм биш үү. Энэ сангуудын удирдлага нь олон улсын жишгээрээ мэргэжлийн менежмент удирдах өсөж өргөжиж байх жишигтэй шүү дээ. Тэгээд өчнөөн жил энэ сангуудынх нь дампууралыг яриад байдаг. Одоо энэ Үндэсний баялгийн сан маань өөрөө маш том сан. Үүний менежментийг яаж удирдаж байгаа юм бэ. Энэ талаар тодруулга авмаар байна.

Х.Булгантуяа: Даваасүрэн дарга хариулах уу. Сангийн яамнаас хариулах уу. Тэгье. Сангийн яамны хэдэн номерын микрофон бэ. Тоогоо өргөөдхөөрэй. Би сайн харахгүй байна шүү. Сангийн яамнаас ажлын хэсгээс хэн хариулах вэ. 17 номерын микрофон.

С.Тулга: Сайн байна уу. Сангийн яамны хэлтсийн дарга Тулга гишүүний асуултад хариулъя. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд зарлага бол тавигдаагүй байгаа. Учир нь бол 2025 онд зарлага гарахгүй. Ирээдүй өв сангийн тухай хуульд заасны дагуу тус сангийн хөрөнгийг 2030 он хүртэл аливаа хэлбэрээр зарцуулалт гаргахгүй гэж заасан байгаа. Хуримтлалын сангийн хувьд бол бид нар хуримтлалын сангийн эх үүсвэрээр төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцын хөтөлбөрт хөрөнгө оруулах ийм хэлбэрээр явж байгаа. Тэр зарлага гарахгүй учраас зарлага тавигдаагүй байгаа.

Х.Булгантуяа: Анар гишүүн тодруулах уу. Чулуунбаатарын Анар гишүүн тодруулъя.

Ч.Анар: Нөгөө Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт заасан 1хувь. Энэ баялгийн сангийн хуульд хэзээ орж, хэрэгжиж эхлэх юм. Нэг.

Дахиад энэ сангийн менежментийг яаж удирдах юм бэ. Энэ дээр мэргэжлийн менежментүүд, мэргэжлийн менежмент, сангийн удирдлагын менежментүүд оруулахгүй бол яг бусад сангуудтайгаа адилхан боллоо гэдэг асуултад ерөөсөө хариулахгүй байна.

Дахиад энэ Засгийн газар чинь миний ойлгосноор энийгээ хянах ёстой бүр сайдтай болчихсон юм байна лээ шүү дээ. Тэр сайд нь одоо хаана байгаа юм. Энэ ажлаа хийх ёстой юм биш үү. Хяналтаа тавьж. Би эсвэл буруу ойлгоод байгаа юм болов уу.

Х.Булгантуяа: 17 номер нэмж хариулъя. Жавхлан сайд хариулах уу. Тэгье. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Анар гишүүн ээ, ийм юм. Бид энэ сангийн удирдлага гэдэг дээр ер нь их гашуун түүхтэй улс шүү. Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан гээд л. Тэрийг удирдаж байна гээд хамгийн өндөр хүү амласан банканд аваачаад л алдчихдаг. Тэгэхээр цаашдаа бид энийг маш нарийн тодорхой болгох хэрэгтэй. Тэгэхдээ ийм зарчим барих хэрэгтэй. Энэ нь олон улсын зарчим шүү. Энэ татвараас бүрддэг аливаа санг 1 дүгээрт эрсдэлгүй байх ёстой, 2 дугаарт хөрвөх чадвартай байх ёстой. Энэ 2 биелж байгаа тохиолдолд ашиг өгөөж хайж болно гэдэг ийм суурь зарчим хуульчлагдсан байгаа. Бусад арилжааны сангууд бол хөрөнгө оруулалтын сангууд. Энэ чинь бол ашиг өгөөж хайгаад явж байдаг ийм бизнесийн зарчмаар явна. Энэ сангууд бол бизнесийн зарчмаар явахгүй шүү. Явж болохгүй. Тэгэх л юм бол энд шунал орно. Тэгэх л юм бол энд нүдний хор ороод, тэгээд л ийм хөрөнгө оруулалт хий, тэнд аваачиж хадгалуул гээд л тийм юм болоод л явчихна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэгэхээр татварын орлогоор бүрддэг ийм сангууд бол 1 дүгээрт аюулгүй, бүтэн хадгалагдаж байх ёстой. Тийм зарчмаар явна. Гэхдээ одоо өмнөхөөсөө өөрчлөгдөж байгаа бага зэрэг арилжааны хэлбэр лүү болж ирж байгаа нь тэр валютаар хадгалж болно. Тэгээд Төв банк үүнийг удирдана гэж байгаа юм. Төв банк удирдахаар цаашаагаа бол маш найдвартай. Түрүүний миний хэлсэн зарчмаар ингээд удирдаад явах ийм л учиртай байгаа. Тэрнээс биш хөрөнгө оруулалтын сангуудаар дамжаад ч юм уу хэт их өндөр ашиг хөөгөөд тэгж явж хэрхэвч болохгүй. Энэ бол арилжааны сан биш.

Х.Булгантуяа: Анар гишүүн нэмэлт тодруулга авъя.

Ч.Анар: Энэ гашуун туршлагатай. Тэгээд нөгөө танил талынхаа банканд аваачиж хийгээд, нөгөө банк нь мөнгө нь байхгүй болчихсон. Тэгээд эрсдэлгүй байх гээд хууль дээрээ заачихсан байгаа юм бол яагаад тийшээгээ хуваарилахгүй байгаа юм бэ. Том эрсдэлгүй банкнууд дээрээ тавихгүй байгаад байна.

2 дугаарт нэг асуулт байгаад байгаа шүү дээ. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт заасан 4.3.1.2-т заасан Үндэсний баялгийн сангийн 1-ээс доошгүй хувийг инновац технологийн салбарт зориулна гэсэн заалт хэзээ хэрэгжих юм бэ. 3 дахь удаагаа асууж байна.

Х.Булгантуяа: Анар гишүүн энийг дахин дахин асуугаад байгаа шүү Жавхлан сайд аа. Хэн хариулах вэ. Эхлээд Даваасүрэн дарга. Төсвийн байнгын хорооны дарга хариулъя.

Ц.Даваасүрэн: Тэр Анар гишүүний асуугаад байгаа ер нь яаж байршуулж, удирдаж явах юм бэ гэдэг дээр Баялгийн сангийн хуульд нэг корпорац байгуулах байна уу нэг заалт байгаа. Тэгэхдээ тэр эрсдэлтэй. Би бол тухайн үед нь энийг бол нэлээн эсэргүүцэж байсан

юм. 2009 оны хямрал, тэгээд 2015, 2016 оны хямралын үе энэ тэрд бол энэ сангуу, Арабын сангууд энэ тэр бол маш их мөнгөө алдсан. Норвегийн сан л хамгийн сайн менежмент хийж, хамгийн бага хохиролтой үлдсэн. Тийм учраас гадаад зах зээл дээр байршуулна гэдэг бол их төвөгтэй. Миний санал бол ямар байсан гэхээр Норвегийн сангийн жишгээр бодлогыг нь бол Сангийн яам гаргаад, хаана байршуулах вэ гэдгээ Сангийн яам нь гаргадаг, Операторын үүргийн төв банк гүйцэтгэдэг ийм хуулийн зохицуулалтыг л хийе гэж ингэж оролдсон боловч яг энэ хууль дээрээ очоод ингээд нарийн хараад үзэх юм бол тийм корпорац олон улсын багаар удирдуулах нэг ийм заваан заалт бол орчихсон байдаг юм.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Энэ Баялгийн сангийн хуулийг нэг хараадхаарай. Энэ дээр ингэж байгаа. 10.3 нь Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанк дахь Төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг үлдэгдэл бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна гэж байгаа. Тэгэхээр энэ хуулийнхаа заалтын дагуу л Төв банк дээр хуримтлал маань хадгалагдаж байгаа гэсэн үг.

Үндэсний баялгийн сангийн хөрөнгөөс 1 хувийг инновацад зарцуулна гэсэн мөрийн хөтөлбөр хэзээ хэрэгжих вэ гэсэн үү. Тэгээд мөрийн хөтөлбөр маань ер нь бол би 4 жил гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр бидэнд хугацаа байна. Дахиад 2026, 2027, 2028 оны төсөв орж ирнэ. Тэр үед тэгээд бэлтгэл яаж хангагдах нь вэ, тэгэхээр бид нарт хугацаа байна л гэж хэлье дээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монголбанкны Мөнгөний бодлогын эцсийн найруулгатай холбоотойгоор 1 тайлбар хэлээд, тэгээд асуулт руугаа орёе. Олон улсын валютын сангийн төлөөлөгчид Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчтэй өмнөх 4 жилд 1 л удаа уулзсан. Англи хэлгүй учраас дахиж уулзах, мэдээлэл солилцож чадаагүй. Одоо Тэргүүн дэд ерөнхийлөгчөө томилохгүй бол гаднын стандартууд нь түрүүлж яваад, Монголбанкны хяналт шалгалттай холбоотой ажлууд нь унаад байгааг бас Монгол Улсын Их Хурлын дарга болон Монголбанк анхаарах хэрэгтэй шүү гэж хэлэх гэж байсан.

Одоо 1 дүгээр асуулт маань эрчим хүчний хүрээнд байгаа юм. Эрчим хүчний реформ гэдэг нэрээр үнийн өргөдөл хийчих гээд байгаа юм. Энийгээ өмнөх 8 жилд хийж байж болоогүй юм уу. Энэ чинь дангаараа нэг нам эрх барьсан, дээрээс нь энэ сайд маань өөрөө улирч ажиллаж байсан. Тэгээд энийгээ хийж байхгүй одоо яагаад ингээд хамтарсан нэрийн доор оруулж ирээд бид нарыг хүртэл ингээд татаж оруулж байгаад 103 гэдэг нэр зүүж байгаад ингэж хийх гээд байгааг бас асуух гээд байгаа юм. Жишээлэхэд 8 жилийн өмнө 3 дугаар цахилгаан станц чинь салбар дотроо хамгийн өндөр ашигтай компаниараа нэрлэгдээд явж байсан чинь сүүлийн 3 жилд 2022 онд 6,5 тэрбум, 2023 онд 1,1 тэрбум, 2024 онд урьдчилсан байдлаар 14,6 тэрбумын алдагдал хүлээж байгаа юм. Тэгээд энэ хамтарсан нэрээр ингээд бусад намуудаа чирж оруулаад асуудалд оруулж байхынхаа оронд энэ байгууллагынхаа дарга цэрэг нарыг эсвэл тэр хуулийн байгууллагад шилжүүлээд асуудлуудыг нь ярьж байж болоогүй юм уу.

Одоо манай Ардчилсан намаас эрчим хүчний реформд орсон Энхтуяа, Цэнгүүн гишүүд ч бас энэ дээр ижилхэн санал байр суурьтай байгаа байх. Тэгээд энийг жишээлэхэд

яг эрчим хүчнийхээ реформыг явуулна гэж байгаа бол төлөвлөгөө гаргаад, энэ онд 2, 3 хувь, ирэх онд 2, 3 хувь, магадгүй эдийн засаг сайжраад, хуримтлал сайжирсан үед бол 4, 5 хувь ч юм уу ингээд явж болдоггүй юм уу гэж асуулт байгаад байгаа юм. Тэгээд энэ чинь одоо яг ингээд өм цөм явна гэж байгаа болбол энэ 103-аас чинь нэрээ татаж байн гэдгээ бас хэлэх гээд байгаа юм.

Тэгээд төсөвтэй холбоотой эдийн засгийн ангиллаар нь бол жиш жишээлэхэд би нхэдэн тооцоо хийж үзсэн юм. Урсгал зардал дотор зөвхөн байр ашиглалттай зардал 2023 он ороод өмнөх 7 жилийн дундаж нь жилд 283 тэрбум төгрөг байсан байгаа юм. 2024 онд 577, 2025 онд 863 тэрбум. Өмнөх оныхоосоо 50 хувь, 2023 ороод тэгээд өмнөх 7 жилтэйгээ харьцуулах юм бол 200 хувиар өсөөд байгаа юм. Хангамж, бараа материалын зардал 2023 он ороод 7 жилийн дундаж нь 163, 24 онд 206 байсан. 2025 онд 281 тэрбум буюу өмнөх оноосоо 31 хувиар өсөж байгаа юм. Эд хогшил, урсгал засварын зардал гэж байгаа юм. Өмнөх 7 жилийн дундаж нь 108, 2024 онд 158, 2025 онд 267. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд 2023 он хүртэл 7 жилийн дундаж нь 635 байсан. 2024 онд 1 их наяд 396 тэрбум, 2025 онд 1 их наяд 857 тэрбум. Тэгээд ингээд харахаар энэ 2024 оныхоороо явах юм бол 2,6 их наяд төгрөг, өмнөх 7 жилийн дунджаараа харьцуулаад харах юм бол 5,7 их наяд төгрөг хэмнэх боломжтой харагдаад байгаа юм.

Энэ 3 дугаар асуулт нь болохоор одоо энэ салбар яамаар нь жишээ авъя. Сая бол зүгээр нөгөө урсгал зардал, нийт дүнгээр нь харж байгаа юм. Жишээлэхэд энэ Боловсролын зээлийн сан гэж нэг газар байгаад байгаа юм. Өмнөх 7 жилийн дундаж нь 48,5 тэрбум төгрөгийн зээл өгдөг байсан байна. Сүүлийн жил буюу энэ 2024 онд 124 тэрбум, 2025 онд 176 тэрбум. Тэгсэн эргэн төлөлт нь 30-хан тэрбум. Тэгээд эргэн төлөлт хийгдэхгүй, тэгээд нөгөө хэдэн дарга нар нь өөрсдөө эрх мэдэлд ойрхон байгаа хүмүүс нь хусчихдаг энэ санг жишээлэхэд 176 тэрбумаар зузаатгах хэрэг байгаа юм уу. Тэгээд зарим асуудлууд нь давхардаад байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг Засгийн газар биш Улсын Их Хурал дээр ярих асуудлууд нь.

Тэгээд ер нь бол Дэгийнхээ тухай хуульд өөрчлөлт оруулахгүй бол зардлуудаа хариуцлагаа ярья гээд... /минут дуусав/

Х.Булгантуяа: Даваагийн Цогтбаатар гишүүн нөгөө төсвийн тухай одоо чинь хуулийг хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж байгаа. Та илүү төсөвтэй холбоотой асуулт асуучих шиг болох юм. Яах вэ энэ чинь дагаж өргөн мэдүүлсэн хуулиуд байгаад байгаа шүү дээ. Тэр хуулиудын хүрээнд одоо яг хэлэлцүүлэг явж байгаа юм. Үүний араас төсөв орж ирэх байх. Даваасүрэн дарга хариулах уу. Яах вэ. Харин тийм наадах чинь яг төсөв дээр л ярих зүйлүүд л дээ. Таны ярьж байгаа зүйлүүд бол. Даваасүрэн дарга.

Ц.Даваасүрэн: Тийм. Ер нь бол дараагийн 2025 оны төсөв хэлэлцэхэд яг энэ асуудлууд, урсгал зардал, энэ хөрөнгө оруулалтын юм энэ тэр бол яригдана. Ер нь зардал би түрүүн хэллээ шүү дээ. 2021 онд 11 их наяд байснаа одоо яагаад 30 хэдэн их наяд болчхов гэж. Тийм учраас Түвшин гишүүнээр ахлуулаад бид нар бас яг энэ урсгал зардал дээр тодорхой хэмжээний бас ажиллаж үзсэн байгаа. Гэхдээ цаг хугацаа бага учраас бид нар нарийвчилж бас чадахгүй байгаа юм. Түвшин гишүүн бас тодруулж болно шүү энэ дээр. Ер нь зүгээр ингээд өнгөцхөн харахад шүү дээ. Энэ хэдхэн хоногийн хугацаанд. Энэ зардал өсөхөд нэлээн өндөр нөлөөлсөн юм бол шинэ байрууд ашиглалтад орсон явдал юм билээ. Тэрний ашиглалтын тэнд ажиллах гэж байгаа нөгөө гэрээт ажилчдын цалин хөлс гэдэг ч юм уу ингээд халаалт, гэрэл цахилгаан гээд л ингээд л явчихна шүү дээ. Тийм учраас яах аргагүй энэ байр ашиглалт бол маш өндөр хувийг эзэлсэн юм байна лээ.

Тэгээд бид нар энэ 11 сарын дундуур яг энэ төсвийн зардлын өсөлттэй холбогдолтой ажлын хэсэг байгуулж ажиллана. Түвшин гишүүн нэлээн голлож, ахалж ажиллах байх. Ер нь судалж үзье гэж байгаа юм. Энэ мөнгөнүүд ер нь хаашаа ороод байна. Юу өсөөд байна вэ гэдэг дээр анализ хийнэ гэж үзэж байгаа.

Эрчим хүчний хувьд бол нэг их яригдаагүй. Зүгээр эрчим хүчин дээр бол нэг ийм зүйлийг анхаарах хэрэгтэй. Энэ бол монопол үйлдвэр. Тийм учраас энийг үнэ чөлөөлнө гэдэг ойлголт бол байж болохгүй. Тэр яагаад 8 жилийн өмнө ашигтай байгаад байсан юм гэхээр тэр үед би сайд байсан санагдаж байна. Яг ингээд баланслуулаад тарифыг нь өсгөчихсөн юм. Баланслуулаад. Тийм учраас дараа жил нь жоохон ашигтай гарсан байхгүй юу. Тэрнээс өмнөх жилдээ алдагдалтай байсан юм. Тэгээд тэрнээс хойш үнэ чөлөөлөхгүй, үнэ, тарифыг нь нэмэгдүүлэхгүй байсан учраас ингээд алдагдал нь өсөөд явчихсан байхгүй юу. Миний бодол ямар байдаг вэ гэвэл зүгээр яг тэр алдагдлын алдагдалгүй ажиллах хэмжээ нь тарифыг нь бариад, тэгээд тодорхой хэмжээний шинэчлэл хийх хэмжээний бас үнийн өсөлтийг нь энэ чинь зохицуулах хороо гэж байгаа шүү дээ. Тэр шийдээд ингээд явахгүй бол зүгээр ингээд чөлөөлөөд хаячихна гэвэл энэ чинь асар том дарамт ирэх байхгүй юу. Тэгээд нөгөө талаас эрчим хүч шинэчлэл хийх хэрэгтэй. Тэгэхдээ зөвхөн тарифын биш. Тэр зардлаа бууруулах ёстой. Гадаадын станц дээр 200, 300 хүн байхад манайд яагаад 1 мянган хүн байгаа юм. Яагаад гадаадын дэд станц дээр хүн байхгүй байхад манайд 20, 30-аараа байгаа юм. Тийм учраас тэрийгээ автоматжуулах, ухаалаг болгох энэ бүх арга хэмжээг авч байж өөрсдөө давхар ийм шинэчлэлийг хийж явахгүй бол зүгээр тариф өсгөөд иргэдийн нуруун дээр энэ ачааг үүрүүлнэ гэвэл бас тийм сайн зүйл биш. Тийм учраас энэ шинэчлэлийн асуудал хийгдэхэд энэ бүгд бол яригдаад явах байх гэж ингэж бодож байна. Тэр зээлийн санг нь ажлын хэсгээс хариулах байх.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс нэмж хариулах уу. Цогтбаатар гишүүн яг төсвийн хэлэлцүүлэг дээр асуух уу. Одоо авчих уу. Ажлын хэсгээс хэдэн номерын микрофон бэ. Сангийн яамныхан. Боловсролын яамнаас хүн алга. Боловсролын сайд байхгүй байна. Боловсролын сайд хариулах нь зүйтэй байх. Яг төсөв хэлэлцэж байхад Цогтбаатар гишүүн ээ, та дахиад асуучхаач тэгэх үү. Эрх биш төсөв хэлэлцэхэд байх байлгүй. Тэгье. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад би зүгээр ерөнхий мэдээлэл өгье. Боловсрол зээлийн сангийн тэр бүтэлгүй хэдэн нөхдүүдээс болоод дараагийн үеийн, дараагийн оюутнууд энэ ирээдүй болсон залуучууд бас хохирч үлдэж болохгүй. Хяналт шалгалтын тэр процессыг нь өөрийг нь ил тод болгох, шударга, хүртээмжтэй байх, зөв хүндээ очих, эргэн төлөлт дээр нь хатуу хяналт тавих, хариуцлага тооцох гээд энийгээ сайжруулаад ингээд цаашаа явах л хэрэгтэй. Бүр зогсоож бас болохгүй. Гэхдээ цаашаагаа явахдаа энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч орчихсон байгаа. Өмнө нь одоо бас хуульчлаад гарчихсан хөтөлбөрүүд, үндэсний хэмжээний хөтөлбөрүүд байгаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит хөтөлбөрүүд байна. Засгийн газар, Ерөнхий сайдын нэрэмжит хөтөлбөрүүд байна. Тэгэхээр энэ 2 хөтөлбөр дээр л зориулагдаж тавьсан. Оюутнуудад үзүүлэх оюутны сургалтын хөтөлбөрийн тэтгэмж байдлаар төсөвт тусгагдаж явж байгаа.

Х.Булгантуяа: Тэгвэл Цогтбаатар гишүүн нэмээд төсөв яг хэлэлцэж байхад нэмээд тодруулчихъя. Пүрэвжавын Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Энэ төсөв дагаж орж ирж байгаа хуулиудад ер нь бол хувийн хэвшил, аж ахуйн нэгж тэр тусмаа жижиг дунд бизнесүүдийг яг дэмжих, гол нь хүртээмжтэй ийм бодитой бодлого алга. Засгийн газрын 4 жилийн хөтөлбөрт уг нь энэ бизнесийн орчныг таатай болгоно. Эдийн засгийг либералчилна гээд их сайхан гоё заалтууд уг нь орсон. Гэтэл

яг энэ хувийн хэвшилд хамгийн том дарамт татварын дарамт болж байгаа. НӨАТ-ын татвар, НДШ-ийн татвар, тэгээд зээлийн хүү гээд олон асуудлууд байж байгаа. Гэтэл энэ 2 гол татвартай холбоотой ямар ч бодлого хэрэгжүүлэх зүйл алга.

Дээр нь энэ оны 1 сарын 1-ээс эхлээд ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ дээр нэг удаагийн шинжтэй орлого дээр НДШ авдаг болоод улам дарамт нэмэгдэж байгаа. Тэгэхээр би бол энэ Засгийн газрынхаа хөтөлбөртэй уг нь уялдсан энэ дагасан хуулиудаа бас өөрчлөлт оруулж ирэх болов уу гэсэн хүлээлттэй байлаа. Ерөнхий сайд маань ч гэсэн НӨАТ-ын татварыг 4 жилээр хойшлуулна гээд Засгийн газрын төлөөллүүд танилцуулга мэдээлэл хийгээд байсан. Энэ хуульд харамсалтай нь алга. Тэгээд энэ ААНОАТ-ын тухай хууль болон Гаалийн тариф, татварын хуультай хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой тодорхой асуултуудыг асууя.

1. Яг энэ ААНОАТ-ын тухай хуульд орж байгаа тэр 5 жилээр хойшлуулж байгаа 90 хувиар хөнгөлж байгаа заалтуудыг яг хэдэн аж ахуйн нэгж, өөрөөр хэлбэл нийт аж ахуйн нэгжүүдийн нийт жижиг дунд бизнесүүдийн яг хэдэн хувь нь хамрагдана гэж тооцоод байгаа вэ. Яг ямар хэмжээтэй татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлнэ гэж тооцож байгаа вэ. Энэ тооцоогоо нарийн хэлмээр байна. Түрүүн бас ганц нэг гишүүд асуусан. Тодорхой бас хариулт өгөөгүй. Гаалийн татвар дээр мөн ялгаагүй. Яг энэ дээр бас тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

2-т энэ ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр тэр татварын орлого олж эхэлсний дараагийн тайлангийн хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар гэхихсэн байгаа юм. Тэгэхээр ирэх жилээс авхуулаад төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэх гээд баахан хөрөнгө оруулалт хийгээд 3, 4 жил үргэлжилж байгаад, татварын орлогоо олоод дөнгөж эхэлнэ. 2029 он, 2030 онд. Тэгж байтал энэ хуулийн 4 дүгээр заалт дээр тэр саяын оруулсан хөнгөлөлт чөлөөлөлтийн заалтаа 2030 оны 12 сарын 31-ийг хүртэл дагаж мөрдөнө гээд хориглочихсон. Тэгэхээр хувийн хэвшил ингээд баахан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийгээд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гээд ороод явж байдаг. 5 жил 90 хувиар чөлөөлөгдөх юм байна гэж байдаг. Гэтэл энэ талд нь ингээд хориглочихсон заалт байж байгаа. Энэ яаж уялдаж байгаа юм бэ. Энэ ер нь оруулж ирэхдээ ямар тооцоо судалгаатай ингэж оруулж ирсэн юм бэ гэдгийг тодруулмаар байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ганзориг гишүүний асуултад хариулъя. Мөн өөр гишүүд ч бас яг энэ асуудал дээр давхардаж асууж байсан. 2 татварын бодлого санал болгож байгаа. ААНОАТ, Гаалийн татвар. 2 тусдаа өөр өөр. Та ААНОАТ-тай нь холбоотой асууж байна гэж ойлголоо. Бид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд энэ жилийн Улсын Их Хурлын 64 дүгээр тогтоол байгаа. Сая мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөр батлагдсан байгаа. Энэ дээр бүсчилсэн хөгжлийн нийтдээ 227 төсөл, арга хэмжээнүүдийг Улсын Их Хурлаар салбар салбараар нь, төрөл төрлөөр нь заасан байгаа. Үгүй ээ, яах вэ тэр дээр ингээд төсөөлөөд тэгвэл тооцё л доо. Төсөл бүр дээр юу гэдэг юм, 1, 1 аж ахуйн нэгжүүд гэх юм бол 1 ийм тоонд хязгаарлагдах байх. Олон аж ахуйн нэгжүүд эрэлт хэрэгцээнээсээ зах зээлийнхээ боломжоос хамаараад явах юм бол тоо нь ингээд үүнээс дээш явах байх. Энэ татварын бодлого энэ урамшуулал, хөнгөлөлт гэдэг маань өөрөө энэ зах зээл рүү уриалж байгаа бодлого шүү дээ. Уриалж байгаа. Боломжуудыг нь нээж өгч байгаа. Тэгэхээр яг хэдэн төсөл нь амжилттай хэрэгжих юм. Аль нь үнэхээр яг тийм bussines able болоод, хөрөнгө оруулагч нарын сонирхлыг татаад орж ирэхийг өнөөдөр хэн ч төсөөлж хэлж мэдэхгүй. Ямар ч байсан бид салбар салбараа заачихсан. Бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалын хүрээнд. Ингээд

татварын бодлогоороо дэмжиж байгаа гэдгээ зарлачихлаа. Ирэх жилийн төсвийн бодлоготойгоо уялдуулаад бүс бүрээр нь ингээд салбар салбаруудыг нь заачихсан байгаа.

Гаалийн албан татварын хувьд бол энэ бүсээр заагаагүй. Энэ ерөөсөө улс орон маань өөрөө нэг том кластер, нэг бүс. Тэгээд бид ер нь худалдааны эдийн засагтай л улс. Боловсруулах чиглэлийн ер нь салбар бол маш муутай. Дараагийн удаа бид хилээ хаагаад, дараагийн удаа ковид болох юм бол бид үндэстнээрээ энэ дээр маш хүнд байдалд орно гэдгийгээ сая бид ковидын үед мэдэж авсан.

Хүнсний аюулгүй байдал ч тэр, энэ нүүрсний зах зээл дээр ч тэр, ер нь 10 жилийн дараагаас бид нар ер нь энэ эрчим хүчний нүүрсийг экспортлох бараг боломжгүй болох байх. Бүгд ногоон хөгжил рүүгээ шилжчихнэ. Тэр үед бид ядаж нүүрсээ тултал нь боловсруулаад гаргадаг болмоор байгаа юм. Тэрийгээ бид өнөөдрөөс л эхлэх ёстой. Ингээд өмнө нь ингээд салбар салбараар сугалаад ингээд технологийн тоног төхөөрөмжийг нь гаалийн албан татварыг чөлөөлнө гээд ингэж заадаг байсан бол одоогоос ингээд салбар харгалзахгүйгээр бүх түвшний боловсруулах, боловсруулалтын шатаа ахиулах энэ боломжууд дээр нь технологийн тоног төхөөрөмжүүдийг нь оруулж ирэхэд нь гаалийн албан татварыг нь чөлөөлье гэж байгаа юм. Ингээд энийг Улсын Их Хурлаар хэрвээ баталдаг болох юм бол одоо яах вэ болно. Гэхдээ энэ чинь яг компани бүрээр ч юм уу тэгж төсөл бүрээр ингэж оруулж байж гаалийн байцаагчийн ажлыг, татварын байцаагчийн ажлыг бол энд хийхгүй нь ойлгомжтой шүү дээ. Тэгэхээр салбар чиглэлээр одоо жишээ нь ийм байдаг юм. НӨАТ-ын хуулийг дагасан юуг боловсруулах үйлдвэр гэж хэлэх вэ гээд ингээд заачихсан жагсаалт байж байгаа. Жишээ нь тэр дээр 33 төрлийн боловсруулах үйлдвэрийн салбаруудыг нь заачихсан байдаг. Бараг тэр л .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ганзориг гишүүн болчихсон уу. Амжихгүй байна уу. Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Тэгэхээр энэ үйлдвэрүүд бол бүх насаараа 40, 50 жил, 100 жил хөнгөлөлт, чөлөөлөлтөд бас хамрагдаж болохгүй. Тодорхой хэмжээний боломжтой болоод ирэхээрээ бусад аж ахуйн нэгжүүдтэйгээ ижилхэн татвараа төлөөд л явдаг болох хэрэгтэй. Тэр хугацааг 5 хүртэл гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл үйлдвэр нь ашиглалтад ороод, орлого болдог болж ирээд, тэгээд 5 жил үйлдвэр тогтоох ийм боломжит хугацаа гэж ингэж тооцоолж судалгаа дээр үндэслэж гаргаж ирж байгаа тоо юм байгаа юм. 10 жил хөнгөлөгдөж болохгүй шүү дээ. 5 жил байхад бол болно л гэж харж байгаа ийм цаг хугацаа.

Х.Булгантуяа: Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: Энэ ААНОАТ-ын тухай хуулийн тэр орж ирж байгаа 1.1, 4 дүгээр зүйл 2 зөрчилдөөд байна л гээд байгаа юм. Орлого олж эхэлснээс хойш гэж байгаа шүү дээ. 5 жил. Гэтэл энэ төслүүд чинь энэ хууль батлагдаад ирэх жилээс л хувийн хэвшлүүд чинь төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхээр ажил руугаа орно шүү дээ. Тэгээд үйлдвэрээ бариад, бүтээн байгуулалтаа эхлэх гэсээр байтал 2, 3 жил болно. Үйл ажиллагаагаа эхэлж орлогоо олох гэсээр байтал бараг 4 жил болно. Тэгж байтал энэ хуулийн чинь хүчинтэй хугацаа дуусчих гээд байгаа байхгүй юу. 2030 он гээд хязгаарлаад хаячихсан. Энэ 2 чинь нэгд уялдахгүй байна гээд.

2-т ер нь бол одоо ингээд хөгжлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтуудыг бол уг нь дэмжээд байгаа. Тэгэхдээ хувийн хэвшлээ дэмжинэ гэж Засгийн газрын хөтөлбөртөө оруулчхаад бодитой дарамт болж байгаа татварын дарамтууд дээр ерөөсөө бодлого хэрэгжүүлэхгүй байна. Зүгээр төсвийн хөрөнгө оруулалтыг харахад үр ашиггүй ач

холбогдолгүй зардлууд зөндөө байна шүү дээ. Зүгээр Тэрэлж рүү гэхэд 1км-ийг нь 6 тэрбум төгрөгөөр тавина гээд 37км замыг 220 тэрбум төгрөгөөр тавьчихсан явж байгаа.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ганзориг гишүүний асуултад Жавхлан сайд хариулах уу.

Харин тийм. Уг нь дагасан хууль хэлэлцэж байгаа гишүүд маань яг төсвөөс асуулт асуугаад байх юм. Зам нь бол төсөвтэй холбоотой километрийн 6 тэрбумаар зам тавиад байна. Энэ яг хэрэгтэй юм уу гээд Ганзориг гишүүн бас яриад байсан. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ямар ч байсан ингээд чөлөөлөлтөө бид нар хөнгөлөлт хийнэ гэдгийгээ бодлогоо зарлачихлаа. Хугацаагаа ингээд бас 5 жил хүртэл гээд зарлачихлаа. Яг орлого олоод цаашаа явбал ингээд 3-4 жилийн боломж бас харагдаж байгаа төслүүд дээр. Тэгэхдээ энэ замбараагүй бас урт хугацаатай бас байж болохгүй. Тэгэхдээ Их Хурал дээр та бүхэнд тэгээд л хэлэлц. Бүгдээрээ хэлэлцье. Энэ хэрвээ богинохон байна гэж байвал нэмж болно. Урт байна гэж байвал хасаж болно. Ямар ч байсан дунджаар 5 жил, өөрөөр хэлбэл үйлдвэрээ бариад 1, 2 жил орлого олоход 3-4 жил гэж л ингэж төсөөлж орж ирж байгаа гэсэн үг.

Х.Булгантуяа: Ганзориг гишүүн төсөвтэй холбоотой асуудлыг нь төсөв хэлэлцэж байхад дараагийн хэлэлцэх асуудал дээр асуучихъя. Зам, тээврийн сайд ч гэсэн тэр үед байх байх. Дараагийн гишүүн Жудгийн Баярмаа. Баярмаа гишүүн байхгүй байна. Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Энэ удаагийн төсөв болон түүнийг дагаж ирсэн хуулиудын тухай бас нэлээн сууж ажлын хэсэг дээр ч бас нэлээн ярьсан. Тэгээд энэ ажлын хэсэг дээр төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал, төсвийн орлого талаас гээд нэлээн задаргаа гаргаад, нэг талаасаа төсвийг үр ашигтай байлгах талаар, нөгөө талаасаа төсвийн тэнцлийг, алдагдлыг бууруулах талаар нэлээн идэвхтэй ажиллаад, ихдээ 1-2 их наяд төгрөгийн зардлын хэмнэлт үүсгэж болох юм. Багадаа 100-аад тэрбум төгрөгийн хэмнэлт үүсгэж болох юм гээд ингээд явж байгаад, сая тэр тойрог дээр мөнгө татах гэсэн гэдэг шуугианаар энэ ажил зогсчихлоо л доо. Тэгээд энэ шуугианыг яг юу гэж үзэж байна вэ гэхээр Улсын Их Хурлын төсөв батлах бүрэн эрхэд бол халдаж байна гэж үзэж байгаа. Хэдүүлээ ингээд хууль батлаад, төсөв батлахаараа бие биенээ муухай харагдуулдаг, гүтгэдэг, хэлээгүй, яриагүй зүйлээр ярьсан, харсан болгож байх замаар тэгээд олон нийт дээр ингэж харагдуулж байгаад ингэж төсвөө батлуулдаг зарим хүмүүс энэ талаасаа бас жоохон санаа зовмоор байна. Удахгүй ингээд баригдана л даа.

Тэгээд энэ төсөв дээр бас 2, 3 саналыг хэлье гэж бодсон юм. Ер нь яах вэ тэр зардлын нэр төрлөөр зардал болгоныг хасах ч тийм сайн зүйл биш л дээ. Зардал гэдэг чинь өөрөө агуулгаараа хувьсаж байдаг, дээрээс нь цаад талд нь ямар ч үйл ажиллагааг юу гээч нэрлэчихсэн ч байж болдог гэдгийг бол ойлгож байгаа. Гэхдээ 35 их наядаар төсөв нэмэгдэж байгаа гэж бүгдээрээ бодож байгаа. Үүний цаана ямар үг хэлээд байгаа вэ гэхлээрээ 14 мега төслийг л санхүүжүүлэх гээд байна гэж бодоод байгаа юм. Бодит байдал дээрээ 35 их наядын 26 их наяд нь төсвийн урсгал зардал. Өнгөрсөн 2024 онд 22 их наяд байсан. Энэ урсгал зардлыг нэмэгдүүлэх, энэ урсгал зардлуудын дотор бол үр ашгийг сайжруулах юм тодорхой хуваарь бол байж байгаа. Саяын богино хугацаанд тодорхой хэмжээгээр лавлаж асууж, анализ хийж явж байгаад тэгээд энэ үйл ажиллагаа ингээд тодорхой шуумаас болоод зогсож байх шиг байна.

Тэгэхээр одоо бол бид нарын гол зорилго бол яг энэ төсвийн алдагдлыг бууруулах л асуудал байж байгаа. Энэ дээр ийм 2 арга зам байгаа харагдаад байна. Үндэсний баялгийн

сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр орж ирснээр 1 дүгээр зүйлийн Үндэсний баялгийн сангийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1 дүгээр зүйлийн 2025 онд гэдгийг 40 гэж орж ирсэн байгаа. Үндсэн одоо яг байгаа хуулийн заалт нь бол 65 байгаа. 2024 онд 20-оор оруулж ирж байсан. Тэгэхээр энэ 40-ийг 65 болгоход үнийн дүнгийн зөрүү нь хэд болох вэ. Орлого яаж өөрчлөгдөх вэ. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт Төсвийн тэнцэл 1,9.../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хариулт явах ёстой. Тэгж байгаад нэмэлт тодруулга явна. Түвшин гишүүн бас яг төсөвтэй холбоотой асуулт асуугаад байх шиг байх юм. Одоо чинь дагаж өргөн барьсан хуультай холбоотой асуултууд. Та чинь тэнцэл асуугаад, урсгал зардлыг бууруулах арга хэмжээний тухай асуугаад байдаг. Харин тийм. Тэгэхдээ Түвшин гишүүний хэлж байгаа үнэн шүү. Түвшин гишүүн төсвийн ажлын хэсэг дээр урсгал зардлын ажлын хэсгийг ахалж ажилласан. Урсгал зардал 26 их наяд байгаа. Энэ бол өмнөх оноос 18 хувиар өссөн байна гэдэг ийм дүгнэлтийг гаргаад, зарим нэг зардлыг бууруулья гэсэн. Энэ бол мега төслүүдээс, бүсчилсэн хөрөнгө оруулалтуудаас бууруулья гэсэн зүйл заалт яриагүй байхад үүнийг тэгээд тойрогтоо төсөв тавиулах гээд байгаа юм шиг гишүүд рүү ингэж сүүл рүүгээ бүр мушгиж олон нийтэд мэдээлсэн зүйл байгаа шүү. Тийм зүйл бол яриагүй шүү дээ. Ажлын хэсэг дээр ч гэсэндээ. Үгүй ээ мэдэхгүй, харин. Урсгал зардлаас нь хасагдчих гээд байна гээд эсвэл сандраад байгаа юм уу хүмүүс. Түвшин гишүүн асуултаа нэмж асуухгүй бол асуултгүй болчихлоо. Та оршил ярьсаар байгаад яах вэ. Жавхлан сайд эхлээд хариулчихъя. Тэгээд та нэмээд тодруулья тэгэх үү.

Б.Жавхлан: Ирээдүй өв санг хэрвээ тэр дээр таны хэлснээр тийм 40-65 гээд өөрчлөлт орох юм бол болно л доо. Тэгэхдээ энэ чинь нөгөө тэнцлийнх чинь алдагдал нэмэгдэнэ шүү дээ. Тийшээ хуваарилалтаа оруулчихаар. Сайжруулах биш бүр нэмэгдээд явчихна. 1 дүгээрт.

2 дугаарт тэнцлийг алдагдалгүй болгох нь бол Улсын Их Хурал дээр сонголт байгаа. Энэ маш амархан. Эрэмбийн хувьд шинээр хөрөнгө оруулалтуудаа зогсоочхож болно. 1,9 их наяд хүрэхгүй бол үргэлжилж байгаагаа зогсоочхож болно. Харин хамгийн сүүлд нь урсгал зардал руу л ороорой. Тэр урсгал зардал чинь цаана нь дандаа Засгийн газрын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд байж байдаг. Үйл ажиллагаа санхүүжүүлдэг л урсгал зардал шүү дээ. Тийм учраас одоо хэрвээ томоохон бүтээн байгуулалтууд хийхгүй энэ удаа яах юм. Зүгээр төсвөө л сайхан болгочихъё гэвэл маш амархан. Одоо тэр урсгал зардал нэмэгдэж байгаа чинь 5,3 их наяд, үүний чинь 1,7 шинэ бүтээн байгуулалтууд байгаа. 3,5 нь нөгөө тариф, статистик, өсөлт энэ юмнуудаас шалтгаалсан, мөн шинэ янз бүрийн хуулиуд гарч ирээд зардлыг шууд нэмж байгаа ийм заалтууд ч байгаа. Ингээд л хөрөнгө оруулалтуудаа тэгвэл хийхгүй. Хэдүүлээ сайхан гараа хумиад л урдах юмнуудаа үргэлжлүүлээд л сууж байя гэвэл энэ сонголт байгаа. Маш амархан.

Х.Булгантуяа: Түвшин гишүүн тодруулья.

Б.Түвшин: Нэмэлт Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр асуултыг асуусан шүү дээ. Дагаж орж байгаа хуулийн тухай. Тэгээд энэ дээр бол тэр баялгийн сангийн дагаж мөрдөх хуулийн 1 дүгээр зүйлийн 2025 онд мөрдөх 40 гэснийг 65 болгож өөрчилбөл тоо нь хэд вэ гэж. Би өөрөө тооцсон л байгаа. Зүгээр 1,2 их наяд гарч байх шиг байна. Орлогыг энэ 1,2 их наядар бууруулах боломж байна. Нөгөө талдаа баялгийн сан нэмэгдэнэ гэж ойлгож байгаа. Бууруулах зардал дээр бол хэдхэн жишээ хэлье л дээ. Гадаад томилолт улсын хэмжээнд урсгал зардал дээр 35 тэрбум байснаа 41 болсон. 118 хувь өссөн. Дотоод томилолт 132 хувь өссөн. Зочны зардал 137 хувь өссөн. Их

засвар 186 хувь өссөн. Урсгал засвар 150 хувь өссөн. Бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээ 1 их наяд байснаа 1.4 их наяд. Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээ 979 тэрбум байснаа 1,4 их наяд гэх мэт. Тэгээд энэ цаашаа өргөн .../минут дуусав/

Х.Булгантуяа: Түвшин гишүүн төсөвтэй холбоотой асуулт асуулаа. Тэгэхдээ яг энэ урсгал зардалтай холбоотой ажлын хэсэг ахалж байсан хүний хувьд яг ийм өсөлтүүд гэв гэнэт яагаад үүсчэв. Үүнтэй холбоотой зардлыг бууруулах нь зүйтэй гэдэг саналыг бол Түвшин гишүүн ажлын хэсэг дээр гаргасан шүү. Тэрнээс биш тэр дээр тойрог дээр төсөв тавимаар байна гэж өөрөө тойргийн гишүүний хувьд бол тийм санал яриагүй. Яах вэ Түвшин гишүүн ээ төсвийн үед асуух уу. Тэгье. Одоо нөгөө дагалдах хууль хэлэлцэж байгаа учраас. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Тэмүүлэн гишүүн байхгүй байна. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Энэ одоо нөгөө асуугаад, асуултын хариултыг нь бараг урьдчилаад мэдээд, тааж байхад тэр хариултыг л буцаагаад өгчхөөд байгаа юм. Төсвийн тодотгол, төсвийн хэлэлцүүлэг, төсөв дагаж орж ирж байгаа хууль, тэгээд бие биедээ асуусан хариулсан болоод өнгөрөөд байдаг өөрчлөлт орж өгдөггүй. Энийгээ бид нар яаж хийх юм гээд. Одоо ДНБ энэ жил 90 их наяд орчим, 90 их наяд болно гээд төсөөлөөд үзэхэд энэ засаг барьж байгаа 3 нам чинь бол сонгуулийнхаа амлалтаар 23 их наяд буюу 25 хувиас нь хэтрүүлэхгүй л гэж амлаад байгаа шүү дээ. Амлаж байж орж ирсэн. Эрх барьж байгаа. Энэ амлалтуудыг бол байнга сануулна. Бусад зүйл дээр ч гэсэн сануулна. Тухай тухайн чиглэлээрээ юу амлаж байсан юм бэ гэдгийг.

Улсын төсөв 35,8 их наяд байж байдаг. Энэ чинь мөнгөний нийлүүлэлт нь болохоор 42 их наяд байж байдаг. Энэ чинь бол үндсэндээ коэффициентлээд хувиар нь үзэхээр бараг 85 хувь нь улсын төсөвтэй очиж холбогдоод байгаа. Тэгээд энэ тохиолдолд юу болж байна вэ гэхээр төв банк нь бодлогын хүүгээ өндөрсгөчихдөг. Бодлогын хүүгээ өндөрсгөхөөр нөгөө банкнууд нь эрсдэлгүй утгаараа төв банк руу хадгаламжаа байршуулчихдаг. Ингэхээр энэ иргэдийн ажиллах, амьдрах, өөрсдийнхөө сайн сайхны төлөө бүтээх, тэр боломж нөгөө мөнгөний эргэлтээрээ дутагдаад явчхаад байгаа байхгүй юу. Төсөв болон төсвийг дагаж байгаа хуулиудад үүнийгээ иргэд маань дарга нараас буюу төсвөөс хамааралтай, төрийн өмчит байгууллагаас хамааралтай ийм нөхцөл байдал болоод байхаар зээлийн хүү нь өндөрсөөд. Тэгэхээр энийгээ энэ төсвийн бодлого дээрээ яаж зохицуулмаар юм. Дагаж мөрдөж байгаа хуулиуд дээр нь жишээлэхэд бүсчилсэн хөгжил, хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжил гээд яриад байдаг. Тэгэхэд нөгөө бүсчилсэн хөгжлөө дэмжсэн тэр зүйлээсээ илүү нөгөө улс төрийн амлалтаа хадгалсан, хамгаалсан чиглэл рүүгээ хөрөнгө оруулалтууд юм уу бусад зүйл нь харагдаад байдаг. Дагалдах хуульд аж ахуйн нэгжээ дэмжинэ гэххэд энэ нь болохоор нөгөө төсвийн төслийнхөө тэлсэн байдалтай болохоор харагдаж өгдөггүй. Нөгөө эрүүл мэнд, хавдрын өвчлөл, аюулгүй байдал, утаад тортог энэ юмнуудаа яаж хийдэг юм гэдэг юмнууд нь болж өгдөггүй. Тэгээд төсвийн хөрөнгө оруулалтууд нь төсвийг батлахын тулд л энэ дагалдах хууль баталж байгаа шүү дээ. Одоо заримыг нь төсөв асуугаад байна гэдэг нь нэг талаасаа аргагүй юм байгаа юм. Урд нь тэр оюутны хотхон, Газрын тос өөр юу ч байдаг юм. ТЭЗҮ эд нар гээд баахан юм хийсэн. ТЭЗҮ гэж баахан цаас үйлдвэрлээд тэр нь амьдардаггүй. Амилж өгдөггүй. Тэгээд тэр лүүгээ хэчнээн сая доллароор нь ч гэлүү, хэдэн тэрбумаар нь ч байдаг юм мөнгө гаргаад явуулчихдаг. Нөгөөдөх нь хийгдэхгүй.

Эгийн голын УЦС л гэж байсан. Анх хүмүүс яриад л байсан нэг хэсэг нь. Энийгээ гадаад, дотоод нөхцөл байдлаа тооцсон юм уу. 50 тэрбум төгрөг байхаа төсвөөс өгсөн. Тэгээд ямар ч үр дүн байдаггүй.

Х.Булгантуяа: Батбаатар гишүүн ээ, нөгөө дагаж өргөн барьсан хуулиудаа та уг нь тэр хүрээнд асуулт асуух ёстой байсан. Санал хэлчих шиг боллоо. Бараг асуултынх нь хариуг нь мэдэж байна даа гээд. Тэгээд санал хэлчих шиг боллоо гэж ойлгосон зөв үү. Хариултыг нь бараг мэдэж байгаа гээд тэгж байна. Тэгвэл Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн. Пүрэвдаваа гишүүн байхгүй байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: ААНОАТ-ын тухай хууль болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл дээр асуулт байна.

Нэгд нь том аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжихээс гадна, гарааны бизнес, жижиг, хөл дээрээ дөнгөж босох гэж байгаа энэ хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийг ер нь ямар бодлогоор дэмжих вэ. Энэ удаа Төсвийн тухай хуулийг дагалдуулаад ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах, дэмжлэг үзүүлэх ийм бодлогыг оруулж ирж байна. Тэгвэл дараагийн удаа жижиг аж ахуйн нэгжүүдээ яаж дэмжих вэ. Энэ дээр ер нь ямар бодлого баримталья гэж Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яам үзэж байгаа вэ. Энийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт нь энэ ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээл, Сум хөгжүүлэх сан гээд энэ яах вэ олон улсад хэрэгждэг л бизнесийг дэмжих төр бизнес хийж болохгүй учраас ингээд хөнгөлөлттэй зээлийн бодлого хэрэгжүүлдэг байсан. Тэгээд харамсалтай нь энэ засаглалын дотоод буруу засаглалын нөхцөл байдлаасаа болоод энэ үр дүнгүй болж байгаа зарим тохиолдлыг буруу оношилсон. Өөрөөр хэлбэл ерөөсөө энэ зээл нь буруу юм байна. Ингэж өгөх нь гэдэг ийм зүйл гараад, орон нутагт гэхэд ингээд Сум хөгжүүлэх санд анх олгосон 50 сая төгрөг яг хэвээрээ л байж байгаа юм. Энэ 1 ч төгрөг нэмэгдээгүй, бараг 20 жилийн өмнө эхэлсэн энэ төсөл, арга хэмжээ яг ингээд царцчихсан байдалтай. Тэгээд тэр үеийн 50 сая төгрөг өнөөдрийн 50 сая төгрөгийн хооронд бол инфляцаас үүдэлтэй асар том зөрүү гарчихсан. Тэр үед 50 сая төгрөгөөр магадгүй сумд 5, 10 хувийн хэвшилд дэмжлэг олгодог байсан бол, зээл олгодог байсан бол өнөөдөр бараг 1 төслийг хэрэгжүүлэхэд хүрэхгүй болчихсон мөнгө байх жишээтэй. Тэгэхээр энийг ер нь цаашдаа яаж засах вэ. Өөрөөр хэлбэл энийг цаг үетэйгээ хөл нийлүүлж, энэ нөхцөл байдал, эрэлт хэрэгцээндээ үндэслэж энийг яаж илүү хүртээмжтэй, илүү эргэлтэд оруулах вэ. Үгүй ээ, сонгуулиар бас л амлаад л яриад л явсан шүү дээ бид нар. Энэ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ, хүртээмжийг нь нэмэгдүүлнэ гээд. Тэгээд ингээд сонгуульд үр дүн гарсны дараа болохоор сонгуулиар гол ярьж байсан, дэвшүүлж байсан зүйлээ хэрэгжүүлэх тал дээр жоохон хойрго байгаад байна.

2 дахь асуудал нь Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хууль гээд. Ер нь цаашдаа энд одоо бол яах вэ иргэдэд одоо байгаа иргэдэд болон ирээдүй үедээ тэгш хүртээмжтэй болгох, хүртээх ийм зорилготой л хууль л даа. Энэ бол их зөв, сайн хууль болсон гэж би бол энэ хуулийг баталсанд бол өмнөх парламентад их баяртай байдгаа бас илэрхийлнэ. Тэгээд үүний зэрэгцээ гол нь энэ дээр дахиад нэг зүйлийг бас хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ гэдгийг асууя.

Өөрөөр хэлбэл нөхөн сэргээгддэггүй энэ олон 100 сая жилийн туршид бүрдэн бий болсон хөрсөн доорх байгалийн баялгаас хуримтлуулж орж байгаа мөнгийг нөхөн сэргээгддэг салбар буюу хөдөө аж ахуйн салбар, аялал жуулчлалын салбарыг дэмжихэд яаж ийм тодорхой 1 сайд, Засгийн газар, 1 удирдлагаас хамаарахгүйгээр ийм тогтолцоог Үндэсний баялгийн сангийн тухай хууль шиг яаж бүрдүүлэх вэ. Тийм учраас энэ баялгийн сангийн хуульд нэмэлт оруулах боломж байгаа юу. Нөхөн сэргээгддэг салбар буюу хөдөө аж ахуй, аялал жуулчлал 2-т зориулж хөнгөлөлттэй зээл олгоход төсөл хэрэгжүүлэхэд ямар

бодлогын ийм арга хэмжээ авах вэ. Энэ дээр төлөвлөж байгаа зүйлүүд байгаа юу гэдэг ийм 2 зүйл дээр асууя.

Тодотгоод хэлэхэд Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлдэгтэй адилхан жижиг гарааны бизнес яаж дэмжих вэ.

2-т нь Үндэсний баялгийн сангийн хуулийн тогтолцоотой адил яаж нөхөн сэргээгдэх салбарт дэмжлэг үзүүлэх вэ.

Х.Булгантуяа: Бадамсүрэн гишүүний асуултад Жавхлан сайд хариулах уу. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Эхний асуудалд нь ийм юм байгаа юм шүү. Энэ одоогийн оруулж ирж байгаа татварын бодлого, ААНОАТ-тай холбоотой асуудлууд маань бүх аж ахуйн нэгжүүдэд хамааралтай, Жижиг, дунд, том аж ахуйн нэгжүүд ямар ч ялгаагүй бүгдэд нь хамааралтай гэдгийг хэлье.

2 дугаарт яг одоогоор Үндэсний баялгийн сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад таны саяын энэ хэлсэнчлэн хөдөө аж ахуй болон бусад одоо нөхөн сэргээгддэг ийм баялаг бүтээдэг ийм салбаруудыг оруулна, нэмнэ гэдэг ийм төлөвлөлт бол одоогоор байхгүй. Гэхдээ нөгөө баялгийн сангаас хийгдэх гэж байгаа тэр нөгөө хөрөнгө оруулалт, хуримтлалын сан бол бас яг л ийм зориулалттай шүү дээ. Тэр дээр бол чиглэл л заагаагүй. Тэгээд мөрийн хөтөлбөртөө орсон, яг үнэхээр тулгамдсан стратегийн хувьд өндөр ач холбогдолтой гэвэл таны ярьж байгаа хөдөө аж ахуйн салбар ч байж болно. Бусад өөр ЖДҮ-лэл болон бусад хөнгөн үйлдвэр ч гэдэг юм уу. Тэгээд энийг бол тухайн үед нь мэдээж Засгийн газар, Улсын Их Хурал дээр яригдаж байгаад л ингээд шилжилт хийх, хуваарилалт дээр дахиж өөрчлөлт гаргах ийм зүйлүүд бол би байж болно л гэж ингэж харж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бадамсүрэн гишүүн болсон уу. Нэмж тодруулах уу. Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Гол нь нөгөө төрөөс чинь хувийн хэвшлийг дэмжихийн тулд төр өөрөө бизнес хийж болохгүй учраас 3 л бодлого хэрэгжүүлж байгаа шүү дээ. Дэд бүтцийг дэмжинэ. Хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ. 3-д нь газар олголтын бодлогоор дэмжинэ гээд. Тэгээд энэ маань ингээд газар олголтын бодлого, хөнгөлөлттэй зээлийн бодлого тийм сайн явахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь 3 тулгуур дэмжлэгийнх нь яах вэ дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь хийгдээд байдаг. Нөгөө талдаа энэ 2-ыг нь жижиг гэж бодоод байж магадгүй. Тэгэхдээ энэ чинь өөрөө яг бизнес эрхэлье гэж бодож байгаа, ялангуяа залуучуудад бизнес эрхэлье гэхээр олдохгүй байгаа гол зүйл чинь хөнгөлөлттэй зээл. Тэгээд газартай болж чадахгүй байгаад байна. Дуудлага худалдаагаар газраа авч чадахгүй байгаад байна. Тэгэхээр энэ дээр Монголынхоо онцлогт тохирсон ямар уян хатан ийм бодлогыг бусад орнуудын бодлоготой харьцуулаад явах юм бэ. Бусад орныхон яагаад Монголд ирж бизнес хийгээд байна. Тэнд маш бага хөнгөлөлттэй бага хүүтэй зээл олгож байгаа учраас тэр мөнгөө барьж ирж энд бизнес хийж байгаа нь үнэн шүү дээ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмэх үү.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүний хэлж байгаа зүйлийг би санал гэж ойлголоо. Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлого бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр байдаг. Би сайдад нь, салбарт нь уламжилъя.

Х.Булгантуяа: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн. Засгийн газрын сайд Засгийн газраасаа өргөн мэдүүлсэн хуульд асуулт асуух зохимжгүй байлгүй дээ. Ингээд асуулт асууж дууссан. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 22 санал байгаа. Гишүүд санал хураалт болох гэж байна. Танхимдаа цуглаарай. Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлье. Үдээс хойших санал хураалтын ирцийн санал хураалтыг нэг явуулъя.

Үндэсний хороод бас хуралдаад байх шиг байна. Яг ингээд чуулгантай давхцаад санал хураалттай үед давхар хурал зохион байгуулахаар Тамгын газрынхан ирц бүрдэхгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгвэл эхлээд бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт гишүүд ээ, анхааралтай. Төхөөрөмж нь зарим нь ажиллахгүй байгаад байна уу. Тэгвэл бүртгэлийн санал хураалтыг дахиж нэг явуулъя. Гишүүд анхааралтай. Бүртгэлийн санал хураалт. Зарчмын зөрүүтэй саналыг явуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу дэмжсэн, дэмжээгүй, эсрэг байр суурьтай гишүүдээс тус бүр 2 хүртэлх гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараагаар санал хураалт явуулахаар байгаа. Тэгээд хэлж болно.

1.Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 22.5.22 дахь заалтын “үзэл баримтлалд нийцсэн” гэснийг “үзэл баримтлалд туссан” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, Б.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалт.

Д.Амарбаясгалан: 61 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Улсын Их Хурал” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал гаргасан ажлын хэсгийг төлөөлж Пүрэвжавын Сайнзориг гишүүнд үг өгье.

П.Сайнзориг: Олон гишүүд бас энэ дээр Засгийн газар яг энэ жагсаалтыг батлахыг бас эрсдэлтэй. Бас энийг Улсын Их Хурал баталж байх ёстой гээд хэлээд байх шиг байна. Тэгэхдээ энэ дээр нэг зүйлийг бас би гүйцээн боловсруулах чиглэлийг танаас өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Улсын Их Хурал болгож болно. Харин Засгийн газрын өргөн мэдүүлснээр гэж заавал оруулах ёстой. Ингэж байж энэ өөрөө эргээд Улсын Их Хурлын гишүүд бас

лоббинд автахгүй байх нөхцөл бүрдэнэ шүү. Тэгээд энэ төсөв мөнгөтэй, төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотой, төсөв дээр нэмэлт ачаалал үүсэх үү эсвэл төсвийн орлого буурах уу, үгүй юу гэдэг ийм дүгнэлт гаргадаг энэ зүйлүүдийг Улсын Их Хурал ерөнхийд нь батална гэх юм бол энэ гишүүд чинь нэг компанийн өмнөөс ч юм уу, тодорхой бүлэг бизнесүүдийн өмнөөс ингээд Улсын Их Хурлын тогтоолын төсөл ч юм уу санаачлаад гүйнэ. Тэгэхээр энэ зүйлүүдээ бид хэд бас харж яана. Тэрнээс биш туйлширч болохгүй. Би бол зүгээр зарим зүйлүүдийг бас эрсдэлийг хааж юм уу, сайжруулах саналуудыг бол ойлгож байгаа. Тэгэхдээ нэгэнт бас энэ Монгол Улсын Засгийн газар уг нь тооцоо судалгаатай энэ Засгийн газрынхаа үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон энэ төсөв бүх юмтайгаа уялдуулж орж ирж байгаа л гэж би ойлгож байгаа. Тэр хүрээндээ бас шийдэж уг нь болно. Тэгэхдээ энийг Улсын Их Хурлаар болгох гэж байгаа бол Засгийн газрын өргөн мэдүүлснээр гэдэг томъёоллыг заавал гүйцээж оруулж ирэх ёстой. Энэ дээр та бас чиглэл өгөөч ээ гэдэг хүсэлт байна.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулахаар ажлын хэсэгт буцаая.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийн 22.5.22-т заасан хөнгөлөлтийг 22.5.11, 22.5.20, 22.5.21-т заасан хөнгөлөлттэй давхардуулан эдлэхгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,7 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “Монголын үндэсний олимпын хорооны” гэснийг “Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,7 хувиарсанал дэмжигдлээ.

5.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Пүрэвжавын Ганзориг гишүүнд үг өгье.

П.Ганзориг: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1.1. Энэ дээр бол энэ тухайн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, импортыг орлох, экспортыг дэмжих энэ төсөл хөтөлбөрүүдийг орлого олж эхэлснээс нь хойш 5 жилийн хугацаанд 90 хувиар нь татвараас чөлөөлөхөөр байгаа. Энэ бол их чухал заалт. Гэтэл энэ 4 дүгээр зүйл дээрээ энэ заалтын хүчинтэй байх хугацаа 2030 оноор хязгаарлачихсан байгаад байгаа. Тэгэхээр Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл дээр энэ хугацааг анхаарч өгөөч ээ гэдэг ийм горимын санал гаргаж байна. Тэгэхгүй бол энэ хуулийн заалт энэ хугацааны хязгаарлалтаараа бас ач холбогдолгүй болчих гээд байна. Өөрөөр хэлбэл төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажил 2, 3 жил үргэлжилнэ. 3, 4 жил үргэлжилнэ. Тэгээд тухайн аж ахуйн нэгжүүд дөнгөж орлогоо олоод эхэлж байтал энэ 2030 он болоод, тэгээд энэ татварын заалтын хөнгөлөлтийг эдлэх ямар ч боломжгүй болчих ийм нөхцөл байдал үүсэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тэгвэл 5 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Гүйцээн боловсруулах чиглэл 5-ыг. Харин тийм. Тэгэхээр энэ асуудал дээр байна уу. Биш үү. Тэгвэл 5 дахь санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 60,8 хувиарсанал дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүнд үг өгье.

Б.Энхбаяр: Энэ нөгөө гаалийн албан татварын боловсрох үйлдвэр дээр Засгийн газар батлахаар орж ирснийг Улсын Их Хурал баталж бай гэдэг санал гаргаад, Төсвийн байнгын хороо дэмжсэн. Тэгэхдээ дэмжиж орж ирэхдээ дахиад нэг гүйцээн боловсруулахгүй бол одоо бидний санал хураах гэж байгаа томъёолол болохоор боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална гэхээр жишээлбэл хөдөө аж ахуйн салбарын боловсруулах үйлдвэрийг 100 хувь чөлөөлнө. Уул уурхайн салбарын, барилгын салбарын гээд энэ яг бас дахиад асуудал үүсгэх гээд байгаа юм. Яг ямар бараа бүтээгдэхүүн, ямар төсөл юм, ямар хувь хэмжээгээр юм гэдэг нөгөө тодорхой байх гэдэг асуудал маань дахиад л тодорхой болж чадахгүй болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ салбарын гэдэг асуудлыг Байнгын хороо дээр бас дахиж эргэж ярьж энэ бол дахиад их ерөнхий байна. Энийг тухайн тэр төсөл хөтөлбөрийнх нь жагсаалт баталж болно шүү дээ. Жишээлбэл яг энэ Дарханы арьс боловсруулах тэр үйлдвэрийн тэр гэж байж энэ чинь тодорхой болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг гүйцээн боловсруулах чиглэлийг хурал даргалагчаас хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн бас үг авъя.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүний хэлж байгаа дээр бас нэмээд гүйцээн боловсруулахдаа бас энэ салбарын жагсаалтыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталдаг болмоор байна. Ингэж байж бас бид нар тодорхой хэмжээний эдийн засгийн тооцоо судалгаатай юмнууд явна.

2 дугаарт яах вэ, зүгээр эдийн засгийн салбарын нөгөө кодчиллын дагуу бас энэ жагсаалтуудаа бас оруулаад ирж болох юм. Энхбаяр гишүүний хэлж байгаа тэр юун дээр. Тэгэхээр ер нь зүгээр ийм төсөв, санхүүтэй, татвартай холбоотой юмнуудаа бол Засгийн газрын өргөн мэдүүлснээр явах хэрэгтэй. Ингэхгүйгээр явах юм бол Улсын Их Хурлын гишүүд болгон чинь 1 тогтоол барьж гүйнэ шүү. Би энийг бол бүр баталгаатай хэлчихье.

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүнд үг өгье.

Г.Очирбат: Энэ Сайнзориг гишүүн та хэтэрхий энэ Засгийн газрынхан ёстой жинхэнэ өөрийн эрх ашгийн ямар нэгэн хамааралтай байна уу, үгүй юу. Энд Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэй. Тэгээд юм болохоор чи Засгийн газар луу аваачиж чихээд, тэгээд энэ чинь анхных нь өргөн мэдүүлсэн нь угаасаа л тийм байсан шүү дээ. Засгийн газрын жагсаалтаар гээд л явж байсан шүү дээ. Харин тийм. Тэгэхээр чи наад ярьж байгаа юмаа бас энд хууль тогтоох Их Хурлын гишүүд сууж байна. Жоохон бодож ярь. Бүх юм руу чи Засгий газар луу, Засгийн газар луу л гээд байх юм. Наадхаа жоохон бодож яриарай. Тэгээд энэ ажлын хэсгийнхэн чинь бас энэ чинь зарчмын зөрүүтэй саналуудаа оруулж ирээд, энэ дээрээ санал хураалт явж байна шүү дээ. Тэгээд л үг аваад л юм болгон дээр нь гишүүдийг

эсэргүүцээд байх юм. Үгүй ээ, харин тийм. Тэгээд бодож хэл л дээ. Энэ ажлын хэсгийнхэн чинь ажиллачхаад байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Энхбаяр гишүүний гаргасан саналаар гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт өглөө.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай “2 дугаар зүйл” нэмэх:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “чөлөөлөх” гэсний дараа “, хөнгөлөх” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийлүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,7 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 11 дэх хэсгийн “, сонгон шалгаруулах этгээдийг” гэснийг “болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 9 дэх заалтын “болон бусад үйл ажиллагааны” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,9 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн “10”, “12” дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцад үг өгье.

Г.Лувсанжамц: Сайн байна уу. Сая асуулт хариултын хэсэг дээр Номинчимэг гишүүн бас энэ асуудлыг хөндөж байсан. Энэ хасах гээд байгаа 10 дугаар заалт гэдэг нь төрийн өмчит компаниудын бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын талаарх мэдээлэл, нийлүүлэгч этгээд, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал болон явц. 12 нь болохоор төрийн болон орон нутгийн өмч, төрийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг эхийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн гээд биччихсэн байгаа. Энэ дээр нөгөө Засгийн газраас ингээд төрийн өмчит компанийн менежментийг сайжруулах ингээд ил тод байлгах гэсэн ийм асуудлуудыг нь ингээд хийе гээд ороод ирсэн чинь Төсвийн байнгын хороо дээр унагачихсан байгаа юм л даа. Энийг гүйцээн боловсруулах байдаг юм уу, эсвэл та бүхнийг дэмжихгүй байхыг хүсэж байна гэсэн тийм санал байна. Одоо яг юу болоод байгаа гэхээр төрийн өмчит компаниуд өөрсдөө дотроо журам, дүрэм батлаад, тэгээд хангамж аваад байгаа юм. Маш их хэмжээний. Ийм зүйлүүдийг нь ил тод болгохгүй бол ингээд хэдэн дарга нар цаана нь нуугдчихаад л ил тод болдоггүй, мөнгө аваад байдаг Энийг нь таслан зогсоох хэрэгтэй байгаа юм гэсэн тийм саналтай байна. Гүйцээж боловсруулах эсвэл дэмжихгүй байхыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,8 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Батбаярын Жаргалан гишүүн үг авъя.

Б.Жаргалан: Энэ “Засгийн газарт үнэт цаас гаргах эрх олгох тухай” тогтоолын төсөл бол анхнаасаа үнийн дүнгүй орж ирсэн. Тэгээд ажлын хэсэг дээр ийм 4 их наяд гэсэн үнийн дүн тавигдсан юм байна. Зарчмын зөрүүтэй саналууд болохлоор арай өөр дүнтэй бас ажлын хэсэг дээр яригдсан байгаа. Тэгэхээр энэ дээр бас гүйцээн боловсруулах чиглэл өгвөл яадаг юм. Яагаад гэхээр энэ үнийн дүн нь бас маш ойлгомжгүй хэвээр л яваад байна л даа. Үгүй ээ, үгүй Харин тийм л дээ. Гэхдээ хэд хэдэн тийм өөр санаа үгүй ээ, үгүй тэр чинь 2 их наяд шүү дээ. 2 их наяд байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө ажлын хэсэгт.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Нэг.Төсөл доор дурдсан агуулгатай “1 дэх” заалт нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт, хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлан хийн, аудитын дүгнэлт гаргуулж нэгдсэн журмаар шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Даваасүрэн гишүүнд үг өгье.

Ц.Даваасүрэн: Энэ дээр манай Батжаргал гишүүн энэ тэр бас гүйцээн боловсруулах чиглэл авъя гээд байгаа юм. Энэ 3 дахь улсын төсвийн хөрөнгөөр хийгдчихээд, төсөвт өртөг нэмэгдээд байгаа энэ ажлуудын юуг бол бас яаралтай шийдэхгүй бол энэ чинь үүний цаана нэлээн олон компани маш хүнд байдалд орчихсон байгаа юм билээ. Тийм учраас 2025 оны

1 дүгээр улиралд багтааж энэ аудитын дүгнэлт, магадлан хийх ажлаа цэгцлээд оруул гэдэг ийм хугацаа тавья гээд байгаа юм байна лээ. Тэгэхээр ийм чиглэл авъя.

Д.Амарбаясгалан: Ер нь ажлын хэсэг, Байнгын хороо дээрээ асуудлыг маш сайн ярьж, нэг талдаа шийдэж орж ирж байх хэрэгтэй шүү гишүүд. Тэгэхгүй бол бас гүйцээн боловсруулах чиглэлийг бас бүх асуудал дээр авах гээд байдаг байж болохгүй. Ингээд гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт өгье.

2.Төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “төрийн болон орон нутгийн өмчит” гэсний дараа “, төрийн өмчийн оролцоотой” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,9 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дэх заалтын 6 дахь дэд заалтын “төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын” гэснийг “санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,8 хувиар санал дэмжигдлээ.

4. 3 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “олон нийтэд” гэсний дараа “ нээлттэй” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 48 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төсөл доор дурдсан агуулгатай “3 дахь” заалт нэмэх:

“3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар хөнгөлөлт эдлүүлэх төслийн жагсаалттай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 35 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “3 дахь” дэд заалт нэмэх:

“3/хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг

хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх,” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Лувсанжамц гишүүнд үг өгье.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу. Энэ 2 санал гаргасан. 3, 4 хоёуланг нь та бүхнийг татгалзаж өгөхийг хүсэж байна. Тайлбараа хэлье. Ирэх жил жишээ нь 3 аймаг дээр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулна. 20 минутын хотын үзэл баримтлал батлагдаад ирэхээр Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дагасан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд шинэчлэгдэх ажлууд явагдаж эхлэх юм байгаа юм. Тэгээд тэрэндээ бэлдээд иргэдийнхээ дуу хоолойг сонсдог болъё. Оршин суугчдынхаа дуу хоолойг сонсоод, аж ахуйн нэгжийг гэсэн тухайн газартаа яаж амьдармаар байгаа юм. Юу төлөвлөмөөр байгаа юм бэ гэснийг нь дуу хоолойг нь сонсож байгаад, хот байгуулалтын баримт бичгээ боловсруулдаг болъё гэсэн зүйл байгаа. Одоо нөгөө яам дээр 3 багц хуулиуд явж байгаа. Тэр дотор нь тэр зүйлүүдийг оруулж өгөөч гэсэн тийм зорилготой санал нь 3 дугаар санал юм байгаа юм.

4 дүгээр санал болохоор одоо бид нар 14 мега төсөл ингээд хэрэгжүүлээд явна. Тэгэхэд бид нарын боловсон хүчин ажиллах гээд эхлэхлээр норм нормативууд нь ерөөсөө яаралтай шинэчлэгдэхгүй бол болохгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ бол ерөөсөө төсөв нэмэх заалт биш. Одоо байгаа барилга байгууламжийн норм нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой ажил учраас одоо Эрдэнэбүрэнгийн УЦС ч байдаг юм уу, тийм том төслүүд дээрээ зориулаад бид нар норм норматив нь бэлэн байгаад, тэрнийгээ ашиглаж явдаг боломжийг нь бүрдүүлэх ажлыг ирэх жилдээ багтаагаад хийлгэх зорилготой тийм чиглэлийн заалт оруулсан юм. Тэгээд татгалзаж өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. 6.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “4 дэх” дэд заалт нэмэх:

“4/инновац шингэж шинээр бүртгэгдсэн, олон улсад туршигдсан бараа, материал, барилгын ажил гүйцэтгэх арга барил, тэргүүн туршлагыг барилгын салбарт хурдацтай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, нормативын баримт бичиг, дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга, байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Санал хураалт. Дүн танилцуулахаас өмнө үү. 7,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Сангийн сайд Болдын Жавхлан үг өгье.

Б.Жавхлан: За баярлалаа дарга аа. Үүний өмнөхийн өмнөх заалт дээр нэг ийм юм би тайлбарлах байсан, анзааралгүй өнгөрчихжээ. Уучлаарай гишүүд ээ. Тэр одоо ингээд Засгийн газар Улсын Их Хуралд нөгөө жагсаалт төсөл нөгөө салбаруудаар өргөн барина. Тэр хугацаа 12 сарын 1 гэхээр энэ яагаад ч амжихгүй байхгүй юу. Хуулийн боломж байхгүй. Бид нар хууль өргөн барих тухай хуулиао хуулиар өргөн барина. Тэгээд энэ чинь дор хаяж бид нар 60 хоног бид нар энэ веб сайт дээрээ мэдээллээ тавьж байж, хэлэлцүүлэг хийж байж,

Д.Амарбаясгалан: Одоо тэгээд наадах чинь дараачийн хэлэлцүүлэг дээр 2/3-оор босгохоос өөр арга алга шүү дээ. Санал хураагдсан.

Б.Жавхлан: 11 сарын 15-нд хууль бол өргөн баригдаад, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээсээр байтал 12 сарын 1 болчихно. Тэгээд бид нар тэрийг чинь хууль зөрчиж өргөн барьж чадахгүй шүү дээ. Хэлэлцүүлэг хийж байж, олон нийтэд мэдээлэл өгч байж яг тэр нөгөө хуулийнхаа дагуу бид нар зарчмаар орж ирэхгүй бол яагаад ч амжихгүй. Тэр хугацаа 12 сарын 1 гэдэг.

Д.Амарбаясгалан: Байнгын хороо дээр ажлын хэсэг дээрээ энэ асуудлыг ярья.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

17.11 цаг.

Дараагийн асуудалд орё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн танилцуулна. Индэрт урья.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 4, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 207 дугаар захирамжаар 2025 оны төсвийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан бөгөөд уг ажлын хэсгээс төсвийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд дэд ажлын хэсгүүдийг байгуулан саналуудыг нэгтгэн хэлэлцлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн хэлэлцүүлгийн 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбогдуулан Улсын Их Хурлын бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслийг хэлэлцээд зарчмын зөрүүтэй санал бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж, Төсвийн болон бусад Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн

хэлэлцсэн бөгөөд төсвийн ажлын хэсэг болон Төсвийн байнгын хорооноос Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд доорх зохицуулалт хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зардлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц дотор зардлын зохицуулалт, зориулалт өөрчлөх;

2.Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх;

3.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадлыг өөрчлөх саналуудыг гаргасан болно.

Мөн төсвийн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаар чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тусгасан 1 дүгээр хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн нэр өөрчлөх зэрэг асуудал хэлэлцэгдсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хороо төсвийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг, бусад Байнгын хороо, түүнчлэн Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан санал нэг бүрийг хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2 дахь хэл хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр стандарт бус шийдвэр гарган байгуулагдсан 3 намын хамтарсан хамгийн том бүтэцтэй, хамгийн олон яам нэгжтэй, хамгийн олон төрийн албан хаагч, төсөвтэй том хамтрал, төлөөлөл бүхий Засгийн газрын өргөн барьж буй анхны төсвийн төслийг та бид хэлэлцэж байна.

Хамтарсан Засгийн газрын тэргүүлэх зорилт нь түүхий эдийн үнэ, тоо хэмжээний өсөлтөөс үүдэлтэй боломжийг зөв зохистой удирдаж, тогтвортой байдлыг хангах замаар Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилгод нийцэх шинэчлэл, бүтээн байгуулалтыг хийх явдал билээ. Энэ утгаараа хөгжлийн мега төслүүдийг дэвшүүлж, тэдгээрт чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлье гэсэн төсвийн үзэл баримтлалыг зарчмын хувьд бас дэмжинэ.

Гэхдээ энэхүү төсвийн төсөлд анхаарах ёстой асуудлууд маш олон байгааг дурдъя. Төсвийн орлого төлөвлөлтийн тогтворгүй байдал, зарлагын хэт тэлэлт, эдийн засаг дахь төрийн өндөр оролцоо, үндэсний хуримтлалгүй мөчлөг дагасан зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслийн тодорхой бус шалгуур гэх зэрэг олон асуудлыг харгалзан үзэж,

төсвийн төсөлдийг төслийг бүхэлд нь сайжруулан чанаржуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд.

1 дүгээрт нь. Монгол Улсын 2025 оны ний нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийг өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 6,2 их наяд төгрөг буюу 20 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн нь эдийн засгийн өсөлтийн хүлээлт, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурах хандлага богино хугацаанд эрс өөрчлөлт гарах боломжгүй зэрэг тээвэр боомтын хүчин чадал зэрэг хүчин зүйлтэй уялдуулан авч үзэхэд ихээхэн өөдрөг тасалдах эрсдэлтэй төсвийн төлөвлөгөө болжээ.

Мөн төсвийн орлого дахь татварын орлогын хувь хэмжээ улам бүр нэмэгдэн 94 хувьд хүрэхээр байгаа нь нэг талаас татварын ачаалал, дарамт болон уул уурхайн цөөн бүтээгдэхүүнээс хамаарах байдал улам нэмэгдэж буйг, нөгөө талаас төрийн асар өндөр хөрөнгө тэр дундаа төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны ашигт байдал хангалтгүй байгааг бас харуулж байна.

Яг өнөөдрийн байдлаар авч үзэхэд манай экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд хэмжээндээ байгаа боловч үнэ унаснаас улбаалан төлбөрийн тэнцэл алдагдалтай, төгрөгийн ханш суларсан, валютын нөөц багассан гэх зэрэг бараа мэдээ бас олонтой байна. Ийм учраас бид хэтэрхий өөдрөгөөр төсөөлж ирэх оны орлогын төсөөлөл, түүнтэй уялдуулан тооцсон зарлагын хэт өсөлтөө эргэж харах шаардлага байгааг та бүхэнд бас хэлье.

2 дугаарт нь. Ирэх оны төсвийн нийт зарлага 35,8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 38 хувьд хүрэхээр төлөвлөсний 70 гаруй хувь нь урсгал зардал, тэр дундаа талаас илүү нь нийгмийн хамгаалал, тэтгэвэр тэтгэмж, төрийн албаны цалин хөлс байна. Ингэснээр дундаж орлоготой ижил төстэй орнуудтай харьцуулахад манай улсын эдийн засаг дахь төрийн оролцоо хэт өндөр, халамжийн зардал ихтэй улс болж хувираад байна.

Нөгөөтээгүүр төсвийн тэлэх бодлого нь Монгол Улсын гадаад болон дотоод тэнцвэргүй байдлыг улам нэмэгдүүлж байгааг олон улсын байгууллагуудын судалгаа нотолж байна. Инфляц 2024 оны сүүлийн хагаст үргэлжлэн өсөж 2026 он хүртэл зорилтот түвшнээс өндөр байхаар байна. Үүний гол шалтгаан нь их хэмжээний төсвийн зарлага, мөн ирэх онд эрчим хүчний тарифын өөрчлөлт хийгдвэл үнийн өсөлт улам бүр нэмэгдэж гадаад валютын ханш өсөх эрсдэл өндөр байгааг судлаачид, олон улсын байгууллагын судлаачид бас анхааруулжээ.

Монгол Улсын гадаад сектороос хамаарах эмзэг байдал их, импортын хамаарал өндөр. Дотоодын санхүүжилт татах хүчин чадал хязгаарлагдмал, хөрөнгө оруулалтын мега төслийн менежментийн тогтолцоо сул зэрэг шалтгааны улмаас сайхан сэтгэлээр эхлүүлсэн том төслүүд сайнаасаа илүү муу үр дүнд хүргэж, улсын өрийг нэмдэг алдааг манай улс хангалттай үзэж туулж байгаа билээ. Ийм нөхцөлд төсвөөс хэрэгжүүлэх аливаа хөрөнгө оруулалт нь хөгжлийн бодлогод нийцсэн эдийн засгийн үр ашгийг тооцсон эрэмбэ дараалал нь нэн чухал байх ёстой. Гэтэл 2025 оны төсөвт тусгасан зарим томоохон төсөлд эдгээр шалгуурыг баримтлагүй, нэн тэргүүнд чухал эсэх нь эргэлзээтэй, заавал төсвөөс хийх шаардлагатай, шаардлагагүй ажил байгааг хөндлөнгийн хараат бус байгууллагууд онцолж байгааг Ардчилсан намын бүлгээс Засгийн газарт дахин бас сануулан хэлье.

2025 оны төсвийн нийт тэнцэл 1,9 их наяд төгрөг буюу ихээхэн хэмжээнд өсөлттэйгөөр тооцсон ДНБ-ий 2 хувьтай тэнцэхүйц алдагдалтай байхаар төлөвлөсөн нь төсвийг алдагдалгүйгээр баталдаг байх суурь зарчимд бас нийцэхгүй байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг нөхөх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан АМНАТ-ийг орлогын 65 хүртэл хувийг Ирээдүйн хувь санд хуримтлуулах ёстойг 2025 онд 40 хувь болгон бууруулах санал оруулж ирсэн нь ирээдүйгээсээ хулгайлан өнөөдөр зарцуулах гэсэн тун хариуцлагагүй сэдэл болжээ гэж Ардчилсан намын бүлгийн зүгээс бас дүгнэж байна.

Ирэх онд дотоод эдийн засгийн идэвхжил буурах мөчлөгт дахин орж, төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдал бий болгох буюу төсөв урсгал тэнцлийн хос алдагдал бий болж, эдийн засгийн дархлаа унаж болзошгүй байна гэж Улсын Их Хурлын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэснийг бас онцгойлон анхаарах шаардлагатай.

Дээрх дүгнэлтүүдэд үндэслэн 2025 оны төсвийн эцсийн хэлэлцүүлэгт зориулж Улсын Их Хурал дахь Арпчилсан намын бүлгээс дараах саналуудыг бас дэвшүүлж байна.

1 дүгээрт нь, төсвийн орлого, зарлагын дүнг өргөн барьснаас бууруулж, эрсдэл багатай, бодитой хэмжээнд төлөвлөх, улмаар эдийн засагт хэт халалт үүсэх нь үнийн өсөлтийг өдөөхгүй, төрийн оролцоог нэмэхгүй байх зохистой түвшинд хүргэх;

Нэн ялангуяа урсгал зардлын реформ хийж цомхон чадварлаг төрийг бий болгох, ард түмэнд амласан мөрийн хөтөлбөр хамтарсан Засгийн газрын гэрээний заалтаа анхааран биелүүлэх;

2 дугаарт нь хөрөнгө оруулалтын мега төслүүдийг ач холбогдлоор нь зөв эрэмбэлж, зохих тооцоо судалгааг хийсний дараа төсвийн дунд хугацааны зорилттой нийцүүлэн үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх, төслийн менежментийн олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүжилтийн шинэлэг аргуудыг ашиглах. Эдгээр зорилтыг хангахын тулд Төсвийн хөрөнгө оруулалтын тухай Төсвийн тогтвортой байдлын зөвлөж байгаа Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан гаргаж, хариуцлага хяналтыг сайжруулах;

Орлого, зарлагыг оновчтой болгосноор Монгол Улсын төсвийн 2025 оны төсвийг алдагдалгүйгээр батлах, тэнцвэржүүлсэн төслийн тэнцвэржүүлсэн алдагдлыг нөхөх зорилгоор Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлогоос татан авах зорилго бүхий Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг бас буцаах нь зүйтэй.

Өнөөдөр үүсээд буй олон асуудлын учир шалтгаан нь уг гарвал нь том төр, тэлсэн төсөв болсныг та бид хангалттай бас харж байна. Төсөв тэлэхийн хэрээр авлига, хулгай цэцэглэж, ажил гацаж, ардын нуруун дээр дарамт ирдэг болсон. Саяхан болж өнгөрсөн нүүрсний асуудал, Ногоон автобусны будилаан зэрэг асуудлууд, хэргүүд давтагдах эрсдэл шимт хөрс нь өнөө ч бас хэвээрээ л байна. Ийм учраас урьдын алдааг давтах эрсдэл буйг асуудал бүхний шийдэл нь том төсөв байгаагүйг Ардчилсан намын зүгээс ахин бас анхааруулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь энэ хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлтсийн дарга Даваасүрэнгийн Эрдэнэсамбуу танилцуулна. Ажлын хэсгийн 1 дүгээр индэрт урьж байна.

Д.Эрдэнэсамбуу: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, олонхын дэмжлэг авсан саналуудад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.13 дахь заалтын дагуу тус хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг хүргүүлж байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн үеэр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх 1 санал, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багц доторх зардлын зориулалтыг өөрчлөх 1 санал, урсгал зардал нэмэгдүүлэх 1 санал, мөн хөрөнгө оруулалтын зардал нэмэгдүүлэх болон бууруулах саналууд тус тус гарсан.

Урсгал зардлын хувьд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн гэсэн 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүжилт болох 16 тэрбум 492 сая 500 төгрөгийг Боловсролын сайдын төсвийн багцаас Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад хийж шилжүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд тусгасан 49 тэрбум 831,9 сая төгрөгийн зээлийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас болгон зориулалтыг өөрчилж байгаатай холбогдуулан урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх.

Орон нутагт, хөдөөгийн багуудын хөгжил, залууст чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцыг 2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт 51 тэрбм 831 сая 900 мянган төгрөгөөр урсгал зардал өссөн байна.

Хөрөнгийн зардлын хувьд хөрөнгө оруулалтын 5 төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 17 тэрбм 820,3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, мөн 2025 онд 4 тэрбум 850,50 сая төгрөгийн санхүүжих дүнтэй хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээг шинээр нэмснээр 2025 онд санхүүжих дүн 22 тэрбум 670,3 сая төгрөгөөр нэмэгдэж, харин 2025 онд 1 тэрбум 380 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг хасаж, үргэлжлүүлэн хэрэгжиж байгаа 5 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 23 тэрбум 290,3 сая төгрөгөөр бууруулснаар хөрөнгийн зардал 2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас олгон зарцуулалтыг өөрчилж байгаатай холбогдуулан эргэн төлөгдөх цэвэр зээлийн дүн 49 тэрбум 831,9 сая төгрөгөөр буурсан. Урсгал зардлыг 51 тэрбм 831,9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, хөрөнгийн зардлыг 2 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдөх цэвэр зээлийг 49 тэрбум 831,9 сая төгрөгөөр тус тус бууруулах зохицуулалтын саналууд гарснаар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д заасан зарчимд нийцэж, төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг нэмэгдүүлэхгүй байх нөхцөлийг хангасан.

Хөрөнгөөр хураалтын төсөл арга хэмжээний нийт саналыг гаргахдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1-29.3.5-д заасан зарчимд нийцүүлж, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасан шалгуурыг хангасан байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед олонхын дэмжлэг авсан саналууд нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагын болон алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг авъя. Ажлын хэсгийн гишүүд. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд зарчмын зөрүүтэй санал хураалтад шууд орно. Танхимд байхгүй байгаа гишүүдэд мэдээлэл хүргэхийг хүсэж байна. Ажлын хэсгийн нэрсийг танилцуулсны дараа санал хураалт шууд эхлэхээр байгаа шүү. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж. Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Баатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батнямын Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Төсвийн байнгын хорооноос нэгтгэн гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж эхэлнэ. Нийт 52 санал байгаа. Гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. Асуулт байхгүй. Санал гаргасан гишүүн гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэх дэгтэй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

1.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийх санал:

1.Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд урсгал зардал шилжүүлэх санал.

1.1.Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Мал, аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн гэсэн 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүжилт болох 16,492.5 сая төгрөгийг Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн, Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Жангабель, Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Найдлаа, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэболд /цаашид “ажлын хэсэг” гэх/. Санал хураалт явагдах учиртай. Эхлээд ирцийн санал хураалт явуулъя. Ирцийн санал хураалт. 102 гишүүн ирцэд бүртгэлтэйгээс 57 гишүүн санал хураалтад орсон байна. Санал хураалт. 1.1. Санал хураалт. 46,1 хувиар санал уналаа.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ зохицуулалт хийх санал.

2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийх санал. Санал хураалтдаа хариуцлагатай орно шүү. Номинчимэг гишүүн горимын санал.

О.Номинчимэг: Сая санал хураалт дээр төхөөрөмжийн нөгөө юу мэдэрдэг хэсэг нь жоохон бохир болчихсон цэвэрлэх гээд тэгээд улаан юм гараад, тэгээд саналаа өгч чадсангүй. Тэгэхээр санал хураалтыг дахин явуулж өгнө үү гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Яг танхимд байгаа гишүүдээс яг хэдэн хүн саналаа өгч чадаагүй юм. Гараа өргө дөө. Ариунзаяа, Мандхай, Мөнхсайхан, Энхтүвшин, Номинчимэг, Саранчулуун, Наранбаяр, Цэнгүүн гээд 10-аад гишүүд санал өгч чадаагүй юм уу. Энэ горимын саналаар 1 удаа санал хураалт явуулна. Ер нь 1 асуудлаар нэг л удаа горимын санал гаргах дэгийн зохицуулалт бас байгаа. Тэгээд удаа дараа бас ингэж горимын саналаар дахин санал хураалт явуулахгүй гэдгийг бас албан ёсоор хэлье. Ингээд Номинчимэг гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Энэ санал хураалт цуцлагдлаа. Хонх дуугараагүй. Байж бай.10 секунд. Төхөөрөмж бас. Номинчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя. 51 хувиар санал дэмжигдлээ. 1.1 дэх санал хураалтыг дахиж явуулъя. Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн гэсэн 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүжилт болох 16,492.5 сая төгрөгийг Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зохицуулалт хийх санал.

2.1.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.29.Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 70,105.1 сая төгрөг, санхүүжих дүн 20,802.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая

төгрөгөөр бууруулж, ХХП.1.6.Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн барилга, 80 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 14,587.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,118.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,9 хувиар санал дэмжигдлээ.

2.2.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.42.Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх хатуу хучилттай авто зам /Ховд, Булган, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 22,607.2 сая төгрөг, санхүүжих дүн 13,030.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах, XVIII.1.18.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 600.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг болон XIV.1.1.77.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 1,560.0 сая төгрөг, санхүүжих дүн 780.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, нийт 12,880.0 сая төгрөгийн эх үүсвэрээр XVIII.1.12.Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ, бохир усны гол магистрал шугам 2 дугаар ээлж /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Тахилт, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,293.2 сая төгрөг, санхүүжих дүн 4,090.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,417.0 сая төгрөгөөр, Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, залууст чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Ховд аймагт хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зориулж Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцыг 2,000.0 сая төгрөгөөр, XIX.1.9."Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,463.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 50 хувиар дэмжигдсэнгүй.

Та хэдэд маань наргиан, ард иргэдэд энэ бол хариуцлагагүй байгаа байдал шүү дээ. Монгол Улсын Шадар сайд Амарсайхан горимын санал.

С.Амарсайхан: Дэмжиж санал өгсөн. Сая энэ систем дээр гацаад орсонгүй Их Хурлын дарга аа, Тийм учраас горимын санал гаргаж саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураах санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Шадар сайд Амарсайханы гаргасан саналаар санал хураалтыг хүчингүй болгох горимын санал хураалт. 52 хувиар горимын санал дэмжигдлээ. 2.2 дахь санал хураалтыг дахиж явуулна. Санал хураалт. 52 хувиар санал дэмжигдлээ.

2.3.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.24.Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, XIX.1.9."Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 46,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын XV.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 20,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,850.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хараагүй

хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн тоног төхөөрөмж, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв”-ийн үйлдвэрийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,350.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга. Санал хураалт. 62,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц доторх зохицуулалт хийх санал.

3.1.Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд тусгагдсан 49.8 тэрбум төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас болгон зориулалтыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал гаргасан ажлын хэсэг, санал гаргасан гишүүн л үг авах эрхтэй. Дэгээрээ. Санал хураалт. Санал хураалт явчихлаа шүү дээ. Даваасүрэн гишүүнд үг өгье.

Ц.Даваасүрэн: Бид нар ажлын хэсэг дээр 49,8 тэрбум төгрөг гээд хураасан юм. Тэгэхээр Бадамсүрэн гишүүн бол нөгөө санал гаргасан 49.831.9 сая төгрөг гэж болгож өгөөч гэж байгаа юм байна.

Д.Амарбаясгалан: Санал хураалт 33,3 хувиар дэмжигдсэнгүй.

2.Төсөл хөтөлбөрийн нэр өөрчлөх санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 17.3.5.1.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох гэсэн төсөл, хөтөлбөрийн нэрийг “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 45,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/ гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,8 хувиар санал дэмжигдлээ.

3.Бусад байнгын хорооны санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрийн 27.1.1 дэх арга хэмжээг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.1.Зэвсэгт хүчнийг “Нисгэгчгүй нисэх хэрэгсэл”, “Дрон”, “Хиймэл оюун ухаан”-д суурилсан дэвшилтэт техник, хэрэгслээр хангах, Шалгуур үзүүлэлтийн дугаар-27.1.1.1, Шалгуур үзүүлэлт-техник хэрэгслийн хангалт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-8.5, Зорилтот түвшин-20” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт. 65,7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.4 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, Шалгуур үзүүлэлтийн дугаар-27.1.4.1, Шалгуур үзүүлэлт-арга хэмжээний хэрэгжилт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-10, Зорилтот түвшин-15” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт. 64,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.36.Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 9,618.3 сая төгрөг, санхүүжих дүн 4,555.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,219.3 сая төгрөгөөр бууруулж, Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, төсөвт өртөг 14,926.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,219.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжсэн санал. Санал хураалт 47,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Батбаярын Жаргалан гишүүн горимын санал.

Б.Жаргалан: Сая цахим төхөөрөмж гацлаа. Цахим төхөөрөмж гацсан тул дахиж санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Мэргэжлийн Байнгын хорооны дэмжсэн санал дээр гишүүд анхааралтай хандъя. Батбаярын Жаргалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. 54,9 хувиар санал дэмжигдлээ. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжсэн 3 дахь саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. 55,9 хувиар санал дэмжигдлээ.

4.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:

1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацаа, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,7 хувиар санал дэмжигдлээ.

5.Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.2.7 дахь дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь” гэж, 8.1.3 дахь заалтын “хэрэгжилтэд” гэсний дараа “хяналт” гэж, 9.1.1.3 дахь дэд заалтын “дүгнэлт” гэсний дараа “өгөх ” гэж, 10.1.2.1 дэх дэд заалтын “Төсвийн” гэсний өмнө “Улсын Их Хурлын” гэж, 13.1.10 дахь заалтын “гомдол” гэсний өмнө “зөрчлийн талаарх” гэж тус тус нэмэх.

2.Төсвийн 1 дүгээр хавсралтын 1.1.2 дахь заалтын “бэхжүүлж” гэснийг “хангаж” гэж, 1.2.1 дэх заалтын “Монгол Улсын төр засгийн удирдлага ба төв байгууллагууд” гэснийг “Төрийн байгууллага” гэж, 4.1.1 дэх заалтын “шударга, шуурхай шүүхээр” гэснийг “шударга шүүхээр шуурхай” гэж, 17.1.1 дэх заалтын “аж ахуйн нэгжүүдийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 25.1.1 дэх заалтын “эд зүйлийн илрүүлэлтийг 50” гэснийг “эд

зүйлийн илрүүлэлтийг 85.5” гэж, “хэргийн илрүүлэлтийг 50” гэснийг “хэргийн илрүүлэлтийг 58” гэж, “арга хэмжээг 90” гэснийг “арга хэмжээг 92” гэж, 25.2.1 дэх заалтын “70” гэснийг “72” гэж, “85” гэснийг “86.1” гэж, 25.4.1.4 дэх дэд заалтын “чиглэлээр” гэснийг “ажиллагааны бодит биелэлт” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1 дэх заалтын “өргөн”, “гадаад ертөнц”, “дотоодын” гэснийг, 1.2.1.1 дэх дэд заалтын “Дотоодын” гэснийг, 2.1.1.1 дэх дэд заалтын “Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж,” гэснийг, 13.1.1.6 дахь дэд заалтыг, 13.1.6 дахь заалтын “өөрт нь” гэснийг, 17.2.3.2 дахь дэд заалтыг бүхэлд нь, 21.1.1 дэх заалтын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62,7 хувиар санал дэмжигдлээ.

Энэ санал хураалтыг явуулахаас өмнө 18 цаг болж байна. 18 цаг болж байгаа учраас санал хураалтаа өнөөдөртөө явуулаад дуусгах уу, маргааш үргэлжлүүлэх үү. Байж бай, санал хураалтаар шийднэ. Байж байгаарай, байж байгаарай. Гишүүдийн байр суурь зөрүүтэй байгаа учраас. Алив Пүрэвдорж гишүүн ээ, байж бай даа. Хөөе Пүүжээ гишүүн. Татгалзаж байгаа гишүүн байвал гараа өргө дөө. Өнөөдөр үргэлжлүүлэхийг татгалзаж байгаа гишүүн байвал гараа өргөе. 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 гишүүн 12, 13, 14 гишүүн 15 гишүүн татгалзаж байна. Танхимд нийтдээ 65 гишүүн байгаа. 14 гишүүн татгалзаж байгаа учраас санал хураалтыг үргэлжлүүлээ.

6.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт буюу Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого 279,336.5 сая төгрөг гэснийг 295,822.0 сая төгрөг гэж өөрчлөх. Гишүүд санал хураалтдаа анхааралтай оролцоод, мэргэжлийн Байнгын хорооныхоо дэмжсэн санал дээр санал өгөхдөө бас анхаарал бодолтой хандахгүй бол гишүүдийн хооронд гомдол, үл ойлголцол гарч байна шүү. Энэ чинь бас өчнөөн ажил болж байж санал гаргасан, Байнгын хороо нь дэмжчихсэн саналууд гэдгийг бас бүх талдаа бодох хэрэгтэй. Түрүүний тэр Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дараачийн Байнгын хороо 3 дугаар хэлэлцүүлэг дээр 2/3-оор босгох шаардлагатай гэж үзвэл гишүүд дэмжих ёстой. Бас энэ зарчмын байр суурь дээрээ хатуу зогсоцгоож байх хэрэгтэй. Өчигдөр 23 цаг хүртэл бас хуралдсан байгаа. Одоо болно.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт буюу Сангийн сайдын энэ нөгөө 6-гийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар 1 дэх санал хураалт би уншиж танилцуулсан байгаа. Санал гаргасан ажлын хэсэг санал. 59,8 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулж эхэлнэ.

1.Эхлээд уншиж танилцуулна. Дэгээрээ явъя гишүүд.

1.Төслийн 2 дугаар хавсралтад Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүхийн байрууд /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 61,600.0 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 10,383.7 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг тус тус нэмэх. Нийт 71,983.7 сая төгрөгийн эх

үүсвэрийг доор дурдсан төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулах замаар гаргах:
Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын IV.1.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/” төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын X.2.1.2.Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах /Бүсүүдэд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 11,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын X.1.3.2.Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 12,983.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

-Төслийн 2 дугаар хавсралтын X.3.3.1.Татварын байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 8,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарт үг өгье.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Их Хурлын даргаас Дэгийн тухай хуулийн 74.14 дүгээр заалтын дагуу энэ гүйцээн боловсруулах чиглэл авахыг хүсэж байна. Энэ дээр тэгээд санал хураалгаж өгөөч ээ гээд. Асуудал нь юу байгаа гэхээр бид нар бол яг цэвэр хуулийн дагуу, хуулийг биелүүлж ажиллахыг л манай Байнгын хорооноос бол хүсэж байгаа юм. Тэгээд энэ дээр ямар асуудал гараад ирж байна гэхээр эх үүсвэрийг нь илүү тодорхой болгож, зураг төсөв дээр нь бас эргэж харах юмнууд яг ажлын явцад бол гарч байна. Тийм учраас энэ дээр нь бид нар бас энийг ойлголцоод энийг ингээд гүйцээн боловсруулах шаардлага байна гэж үзэж байгаа. Энэ завсраа нэг зүйлийг хэлмээр байна. Хууль ер нь хяналтын байгууллагууд, ялангуяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, прокурор, АТГ, цагдаа гэсэн энэ байгууллагууд чинь ажил нь өдөр болгон явж байдаг, хүний эрхтэй өдөр болгон тулж байдаг ийм байгууллагууд учраас эдний ер нь ажилтай Хүний эрхийн дэд хороо явж танилцаж байгаа. Би Сангийн яамны бас мэргэжилтнүүдийг яг газар дээрээ очиж үүнтэй бас танилцаарай гэж хэлмээр байгаа юм. Эдний төсвийг ер нь бол харж үзэж байхгүй бол цаана нь хүний эрхийн асуудал чинь жинхэнэ яригдаж байгаа газар шүү л гэдгийг би энд бас цохож хэлмээр байна. Тэгээд тэр төсөв дээр нь тийм учраас ойлгож хандаж байгаарай л гэж хүсмээр байгаа юм. Баярлалаа. Санал хураалгаж өгөөч.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ дээр нэг байна уу. Энэ нэг ийм байгаа юм. Үнэхээр бид нар бас нэг их нэг ядуу айл жоохон мөнгө олчихоод цагаан сар хийх гээд бараг гэрээ зараад, хүрээний нэг гуйлгачин тэгдэг шиг л ийм л төсөв баталж байгаа юм л даа. Энэ жил. Энэ 2025 онд байдал их хүндэрнэ. Тэр бол ойлгомжтой. Алдагдалтай төсөв. Сайн сайхан бол дараа нь ярина. Тэгээд энэ дээр хамгийн хуулийн дагуу манай Цогтбаатар дарга хэллээ. Хамгийн хуулийн дагуу байх ёстой юмыг энэ Төсвийн байнгын хороо дэмжээгүй байна л даа. Ялангуяа шүүхийн төсөв дээр бол ингэж орж болохгүй шүү дээ. Хуулийн зүйл заалттай. Хасах ч эрх байхгүй. Тэгээд Монгол Улс шүүх байгуулаад 120 жил болж байх хугацаандаа 1 ч удаа байрыг нь барьж өгөөгүй юм билээ. Тэгээд энэ жил 4, 5 байр барих гэж байгаа юм байна лээ. Тэр мөнгө нь 70 тэрбум орчим байгаа. Жавхлан сайд энэ дээр анхаараарай. Эх

үүсвэрийг нь тусгаарай. Тэгээд бид нар чинь шүүхээр дандаа хойгуур байр эзлээд байгаа шүү дээ. Энэ шүүх засаглал гэдгийг засаглал гэдэг хэмжээнд нь бага ч гэсэн дөхүүлье.

Тэгээд энэ юмыг бол одоо яг тэр хүрээндээ хэлэлцээд, хууль номынх нь дагуу эх үүсвэрийг нь дагаад, энэ төсөвтөө оруулж өгөхгүй бол Монгол Улс чинь бүр балрах нь. Энэ дээр ингэж анхаарч өгөөч гэж хэлье дарга аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн тайлбар хийе.

Ц.Даваасүрэн: Энэ Цогтбаатар гишүүний хэлээд байгаа дэгийн хуулийн 71.14 бол байна шүү дээ. Ийм заалт шүү. Та нар бас анхаарчихсан нь дээр байх. 2 дугаар хэлэлцүүлэгт энэ асуудлыг буцаая гэж байгаа юм. Тэгэхээр манай Байнгын хорооны 2 дугаар хэлэлцүүлэг үргэлжилнэ. Дахиад Улсын Их Хурлын чуулганы 2 дугаар хэлэлцүүлэг зөвхөн энэ асуудлаар явна шүү.

Д.Амарбаясгалан: Баасандорж дарга тайлбар хийх үү. Даваасүрэн гишүүний саяын хэлсэн асуудлаар.

Б.Баасандорж: Сая гишүүдийн ярьсан асуудалтай холбоотойгоор Дэгийн хууль дээр бас зохицуулалт байгаа. Зохицуулж өгсөн байгаа яг энэ асуудлыг. Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.14 дээр нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно гэсэн үг. Тэгэхээр хэрвээ гишүүд маань тодорхой асуудлаар санал хураагаад, яг энэ асуудлаар Төсвийн байнгын хороо дахин хэлэлцүүлэг хийе гэх асуудал энэ Дэгийн хуулиар нээлттэй гэсэн үг. 71.14-өөр тодорхой асуудлаар.

Д.Амарбаясгалан: Ийм байгаа гишүүд ээ, Дэгийн тухай хуулийн 71.4 анхааралтай сонсоорой.

Нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч, буцааж болно гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр өөр асуудлаар бол Улсын Их Хурлын дарга хурал даргалагч гүйцээн боловсруулах чиглэлийг өгчих боломж байгаа. Төсвийн хэлэлцүүлэг дээр хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонх нь буцаах нь зөв гэж үзсэн тохиолдолд энэ буцаагдана. Тэгэхээр өөр санал хураалт явагдах гэж байна шүү дээ.

Нөгөө талдаа сая Хууль зүйн байнгын хорооны дарга санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, манай Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат гишүүн нарын гаргасан саналтай 100 хувь санал нэг байгаа. Улсын Их Хурал баталсан хуулиа хэрэгжүүлж байх үүргийг хүлээх ёстой. Шүүхийн тухай хууль батлагдчихсан. Шүүхийн төсөв мөнгөтэй холбоотой асуудал нь Хууль зүйн байнгын хорооны эрх хэмжээний асуудал байгаа. Энэ асуудал яагаад өнөөдөр ингэж орж ирэв ээ гэхээр Хууль зүйн байнгын хороо дээр шийдвэр гаргахдаа эх үүсвэрийгээ цуцлах асуудлыг, эх үүсвэрийг бүрэн тооцож бас Эдийн засгийн, Төсвийн байнгын хороотойгоо бүрэн асуудлаа эцэслэн тохиролцож чадаагүйгээс энэ асуудал үүссэн байгаа юм. Тэгэхээр 1 дүгээрт Улсын Их Хурлаас энийг буцааж, гүйцээн боловсруулах чиглэлийг гишүүдийн олонхын саналаар өгөх нь байна.

2 дугаарт эх үүсвэртэй холбоотой асуудал дээрээ бас хөндөх ёстой. Яагаад гэвэл Хууль зүйн байнгын хорооноос орж ирсэн санал нь Эдийн засаг, хөгжлийн яам дээр байгаа ирэх онд хийгдэх зураг төсвийн мөнгийг хасах саналаар орж ирчихсэн байгаа учраас энэ бас эрсдэл дагуулж байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тохиолдолд эх үүсвэртэй холбоотой асуудал давхар хөндөгдөнө гэдгийг бас энд протоколд тэмдэглэж хэлүүлье.

Хууль зүйн байнгын хороо хуралдана. Төсвийн байнгын хороо хуралдана. Тийм тэгээд тэр зардлынхаа эх үүсвэрийг дахиж ярилцъя л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр Дэгийн тухай хуулийн 71.14 дэх заалтаар уг асуудлыг Байнгын хороонд чиглэл өгч буцаая гэснийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулья. 66,7 хувиар Дэгийн тухай хуулийн 71.14 дэх заалт дэмжигдлээ. Тэгэхээр уг асуудал Байнгын хороодод буцаагдлаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр дахин боловсруулж орж ирэх нь ээ. Эх үүсвэртэй холбоотой асуудал дээр Засгийн газар бас энэ дээр анхаарах хэрэгтэй. Ер нь Засгийн газрын зүгээс дараа дараа жилийн улсын төсөв дээр гүйцэтгэх засаглалтай холбоотой төсвийг мэдээж хэрэг улсын төсвийнхөө нөхцөл боломж, бүх зүйлийг харгалзан үзэж хуулийн хэрэгжилтийг хангаж орж ирж байх шаардлагатай гэдгийг бас энэ ташрамд хэлье. Буцаагдлаа.

2.Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.1.1.Улсын дээд шүүхийн цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,493.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,917.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр XXIV.3.1.Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,942.0 сая төгрөг гэсэн төсөл арга, хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар. Санал хураалт. 19,6 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд тусгагдсан Нийгмийн халамжийн сангийн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилт болох 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс зориулалтаар нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт . Төсвийн байнгын хорооны дэмжээгүй, Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна. Санал хураалт. 37,3 хувиарссанал дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн үг өгье.

Ц.Даваасүрэн: Энэ дараагийн санал дэмжигдэх юм бол энэ их ноцтой юм болно. Бүх төсвийн төсөл, арга хэмжээ энэ 2 дугаар байгааг 5 хувиар бууруулж гээд нийтэд нь бууруулаад ингээд Эрүүл мэндийн сайдын төсвийн багцыг 205 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ гэвэл энэ төсөв нэлээн эвдэрчихнэ. Тэгээд энэ хэрвээ босчих юм бол төсөв эвдэрнэ. Тэгэхээр хэрвээ яг ийм нөхцөл байдал тулж байгаа бол зогсоосон нь дээр байх.

Д.Амарбаясгалан: Энэ дээр Ганмаа гишүүн үг хэлнэ. Тийм ээ. Би уншаад танилцуулчихъя.

Төслийн 2 дугаар хавсралтын бүх төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205.0 тэрбум төгрөгөөр

нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Төсвийн байнгын хороо болон Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байгаа. Санал гаргасан гишүүн Ганмаа үг өгье.

Д.Ганмаа: Байж бай л даа. Сайн байцгаана уу. Энэ 2020-иод он ковидоос хойш л нөгөө улиран 218 тэрбум төгрөгийн асуудал эрүүл мэнд дээр асуудал шийдэгдэхгүй байгаа. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Энэ асуудлыг гаргасан бас нөгөө гаргалгааг нь ч гаргасан. Нийт төсвийг бол өөрчлөхгүйгээр 2025 оны гэсэн үг шүү дээ. Шинээр төлөвлөж байгаа. Нийт хөрөнгө оруулалтын 5 хувь гэж байсан. Тэгэхдээ энэ саналаа би өнөөдөр татаад, 32 дээр яригдах Б.Түвшин гишүүний тавьсан санал дээр та бүхнийг дэмжиж өгнө үү гэж хүсье. Баярлалаа.

Тэгэх юм бол эрүүл мэндийн салбарт үүсээд байгаа нөхцөл байдал, эм хангамж яригдаж байгаа олон асуудлууд шийдэгдэх боломжтой. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 4 дэх саналыг санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа татлаа.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 19.1.1.2-т тусгасан “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт” гэснийг “Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж” гэж, “хувь” гэснийг “тоо” гэж, мөн 19.1.1.3-т тусгасан Хэмжих нэгжийн “хувь” гэснийг “тоо” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Санал хураалт. Уучлаарай. Санал хураалтыг цуцалъя. Санал гаргасан гишүүн Анар үг өгье.

Ч.Анар: Оройн мэнд ээ, энэ дараагийн дэмжигдээгүй саналууд бол ямар ч төсөвтэй холбоогүй. Энэ тоо, хэмжих үзүүлэлтүүд нь өөрөө Засгийн газар, Батлан хамгаалах яам өөрөө оруулж ирсэн. 2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэйгөө Төсвийн тухай хууль маань уялдах ёстой гэсэн заалтыг л баримтлаад, тэр шалгуур үзүүлэлтүүдийг оруулж ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө Төсвийн тухай хууль уялдах ёстой заалтуудаар л орж ирсэн үзүүлэлтүүдийн юм байгаа шүү. Төсөвтэй бол ямар ч холбоогүй. Тэгэхээр дэмжихгүй байж босгож ирнэ. Тэгж байж энэ улсын төсөв дээр заагдсан ажлууд маань хэрэгжих суурь нөхцөл нь болно. 2025 оны хөгжлийн төлөвлөгөө дээр.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны дарга үг хэлэх үү. Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Энэ юу гэдэг юм. Төсөвт зардал, тэнцэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Энэ нөгөө төсвийн үзүүлэлт дээр л оруулъя гэсэн санал орж болно. Тухайн үед яах вэ, бид нар тэгээд л нөгөө бас л санал хураалт дээрээ 1, 2-оор зөрөөд байсан учраас уначихсан байх. Энэ дээр бол төсөвт нөлөөлөх зүйл бол гарахгүй.

5 дахь саналаар санал хураалт явуулъя. 3,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай арга хэмжээ нэмэх:

“23.2.2.“Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулах” Шалгуур үзүүлэлтийн дугаар-23.2.2.1, Шалгуур үзүүлэлт-Гадаад улстай хийх хэлэлцээр, Хэмжих нэгж-тоо, Суурь он-2023, Суурь түвшин-64, 2025 оны зорилтот түвшин-75” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт. Энэ Байнгын хорооны дэмжээгүй санал байхгүй юу. 26,5 хувиар санал дэмжигдсэнгүй.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5 гэсэн хөтөлбөр нэмэх:

“23.5.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр 23.5.1, Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн-“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Шалгуур үзүүлэлтийн дугаар-23.5.1.1, Шалгуур үзүүлэлт-Арга хэмжээний хэрэгжилт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-95, 2025 оны зорилтот түвшин-100” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. 10,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.2 гэсэн арга хэмжээг нэмэх:

“27.1.2 Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх зэвсэглэл цэргийн техникийг шинэчлэх”, Шалгуур үзүүлэлтийн дугаар-27.1.2.1, Шалгуур үзүүлэлт-Бэлэн байдлын түвшин, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-18, Зорилтот түвшин-28” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. 4,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалах сайдын төсвийн багцын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөрт дараах агуулгатай 27.1.3 гэсэн арга хэмжээ нэмэх:

“27.1.3.“Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх”, Шалгуур үзүүлэлтийн дугаар: 27.1.3.1, Шалгуур үзүүлэлт-Хэрэгжилтийн хувь, Хэмжих нэгж- хувь, Суурь он-2023, Суурь түвшин-25, Зорилтот түвшин-30” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. 4,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харилцааны сайдын төсвийн багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрт дараах агуулгатай 23.5.2 гэсэн арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөр 23.5.2, Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн “Монгол Үндэстний үнэлэмж цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх”, Шалгуур үзүүлэлтийн дугаар-23.5.2.1, Шалгуур үзүүлэлт-Арга хэмжээний хэрэгжилт, Хэмжих нэгж-хувь, Суурь он-2023, Суурь түвшин-95, 2025 оны зорилтот түвшин-100” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. 4,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гишүүд ээ, 11 дэх санал хураалт.

Төслийн 2 дугаар хавсралтын IX.1.2.“Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал

гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор. Баярмаа гишүүн үг авах гээд байна уу. Баярмаа гишүүнд үг өгье.

Ж.Баярмаа: 1 дүгээрт, хууль гэж нэг юм байна. Хуулийг ер нь Амарбаясгалан дарга аа, бид нар мөрдөх юм уу, мөрдөхгүй юм уу. Бас дахиад яс юман дээр 1 юм ярих юм бол энэ дагалдах хуулиудыг чинь ердийн хуулиар бид нар хэлэлцэх ёстой юм биш үү. Тэгвэл энэ чинь өнөөдөр биш маргааш хэлэлцэх ёстой байсан.

2 дугаарт энэ аудитын дүгнэлт дээр ийм байгаа юм. Зураг төсөвгүй гэж байгаа юм. 2 байшин. Бүр зураг төсөвгүй е, магадланд ороогүй гэж. Тэгэхээр ингээд хуулиа зөрчөөд зураг төсөвгүй юм оруулж ирээд байдаг юм уу. Болох юм уу Жавхлан сайд аа. Би зохиогоогүй шүү дээ. Та ингээд намайг дандаа нэг юм зохиож яриад байдаг юм шиг яриад байдаг юм. Энэ аудитын чинь дүгнэлт дээр зураг төсөвгүй 2 барилга байна. Магадланд ороогүй 14 барилга байшин, засвар, зам байна. Магадланд ороогүй ингээд төсөв батлагдаад яваад байдгийн гай чинь юун дээр гардаг вэ гэхээр нөгөө ямар ч хамаагүй дүн ингээд найрын дундаа ингээд 2 тэрбум, хөгшөөн 3 гээд тавьчих гэдэг юм шиг байгаа юм. Тэгэнгүүт 2 тэрбум, 3 тэрбум гээд тавьчихаар цаанаа юу үүсдэг вэ гэвэл магадгүй тэр нь багаар тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд магадланд ороод ирэхээр 3 биш 5 тэрбумын өртөгтэй байшин байдаг юм байна. Тэгээд нөгөөдөх чинь яалт ч үгүй шилжих өртөг нь ингээд нэмэгдээд явдаг юм байна. Учрыг нь олсон чинь. Тэгэхээр магадгүй энэ магадлал хийлгээгүй байна гэдэг чинь 13 тэрбум биш 15 тэрбум байхыг ч үгүйсгэхгүй. Ингээд нөгөө төсөвт чинь дарамт болоод явдаг юм байна. Энэ бол хууль зүйн талаасаа. Хууль зүйн талаасаа энэ бол хууль бус шүү. Тэгэхээр хууль бус юмыг бид нар ингээд дэмжээд дандаа зураг төсөвгүй юм оруулсаар байх юм бол энэ хуулийн засаглалаа болих хэрэгтэй. Намын засаглал гэж шилжих хэрэгтэй.

2 дугаарт төрийн орох юм, орохгүй юм гэж байхгүй юм уу. Дуртай юмаа хийгээд л явж байх юм уу энэ төр чинь. Би бол гадаад яаманд ажиллаж байсан хүн. Ёстой I am sorry гэдэг шиг жоохон эвгүй л байна. Гэхдээ энэ чинь нэг зарчим гэж байна шүү дээ. Тэгээд та нар унш л даа. Олон улсын мэдээлэл солилцоо, ёслол арга хэмжээний төв. Энэ чинь жоохон олон улсын хэмжээний соёлын төв юм уу. Нөгөө бид нарын ингээд яриад байдаг гэж уншигдаж байна. Тэгэхээр би Гадаад яаманд бол хайртай. Мэдээж Батцэцэг сайд бол маш их ажил хийж байгаа. Энэ соёлын төвтэй, төвгүй ажил сайн хийж байгаа шүү дээ. Тэгэхээр бүхэл бүтэн 13 тэрбум төгрөгөөр ингэж төсөвт ачаалал үүсгэх хэрэг байгаа юм уу. Шаардлагатай гэж үзвэл яагаад зураг төсвийг нь хийлгээгүй юм. Яагаад магадланд оруулаагүй юм. Жоохон зарчим баримаар байна шүү дээ. Жоохон хуулиа дагамаар байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн одоо тэгээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжээд энэ барилгыг хасаж өгөөч гэж үг хэлээд байна гэж ойлгож болох уу. Харин тийм. Тэгээд гишүүд яг л тэгж ойлгоод байгаа шүү дээ. Та чинь микрофон аваад учиргүй загначих шиг болох юм.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явагдана. Гадаад харилцааны сайд Батцэцэг сайдад үг өгье.

Б.Батцэцэг: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэнд хүргэе. Би Байнгын хороо дээр бас тайлбараа хэлж байсан. Баярмаа гишүүнд зураг төсөл, холбогдох материалуудыг нь хүргүүлбэ. Манай яам хамгийн бага төсөвтэй, манай яам хүссэн дуртай юмаа ерөөсөө хийдэггүй. Та өөрөө ажиллаж байсан бол бас сайн мэдэж байгаа байх. Тэгээд энэ өөрөө олон

улсын байгууллагууд, дипломат төлөөлөгчийн газруудын олон жилийн хүсэлтээр бас ийм барилга барья гэсэн байгаа юм. Энд мэдээж олон төрөл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 45,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

12.Төслийн 2 дугаар хавсралтын одоо энэ чинь Баярмаа гишүүний ... Нара гишүүн. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн горимын санал гэж байна.

М.Нарантуяа-Нара: Бодвол өнөөдөр бас миний аз таарсан өдөр юм байлгүй. Нөгөө улаан юм чинь гараад ирлээ. Тийм учраас санал хураалтыг дахин явуулах горимын санал гаргах гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Үгүй ээ үгүй, байж бай. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн эхлээд горимын санал гаргаадаа даа. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүнд микрофон өгье.

М.Нарантуяа-Нара: Үгүй ээ, би одоо 2 дахиа ярьчихлаа. Би өнөөдөр их азтай байгаа юм уу. Ямар байгаа юм. Мэдэхгүй ээ, энэ нөгөө улаан юм чинь дахиад гараад ирлээ. Тэгэхээр горимын санал явуулаад, дахин санал хураалт явуулах горимын санал өгөх гэж байна.

Д.Амарбаясгалан: Байлгүй яах вэ, энэ дээр. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж горимын санал гаргах эрхтэй. Тэгээд тэр эрхийнх нь дагуу горимын саналыг 1 асуудлаар 1 гишүүнд 1 л горимын санал гаргах боломжтой. Тэгээд одоо Улсын Их Хурлын гишүүн горимын санал гаргачихаар санал хураалгах үүрэг нь хурал даргалагчид байгаа. Тэгэхээр Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулья. Санал хураалт. 51 хувиар санал дэмжигдэж, 11 дэх санал хураалт хүчингүй боллоо.

11 дэх санал хураалтыг дахиж уншиж танилцуулья.

Төслийн 2 дугаар хавсралтын IX.1.2.“Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэж санал хураалт явуулж байна. Санал хураалт. 52,9 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал гаргасан гишүүн Бадамсүрэн гишүүн үг хэлэх боломжтой.

М.Бадамсүрэн: Би энийг тайлбарлая. Энэ асуудлаар Сангийн сайд дэмжиж байгаа. Барилгын сайд бас дэмжиж байгаа. Тэгээд эдийн засгийн 12, 13 шүү. 12 13 адилхан. Яагаад гэхээр Эдийн засгийн байнгын хороо дээр энийг сайн хэлэлцээд дэмжсэн юм. Яагаад гэхээр энэ мөнгөн дүнд ямар ч өөрчлөлт орохгүй. Зөвхөн улсын төсвөөс гаргадаг хөрөнгө дээр орон нутгийн төсвийн хөрөнгийг гаргаад 3 жилийн хугацаанд багтаагаад Монгол Улсын

бүх сум, сумын төв, сумдад төрийн албан хаагчдын орон сууцыг барья. Ийм нэг бодлогын том төслийг хийе л гэж байгаа юм. Энэ бол яг амьдрал дээрээ нөгөө манай аймагт хэрэгжээд үр дүнд хүрчихсэн. Тэгээд энэ утгаараа энийг бас дэмжихгүй байж өгөөч ээ гээд.

2-т нь түрүүн энэ 3.1 дээр алдаатай санал хураалт явагдсан. Хурлын дарга аа, би гар өргөөд, та надад үг өгөөгүй. Энэ үнийн дүнг Төсвийн байнгын хорооноос оруулж ирэхдээ алдаатай оруулж ирсэн.

Д.Амарбаясгалан: 12.Бадамсүрэн гишүүний гаргасан Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Бүсүүдийн хөгжлийг дэмжих гэж байна. 5,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

13.Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.2.Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/, төсөвт өртөг 90,000.0 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 30,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 5,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

14.Орон нутгийн төсвийн хэсэгт 1,100.0 сая төгрөгөөр санхүү бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр тусгагдсанаас Аудитын дүгнэлтэд үндэслэн Нийслэлийн суурь зардлыг 600.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зориулалтаар Эрчим хүчний сайдын урсгал зардлыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор. Үг үү. Энхцэцэг гишүүнд үг өгье.

М.Энхцэцэг: Би энэ асуудлыг маш удаан ярьж байгаа. Та бүхэн мэдэж байгаа өнөөдөр бид нар хүндээ ээлгүй, аюултай тийм нийгмийг, тийм хотыг бий болгочоод байгаа юм. Сүүлийн жилүүдэд цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч байгаа. Шангрила шатлаа л гэдэг. Их дэлгүүр шатлаа л гэдэг. Алтжин шатлаа л гэдэг. Иргэд, аж ахуйн нэгжүүд асар их хэмжээний хөрөнгө санхүүгийн хохирлыг амсаж байгаа юм. Хүүхэд хүмүүс тогонд цохиулж нас барж байгаа. Хэдхэн жилийн өмнө Дарханд 1 айлын 3 хүүхэд цахилгаанд цохиулж нас барсан. Өнгөрсөн онд гэхэд л 9 настай хүүхэд Улаанбаатар хотод зүгээр л эмийн сан руу орох гэж байгаад, бариулаас нь бариад л тогонд цохиулаад л нас барсан. Тэгэхээр бид нар энийг өөрчлөхийн төлөө ямар нэгэн юм хийхгүй байх юм уу. Бид нар хүндээ ээлтэй нийгмийг бий болгох хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхээр энэ ажлын хүрээнд өнөөдөр бид нар стандартаа орчин үеийн түвшинд хүргэх шаардлагатай байгаа. Тэр стандартаараа хүмүүсийнхээ тархийг цэнэглэдэг, их сургуульд нь сургалтын төвүүд нь тусгайлан хичээл болгож ордог байх хэрэгтэй байгаа юм.

Жишээ нь намайг Австралид магистрт сурч байхад бүхэл бүтэн 1 хичээл стандартаар хичээл орж байсан. Яагаад гэвэл стандарт гэдэг чинь өөрөө нарийн онол байдаг юм байна. Тэрүүгээр хүмүүсийнхээ тархийг цэнэглэж байж, өнөөдөр тэр стандарт бодит амьдралд хэрэгждэг. Тэгээд тэр стандартыг өнөөдөр зургийн компани нь, барилга угсралтын компани нь бодит байдалд ашигладаг. Ашиглалтыг хариуцаж байгаа компани нь, салбарууд нь, байгууллагууд нь өнөөдөр бодит байдал нь стандартынхаа түвшинд байгаа юм уу. Хүн

тогонд цохиулах хэмжээнд байгаа юм уу. Гал түймэр гарах хэмжээнд байгаа юм уу гэдэг дээр дахин үнэлгээ хийж, сайжруулах ажлыг хийдэг ийм цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн ийм реформыг хэрэгжүүлж байж өнөөдөр бид нар хүндээ ээлтэй, аюулгүй нийгмийг бий болгоно.

Тэгэхээр энийг би маш олон удаа ярьж явж байгаа. Энэ асуудал болохоор өнөөдөр Эрчим хүчний яам нь ч анхаарал хандуулдаггүй. Бид нар хариуцдаггүй гээд. Барилгын дотор цахилгаан хангамжийг Барилга, хот байгуулалтын яам хариуцдаг. Барилга, хот байгуулалтын хувьд цахилгаан нь бол 2 дахь асуудал гээд хариуцдаггүй. Ингээд энэ асуудал хаягдаад байна. Өнөөдөр бид нар хүндээ аюултай нийгмийг бий болгочоод байна. Хотыг бий болгочоод байна. Тийм учраас энэ ажлыг дэмжиж өгөөч гэж та бүхнээс хүсье.

Тэгээд хамгийн гол нь нэг ийм асуудал байна л даа. Зарчмын зөрүүтэй санал гаргаж явна гэдэг нь ер нь бол маш хэцүү юм байна. Бараг л худлаа. Хэн нэгэн том хүний төсвөөс хасуулдаг. Одоо энийг хардаа. Нийслэлээс ингээд л хасуулна гээд л. Яагаад гэвэл аудитын дүгнэлтээр нийслэл дээр ийм төсөв байна. Эндээс хэт өндөр төсөв байна. Энийг хас гэсэн дүгнэлт гаргасан учраас энийг хасах нь зүйтэй, үүнээс хасаад энэ төсвийг тусгая гээд ингээд орж ирж байгаа юм. Гэтэл энэ зарчмын зөрүүтэй санал гэдэг нь өөрөө буцаад нөгөө гишүүнээ бүр нуман тулгуурт хийчихсэн. Хэн нэгэн том хүнтэй чи дайсан болох дуртай юм бол чи хасах юмаа гаргаад ир дээ гээд. Тэгэхээр энэ бол үнэхээр ийм төсөв дээр өөрчлөлт оруулна гэсэн ойлголт байхгүй юм байна.

Д.Амарбаясгалан: Энхцэцэг гишүүний гаргасан Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн, ажлын хэсгийн дарга тайлбар хэлье.

Ц.Даваасүрэн: Энэ зүгээр нэг ийм юм болоод байна. Нөгөө орон нутгийн төсвийн иргэдийн хурлын шийддэг мөнгийг л бид нар одоо энд шийдчихээр харин асуудал үүсэж бас, эрх зүйн зөрчил гарч магадгүй шүү.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд энэ дээр тайлбар хийе.

Б.Жавхлан: Энхцэцэг гишүүний ярьж байгаа тэр зовлонтой асуудлыг бол ойлгож байна. Дэмжиж байна. Чойжилсүрэн сайд ч гэсэн дараа жилийнхээ төсөв дээр энийг анхаараарай. Хүсэлт юмнуудаа оруулаад явах хэрэгтэй. Энэ жил бол ийм ийм зүйл ирээгүй юм. Харин саяын тэр Даваасүрэн сайдын даргын хэлдэг үнэн байхгүй юу Энхцэцэг гишүүн ээ. Хэдүүлээ тэр иргэдийн хурлаар шийддэг төсөв, тэр онцгой эрхэд нь халдаж, тэдний төсвийг энд бид нар ярьж болохгүй. Хөндөж огт болохгүй. Тэр эх үүсвэр талдаа асуудалтай байхгүй юу. Тэгэхээр энэ дэмжигдээгүй юм Байнгын хороо дээр.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр ингэе. Энэ гаргасан санал өөрөө бас чухал санал байгаа учраас түрүүн Цогтбаатар гишүүний гаргасан саналтай адилхан Дэгийн тухай хуулийн 71.14-өөр санал хурааж, бас гүйцээн боловсруулж буцаая.

Тэгэхээр одоо тэгвэл энд яасан байна вэ гэхээр байна шүү дээ. Байнгын хорооноос дэмжээгүй санал гэж орж ирж байгаа санал дээр өөрөө орон нутгийн ИТХ-ын эрх хэмжээнд халдчихсан асуудлууд үүсээд, ахиж Их Хурлаар орж ирж санал хураагдах гээд байна шүү дээ. Энийг тэр гишүүддээ юм уу, санал гаргасан хүмүүст ойлгуулж, саналаа татуулах асуудлыг ажлын хэсэг, Байнгын хороо хийх ёстой л доо. Тэгээд Их Хурал дээр ийм санал оруулж ирж санал хураалгаж байгаа нь өөрөө асуудалтай байна. Энхцэцэг гишүүн саналаа гаргая. Микрофон өгье.

М.Энхцэцэг: Тэгэхээр энэ дээр Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам дараагийн удаадаа маш анхаарах юм байна гэж үзээд, би энэ саналаа татаж байна. Үгүй ээ, харин тэгээд би хэлээд байна шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал гэдэг чинь маш.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 14 дэх санал татагдлаа.

Энэ саяын Баттөмөрийн Энхбаяр гишүүний гаргасан санал бас үндэслэлтэй зүйл ярих юм. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд бас бодолцох шаардлага гарч байх шиг байх юм. Энэ дээр юу гэж бодож байна. Их Хурлын Тамгын газраас тайлбар хийх үү. Бид санал хураалт явуулчихсан. Гэхдээ өнөөдөр Улсын Их Хурал дээр хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө оруулалт гээд ороод ирж байгаа юм. Энд улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт. Аймаг, сумын ИТХ-ын батлах төсвийг урьдчилаад Их Хурал энд баталж байгаа хэлбэр гарч байна гэсэн ийм байр суурийг Энхбаяр гишүүн хэлсэн байгаа. Тэгээд Тамгын газар энэ дээр тайлбар хийгээдэх үү.

Ч.Ариунхур: 12 дахь санал хураалтаар дэмжигдсэн 2 дахь хэлэлцүүлгийн үед. Тэгэхээр 3 дахь хэлэлцүүлэг дээр ямар ажиллагаа явагдах вэ гэхээр 3 дахь хэлэлцүүлэг дээр Төсвийн байнгын хороо 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусгаад, шаардлагатай бол төсөл, арга хэмжээний төсөвт өртөх санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг хийж, төслийн эцсийн хувилбарын танилцуулгыг нэгдсэн хуралдаанд оруулна. 3 дахь хэлэлцүүлэг дээр санал хураалт явуулахгүй гэж байгаа. Тэгэхээр 3 дахь хэлэлцүүлэг дээр ямар нэгэн санал хураалт явагдахгүй. Одоо 2 дахь хэлэлцүүлэг дээр 71.14-өөр нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч, буцааж болно. Эсвэл хэрвээ санал хураалтын үед техникийн зөрчилтэй гэж үзэж горимын санал гишүүд гаргах юм бол нэг тийм асуудал байж болох байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: 12, 13 дугаар саналыг гаргасан. Санал хураалт явагдсан. Тэгэхдээ бас энд техникийн зөрчилтэй гэдэг бас асуудал яригдаж байгаа учраас санал гаргасан гишүүн Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнд үг өгье.

М.Бадамсүрэн: Энэ би сая Энхбаяр гишүүнтэй очиж зөвлөлдлөө. Энийгээ харууллаа. Гаргасан зарчмын зөрүүтэй саналаа. Тэгээд Төсвийн байнгын хороо дээр энийг ингээд 2 удаа миний саналыг өөрчилж байгаа байхгүй юу. Ямар зорилгоор гэдгийг би ойлгохгүй байна. Миний томъёолж өгсөн энэ байна. Үгүй ээ, миний томъёолж өгсөн энэ байна. Аймаг, сумдын хамтарсан хөрөнгө би ярьчихъя л даа. Аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлогын дагуу улсын төсвөөс гаргах хөрөнгө гэж оруулсан байхгүй юу. Үгүй ээ, миний хувьд чинь бас төсвийн ерөнхийлөн захирагчаар олон жил ажилласан хүн шүү дээ. Мэдэж байгаа. Тэгэнгүүт энэ дээр хураахдаа аймаг, сумын хамтарсан хөрөнгө оруулалт гээд биччихсэн нь зөрчил болчхож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүний гаргаж өгсөн саналыг өөртэй нь зөвшилцөж хэлэхгүйгээр ингээд өөрчилчихсэн. Тэр нь энэ дээр маргаан дагуулж байгаа юм. Бодлогын дагуу хамтарсан хөрөнгө оруулалтын бодлогын дагуу улсын төсвөөс гаргах хөрөнгө гэж байгаа байхгүй юу. Энэ байна. Харин найруулгаараа болж байгаа байхгүй юу. Энд юу нь болохгүй байгаа юм. Болохгүй юм байхгүй шүү дээ. 12, 13.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүнд микрофон өгье.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, Бадамсүрэн гишүүн ээ, өөрөө ажлын хэсэгт байсан байж байж одоо өөрөө байгаагүй юм шиг юм ярьж болохгүй шүү дээ. Юугаа хийж суусан юм тэгвэл. Ажлын хэсэг дээр л хураагдсан санал шүү дээ. Өөрөө гараад явсан бол хохино. Чи өөрөө ажлын хэсэгт байсан. Битгий ийм балай балай юм ярьж бай. Энийг би бол тэгж Тамгын газар энэ тэр өөрчлөөгүй байх гэж бодож байна. Хэрвээ Тамгын газар өөрчилсөн бол ёстой нөгөө орон нутгийн төсөв, энийг нь зохицуулах гэж л энэ хэд өөрчилсөн байх. Тэрнээс биш бол ажлын хэсэг дээр бид нар яриад өөрчилсөн юм огт байхгүй шүү. Битгий тэгээд дураараа ярьж бай. Чи ер нь хараад байхад хааяа нэг хамаагүй ярих юм байна шүү.

Д.Амарбаясгалан: Энэ манай Төсвийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо ажлын хэсгийнхэн яагаад ийм техникийн алдаатай зүйл Улсын Их Хурал руу оруулж ирж, санал хураалт хийлгэж байна. Энэ дээр бас асуудалтай шүү дээ. Тэгэхээр энэ 12 дугаар санал, 13 дугаар саналыг хураасныг хүчингүй болгох горимын санал гаргаж, санал хураалтаа явуулаад, тэгээд Дэгийн тухай хуулийн 71.14 дэх заалтын дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байна. 71.14-өөр. Найруулгаар авч болохгүй л дээ. Тамгын газраас тайлбар авъя. Энэ 12, 13 дугаар саналаар санал хураачихсан байгаа. Тэгэхээр энэ Дэгийн тухай хуулийн 72.1-ийг үндэслээд “Төсвийн төслийн 3 дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.” гэсэн энэ заалтаар чиглэл өгөөд явж болж байна уу. Тамгын газраас тайлбар авчихъя. Тамгын газрын микрофоныг өгье. 11 дүгээр микрофон.

Ч.Ариунхур: 12, 13 дугаар саналын тухайд яг арга хэмжээний нэр юм уу, арга хэмжээ өөрөө хэвээрээ, төсөвт өртөг хэвээрээ төсөв хувааж байгаа нөхцөлд бол агуулга зарчмыг өөрчлөхгүйгээр, санхүүжих дүнг өөрчлөхгүйгээр 3 дугаар хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо танилцуулах боломжтой гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: 3 дугаар хэлэлцүүлгээр 12, 13 дугаар саналыг найруулж орж ирэх чиглэлийг өглөө.

15.Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр, 216 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчилж, уг төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 18,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулах замаар шийдвэрлэх. Үүнд:

-XV.5.3.1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2 тэрбум төгрөгөөр;

-XVI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4 тэрбум төгрөгөөр;

-XVI.1.1.15.Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 км /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2 тэрбум төгрөгөөр;

-XVI.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2 тэрбум төгрөгөөр;

-XVI.1.2.2.Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4 тэрбум сая төгрөгөөр;

-XVI.3.1.1.Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан үг өгье.

С.Амарсайхан: Их Хурлын дарга аа, энэ саналыг татъя гэж байгаа. Яагаад гэвэл Эдийн засгийн байнгын хороо дээр энэ саналыг хураах явцад дахиж ажлын хэсэг дээр төсөвт өртөг, санхүүжих дүнд нь ямар нэгэн өөрчлөлт оруулахгүйгээр хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийн нэр өөрчлөх гэдгээр түрүүн 2.2 дээр санал хураагдаад шийдвэрлэгдсэн учраас энэ саналыг буцааж татаж байна. Тийм учраас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 15 дугаар саналыг татлаа.

16.Төслийн 2 дугаар хавсралтын VII.4.1.Авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 15,645.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,200.0 сая төгрөгөөр бууруулж Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцад Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mm” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг болон санхүүжих дүнтэй гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн. Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье. Санал гаргасан Золжаргал гишүүнд үг өгье.

Ж.Золжаргал: Та бүхнийг татгалзаж өгөөсэй гэж хүсэж байна. Гар хүрэхгүйгээр. Саяхан Япон-Монголын эмнэлэг рүү дроноор цус хүргэсэн. Санаж байгаа байх. Тэгээд энэ хотын эргэн тойронд нөгөө Сибирийн хүр хорхой мод идээд байдаг. Одоо бол бетоной хүн очиж хор цацахаа болиод, дроноор цацдаг болчихсон. Гал унтраахад бас өндөр давхар дрон хэрэглэдэг. Сонирхолтой нь Монголчууд энийг хийгээд туршаад прототап загвар гаргаад нисгэчихсэн. Тэгээд чаддаг хүмүүс нь бэлэн, суурь нь байгаа. Тэгэхээр ойролцоогоор 15 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, зураг төслөөс 1-ийг нь аваад, тэгээд бэлэн юмыг нь үйлдвэрлэл болгочихъё. Тэр 1.2 тэрбумын 2/3 нь тоног төхөөрөмж, 1/3 нь болохоор ажиллах хүний хөлс л байгаа юм. Эд нар энэ төслийг хэрэгжүүлэх хугацаандаа дронуудаа үйлдвэрлэчихнэ. Тэгээд 5 дроны мөнгөөр тэртээ тэргүй худалдаж авч байгаа хил хамгаалах дээр бол зөндөө хэрэглээд эхэлчихсэн байгаа. Тэрийг төсөв нь ингээд үндсэндээ өөрийгөө нөхчхөж байгаа байхгүй юу. Тэгээд бэлэн ийм жижигхэн инновацын төслийг бэлэн гэлгүйгээр хийчих юм бол дараа нь Монгол даяар маш их хэрэглээ байна. Энийг татгалзаж гар хүрэхгүйгээр өгөөч гэж хүсэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын за Золжаргал гишүүн дуусаагүй байна.

Ж.Золжаргал: Тийм. Тэгээд зүгээр сонирхуулахад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны энэ цахимжилттай холбоотой төсөв нь сонирхолтой нь бусад бүх чиглэлүүдээсээ бага байдаг юм байна. Тэгээд аймгуудын цахимжилттай холбоотойгоор цахимжилтыг нэмэгдүүлэх дараагийн санал нь байгаа. Тэрийг бас босгож өгнө үү гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүнд үг өгье.

Ц.Даваасүрэн: Яах вэ, энэ зүгээр ач холбогдолтой байж магадгүй. Тэгэхдээ нөгөө нэг Их Хурлын гишүүд тэгээд л 1 хүний захиалгаар юм хийгээд байна гэдэгтээ л энэ юм чинь л нөгөө хардалт чинь л жинхэнэ явчих гээд байгаа байхгүй юу. Одоо ингээд л нэг найзынхаа бизнесийг дэмжиж байгаа гэдэг ч юм уу, Их Хурлын гишүүд мөнгө авчихлаа гэдэг ч юм уу. Түүнтэй чинь л энэ асуудлууд л холбогдчихоод байгаа учраас л бид нар зохимжгүй байна гэж үзсэн. Магадгүй энэ зөв зүйл байж магадгүй л дээ. Тэгэхдээ 1 талаасаа тэгж харагдаад байгаа байхгүй юу. Би жишээлбэл ийм санал гаргахад, манай найзын бизнес эрхэлж байгаа бол одоо тэ энэ чинь нөгөө ашиг сонирхлын зөрчилтэй холбогдож байгаа учраас тийм юм харагдаад байгаа юм. Сая нийгмийн шуугиан боллоо шүү дээ. 5 тэрбум гэлүү, 10 тэрбумыг ингээд л гишүүд авах гээд байна гэдэг ч юм уу. нэгнийхээ бизнесийг дэмжих гээд байна гэдэг ч юм уу. Тэр шиг л харагдчих юм уу л гэж би зүгээр яриад л ингэсэн юм.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах нь ээ. 38,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

17.Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 5,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал байгаа. Төсвийн байнгын хороон дарга Даваасүрэн гишүүнд үг өгье.

Ц.Даваасүрэн: Энэ дээр би одоо дахиад л хэлье. Энэ жишээлбэл ингэчихсэн байгаа байхгүй юу. Барилга, хот байгуулалтын сайдын багцын мөнгийг аваад Цахим хөгжлийн сайдын багцын мөнгө рүү хийж байгаа юм л даа. Гишүүд яг ингээд байвал энэ их тийм зохимжгүй л харагдана даа. Нөгөө 5 тэрбум, тэрийг ингэдэг гэдэг чинь л болчих гээд байгаа байхгүй юу. Энийг л бид нар ийм зүйл гаргахгүй байя гэж бүлгүүд дээрээ шийдээд л, тэгээд бид нар энэ гишүүдийн оруулж ирж байгаа асуудлуудыг бүгдийг нь унагасан байгаа шүү дээ. Гишүүд янз бүрийн санал гаргасан байгаа. Манай тойрогт ийм асуудал байна. Тэр тойрогт ийм асуудал байна. Үерийн хамгаалалтын асуудал байна. Дотуур байр шатсан байна энэ тэр гээд л тулгамдсан асуудлууд оруулж ирснийг бид бүгд буцаасан байхгүй юу. Ингээд дураараа байх юм бол хэн нэгний төсвийг гишүүд аваачаад л нөгөө сайдын багц руу хийгээд л байдаг байх юм бол энэ чинь зүгээр л холион бантан болох байхгүй юу даа.

Д.Амарбаясгалан: Золжаргал гишүүн яах юм. Санал гаргая. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн үг хэлэх ёстой. Төсвийн байнгын хорооны дарга, ажлын хэсгийн дарга тайлбар хийж байгаа.

Ж.Золжаргал: Гишүүд яах вэ өгсөн мэдээлэл дээр үндэслээд тэгээд шийдвэрээ гаргах байлгүй дээ. Ер нь бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас ...

Д.Амарбаясгалан: Санал татахгүй юм байна. Боломжгүй. Дэгээрээ санал гаргасан гишүүн үг хэлж байгаа. 17 дугаар саналаар санал хураалт явуулъя. Гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Золжаргалын гаргасан саналыг Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Төхөөрөмж гагцчихлаа. Энэ санал хураалтыг хүчингүй болгочихъё. 2, 3 гишүүд гар өргөж байна. Санал хураалтыг цуцалъя.

17 дугаар саналаар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 36,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

18.Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.3.1.Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцад Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 4,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 52,4 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.3.1.Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 24,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,590.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцад Хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,590.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Санал гаргасан гишүүн Батбаярын Жаргаланд микрофон өгье.

Б.Жаргалан: Энэ саналыг татъя.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

20.Төслийн 2 дугаар хавсралтын IV.2.1.1.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг 154,491.7 сая төгрөг, санхүүжих дүн 30,444.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэлд микрофон өгье.

Д.Рэгдэл: Оройн мэнд хүргэе гишүүд ээ. Орой болсон хойно бас нэмж чилээж байгаадаа уучлал хүсье. Энэ ийм учиртай юм байгаа юм. Манай Засгийн газраас сүүлийн 7 жил шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн лабораторийн тоног төхөөрөмжид 1 ч төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээгүй. Тэгээд энэ жил хийхгүй бол 8 дахь жилдээ болчих юм байгаа юм. Тэгээд манай Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодорхой санал явуулаад, дараагийн шатдаа энэ лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгө хасагдчихаад, бүр 0 болчихсон яваад ороод ирсэн. Ингээд Байнгын хороо дээр оруулаад, манай Байнгын хороо үндсэндээ

7 зарчмын санал орж ирснээс манай ганцхан энэ 20 дугаартай саналыг дэмжээд, ингээд Төсвийн байнгын хороонд очоод бас ирцтэй холбоотой юмнаас болоод дэмжигдээгүй ирээд байгаа юм. Тэгээд бид нар чинь шинжлэх ухаанаа хөгжүүлэх, энэ хэдэн ЭША-даа бас гарт нь барьдаг зэвсэгтэй байлгаж байхын тулд ер нь энд бол жил болгон бага бага ч болов санхүүжилт хийгээд байх ёстой юм л даа. Тэгээд энэ жил энэ лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт гэдэг юмыг 2025 оны төсвөөс эхлээд явах зорилготой ингээд дэвшүүлээд явж байгаа санал байгаа юм. Та бүхэн маань бас дэмжээд босгоод өгөөрэй.

Д.Амарбаясгалан: 20 дахь саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 23,3 хувиар санал дэмжигдсэнгүй.

21.Төслийн 1 дүгээр хавсралтын 28.5.Боловсролын сайд, хөтөлбөр 28.5.1, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах ажил амьдралын орчинд суралцах тэгш боломж бүрдүүлнэ.” Гэснийг “Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 19,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

22.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Санал гаргасан гишүүн Ц.Мөнхтуяад үг өгье.

Ц.Мөнхтуяа: Байна уу. Би энэ саналаа татаж байгаа. Татчихъя.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

23.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.5 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 200 ор /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,000.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Санал хураалт. 41,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Наранбаяр горимын санал гаргаж байна.

П.Наранбаяр: Сая бас нөгөө миний энэ яг одоо баримттай. Энэ улаан нөгөө тууз нь гараад, саналаа өгч болсонгүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгоод, хүчингүй болгох ийм санал хураалтыг явуулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Наранбаярын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. 42,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

24.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.137.Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор/Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 6,710.4 сая төгрөг, санхүүжих дүн 5,910.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ор/Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,100.0 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ор/Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,810.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус шинээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 41,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

25.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг. Санал гаргасан гишүүн Жудагийн Баярмаад үг өгье.

Ж.Баярмаа: Энийг нэлээн олон ярьчихсан учраас бас л нүүр халуун байна. Би соёл, урлагт хайртай, дуртай. Манай эмээ бас жүжигчин, дуучин явсан хүн. Манай гэрт бас дуулж, хуурдаг хүмүүс байдаг юм. Гэхдээ би соёл урлагт дургүйдээ биш. Энэ татвар төлөгчдийн хэдэн мөнгийг л аминдаа хэмнэх гээд байгаа шүү дээ. Нэг талаасаа. Нөгөө талаасаа энэ өсвөр үеийнхэнд мөнгө тарааж ийм бэлэнчлэх сэтгэлгээнд сургах гээд байгаа юм уу. Эцэг эхийнх нь ажил орлогыг нь нэмэгдүүл л дээ. Ажлын байртай болго л доо. Өөрснөө орлого олоод, мөнгөө төлөөд авах тэр ажлыг нь хийж өг л дөө гэмээр байгаа юм. Тэгээд судалгаа яриад байна л даа. Тэгээд олон улсын байгууллагууд энэ өсвөр үеийнхэндээ ингээд ваучер тараа, тэгэхээр амиа хорлолт багасна гэж бол хэлээгүй байх гэж би бодож байна. Дахиад судалгаа авсан гэж яриад байгаа юм. Тэгээд өсвөр үеийнхэн тэг ээ, бид нарт өг өө, тэгвэл бид нар хүмүүжилтэй болно гэж хэлээгүй гэж би бодож байна. Дээрээс нь одоо ер нь бол хүнээр юмаа даалгана гэдэг чинь маш соёлгүй үзэгдэл шүү дээ уг нь бол. Шарая биз дээ энэ чинь. Тийм сэтгэлгээнд ингээд дөнгөж 18 нас хүрэх гэж байгаа залуучуудыг сургаад соёлжуулах биш, бүр соёлгүй болгоод байна шүү дээ. Тэгэхээр энэ нэг өсвөр насныхныг гэгээрүүлэх нэрийн доор ингэж халамж тараах ийм сонгуульд бэлдэж санал авах энэ ажиллагаагаа одоо боливол яасан юм бэ. Одоо сонгууль болох болоогүй шүү дээ. Тэгээд нөгөө төсвийг хэмнэнэ, үр ашигтай зарцуулна гэж ингэж 2, 3 талдаа гарч ярьж, ярьчаад яг цагаа тулахаар үнэгүй ваучер тараана гээд ингээд байх юм. Тэгээд аудитын дүгнэлт дээр чинь дахиад байж байгаа шүү дээ. Хэдэн төгрөг яаж тараах, тэр Засгийн газрын журам энэ тэр нь байхгүй гээд. Тэгээд энийг яагаад ингээд нэг ийм 18,3 тэрбум төгрөг чинь бага мөнгө биш шүү дээ. Тэгээд энийг кофе шопод суугаад байна гэх юм. Залуучууд кофе шопод суух эрхтэй шүү дээ. Тэд нарыг хүчээр юм үзүүлэх гээд байгаа юм уу. Кофе шопоос нь гаргаад. Тэгээд жүжиг кино үзэнгүүтээ амиа хорлолт нь багасах юм уу. Энэ бол ерөөсөө ойлгомжтой шүү дээ. Санал авах гэсэн л оролдлого шүү дээ. Энийг тэгээд 4 жил хийх юм уу. 4 жил 18 тэрбум тараах юм уу. Тэгээд яг ар дээр нь ямар зорилго яваад байгаа юм. Соёлжуулах гээд байгаа юм уу. Гэгээрүүлэх гээд байгаа юм уу. Үнэгүй юм авдаг чинь соёлгүй явдал. Хүнээр юмаа даалгана гэдэг чинь соёлгүй үзэгдэл. Орчин үе, 21 дүгээр зуун. Би яах вэ эцэст нь дахиад давтаад хэлчихье. Бид нарын ад үзээд халъя сольё гээд халсан тэр социалист нийгэмд чинь хүртэл үнэгүй кино, жүжиг, музей байгаагүй. Бүгд мөнгөө төлөөд үздэг

байсан. Энэ бол бүр ухралт биш бүр гамшиг болох гэж байна. Тэгэхээр энийгээ боль л доо. Одоо болиод 1 ч гэсэн юмыг хэмнэ л дээ.

Тэр эмнэлэг, цэцэрлэг, сургууль, хавдрын эмнэлэгтээ зарцуул л даа. Жил болгон 7 мянган хүн хавдраар өвдөж байна. 60 гаруй хувь нь хожуу үедээ, 50 хэдэн хувь нь хөдөө орон нутгийнх. Гэтэл хавдрын эмнэлэг байхгүй байна шүү дээ. Тэгэхээр та өөрөө бас татгалзаад, хавдрын эмнэлэг энэ өвчтэй зовлонтой явж байгаа энэ хүмүүст энэ тавиулах гээд байгаа мөнгөө өг л дөө. Миний бодлоор наад мөнгийг чинь залуучууд авлаа гээд соёлжих ч үгүй, гэгээрэх ч үгүй. Бэлэнчлэх сэтгэлгээнд суралцана. Соёлгүй, бүдүүлэг болно. Юмаа хүнээр даалгах гэсэн тийм сэтгэлгээнд суралцана. Энэ бол капитализм биш. Бид нар чинь ер нь социализмаас капитализмд шилжиж ядаж явж байгаа улсууд шүү дээ. 34 жил болж байна шүү дээ. Тэгэхээр энэ зорилготой юмаа боль л доо.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Жавхлан төсөл өргөн барьсан. Номин сайд энэ дээр тайлбар хэлнэ биз дээ. Би 24 дээр тайлбар хэлэх гэсэн юм. Галбадрах гишүүн ээ, танд би санал хэлье. Та энэ төслөө татаж аваа. Та хардаа үгүй ээ, байж бай. Би хэлчихье. Та бүр дүүргийг нь заагаад, 2 цэцэрлэгийн худалдаж авах дүнг тавьж байгаад ингэж оруулна гэдэг чинь түрүүний Золжаргал гишүүнийхтэй яг ижилхэн байхгүй юу. Энэ чинь төсөвт 2 бүр цэцэрлэг шахах гэж байна шүү дээ. Дүнг нь тавьж байгаад. Энд худалдан авах ажиллагаа, тендер зарлагдана. Тэр хавьд нь өөр цэцэрлэг байхгүй. Эднийх үнээ явуулах юм байна л даа. Бүр үнийг нь хэлээд шивнэж байгаад таныг явуулчхаж. Таныг шинэ байгаа дээр чинь наадуул чинь ашигласан байна шүү. Таныг маш буруу юм руу түлхэж оруулна. Тийм учраас энэ төслөө та татаж авсан нь зөв байх. Би ингэж зөвлөж байна шүү энэ 24 дэх санал. Энэ ерөөсөө маш болохгүй.

25 дугаар саналтай холбоотой асуудал ярьж байна. Горимын санал. Мэндбаярын Мандхай гишүүн горимын санал гаргая.

М.Мандхай: Түрүүн сүүлийн 2 санал дээр төхөөрөмж ерөөсөө ажилласангүй. Тэгээд гараа өргөөд дарга аа гээд хэлсэн боловч харахгүй өнгөрчихлөө. Тэгээд тийм учраас би дахиж санал хураалт хийхийг хүсэж байна. Энэ саяын саналыг хүчингүй болгоод, дахиж санал хураалт явуулах хүсэлт гаргаж байна. 24-ийг.

Д.Амарбаясгалан: Энэ 24 дэх саналыг бол түрүүн дүнг нь зарлаад цохичихсон. Тэгээд 25 дугаар асуудалд орсон хойно горимын санал гаргасан учраас горимын саналыг хүлээж авах боломжгүй.

Гишүүд өөрсдөө Байнгын хороо дээрээ дахиж ярилц. Хэрвээ унагаах асуудал яригдаж байгаа бол тэрийгээ Байнгын хороо дээр 2/3-оор саналаа дэмжиж орж ир гэдгийг хэлье. Ингээд 25 дахь санал хураалт явагдаж байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Жудагийн Баярмаа гишүүн санал гаргасан байгаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй сана, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Тэгээд одоо дахиад 3 дахиа Улсын Их Хурал дээр орж ирж санал хураалгаж байгаа ийм санал явж байна. Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Номин сайд тайлбар өгье.

Ч.Номин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Мэдээж энэ болбол боломжтой айлын хүүхдүүдэд бол шаардлагагүй зүйл байх. Манай Ардчилсан намын гишүүдээс бас санал гарч байна. Энэ бол тийм улс төрийн шийдвэр зүйл биш ээ. Та бүхэн өөрсдөө 30

мянган төгрөгийг сар болгон хүүхдэд өгье гээд явж байсан ийм зүйл гарч ирсэн. Та намайг судалгаа ярьсан гэж байна лээ. Би дахиад нэг судалгаа хэлье.

Энэ тандан судалгаанд 19500 хүүхэд ороод 94 хувь нь энэ хүмүүст хэрэгцээтэй байна гэж үзсэн. Яагаад вэ гэхээр энэ өсвөр насны хүүхдүүд маань өөрсдөө санхүүгийн боломжгүй байна. Нийт хүүхдийн 70 хувь нь соёлын болон спортын арга хэмжээнд огт оролцож чадахгүй байна. Яагаад вэ гэхээр санхүүгийн боломжгүй байна гэдэг ийм зүйл хэлсэн. Энийг бүтэн зургаар нь үзэх юм бол 186 мянган хүүхдийн төлөө 3км замыг л одоо танаж байгаа ийм зүйл байгаа. Тэгээд та бүхэн одоо хүүхдийн төлөө энийг бодолцож үзээрэй. Тэгээд дэмжсэн санал гаргаад, Төсвийн байнгын хорооны татгалзсан саналыг дэмжсэн санал гаргаад өгөөрэй гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Санал хураалт явуулъя. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Төхөөрөмж гацлаа гээд гишүүд гар өргөж байна. Цуцалъя. Сангийн сайд Болдын Жавхлан горимын санал.

Б.Жавхлан: Оройн мэнд ээ гишүүд ээ. Цаг нэлээн орой болсон байна. Манай гишүүд нэлээн ядарсан байна. Өнөөдөр бүтэн өдөр ажлын цагаар ажлын цагаа сунгаад, төсөв батлах гээд цуг сууж байгаа гишүүддээ их баярлалаа. Тийм учраас өнөөдөр одоо ингээд санал хураалтаа зогсоогоод, өглөө 10 цагаас үргэлжлүүлье гэсэн горимын саналтай байна. Санал хураалгаж өгнө үү. Биш ээ, юу билээ санал хураахгүй. Их Хурлын дарга шийдэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлангийн гаргасан горимын саналаар 24 дүгээр санал хураалтаар өнөөдрийн санал хураалтыг дуусгаад, маргааш өглөө 10 цагаас үргэлжлэх чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалтаа үргэлжлүүлнэ. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан хаалаа.

19.20 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ